

Ulaanbaatar
2021

JOURNAL OF LAW AND MANAGEMENT

SHIHUTUG

SHIHUTUG UNIVERSITY



© ШИХИХУТУГ сэтгүүл нь бүхэлдээ зохиогчийн эрхээр баталгаажсан болно.

Шихихутуг их сургуулийн 30 жилийн ойд зориулав

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:	Д.Лүндээжанцан
Зөвлөлийн гишүүд:	Ж.Бямбаа Н.Жалбажав Д.Оюунцэцэг А.Доржготов Р.Оюунбадам Г.Энхбаяр Т.Сүхбаатар Б.Одончимэг
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнх-Эрдэнэ
Дизайнер:	Н.Тэлмүүн
Хэвлэлийн хуудас:	9.0 х.х
Хэвлэсэн газар:	"Мөнхийн Үсэг" ХХК

Хаяг:

СБД 5-р хороо Үндсэн хуулийн гудамж
Шихихутуг их сургууль.

Web site: www.shihihutug.edu.mn

Tel: 11+314977 Ulaanbaatar, Mongolia.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
ЭРХ ЗҮЙН ИЛТГЭЛ, НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЛЭГ	7
Байнгын ажиллагаатай парламент - 30: ололт, сорилт / Д.Лүндээжанцан / ..	8
Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх арга зүйн үндэс / Н.Жалбажав /	20
Өршөөл өөгүй байх учир шалтгаан / Р.Оюунбадам /	29
Хуульчдын ёс зүйн үнэлэмж дэх шинжлэх ухааны зарим нэг ойлголтуудаас / Э.Ариунаа, Д.Отгончимэг /	41
Монгол улсын хөгжилд эрх зүйн шинэчлэлийн үр нөлөө / Хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн асуудал Ц.Амарсанаа /	47
Өмчлөл, эзэмшлийн онол, иргэний хуулийн зохицуулалтын зарим асуудал / Ё.Болормаа /	63
Эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх эрх зүйн асуудал / Д.Цолмонгэрэл / ...	73
Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцох эрх зүйн зохицуулалтын асуудал / С.Номынбаясгалан /	83
Уул уурхайн салбар дахь худалдан авах ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалт / Г.Батнасан, Г.Гантөгс /	102
Монгол улс дахь газар өмчлөх эрхийн уламжлал, шинэчлэл / Э.Анхбаяр / ..	119
Монгол улсын үндсэн хууль дахь үндэсний баялгийн сангийн тухай зохицуулалт ба олон улсын туршлага / С.Асланбек /	126
Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт / Г.Халиунаа, Б.Ариунжаргал /	138
Монголчуудын удмын судар ба монгол овог, нэрийн учир / Д.Отгончимэг /	149
Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх / Б.Мөнх-Эрдэнэ /	157
ОРЧУУЛГА	173
Төрийн эрүүгийн бодлого / Т.Сүхбаатар /	174
Хувь хүний дангаарших эрхийн талаарх америкийн нэгдсэн улсын дээд шүүхийн голлох шийдвэр, түүний зарим үр дагавар №2: грисволдын маргаан / М.Хатанзориг /	182
ХУУЛИЙН ТАЙЛБАР	189
Компанийн хуулийн тайлбар / А.Доржготов /	190
ЯРИЛЦЪЯ	211
Хууль зүйн ухааны доктор, профессор / Ж.Бямбаа /	212
СУДАЛГАА	219
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацаа	220
Сургалтын хөтөлбөр, агуулгаар шударга ёсны хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх талаарх экспертийн ярилцлагын дүн.....	224
УДИРДАХУЙН УХААНЫ ИЛТГЭЛ, ОРЧУУЛГА	239
Нийгмийн капитал ба "нийгмийн хамгааллын япон загвар" / Г.Энхбаяр /... ..	240
Үндэсний соёлын үнэт зүйлийн судалгааны зарим үр дүн / Я.Шуурав /	248
Виртуал хөрөнгийг эрх зүйн үүднээс тодорхойлох нь / М.Түвшинжаргал /	258



ӨМНӨХ ҮГ



Шихихутуг сэтгүүл нь Шихихутуг Их сургуулийн эрдэмтэн судлаач нарын төдийгүй тэргээрийн болон олон практикийн эрдэмтэн судлаачдын өгүүлэл, илтгэлүүдийг нийтэд хүргэдэг хэвлэл юм. Энийг мээс энэ сэтгүүлд шинийг эрэлхийлсэн, эрх зүйн хүрээ салбарын анхаарал гагахуйн асуудал хөндсөн тодорхой санал шүүмжлэл дүхий танартай, өгөөжтэй, редакцын шаардлага хангахуйн илтгэл, нийтлэлүүд тавигдах нь эхний шалгуур болдог билээ. Шихихутуг сэтгүүлийн зөвлөл нь 1999 оны 3 сарын 20 өдөр Шихихутуг Их сургуулийн захирлын дугаар 24 үгээр тушаалаар байгуулагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл тус сэтгүүл нь дотоодын их, дээд сургуулиудын номын санг байршиж, эрдэм шинжилгээний, судалгааны бүтээлийн эргэлтэнд орж тодорхой хүрээлэлд нэр хүндтэй, уншигчидтай сэтгүүл болж тавсан юм.

Сэтгүүл нийтлэлийн бодлогодоо анхаарт цаашдаа эрх зүйн шинэлэлийн хүрээнд хийгдэж дүй хууль тогтоолжийн талаарх олон үндэсний болон дотоодын эрх зүйн хүрээнд олон, практикт түлгэмтсэн асуудлыг хөндсөн, гүүнийг шийдвэрлэх арга замын талаар санал, дүгнэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гаргасан нийтлэлүүдийг түлхүү хэвлэн гаргах зорилготой байгаагаас гадна Шихихутуг их сургууль шинээр Удирдахуйн ухааны тэнхимтэй болсонтой холбогдуулан удирдахуйн ухаан, менежментийн сонирхолтой илтгэл, нийтлэлүүдийг сэтгүүлдээ нийтлэхээр ажиллаж байна.

Шихихутуг сэтгүүлийн зөвлөл нь иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, судлаач эрдэмтэн, багш нарын илтгэлийг олон нийтэд таниулж түгээх зорилго нэгтэй, хамтран ажилладаг төрийн болон төрийн дүс байгууллага, хувь хүтүүс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын санал бодлыг хүлээн авч хамтран ажиллагаагаас гадна уншигч оны сэтгэгдэл болоод саналыг иргэдэд хүндэтгэн сэтгүүлийнхээ танарт шингээж тусгахыг эрхэмлэдэг.

Энэ удаагийн дугаар Монгол Улсад оршин иагийн боловсрол, шинжлэх ухааны байгууллага үүсвэр, хөгжсөний 100 жил, Шихихутуг их сургуулийн 30 жилийн ойн хүрээнд гарч дүй туегаар дугаар гэгдээрээ онцлогтой. Бид энэ дугаартаа судлаач багш нар, эрдэмтдийнхээ гярхай ажиглалтаар шинжлэх ухааны салбарт дэм болохоор шинэлэг бодууштай санаагаар баялаг илтгэл, өгүүлэл, нийтлэлүүдийг хүргэж байна. Ирэх он жилүүдэд бид сэтгүүлээ илүү олон улсын жишигт ойртуулахын төлөө хилээн зүтгэх болно.

Эрхэм уншигч танг Шихихутуг их сургуулийнхаа 30 жилийн ойн баярын халуун мэндийг эрдэмийн хамт олныхоо өмнөөс хүргэе. Өрсөж сэтгэж хөгжсөнд хөтөлж яваарай гэж хүсье.

Шихихутуг их сургуулийн захирал, дэд профессор: Д.Оюунцэцэг



ЭРХ ЗҮЙН ИЛТГЭЛ,
НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЛЭГ

БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ-30: ОЛОЛТ, СОРИЛТ



Д.Лүндээжанцан- Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, гавьяат хуульч

Монгол Улсад парламентат ёсны үндэс суурь хэдийд тавигдаж бий болсон талаар эрдэмтэн, судлаачид нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй байгаа билээ.

Судлаачдын бүтээл, эх сурвалжуудаас үзэхэд нэг хэсэг нь Хамаг Монголын ноёдын хуралдай парламентын шинжийг агуулсан байдаг тул эндээс эхлэн судлах ёстой гэж үздэг бол, нэг хэсэг нь Их Монголын эзэнт гүрний Их Хуралдай бол төрийн дээд байгууллагын шинжийг агуулсан манай анхны хурал гэж, харин зарим судлаачид Богд Хаант Монгол Улсын үеэс Монголын парламентат ёс эхтэй гэж үздэг.

Бидний үзэж буйгаар Монголын парламентат ёсны үүсэл, төлөвшлийг:

- Парламентат ёсны угтал үе (Монголын нэгдсэн төр улсаас - Олноо өргөгдсөн Монгол улсын төрийн үе);

- Парламентат ёс хэлбэрээ олж, эхлэл нь тавигдсан үе (1924-1990 он);
- Парламентат ёсны төлөвшлийн үе (1990 оноос хойших үе) гэж 3 үндсэн үе шатанд авч үзэх ёстой гэж үзэж байна.¹

1. Монголын парламентат ёсны угтал үе

Эхний үе шатанд парламентат ёсны үр хөврөл, зарим нэг элементүүд үүсч байсан боловч хууль тогтоох төлөөллийн байгууллын хэлбэрийг олоогүй байсан.

Их Монгол Улсын Их Хуралдай нь хааныг сонгож, төр улсын тулгамдсан асуудалд ончтой хариу эрэлхийлж, нягтлан магадласны үндсэн дээр их хаанд зөвлөх эрх, үүрэг бүхий төрийн байгууллага юм. Их Хуралдай нь эртний улсуудын үеийнхээс зохион байгуулалт, хэлбэрийн хувьд боловсронгуй болж, төрийн дээд байгууллагын шинжийг илүүтэй агуулах болсон байв.²

Их Хуралдай чуулах тов, хэлэлцэх асуудлыг урьдчилан мэдэгдэж, оролцогчдыг эртнээс сайтар бэлтгэн, хаан өргөмжлөх, дайн зарлах, алба гувчуур тогтоох зэрэг олон чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байжээ. Мөн Их хуралдайн жаяг дэгийг улам нарийсгаж, хуран чуулах ихэс дээдсийг тусгайлан тогтоож байжээ.

¹ Д.Лүндээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. Хоёр дахь хэвлэл. УБ 2014

² Мөн тэнд

Ийнхүү Их Монголын эзэнт гүрний үеийн хуралдай, "бага хаадын" үеийн хуралдайнүүд нь улс орны тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргаж, улс орон даяар мөрдөх хэм хэмжээ тогтоож байснаараа парламентын зарим хэлбэрийг агуулсан, монголын парламентат ёсны үүслийн анхны үр хөврөл байв.

Монголын парламентат ёсны үүсэл, хөгжлийн түүхэнд Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн Улсын дээд, доод хурлууд онцгой байр суурь эзэлнэ гэж олон судлаачид үздэг.¹

Олноо өргөгдсөн Монгол Улсын үед Богд хааны зарлигаар дээд, доод хоёр танхимтай улсын хурлыг 1914 онд байгуулжээ. Богд хаан "Улсын хурлын найман зүйл бүхий дүрэм"-ийг баталж, энэ дүрмээр улсын дээд, доод хурлын хэм хэмжээ, дэгийн шинжтэй журмуудыг тогтоосон ба Улсын хурлын хуралдаан нь хатуу чанд дэг журам, нарийн зохион байгуулалттайгаар явагдаж байжээ.

Сонирхуулан дурдахад: Улсын хууль зохиох комисс зохиох ёсоор ажилласны үр дүнд "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг" хэмээх хуулийг 1915-1918 онуудад зохион боловсруулж, улсын дээд, доод хурлаар хэлэлцүүлсний дараа зохих засвар, нэмэлт үйлдэж, Улсын эзэн хаанаар батлуулсан юм. Эл хуулийг боловсруулж бэлтгэхдээ монголын хууль цаазын уламжлалд тулгуурлахын зэрэгцээ дээр дурьдсан гадаад орны хууль цаазын жишгийг харьцуулан судалж ашигласан ажээ. Уг хуулийг

боловсруулан уван цуван байдлаар гаргаж, эцэст нь жаран таван дэвтэр болгон эмхэтгэсэн байна. Эл цаазын бичгийн нэлээдийг нь хорголжин бараар нийтэлсэн бөгөөд нэг хэсгийг нь хэвлэж амжаагүй гар бичмэлээрээ үлдэн, бидэнд уламжлагдан иржээ. Улсын архив, Улсын төв номын санд хадгалагдаж байгаа 58 дэвтэр эхийг З.Лонжид, О.Батсайхан нарын зэрэг түүхчид худам монголоос кирилл монгол бичигт буулган 1995 онд нийтлүүлсэн билээ.

Энэ үеийн Улсын хурал нь сонгуулийн бус, гол төлөв язгуур угсаа, албан тушаалын зарчмыг баримтлан байгуулагдсан ч төрийн хэргийг шийдэхэд төлөөлөгчдийн байгууллагаар хэлэлцдэг дэлхийн нийтлэг "жишиг"-т ойртсон парламентат ёсыг Монгол оронд анх нэвтрүүлэх гэсэн оролдлого байв. Гэвч энэ үед Монголд хууль тогтоох эрх мэдлийг өөртөө агуулсан парламент хэмээх төрийн институт сонгодог утгаараа байгаагүй гэж үзэж байна.²

Үндсэн хуульт хаант засгийн хэлбэрийн төртэй байсан 1921-1924 онд Монгол Улсад зөвлөх эрх бүхий Улсын түр цагийн хурал ажиллаж байлаа.

2. Парламентат ёс хэлбэрээ олж, эхлэл нь тавигдсан үе

1924-1990 оныг Монгол улсад парламентат ёс хэлбэрээ олж, эхлэл нь тавигдсан үе гэж үзэж болно.

а) 1924 оны 11 дүгээр сарын 26-нд Улсын анхдугаар их хурлаар Монгол

¹ Л.Өлзийсайхан. Парламентат ёсны хөгжил: Харьцуулсан шинжилгээ. УБ. 1999.

² Д.Лүндээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. Хоёр дахь хэвлэл. УБ 2014

Улсын анхны Үндсэн хууль батлагдсанаар Үндсэн хуульд байгууллын эрх зүйн үндэс тавигдсан юм. Үндсэн хуулиар ард түмэн сонгуулийн замаар сонгогдсон төлөөллийн байгууллагаараа дамжуулан засгийн эрх барих Бүгд Найрамдах засгийн хэлбэрт шилжсэн юм.

Анхдугаар Үндсэн хуульд “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хурал хадгалах, хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах бөгөөд бага хурлын чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” хэмээн төрийн эрх мэдлийг хуваарилсан байна.

Улсын Их Хурал, түүний чөлөө цагт Улсын Бага Хурал улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбоотой аливаа асуудал, дотоод, гадаад бодлогын үндсэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, жил бүрийн улсын төсвийн тухай хуулийг баталдаг байхаар хуульчилсан байв. Ийнхүү байгуулагдсан Улсын Их Хурал, Улсын Бага Хурал нь парламентат ёсны хэлбэр Монгол Улсад цаашид суурьшин төлөвших анхны чухал алхмын нэг болжээ.

Гэхдээ 1925 онд батлагдсан Улсын Их Хурлын төлөөлөгчийг сонгох дүрмээр иргэдийнхээ зарим хэсгийн сонгох, сонгогдох эрхийг хассан, 1934 оноос Улсын Их Хурал 3 жилд нэг удаа хуралдаж байхаар тогтсон, нөгөө талаас улс орны амин чухал олон асуудлыг төрийн захиргааны дээд байгууллагын олон тооны тогтоол, тушаалаар зохицуулах практик давамгайлан гүйцэтгэх эрх мэдлийн төвлөрөл хүчтэй болж нийгмийн харилцааг бүхэлд

нь зохицуулах эрх зүйн хэм хэмжээг хуулиар тогтоох парламентат ёсны мөн чанар алдагдсан юм.

б) 1940 оны 6 дугаар сард Улсын 8 дугаар их хурлаар баталсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд “БНМАУ-ын засгийн дээд эрх барих газар нь Улсын Их Хурал болно”, 17 дугаар зүйлд “Улсын Их Хурлын чөлөө завсар БНМАУ-ын засгийн дээд эрхийг Улсын Бага Хурал барина” хэмээн хуульчилжээ. Улсын Их Хурлыг Улсын Бага Хурлаас гурван жилд нэг удаа зарлан хуралдуулах бөгөөд Улсын Бага Хурал (УБХ) нь Сайд нарын Зөвлөлийг байгуулах, яамд ба улсын төсвийн байгууллагыг батлах, Бага хурлын чөлөө цагт Бага хурлын тэргүүлэгчдээс тогтоосон хуулийг батлах, улсын орлого, зарлагыг хянах ба батлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байв.

Үндсэн хуулийн 2, 3 дугаар зүйлүүдэд “БНМАУ-ын улс төрийн үндэс бол ардын хурлууд болно, засгийн бүх эрх нь хөдөлмөрчдийн хурлаар уламжлагдан хот, хөдөөгийн хөдөлмөрчдийн мэдэлд байна” хэмээн нэг талаас төлөөллийн ардчиллын үндсэн зарчмыг хуульчилсан боловч нөгөө талаас ангич байр суурийг тунхагласан нь парламентат ёс жинхэнэ утгаараа хөгжих боломжийг хязгаарлажээ.

1940 оны Үндсэн хуульд нэлээд олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд 1949 онд зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлтийг оруулсан юм. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурал (УИХ) бол төрийн дээд эрхийг барих, хууль тогтоох эрх бүхий байгууллага болохыг хуульчилж, Улсын

Бага Хурлыг татан буулгажээ.

Онцлон дурдвас зохилтой нэгэн чухал зүйл: Үндсэн хуулийн 80-85 дугаар зүйлээр УИХ-ын болон хөдөлмөрчдийн депутатын хурлуудын сонгууль нь нийт, шууд, тэгш сонгуулийн эрхийг үндэслэж, сонгогчид саналаа нууцаар гаргах, бүх иргэн сонгуульд тэгш үндсэн дээр оролцох, эмэгтэйчүүд сонгох, сонгогдох эрхийг эрэгтэйчүүдийн нэгэн адил эдлэх, сонгууль тэгш байж сонгогч бүр саналыг нэг удаа гаргах, сонгуулийн тойргоор УИХ-ын болон хөдөлмөрчдийн депутатуудыг сонгох зэрэг заалт оруулж сонгуульд ангиар ялгаварлах байдлыг эцэслэн, парламентад ард түмний оролцоо, төлөөллийг өргөжүүлсэн нь Монголын парламентад ёсны хөгжилд нэгэн дэвшилтэт алхам болсон юм.

в) 1960 онд батлагдсан манай улсын гуравдахь Үндсэн хуульд БНМАУ-ын Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Ардын Их Хуралд хадгална хэмээн заасан.

Ардын Их Хурлын ээлжит чуулганыг жилд нэг удаа хийнэ, чуулганы чөлөө цагт төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурлын Тэргүүлэгчид мөн гэж заагаад, 20 дугаар зүйлээр Ардын Их Хурлын бүрэн эрхийг, 34 дүгээр зүйлээр Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхийг тогтоосон байдаг.

Үйл ажиллагаа нь байнгын биш, парламентын онцгой бүрэн эрхэд хамаарах олон эрх мэдлийг Тэргүүлэгчдэд олгосон, хууль санаачлах эрхийг хэт хэвтгайруулан олгосон зэрэг нь орчин үеийн парламентад ёсны шалгуурт нийцэхээргүй байв.

Тухайлбал, Үндсэн хуулийн 19 дүгээр заалтаар АИХ-ын Байнгын комисс, Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, Дээд шүүх, АИХ-ын депутатууд хууль санаачилж болохоор заасан бол, Үндсэн хуульд 1978 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын прокурор, мөн Монголын Үйлдвэрчний эвлэл нь Төв Зөвлөлөөрөө, Монголын Хувьсгалт Залуучуудын эвлэл Төв Хороогоороо уламжлан хууль санаачлах эрх эдэлнэ гэж нэмжээ.

Мөн энэ үед Ардын Их Хурал (АИХ)-ын тэргүүлэгчдийн зарлигаар хууль батлаад дараа нь АИХ-ын чуулганд оруулж баталгаажуулдаг байсан нь АИХ-ын хууль тогтоох эрх зарим талаар хэлбэр төдий байжээ гэсэн дүгнэлтэд хүргэдэг.

Монгол Улсын улс төрийн тогтолцооны цөм нь улс төрийн нам байсан, гадаад, дотоод нөхцөл нь ардчилсан парламентад ёс төлөвших бололцоо бүрдүүлээгүй зэрэг олон шалтгаанаас үүдэн парламентын тогтолцоо энэ үед ёс төдий, хэлбэрийн шинжтэй байсан боловч цаашид дэлхий нийтийн чиг хандлагыг даган Монгол Улсад парламентад ёсыг хэвшүүлэн, төлөвшүүлэх нь гарцаагүй зүйл болжээ гэдгийг бүх нийтээрээ ухамсарласан нь энэ түүхэн үеийн нэг онцлог юм.

3. Парламентат ёсны төлөвшлийн үе

3.1. БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль ба анхны байнгын ажиллагаатай парламент- Улсын Бага хурал

1980-аад оны сүүлчээр дэлхий нийтэд, ялангуяа Зүүн Европын орнуудад

гарсан өөрчлөлт, шинэчлэлийн давалгаа Монгол орныг ч дайрч, улс төр, нийгмийн шинэчлэл хийх нь гарцаагүй болсон юм.

Юуны өмнө, Үндсэн хуульт ёс, парламентат ёс, төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг Монгол оронд суурьшуулж, манай улсад илүү тохиромжтой засаглалын хэлбэрийг сонгох, олон намын тогтолцоог бий болгох, чөлөөт ардчилсан сонгууль явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг олон асуудал тулгарсан юм.

1980-аад оны сүүл үеэс тухайн үеийн нам, төрийн удирдлагын зүгээс энэ чиглэлээр нэлээд санал, санаачилга гарч тодорхой ажил хийгдэж байсан. Манай нэрт эрдэмтэн Бяраагийн Чимид Үндсэн хуулийг шинэчлэх ажилд оройлон зүтгэж байв.

Ийнхүү 1990 оны 5 дугаар сард чуулсан АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганаар төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх тухай асуудлыг хэлэлцэн, улмаар 5 дугаар сарын 10-нд БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталсан юм.

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн дээд байгууллагуудын тогтолцоог шинэчлэн, төрийн тэргүүн-ерөнхийлөгчийн институтийг бий болгож, эрх мэдлийг хуваарилах зарчмыг орчин цагийн үндсэн хуулийн эрх зүйн онолд тулгуурлан Үндсэн хуульдаа тусгасан билээ.

БНМАУ-ын Ардын Их Хурал бол

төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн гэж Үндсэн хуульдаа тунхаглаад, АИХ-аас сонгогдон байгуулагдах "БНМАУ-ын Бага Хурал нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага мөн" гэж заасан байна.

АИХ-ын зөвхөн өөрийн шийдвэрлэх онц эрхэд Үндсэн хууль батлах, БНМАУ-ын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Дээд шүүхийн даргыг сонгох, Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ерөнхий сайд, Ерөнхий прокурорыг томилох, чөлөөлөх зэрэг асуудал багтаж байв.

1990 оны 7 дугаар сарын 29-нд Монгол Улсад анх удаа олон намын оролцоотой чөлөөт, ардчилсан сонгууль явагдаж АИХ-ын шинэ бүрэлдэхүүнийг сонгосны зэрэгцээ Монгол Улс парламентат ёсны төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хуралд улс төрийн намуудын эзлэх суудлын тоог тодорхойлохын тулд сонгогчид аль улс төрийн намыг дэмжиж байгаа талаараа давхар санал өгсөн билээ.

АИХ-ын анхдугаар чуулганаар Улсын Бага Хурлыг улс төрийн намуудын төлөө сонгогчдын өгсөн саналын хувийг үндэслэн байгуулж, улмаар Улсын Бага Хурлын анхдугаар чуулганы үйл ажиллагаа 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр эхэлснээр Монгол Улсад парламентат ёсны төлөвшлийн суурь, үндсийг тавьсан анхны байнгын ажиллагаатай парламент бий болжээ.

Улсын Бага Хурал нь хоёр жил хүрэхгүй хугацаанд ажиллахдаа Монгол оронд өрнөсөн улс төр, нийгэм, эдийн

засгийн гүн гүнзгий өөрчлөлтийн эрх зүйн үндсийг тавьсан олон томоохон хуулиудыг батлан гаргасны зэрэгцээ Ардын Их Хурлаас даалгасны дагуу Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийн зарчимд тулгуурлан боловсруулж, ард нийтээр хэлэлцүүлэн Ардын Их Хуралд өргөн мэдүүлснийг 1992 онд баталснаар Монгол Улс ардчиллын замаар эргэлтгүй замнаж, парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс болсон.

Байнгын ажиллагаатай парламенттай болсны үр дүнд нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлж хууль тогтоомжийг тухайн үед нь гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгож байх нөхцөл бүрдсэн.

Улсын Бага Хурал зөвхөн Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Ардын Их Хурлын чуулганы хуралдаанаар батлуулахад голлох үүрэг гүйцэтгээд зогсоогүй, шинэ Үндсэн хуулийн дагуу Улсын Их Хурлын анхны сонгуулийг ямар нэг саадгүй явуулах зорилгоор Сонгуулийн тухай, төрийн зарим дээд байгууллагууд шууд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай, Монгол Улсын Их Хурлын тухай зэрэг 10 гаруй хуулийг баталжээ.

1990-1992 онд ажилласан Улсын Бага Хурал үйл ажиллагаандаа:

- төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй байх ардчиллын суурь зарчим бодитойгоор хэрэгжих;

- төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмаар төрийн дээд байгууллагууд ажиллах;
- ардчилал, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдсан байх;
- хууль дээдлэх, төр засгийн аливаа дур зорго хязгаарлагдах зэрэг парламентат ёсны үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж чадсан юм.

Мөн миний бие Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүнээр 8 удаа сонгогдон ажилласны хувьд Улсын Бага Хурлын гишүүд парламентын ёс зүй, парламент дахь улс төрийн соёлыг эрхэмлэн ажилладаг байсныг дурсан тэмдэглэж байна.

Парламентын үйл ажиллагааны салшгүй хэсэг болох Байнгын хороодод хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажил голлон нь төвлөрдөг байх; парламентын хэлэлцүүлгийн дэг зөв, сайн зохицуулалттай, уян хатан, шуурхай байх; парламентын олонх, цөөнхийн ижил тэгш оролцоог хангах зэрэг чухал шалгууруудыг ханган ажиллаж байснаараа Улсын Бага Хурал Монгол Улсад парламентат ёсыг төлөвшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмрийг оруулсан билээ.

3.2. Монгол Улсын шинэ Үндсэн хууль ба Улсын Их Хурал

1992 оноос Улсын Их Хурал хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх мэдлийг дангаар эдлэх, ард түмний төлөөллийн дээд байгууллага болж, Монгол Улсад парламетат ёсыг төлөвшүүлэх дараагийн алхмуудыг хэрэгжүүлсэн юм.

Шинэ ардчилсан Үндсэн хуулийн

гол үзэл баримтлал нь Үндсэн хуулийн оршил хэсгийн:

Улсынхаан тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,

Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсэн 5 мөрөөр бүрэн илэрхийлэгдэнэ.

Монголын ард түмний туйлын зорилго бол тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал мөн. Үүний төлөө л ихэс дээдэс маань халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж, хамгаалж ирсэний ачаар өнөөдөр бид хүний эрхээр жаргах бус өөрийн эрхээр зовсон ч гэсэн өөрийн эх орондоо эрх чөлөөтэй, амар амгалан аж төрж байгаа билээ.

Ардчиллын замаар тууштай замнах, хүний эрх эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, өөр зуурын болоод өнө холынхонтой эв эеийг хичээх, шударга үнэнч байдлыг эрхэм болгох, Үндэсний эв нэгдлийг сахин хамгаалах, төрт ёс, түүх, соёлын уламжлалаа нандигнан хайрлаж, өвлөх, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтод хүндэтгэлтэй хандах, хүнээ дээдэлсэн нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм дээд үзэл баримтлалд суурилсан Үндсэн хуультайгаараа бид бахархах учиртай.

Парламент байгаа цагт парламентат ёсны төлөвшлийн асуудал гарч ирдэг ч парламентат ёсыг төлөвшүүлэн хөгжүүлж чадахгүй бол парламент өөрөө оршин тогтнох орон зайгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилж, тэдгээрийн харилцан хамаарал, хяналт, тэнцлийг хангах чиглэлээр томоохон өөрчлөлт гаргасныг тэмдэглэхгүй орхигдуулж үл болно.

Хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн өөртөө хадгалах Улсын Их Хурал 1992 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш Улсын Их Хурлын дэгийн тухай, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай, Улс төрийн намын тухай зэрэг хуулиудыг батлан мөрдүүлж, Улсын Их Хурлын үйл ажиллагааг болон парламентат ёсыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг дэс дараатайгаар хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн бичсэнчлэн Үндсэн хууль бол богино хугацааны төсөл, хөтөлбөр бус, урт удаан хугацаанд дагаж мөрдөх учиртай суурь хууль учраас түүнийг хэрэгжүүлж ирсэн 30 жилийн хугацаанд онож олсон нь их байгаа ч, алдаа эндэгдлээс бид даатгагдаж чадаагүйгээ дурдах нь зүйтэй.

Улсын Их Хурлын анхны сонгуулиар байгуулагдан 1992-1996

оны бүрэн эрхийн хугацаанд ажилласан Улсын Их Хурлын төгсгөлийн хуралдаан дээр УИХ-ын дарга Н.Багабанди хэлсэн үгэндээ: "Шилжилтийн дараах Монгол Улсын улс төрийн амьдралын онцлог нь ашиг сонирхолоо хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх зэргээр чөлөөт үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэдийн олонхын саналаар тодорхой хугацаагаар хязгаарлагдмал эрхтэй сонгогддог, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн нарийн хуваарьт үндэслэсэн тогтолцоо бүхий төр засаг бодитой оршин тогтнох болсноор тодорхойлогдож байна. Улсын Их Хурал хууль цаазат төрийн хэм хэмжээнд нийцүүлэн төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх бүрдлийн тухай хуулиудыг хэлэлцэн баталж, тэдгээрийн дагуу уг бүтцүүдийг шинээр буй болгон зохион байгуулан ажиллуулсан юм." гэж хэлжээ. Тэрээр цааш үргэлжлүүлэн: "...шинэ тулгар улс төрийн системийн ажиллагааг цаашид зүгшрүүлж, нийгмийн хөгжлийн "зүрх, тархи" болгон төлөвшүүлэх шаардлагатай" хэмээн тэмдэглэсэн байна.

Энэ бол Улсын Их Хурлын анхдугаар сонгуулиар байгуулагдан ажилласан Улсын Их Хурал шинэ Үндсэн хуулийн дагуу нийгмийн шинэчлэлийн ороо бусгаа цаг үед эрх зүйн цоо шинэ тогтолцооны үрийг сайтар суулгаж, усалж тордсоныг илтгэж буй хэрэг юм. Түүнээс хойш байгуулагдсан Улсын Их Хурлууд нь эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн өмнө нь суулгасан эрх зүйн тогтолцооны шинэ үрийг соёолуулж тордож ургуулах, элдэв хог ургамлыг нь

түүж цэвэрлэх үүргийг гүйцэтгэж иржээ.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 30 жилийн хугацаанд монголын парламент улс орондоо ардчилсан шинэ нийгмийн харилцааг төлөвшүүлэх, эрх зүйн шинэ үндэс суурийг бүрдүүлэхдээ алдаж, онож байсан ч үйл ажиллагааныхаа явцад сайныг нь бататган хөгжүүлж, алдсанаа засан сайжруулж явах жам ёсноос гажаагүй юм.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн алдаа онооны талаар улс төрчид, эрдэмтэн судлаачид, улс төрийн намууд болон иргэний нийгмийн төлөөлөл, иргэд тал бүрээс нь ярьж ирсэн бөгөөд олон удаагийн хурал, хэлэлцүүлэг өрнөж санал бодлоо илэрхийлж байв.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хуулиар тогтоох тухай Үндсэн хуулийн суурь заалтаас шалтгаалаад Улсын Их Хурлын үйл ажиллагааг харьцангуй хөшүүн болгож, уян хатан байдлыг нь алдагдуулсан гэсэн шүүмжлэл ч гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийг мөрдүүлэх явцад тулгарсан хамгийн анхны бэрхшээлүүд нь Үндсэн хуулийн зарим зүйл, заалтуудыг эргэн харахад хүргэсэн юм. Үүнд:

1. Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурал сонгуулийн дараа Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулж чадахгүй хэт хугацаа алдвал хүлээх хариуцлагыг нь орхигдуулсны улмаас үүрэг гүйцэтгэгч Засгийн газар 6 сар ажилласан тохиолдол гарсныг засах шаардлага тулгарч байлаа.

2. Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд оруулахад болон Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөд Ерөнхийлөгчид давуу байдал буй болгосны улмаас Улсын Их Хуралд олонхын суудал авсан нам, эвслийн бүлгээс Ерөнхий сайдад санал болгосон хүнийг, түүнчлэн Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөх явцад удаа дараа буцааж, Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулахад хугацаа алдаж байсан нь уг заалтуудыг эргэн харах шаардлагатайг харуулсан юм.
3. Улсын Их Хурал, түүний бүтцийн нэгжийн хуралдааны ирцийг гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцохоор Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан нь Улсын Их Хуралд 50 суудалтай нам эвсэл ч хуралдааны ирцийг бүрдүүлэхэд бэрхшээлтэй тулгарч, Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа тасрахад хүрч байсны гэрч нь бид өөрсдөө юм.
4. Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг нэг мөр хаасан нь зарим бэрхшээл дагуулж байсныг ч засах хэрэгтэй гэж үзсэн байдаг.

Дээр дурдсан бодитой бэрхшээлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуульд 1999, 2000 онд хоёр удаагийн оролдлогоор уг хуулийн 6 зүйлийн 7 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан бодит бэрхшээлийг даван туулах алхам болсон юм.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурал сонгуулийн дараа Засгийн газрыг эмхлэн байгуулахад хугацаа алдаж, сунжирдаг болсныг та бүхэн мэдэж байгаа.

Мөн Ерөнхий сайдад Улсын Их Хурал дахь олонхын санал болгосон хүнийг Ерөнхийлөгч нэг ч удаа буцааж байгаагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы болон бүтцийн нэгжүүдийн хуралдааны ирцийг 50 хувь+1 саналаар тогтоосноор хурлын ирцийг бүрдүүлэхэд илүү хялбар болсон ч хэт цөөн гишүүний саналаар хууль баталж байна гэсэн шүүмжлэл дагуулах болсныг дурдах нь зүйтэй.

Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний талаар зөвшилцөх үйл явц ч шуурхай шийдэгддэг болов.

Энэ бүхэн бол Үндсэн хуулийн дагуу парламентат ёсыг төлөвшүүлэхэд гарсан ололт гэж хэлж болох юм.

Үндсэн хуулийн дагуу хийгдэх эрх зүйн шинэчлэлийн үйл явц ч өөрийн жам ёсоор үргэлжилсэн нь Монгол Улсад парламентат ёс төлөвшиж, зүгширсний баталгаа болох бизээ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Үндсэн хуульд нэр заагдсан хуулиуд үндсэндээ шинэчлэгдэв. Улсын Их

Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрөөр дараах үндсэн чиглэлээр эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Үүнд:

1. Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх;
2. эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
3. хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах;
4. төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
5. эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх;
6. хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох;
7. олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх.

Энэхүү хөтөлбөр нь 2000 он хүртэл хугацаанд хэрэгжихээр заагдсан байсан ч түүний үзэл санааны дагуу эрх зүйн шинэтгэл 2019 он хүртэл хугацаанд үргэлжилсэн гэж үзэж болох юм.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд:

Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах, төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох талаарх эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх хүрээнд Улсын Их Хурлын тухай, Ерөнхийлөгчийн тухай, Засгийн газрын тухай, Шүүхийн тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж, Дайны байдлын тухай, Дайчилгааны тухай, Яамны эрх зүйн байдлын

тухай, Агентлагийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудыг шинээр батлан гаргажээ.

Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах хүрээнд Эрүүгийн, Иргэний хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Захиргааны хариуцлагын тухай, Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай, Галын аюулгүй байдлын тухай зэрэг хуулиудыг шинээр батлан мөрдүүлсэн байна.

Эдийн засгийн бодлогын хүрээнд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, Газар хувьчлалын тухай, Санхүүгийн түрээсийн тухай, Аялал жуулчлалын тухай, Гадаад худалдааны тухай зэрэг эдийн засгийн салбар тус бүрийн эрх зүйн зохицуулалтад хамаарах олон арван хуулиудыг шинээр батлан гаргажээ.

Нийгмийн салбарын бодлогын хүрээнд Ариун цэврийн тухай, Биеийн тамирын тухай, Залуучуудын тухай, Эмийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийн тухай зэрэг олон хуулийг батлан мөрдүүлсэн байна.

Үндсэн хуульд 1999, 2000 онд оруулсан нэмэлт өөрчлөлт нь дээр дурдсанаар монголын төрийн өмнө тулгарсан зарим бэрхшээлийг нааштайгаар шийдвэрлэж, парламентат ёсны төлөвшилд тодорхой ахиц гаргаж чадсан хэдий ч олон түмний дунд “дордуулсан 7 өөрчлөлт” гэж шүүмжлэгдэх болсон нь доор дурдсан заалтуудтай холбоотой байсан юм. Үүнд:

1. Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын ээлжит чуулганы үргэлжлэх хугацаа 75 хоног байсныг 50 хоног болгон өөрчилж Улсын Их Хурал байнгын ажиллагаатай парламент байх шинжээ зарим талаар алдахад хүргэсэн гэж үзэж байв;
2. Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болох хязгаар тогтоогоогүйгээс Засгийн газрын гишүүд бүгдээрээ парламентын гишүүн болж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн зааг ялгаа, хяналт, тэнцлийг алдагдуулсан хэмээн дүгнэж байв;
3. Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт хуралдааны ирцийг 50 хувь+1 саналаар тогтоож, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэхээр тогтоосон нь Улсын Их Хурал хэт цөөн гишүүн /нийт гишүүний 26,3 хувь/-ий саналаар хууль баталдаг боллоо гэсэн шүүмжлэлийг дагуулж байв;
4. Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэгт "...Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ" гэж өөрчилснөөр улс төрийн намын зүгээс гишүүдэд шахалт, дарамт үзүүлэх механизм болсон гэж шүүмжилж байв.

Гүйцэтгэх эрх мэдлийн хоёр том баталгаа байдгийн **нэг нь** томилгооны эрх мэдэл буюу гүйцэтгэх засаглалын тэргүүн өөрөө танхимаа бүрдүүлэх эрх, **хоёр дахь нь** төсөв мөнгөний эрх мэдэл байдаг. Гэтэл манай Засгийн газрын энэхүү үндсэн эрх мэдэл нь бусад улстай харьцуулахад маш сул байсан. Манайд парламентын засаглал гэхээр Улсын Их Хурал нь бүхнийг шийддэг газар мэт ташаа ойлголт хүчтэй оршиж ирсэн. Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнийг хүн нэг бүрээр хэлэлцэж томилдог, Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийг өөрийн үзэмжээр өөрчилдөг явдал нь гүйцэтгэх эрх мэдлийн дээр дурдсан баталгааг сулруулж байв.

Түүнчлэн дээр дурдсанаас гадна Улсын Их Хуралд хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь тодорхой бус, Ерөнхийлөгчид хуулиар зарим бүрэн эрхийг нэмж эдлүүлэх нь зохих хязгаарыг давсан, түүнчлэн хот, тосгоны эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаа зэрэг асуудал шүүмжлэлд өртөж, тэдгээрийг зохистой шийдвэрлэх олон түмний хүлээлт ч бас байсан юм.

Бидэнтэй нүүр тулсан дээрх бэрхшээлүүд бол Монгол Улсад парламентад ёсыг төлөвшүүлэхэд учирсан **сорилт** байсан юм.

Улсын Их Хурал шүүмжлэл дагуулаад байгаа дээрх асуудлуудад 2010 оноос эхлэн анхаарч Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар 2011 онд, Н.Батбаяр нар 2015 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл өргөн мэдүүлж байсан ч тодорхой шалтгааны улмаас хэлэлцэгдэж амжилгүй 2016

онтой золгосон байдаг. Харин 2016 оны сүүлчээс Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зайлшгүй шаардлагатай болохыг нэг цонхоор харж, хамтран ажилласны үндсэн дээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг судлан улмаар зөвлөлдөх санал асуулга явуулж, Д.Лүндээжанцан миний Улсын Их Хурлын гишүүн байхдаа ахалсан ажлын хэсгээс төслийг боловсруулан олон нийтийн хэлэлцүүлэгт оруулж, Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг баталсан билээ.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр байнга шүүмжлэгдэж байсан дээрх асуудлыг шийдвэрлэсний зэрэгцээ Үндсэн хуульд цаашид нэмэлт, өөрчлөлт оруулахад баримтлах дэг жаягийг тогтоож өгсөн нь ч чухал ач холбогдолтой болсон юм.

Үндсэн хуулийн 19 зүйл, 34 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар цаашид хийгдэх эрх зүйн шинэчлэлийг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн гүйцэтгэх нэн хариуцлагатай үүрэг Улсын Их Хурал, Засгийн газрын өмнө тулж ирээд байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхээр УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолд заасан хуулиудыг нь тогтоолд заасан хуваарийн дагуу шинэчлэн батлах ажил удаашралтай байгаад дүгнэлт хийж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад анхаарах хэрэгтэй байна.

Цаг хугацаа алдах аваас одоо мөрдөгдөж байгаа олон хуулийн зүйл, заалтууд Үндсэн хуульд оруулсан

нэмэлт, өөрчлөлттэй зөрчилдөх бодит бэрхшээлтэй тулгарч мэдэх учраас энэхүү эрх зүйн шинэчлэлийг яаравчлан хэрэгжүүлэх нь хойшлуулшгүй зорилт хэмээн үзэж байна.

ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙГ ХАНГАХ, ЭЕ ЭВЭЭ ХИЧЭЭХ СЭТГЭЛГЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ҮНДЭС



Шихихутуг их сургуулийн Судалгааны
хүрээлэнгийн захирал, Доктор (Ph.D),
профессор Н.Жалбажав

*Бие бөх болбоос ганцыг альюу
Эе бөх болбоос олныг альюу.
/Чингис богдын сургаалиас/*

20

Түлхүүр үгс:

Үндэстэн, ястан, нийгмийн бүлэг давхарга, олигархигжилт, ажилгүйдэл, ядуурал, үндэсний эв нэгдэл, эе эвийн сэтгэлгээ, үндэсний ухамсар, үнэт зүйлс, шударга ёс.

Хураангуй:

Монголчуудын үндэсний эв нэгдлээ хангах, эе эвийн сэтгэлгээний уламжлал. Чингис хааны эе эвээ хичээх, шударга ёсыг сахих ёс суртахуун, үлгэрлэл, манлайлал, туршлага, сургамжийн зүйлүүд (бусад улс орны). Ардчилал зах зээлийн харилцаа, хувийн өмч, чөлөөт өрсөлдөөн ба үндэсний эв нэгдэл, эе эвийн сэтгэлгээ; нийгмийн социал ялгарал, социал шинэ бүтэц, давхаргажилт ба үндэсний эв нэгдэл, үндэсний ухамсар, эх оронч үзэл,

хүмүүжил, үндэсний үнэт зүйлс, бахархлаа хөгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага. Үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг бэхжүүлэх, хөгжүүлэх талаар төр, иргэний нийгмийн байгууллагуудад санал болгох, онол, арга зүйн зүйлүүд (Зөвлөмжийн чанартай).

Илтгэлийн агуулга:

Эцэг дээдэс маань буурал түүхийнхээ өгсөх, уруудах их нугачаанд туурга тусгаар төр улсын ариун гал голомтыг хойч үедээ хамгаалан үлдээсний нэгэн нууц увидсыг Монгол түмний оюун санааны их хүч, ёс суртахууны эрхэм чанараас эрж хайх нь зүйтэй ажээ.

Персийн алдарт түүхч Рашид-Ад-Дин “Судрын чуулган”-даа “Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс, түмэнд хэрэглэх Чингис хааны ёс суртахууныг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно” (Судрын чуулган. I боть. 404 дэх талд) гэжээ. Чингис богд мөнх тэнгэрээс заяагдсан суу билэг, авьяас чадвар, шударга ёс, эе эвийг хичээх ёс суртахууны их хүч, манлайлалаараа Алтайн цаст мөнгөн оргилуудаас Их Хянганы ногоон нарст уул даваад, Байгаль их далайгаас Түмэн газрын Их цагаан хэрэм хүртэлх Төв азийн өргөн уудам нутагт тархай, бутархай

оршиж байсан 30 гаруй овог аймгийн 200-аад түмэн иргэдийг эрхшээн Их Монгол Улсыг байгуулжээ. Академич С.Нарангэрэл "Өөр хоорондоо эвдрэлцэн тэмцэж ирсэн талын нүүдэлчдийн овог аймгаас бүрдсэн Монгол үндэстэн дэлхийн их гүрнийг цогцлоож, тэр их гүрэн нь 150 гаруй жилийн туршид өргөжин хүчирхэгжиж байсны нууц нь суут богд, түүнийг залгамжлагчдын оюун санаа, ёс суртахуунд байсныг онцолжээ. *(Чингис хааны ёс суртахууны эрх зүйн шаштир. 2014 он. 8-9 дэх талд).*

Монголчуудын ёс суртахууны эрхэм чанарын охь дээжист эе эвээ хичээх сэтгэлгээ зүй ёсоор байна. Жувейнын "Дэлхийг байлдан дагуулагчийн түүх" алдарт шаштиртаа "Хөвүүд дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эе эвээ бэхжүүлэхийг чармайхыг үргэлж захин сурган, сургаалт үлгэр, домог ярьж, тэр хэлсэн сургаал үгээ баталгаажуулна". *(Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. 32-33 дахь талд)* Чингис богд нутгархах, овог аймаг, үндэс угсаагаараа бүлгэрхэг байдал гаргах нь эе эвийг сарниулахад хүргэдэг аюул дагуулдгийг ямагт сэрэмжлэн сануулдаг байжээ. Юань улсын түүхийн судар бичигт дурдсанаар эзэн богд эрхэм ноёд, ураг төрлөө дотночилж, бусдыг гадуурхагсад төр улсаа мөхөөхөд хүргэдгийг сануулж ийм үйлийг чандлан хориглож байжээ. *(Чингис хааны товчоо. Дээд дэвтэр. 397-398 дахь талд)*

Чингис богдын эе эвийг хичээх сэтгэлгээ нь түүний шударга ёсны ёс суртахуунтай салшгүй амин холбоотой ажгуу.

Монголчуудын хэзээний сайн танил Жак Уэтерфорд абугайн "Тэр ихэс дээдсийн хэргэм, ямба, угсаа гарвал гэх мэт феодалын тогтолцоог халж, хувь хүний гавьяа зүтгэл, үнэнч шударгуу байдал, ололт амжилтад тулгуурладаг шинэ тогтолцоог бий болгосон юм... Тэр олон улсын хуулийг анхлан бий болгож бүх хүн мөнх хөх тэнгэрийн зарлигт сөгдөн мөргөх болсон. Ихэнх захирагч өөрсдийгөө хуулийн дээгүүр тавьдаг бол Чингис хаан ихэс дээдэс, дорд малчныг ч хуулийн өмнө адил тэгш хариуцлага хүлээхийг шаарддаг байлаа. Ямарч шашинтан байсан шударга ёсыг нийтээр дагаж мөрдөхийг харьяат албатдаа шаарддаг, тэр эзэмшил нутгаа шүтэн бишрэх бүрэн хангасан юм" гэх зэргээр Чингисийн шударга ёс, эе эвийн ёс суртахууны мөн чанарын тухай бичжээ. *(Жак Уэтерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан. 19 дэх талд)*

Германы эрдэмтэн Удо Б.Баркман "Сонирхолтой нь Чингис хааны цусан төрлийнхөн удирдах албан тушаал бараг хашиж байсангүй. Тэгэхлээр орчин үеийн боловсон хүчний бодлогод ч Чингис хаанаас суралцууштай..." гэх зэргээр бичжээ. *(Удо Б.Баркман. Чингис хааны үед төр-цэргийн элит давхарга болж хөгжсөн нь-Монголын түүх, улс төрийн тухай өгүүллүүд. 423 дахь талд)*

Чингисийн энэхүү ёс суртахуун, үлгэрлэл, манлайллын их хүч нь эзэнт гүрнийхээ төдийгүй, эрхшээсэн, харьцдаг харилцаа холбоо бүхий улс орны иргэдийг ч өөртөө соронзон мэт татдаг байжээ. Энэ тухайд алдарт аялагч Марко Поло "Чингис хааны засаглал

шулуун шударга, хүн арддаа энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв” гэжээ.

Монголчуудын эе эвээ хичээх сэтгэлгээ “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн эрх”, “Алтан товч” зэрэг судар бичгүүд, үлгэр домог, “Гэсэр”, “Жангар” туульсууддаа сүсэглэн дээдэлж, хойч үеийнхээ ой тойнд, үндэснийхээ ой санамжид дархлан хадгалж иржээ.

Энэтхэгийн Дж.Неру, Их Британийн У.Черчилл, АНУ-ын Фр.Рузвельт, Хятадын Дэн сяо пип нарын олон үндэстний их удирдагч нар болон ертөнцийн мэргэд ч шударга ёс бол нийгмийг ариутгагч, үндэсний эв нэгдлийг бэхлэгч, ялалт амжилтын нэгэн эх сурвалж болохыг сургасан нь цөөнгүй. Тухайлбал, монголд элэгтэй их эрдэмтэн Л.Н.Гумилев Их Монгол Улсын үеийн монголчуудын хүч чадал, ялалтын учир шалтгааныг XIII зуунд монголчуудад заяагдсан “эрчмийн түрэлт”-ээр тайлбарласан бөгөөд энэхүү эрчмийн түрэлтийн эх сурвалж нь эсгий туургатан нарын эе эв, бат цул нэгдэл гэсэн нь бий. Фр.Рузвельт АНУ XX зууны 20-30-аад оны их хямралыг улам хүчирхэгжин сэргэн мандаж туулсаны гол учир нь америкчууд хүн төрөлхтөний ардчилал, эрх чөлөөний манлай орны иргэд гэдгээ ухаарч эв нэгдэлтэй байсны үр ач гэжээ. (АНУ-ын сэргэн мандалт /англи хэл дээр/. Нью Йорк. 1998 он.)

Монгол Улс хэдийгээр нэг үндэстэн (халх, хүн амын = 80 хувь нь) давамгайлсан, төрийн унитар буюу нэгдмэл тогтолцоотой боловч халх, хасаг, буриад, дөрвөд, баяд, чантуу,

торгууд зэрэг 10 гаруй үндэстэн ястны өлгий орон.

Монголын төр 2200 гаруй жилийнхээ түүхэнд үндэстэн, ястнаа их бага гэж ялгаварлалгүйгээр хэл соёл, зан заншлыг хүндэтгэн эрх тэгш, эв нэгдэлтэй аж төрөх бодлого баримталж иржээ. Үүний үрээр Монголын соёл, иргэншил олон ястан, угсаатны соёлын өнгө булаалдан алаглах цэцэгсийн хүрээлэн мэт бат цулыг бүрдүүлэн хөгжиж буй билээ.

Эдүгээ монголд ардчилал түгэн, хувийн өмчид суурилсан зэх зээлийн харилцаа төлөвшин, үндэсний ухамсар, соёл хөгжих таатай нөхцөл бүрдэн байна. Үүний сацуу зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, хувийн өмчийн өсөлт хөгжил нь нийгмийн социал ялгарал, баян чинээлэг байдал, ядуурлын зөрүүг ихэсгэн нийгмийн өөр өөр ашиг сонирхол бүхий бүлэг давхаргууд төлөвших үндэс болж байна. Эрдэмтэн судлаачдын судалгаанаас (ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэн. Шихихутуг Их Сургууль. Шилжилтийн нийгэм: шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд. /Орос, Монголын жишээн дээр/. УБ.2016 он.) үзэхэд эдүгээ Монгол Улсад баячууд, хүн амын чинээлэг хэсэг буюу дундчууд, ядуучууд, нэн ядуу хэсэг буюу үгээгүйчүүд (өмч хөрөнгөгүй, тогтмол орлогогүй, олдсоноор амь зуудаг, зарим нь орон гэргүй) гэсэн социал давхаргажилтын ерөнхий дүр зураг ажиглагдаж байна.

Чөлөөт өрсөлдөөн, бизнесийн эрх чөлөө нь улс орон хэмээх нэгэн цулыг бүрдүүлж буй үндэстэн, ястны эдийн засгийн харьцангуй бие даасан байдлыг

бэхжүүлж мөн үндсэрхэх үзлийг нь өдөөн сэргээх хүчин зүйл болдог байна. Хэрвээ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогод нийгмийн бүлэг, давхарга, үндэстэн, ястаны хувьд нийгмийн материал баялгийн хуваарилалт, хөрөнгө оруулалт, татварын бодлого зэрэгт шударга ёсны зарчим алдагдах, хүн амын дунд үндэс угсаа, шашин шүтлэг, хэл соёлын өчүүхэн төдий ч ялгаварлах хандлага гарах, газар авбал урьдчилан тооцоолох аргагүй уршиг тарих, салан тусгаарлах, санаа бодол, үйл ажиллагаа үржин төлжих хөрс нь болдгийг Испани (Барселона), Их Британи (Шотланд, Умард Ирланд, Хятад /Шинжан, Уйгар/, Украин, /Донбасс/), Ойрхи Дорнодод өрнөн буй үндэсний асуудал, зөрчил тэмцэл харуулж байна. Харин улс үндэстнээ нэгтгэн нягтруулагч цемент болсон нийтлэг үнэт зүйлс, бахархлаа хөгжүүлж, бэхжүүлж чадвал түмэн хэлтэн, зүсэн зүйлийн арьс өнгө, шашин шүтлэг бүхий олон үндэстэн, ястан нэгэн дээвэр дор эв нэгдэлтэй, сэтгэл хангалуун аж төрж болдгийг АНУ-ын туршлага, сургамж бэлхнээ нотолж буй. Тэнд арьс өнгөөр ялгаварлахын хор уршиг зэрэг асуудал байдаг ч Америк хэмээх нийт орон гэрийнхээ дэлхийд эзлэх байр суурь, нэр хүнд, АНУ-ын иргэн байх үндэсний их бахархал, Америкийн ардчилал, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт, хүн бүрт өсч хөгжих, өөрийгөө нээн сэтгэл хангалуун аж төрөх нөхцөл боломж зэрэг нь их гүрний тогтвортой хөгжил дэвшлийнх нь нэгэн эх сурвалж болж байна.

Нийгмийн оюун санаанд ч зарчмын гэмээр өөрчлөлтүүд гарлаа. Иргэдийн ертөнцийг үзэхүй, амьдрах хэв маяг, үнэт зүйлсийн чиг баримжаа үндсээрээ өөрчлөгдөн улс төрийн олон ургальч үзэл дэлгэрч олон төрөл шашин шүтлэг чөлөөтэй нэвтэрч, нутагшин байна. Ганцхан жишээ дурдахад Монгол Улсад бүртгэлтэй, бүртгэлгүй христийн, лалын болон бусад шашин, сүм хийд, мөргөл шүтлэгийн байгууллага, газрын тоо хэдэн зууд хүрч тэдгээрийн шүтэн бишрэгчдийн тоо 100 мянгаас хол давжээ.

Ертөнцийг үзэхүйн өөр үзэл бодол, итгэл үнэмшлийг үл тэвчигч (ийм шинж байдал загалмайтны, лалын болон бусад олонх шашинд байдаг) олон шашин дэлгэрсэн улс орныг торхтой дарин дээр сандаалагч нэгэнтэй зүйрлэсэн нь бий. Шинэ нөхцөл байдалд төр, шашны харилцааг үндэсний аюулгүй байдал, үндэснийхээ соёл, иргэншлийг хангах, хамгаалах болон иргэнийхээ улс төрийн, шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах бодлогын зангилаан дээр хууль зүйн ухаалаг, оновчтой зохицуулалт хийх, түүний дотор монголчуудын соёлын их уламжлал, сан хөмрөгийг өөртөө агуулсан эцэг өвгөд, ахмадуудаас аваад монголчуудын олонхын оюун санаа, яс маханд нь шингээстэй уламжлалт шашныхаа статусыг оновчтой тодорхойлох нь төрийн бодлогын тулгар асуудал болж байна.

Монгол Улсад үндсэрхэх, нутгархах үзэл бодол цухалзсаар буйг нуух юмгүй мэт. Унасан газар, угаасан ус, яс үндэс, угсаа гурвалаараа бахархах нь эрүүл ухаантай хүн бүрт заяагдсан мэдрэмж

ухаарал. Гэхдээ энэ нь голидорлоосоо хальж бүлгэрхэн явцуурах, бүтээн байгуулалтын бодлого тодорхойлох боловсон хүчнийг шилж сонгох зэрэг төрийн бодлогын зүйлд нөлөөлөх, түүхийг мушгин гуйвуулах, зиндаанд хүрвэл уршгийг нь тааварлах аргагүй. Бөхөө барилдуулахдаа хүртэл ихэд нутгархан талцах болсон нь өөгшүүлэх зүйл огт биш.

Иймэрхүү жижиг сажиг ч гэмээр гажуудлыг эс анхаарах нь Монгол Улсын хамгийн эрхэм, үнэт зүйлийн нэгэн болох үндэсний эв нэгдэлд ан цав суулгах нигууртай, төрийн нийгмийн бодлогод ч, эрх зүйн зохицуулалтад ч бодолцох учиртай.

Энэ цаг үед үндэсний эв нэгдэлд хамгаас илүүтэй уршиг тарих үзэгдэл бол нийтээрээ, дээр доргүй, хот хөдөөгүй улс төржин талцах эмгэг юм. Энэ эмгэг нийгмийн амьдралын бүх хүрээ, нийгмийн бүх бүлэг, давхарга тэр бүү хэл нийгмийн үндэс болсон гэр бүлд хүртэл нэвчин халдварлаж, нийгмийн тогтвортой байдал, төрийн удирдлагын нэгдмэл байдал, үндэсний эв нэгдэлд ан цав суулгаад зогсохгүй нийгмийн материал баялгийн хуваарилалт, бүтээн байгуулалт, хөгжлийн бодлогод хүртэл нөлөөлж уршиг тарьж буйг нуух юмгүй.

Улс төржилт ардчилсан, олон ургальч үзэл дэлгэрсэн, олон намын тогтолцоотой улс оронд байдаг л үзэгдэл бөгөөд улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах, тогвортой хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, дарангуйлал, хэсэг бүлгийн ноёрхол, дур зоргын эсрэг нэн чухал хүчин зүйл болох учиртай

ажээ. Гэтэл Монгол Улсад улс төржилт энэхүү утга чанар, хэм хэмжээгээ алдаж, олигархи бүлэглэлүүдийн явцуу эрх ашгийн төлөө тэмцэл болох магадлал их байгаа нь түүнийг нийгмийн нэн хор уршигтай үзэгдэл болгож байна. Бүх нийтийг хамарсан улс төржилт хүн амын амьжиргааны чанар, түвшин дорой, мэдэгдэхүйц буурахгүй байгаа ажилгүйдэл, ядуурал алхам, алхмаар ухарсаар авч байраа тавьж өгөхгүй байгаа авилгалын хөрсөн дээр өрнөх магадлалтай тул хор уршигийг нь тааварлахад төвөгтэй үзэгдэл юм. Олигархиуд дээр товч дурдсан нутгархах, үндсэрхэх, мөн шашин шүтлэгийн зүйлүүдийг ашиглахаас ч буцахгүй болохыг дурдах хэрэгтэй.

Төрийн ээлжит сонгуулийн жилийн босгон дээр Монгол Улсын Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлтүүд орлоо. Үүнийг иргэдийн дийлэнх хэсэг нь тогтвортой, хариуцлагатай ардчилсан төрийн тогтолцоо төлөвшин иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, үндэсний эв нэгдэл, улсын тусгаар тогтнол бэхжүүлэхэд хийсэн түүхэн алхам хэмээн дэмжиж байна. Мөн Улсын Их Хурлын сонгуулийн хууль ч шинэчлэгдлээ. Энэ бүхэн Монгол Улсад иргэд хууль, төрийн өмнө тэгш байх, нийгмийн материал баялгийг шударгаар хуваарилах, зарчим, сонгуулийн шударга тогтолцоо төлөвшин иргэд сонгох, сонгогдох эрхээ бодитой эдлэх нөхцөл бүрдэж байна гэх итгэл төрүүлж байна. Нийгэмд шударга ёс, хууль дээдлэх ёс сэргэж хүн ам, иргэний нийгмийн хяналт, оролцоо ч идэвхижиж байна.

Дүгнэлт болгон товчоор хэлэхэд нийгмийн амьдралын бүх салаа мөчирт, нийгмийн материаллаг үндэс суурьт ч, оюун санааны амьдралд ч ардчиллын хэм хэмжээг түгээх, сахиулах, нийгмийн бүлэг давхаргын гармони буюу зохицлыг ханган үндэсний эе эвийн сэтгэлгээ, соёлыг төлөвшүүлэхэд зарим хүндрэл бэрхшээл тохион онол, арга зүйн хувьд ч, практикт ч шийдэх олон асуудал байна. Тэдгээрийн (хүндрэл бэрхшээл, асуудал гэх мэт) учир шалтгаан объектив хийгээд субъектив хүчин зүйлүүдээс хамааралтай болохыг онцлон тэмдэглэж байна. **Объектив буюу хүний хүчин зүйлээс үл хамаарах**, эсхүл тун бага (ялимгүй) хамааралтай **хүчин зүйл** юуны өмнө зах зээлийн эдийн засаг, хувийн өмч, чөлөөт өрсөлдөөний жам ёсны зүй тогтол, нөлөөлөл гэх үндэстэй байна. Эдгээр нь нийгмийн оюун санаанд аминчхан хувиа хичээх, хөрөнгөжих сэтгэлгээг өдөөх, нийгмийн социал ялгарлыг лавшруулж социал шинэ бүтэц, давхаргажилт, социал харилцааны шинэ соёл төлөвшихөд нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна. Эдгээрээс үндэслэн зах зээлийн нийгэмд нийгмийн эв нэгдэл, бат цул байдлын бус эсрэгээрээ задралын, төвөөс зугтан бодит хүчин зүйлүүд нуугдмал, ил байдлаар оршин байна гэх үндэстэй юм.

Субъектив хүчин зүйлд нийгэм, төрийн удирдлагын тогтолцоо, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, нэр хүнд, иргэдийн сэтгэлгээ, ухамсрын өөрчлөлт, тэдгээрийн дасан зохицох (адаптаци) үйл явцыг нэрлэж болно гэж үзэж байна. Чухамдаа зах зээлийн харилцаа,

чөлөөт өрсөлдөөн, иргэний ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн, зохицсон төрийн тогтолцоо төлөвшин бодлого нь нийт иргэн, бүх үндэстэн, ястан, хүн амын нийтлэг эрх ашигт, улс үндэснийхээ эв нэгдэл, аюулгүй байдалд үйлчилж байвал “төвөөс зугтах”, “задралын” хүчин зүйлүүдийн нөлөөллийг саармагжуулж чадах юм.

Төрийн бодлого, нийгмийн удирдлагад улс үндэснийхээ нийтлэг үнэт зүйлс, бахархал, эх оронч үндэсний үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, үндэснийхээ ой санамжийг сэргээн хөгжүүлэх, соён гэгээрүүлэх, иргэддээ тэгш шударга чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, эх орондоо, ялангуяа залуустаа сэтгэл хангалуун аж төрөх нөхцөл бүрдүүлэхийг тууштай баримтлах нь үндэсний эв нэгдэл, эе эвээ бэхлэх гол арга зам болно.

Төрийн бодлогод хэсэг бүлгийн тэр тусмаа гаднын нөлөө сүүдэрт автсан аминчхан, явцуу ашиг сонирхолд автахас сэргийлсэн, социал бүлэг, давхаргуудын эв нэгдэл, гармонийг хангасан байх чухал нөхцөл нь иргэний нийгэм нийт иргэнийхээ идэвхитэй оролцоо, дэмжлэгт түшиглэх, бодит үнэн, зөв мэдээлэл, шинжлэх ухааны арга зүй, судалгааны үнэлэлт, зөвлөмжид тулгуурласан байх учиртайг онцлон тэмдэглэж байна. Философи, социологи, улс төр судлалын ул үндэстэй, бодитой, үнэн зөв судалгаа, дүгнэлт, зөвлөмж нь төр засгийн удирдлагад хуралдаж, хуримтлагдсан асуудал, тэдгээрийн учир шалтгаан, гэтлэн давах арга замыг тодорхойлох удирдамж болох учиртай. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд

өнөөдрийн хурал чухал алхам болно гэдэгт итгэлтэй байна. Судлаачийн хувьд үндэсний эв нэгдлийг хангах, эе эвээ хичээх сэтгэлгээг төлөвшүүлэх бүх нийтийн хүчин чармайлтын уялдаа холбоо, чиглэсэн зорилгот байдлыг хангах үүднээс бага хурлаас төр, иргэний нийгмийн байгууллагуудад дараа арга зүйн товч санал, зөвлөмжийг хүргүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Санал, зөвлөмжийн товч утга:

Нэг. Үндэсний эв нэгдлийг хангах бодлого, зорилтын хүрээнд

- 1.1 Төрийн бүх шатны байгууллагын бодлого, үйл ажиллагаанд Монгол Улсын иргэдийн үндэс угсаа, үзэл бодол, нас хүйс, хөрөнгө чинээнээс үл хамааран тэгш, шударга байх үндсэн хуулийн зарчмыг тууштай баримтлан түүнд иргэний нийгмийн оролцоог өргөтгөх, хяналтыг чангатгах;
- 1.2 Бодлого, үйл ажиллагаандаа улс, үндэснийхээ нийтлэг бахархал, үнэт зүйлсийг эрхэмлэн нийт иргэнд үндэсний бахархал, эх оронч үндэсний үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай оролцох, улс төржин явцуурхах, нутгархах, алагчлах, "онцгойрох" (үндэстэн ястны хэт аминч, дэвэрүү, хөөргөн, онцгойрох, тусгаарлах санаа, санаархал гэсэн утгаар)-тай шийдвэртэй тэмцэх;
- 1.3 Бодлого боловсруулах төвшинд үндэстэн ястны тэгш оролцоог хангах механизмыг бүрдүүлэх, тэдэнд чиглэсэн соён гэгээрүүлэх, боловсролын бодлого боловсруулан

хэрэгжүүлэх, хүний эрхийг хангах хөтөлбөр, ОНМХ-гийн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх (ялангуяа шүүн таслах үйл ажиллагаанд) үндэстний цөөнхийн эрх ашиг, эрхийг хамгаалах тогтолцоог баталгаажуулах;

- 1.4 Иргэн, төрийн алба хаагчийг үзэл бодлоор нь алагчлах, ялгаварлан гадуурхах эрх зүйн хамгаалалтыг бүрдүүлэх, төрийн албаны хууль тогтоомжыг тууштай хэрэгжүүлэх;
- 1.5 Нийгмийн социал бүтэц, давхаргад гарч буй өөрчлөлтүүд, нийгмийн социал ялгарал (баян хоосны) нь нийгэмд төрийн тогтвортой, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх энэ зорилгоор "хувь хүний аюулгүй байдалд" суурилсан нийгмийн аюулгүй байдлын сургалт, судалгааг УАБ-ыг хангах чиг үүрэг бүхий байгууллага, тэдгээрийн харъяа их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;
- 1.6 Монголын түүх судлал, бичиглэлийг улс төрийн болон үндэстэн ястны явцуу ашиг сонирхол, өс хонзон, түүхийн хоосон бардамнал зэрэгт автан гуйвуулах, гоёчлон магтах (хуурай магтаал)-аас тууштай хамгаалах;
- 1.7 Түүхийг "Монголын нууц товчоо", "Эрдэнийн эрх", "Алтан товч" зэрэг их эх сурвалжууд, гадаад дотоодын эрдэмтэн мэргэдийн бүтээл туурвил, сан хөмрөгт түшиглэн бодитой үнэн зөв бичих, баяжуулахад идэвхи санаачлага, үр бүтээлтэй хөдөлмөрлөж буй эрдэмтэн

судлаачид, ялангуяа монголын түүхийн судлагдаагүй, “хаягдсан, гээгдсэн” цагаан толбыг арилгахад чиглэсэн бүтээл туурвилыг төрөөс тууштай дэмжих;

- 1.8 Ч.Жүгдэрийн “Монголын нийгэм, улс төр, философи сэтгэлгээний хөгжлийн гурвалсан тойм” бүтээл, Д.Гонгорын “Халх товчоон” 2 дэвтэр бүтээл, Л.Хүрэлбаатарын “Огторгуйн цагаан хүрд” зэрэг ховордсон ном бүтээлүүдийг дахин хэвлүүлж олны хүртээл болгох.

Хоёр. Нийгмийн (социал хүрээний) харилцааг зохицуулах хууль бүтээх бодлого, үйл ажиллагааны хүрээнд

2.1 Татварын, хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид болон УИХ-аар баталгаажуулан хэрэгжүүлж буй нийгэм эдийн засгийн, хүн ам зүйн хөгжлийн бодлого (хөтөлбөр, төсөл г.м)-д нийгмийн социал зохицол (гармони)-д онцгой үүрэгтэй дундаж давхаргыг дэмжсэн тодорхой зорилго, зорилт, зүйл заалтыг шингээж (тусгаж) тодорхой шалгуур үзүүлэлтийг баримталж үе шаттайгаар хэрэгжүүлэх; Үүний тулд:

- a. Нийгмийн социал давхаргажилт (Жишээ нь баячууд буюу чинээлэг хэсэг, дундчууд, ядуу гэх мэт)-ийн шалгуур үзүүлэлтүүд (параметрийг) шинжлэх ухаанчаар тогтоох;
- b. Дундаж давхаргыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон хөрөнгө оруулалтаар дэмжих арга замыг нарийвчлан тодорхойлох;

c. Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх төрийн бодлогын тогтвортой, шударга, нээлттэй тогтолцоо, механизмыг төлөвшүүлэх арга замыг олон нийт, иргэний нийгмийн идэвхитэй оролцоотойгоор тодорхойлох;

2.2 Ажилгүйдэл, ядууралтай тэмцэх (саармагжуулах) үндэсний хөтөлбөрийг шинэчлэх. Энэ зорилгоор:

- a. Ядуурал, түүний учир шалтгааныг шинжлэх ухааны тодорхой судалгаа, дүгнэлтэд тулгуурлан оновчтой тодорхойлох;
- b. Төрийн нийгмийн халамжийн тогтолцоо, хуулийн зохицуулалтыг ядуучуудыг амьжиргааны байнгын эх үүсвэртэй болгох зорилтод нийцүүлэн шинэчлэх;
- c. Иргэдэд үзүүлэх төрийн бүх төрлийн үйлчилгээ (хууль эрх зүйн, боловсролын, эрүүл мэндийн, даатгалын г.м)-ний төлбөрийн параметруудийг тэдгээрийн чанар, үр дүнг түшиглэн тогтоох, (хувийн хэвшлийн мөн төрлийн ажил үйлчилгээнд нэгэн адил хамаарах), хүн амд, ялангуяа эмзэг давхаргынхан (өрөөсгөл гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуучууд, төрийн албан хаагчидад г.м) үзүүлэх дарамт, ачааллалыг тууштай бууруулах бодлого баримтлах.

2.3 Архидан согтуурах, мансуурахад донтох, биеэ үнэлэх зэрэг нийгмийн гаж үзэгдэл, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, хууль тогтоомжийн зохицуулалтыг шинэчлэх, нийгмийн эдгээр сөрөг үзэгдлийн учир шалтгаан, тэдгээрийг саармагжуулах, таслан зогсоох онол, арга зүйн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, үр дүнд хүргэх.

Гурав. Иргэний нийгмийн оролцоог идэвхижүүлэх бодлого, зорилтын хүрээнд

3.1 Иргэний нийгмийн үүрэг роль, зохион байгуулалт, үйл ажиллагааных нь хэм хэмжээ, параметрууд /шалгуур үзүүлэлт/-ийг хуульчлан тогтоох чиглэлээр иргэний нийгмийн байгууллага /институтууд/-ын хууль тогтоомжийн иж бүрдэл, цогц байдлыг хангах, энэ зорилтын хүрээнд:

- ▶ Олон нийтийн оролцооны тухай;
- ▶ Иргэний хяналтын тухай;
- ▶ ТББ-ын тухай;
- ▶ Иргэний шилжилт хөдөлгөөний тухай зэрэг чиглэлээр хуулийн /хуулийн заалт, зүйл, нэмэлт өөрчлөлт, бусад төслийг боловсруулах, баталгаажуулах/;

3.2 Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэний нийгэмтэй зохицон /зэрэгцэн/ орших, хамтран ажиллах чадвар, соёл эзэмшүүлэх арга хэмжээ /сургалт, дадлага, бусад/-г үе шаттай зохион байгуулах, ийм чадвар, хандлага, соёлыг төрийн алба, албан хаагчийг

үнэлэх дүгнэх шалгуур үзүүлэлт болгон хэвшүүлэх;

3.3 Төрийн зарим /социал/ чиг үүргүүдийг иргэний нийгмийн институтэд шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Эх сурвалж, ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ.1992 он.
2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт. УБ.2019 он. /Лавлагаа, танилцуулга/
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ. 2013 он.
4. Ата-Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. УБ. 2006 он.
5. Рашид-Ад-Дин. Судрын чуулган. УБ. 2002 он.
6. Удо Б.Баркман. Чингис хааны үед төр-цэргийн элит давхарга болж хөгжсөн нь-Монголын түүх, улс төрийн тухай өгүүллүүд. 423 дахь талд.
7. Жак Уэтерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан. УБ. 2009 он.
8. Лүндээжанцан.Д. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ. 2014 он.
9. Нарангэрэл. С. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир. УБ. 2014 он.

ӨРШӨӨЛ ӨӨГҮЙ БАЙХ УЧИР ШАЛТГААН



Монгол Улсын гавьяат хуульч.
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)
Р.Оюунбадам

Хорих байгууллагын ажилтан хүн эрүүгийн өршөөлийг өөртөө хамаатай гэж үздэг.

Хорих ял эдлэгсдийн байнгын хүсэл мөрөөдөл нь хорих ялаас чөлөөлөгдөх байдаг. Энэ нь зөвхөн тэдний төдийгүй гэр бүл үр, хүүхэд, төрөл төрөгсдийнх нь мөрөөдөл юм.

Хорих ял эдлэгсэд хэзээ нэгэн цагт суллагдаж нийгэм иргэдийн дунд дахин орох нь гарцаагүй зүйл билээ. Хорих ял эдлэгчдийг ялаас хугацаанаас нь өмнө чөлөөлөх нь хүний эрхийн чухал асуудал төдийгүй эрүүгийн эрх зүйн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх үндсэн асуудал мөн.

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах, өршөөл уучлал үзүүлэн хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх асуудлууд хорих байгууллага ба хоригдол хоёрын хооронд үүссэн эрх зүйн өвөрмөц харилцаа дуусгавар болдог онцлогтой. Хоригдол хугацааны

өмнө ялаас чөлөөлөгдөх нь хорих байгууллагын ажилтан хоригдол хоёрын аль алиных нь хүсэл сонирхлыг нэгтгэсэн ойлголт байдаг. Өршөөлийг ихэвчлэн эрүүгийн эрх зүйн тэр тусмаа ялын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлдэг онцгой арга хэмжээ юм.

Өршөөл үзүүлэн ялаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт нь хугацаанаас өмнө тэнсэн суллах эрх зүйн үндэслэлийг багтаадаг хэдий ч өвөрмөц ялгаатай. Өршөөлийг улс төрийн эрх мэдэлтний санаачлагаар өргөн мэдүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх хэм хэмжээг хуульчлан батлах үйл явцаар илэрдэг. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар ял шийтгэлийг өршөөх эрхийг төрийн эрх барих дээд байгууллага эдэлдэг.

Төрийн өршөөл бол Монгол улсын эрүүгийн эрх зүйн болон ял эдлүүлэх эрх зүйн аль алиных нь судлагдахуун байдаг учраас хорих ял эдлүүлэх ажиллагааны салшгүй хэсэг гэж үздэг. Иймд энэ сэдвийг онол арга зүй практикийн талаас нь нарийвчлан судлах шаардлага надад зүй ёсоор тавигдсан юм.

Эрүүгийн өршөөлийн асуудал олон зуун жилийн өмнөөс эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн хууль зүйн шинжлэх ухааны асуудал учраас эрдэмтэн судлаачдын хийсэн онолын томъёоллоос дурдвал: Хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор Г.Совд “Өршөөл, уучлал үзүүлэх асуудал нь хэлбэрийн хувьд ял шийтгэлээс бүрэн чөлөөлөх, хөнгөрүүлэх мөрдөн шүүлтийн ажлыг зогсоох, ял шийтгэлийг цагаатгах хэлбэрүүдтэй байдаг боловч өршөөл үзүүлэх үйл

ажиллагаа бол тодорхой хэмжээ хязгаартай байдаг” гэжээ.

Академич С.Нарангэрэл “Өршөөл үзүүлэх нь гэмт хэрэг үйлдсэн тодорхой бус этгээдүүдийг эрүүгийн хариуцлага гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоосон бол бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх эсхүл ялын хугацааг багасгах өөр хөнгөн ялаар солих эсхүл ял шийтгэлгүйд тооцох явдал¹ гэсэн байна.

Харин шинжлэх ухааны доктор профессор С.Жанцан “Өршөөлийг хэтэрхий хавтгайруулахгүйгээр ялгавартай хандах нь өршөөл үзүүлэх энэрэнгүй ёсны арга хэмжээний нэр хүнд, хүмүүжлийн ач холбогдлыг дээшлүүлдэг бөгөөд ялтан бүрийн засарч хүмүүжих гэсэн эрмэлзлийг урамшуулж байдаг”² гэжээ.

Эрх зүйн аливаа түүхэн уламжлалыг судлахгүйгээр түүнд шинжлэх ухааны үндэстэй үнэлэлт дүгнэлт өгөх, уг үзэгдлийн зүй тогтол мөн чанарыг зөв танин мэдэх түүний цаашдын чиг хандлагыг зөв оновчтой тодорхойлох, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжгүй юм. Монгол улсын төрийн эрх мэдэл хааны мэдэлд байсан эрт үед өршөөл уучлалыг нэгэн адилаар үзэж өршөөн хэлтрүүлэх гэсэн ерөнхий ойлголтоор тодорхойлогдож байсан ба гэмт хэрэг үйлдсэн хүний амь насыг өршөөн хэлтрүүлэх буюу цаазаар авах ялаас болон бусад төрлийн ялаас өршөөн хэлтрүүлэх явдлаар илэрч байв.

Хаант төрийн хааны бодлого нь ялтан хэрэгтнийг гэм үйлдэвч уучлан хэлтрүүлж ял шийтгүүлсэн зарим

төрлийн ялаас өршөөн хэлтрүүлж байсныг эртний хууль цаазын түүхэн эх сурвалж бичиг болох Монголын нууц товчоо, Их засаг хууль, Юан гүрний нэвтэрхий цааз зэрэгт үлдээжээ.

Монгол орон манжийн эрхшээлээс гарч төрийнхөө тусгаар тогтнолыг зарлан тунхаглаж Богдхааныг хаан ширээнд залсан. 1911 оны 12 сарын 29-нд Богд хаан өршөөл үзүүлэх зарлиг буулгаж уг зарлигт: аливаа элдэв ялтанг цөм хэлтрүүл. Онц хүнд буй боловч насан идэр болбоос цэргийн албанд оруулж зүтгүүл, насан буурай болбоос биеийн чадах албанд зүтгүүл. Мөн аливаа засаг ноёд цөм энд ирж хишигт мөргөвөөс зохимой гэж зарлиг буулгасан³ байна.

Монгол улс 1921 онд Ардын хувьсгалын ялсан даруйд Ардын засгаас авч хэрэгжүүлсэн анхны арга хэмжээний нэг нь Ардын засгийн газрын 1921 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тогтоолд Богд хааны төрсөн өдрийг тохиолдуулан ядуучуудад тэтгэмж олгож хоригдлуудыг өршөөн суллахаар тогтоож байжээ. Цаашдаа Ардын засгийн газрын хэрэгтэн ялтанд төрийн өршөөл уучлал үзүүлэх бодлого нь: Хуучин нийгмийн хуулийн үйлчилгээг өөрчлөхөд оршино гэж үзээд ард ангийн хүмүүсийг ял зэмлэлээс чөлөөлөхөд орших, ардын засгийн энэрэнгүй улс төрийн бодлогын илрэл болгож 1922 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Ардын засгийн газрын 2 дугаар хурлын тогтоолд МАН байгуулагдсаны 2 жилийн ойн баярыг тохиолдуулан хэрэгтэн

¹ Сонц.Г. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ., 1973 он. 446-448 дахь тал.

² Нарангэрэл.С Монгол улсын эрүүгийн эрх зүй Ерөнхий анги УБ 1999 он 355 дахь тал

³ Жанцан.С Монгол улсын эрүүгийн эрх зүй онол. УБ., 2014 он.

⁴ Сан хөмрөг Х-А-6, Д-1, ХН-511 “Богд Эзэн эрдэний сууринд залраад буулгасан хишиг гараах зарлигт тохиолдсон ялт ардын олох ялыг цөм хэтрүүлэн тавих зэрэг явдлыг дагаж шийтгүүлдэхээр дөрвөн аймгийн даа жанжин, эрдэнэ шагздууныг зэрэг 9 газар зарлиг тушаал зарар. 4 яамнаа мэдэгдсэн явуулсан хэрэг” мон. “Өршөөл үзүүлэх гухай хуулийн биелүүлэх журмын гухай” гэдэвт судалгааны ажлын тайлан. ХЗҮХ.

ялтнуудад өршөөл үзүүлэх зарлиг гаргаж хорих ял шийтгүүлэн түүнийхээ тал хувийг эдэлсэн хоригдлуудыг ялаас бүрмөсөн чөлөөлөх, цаазлуулах ялтай хүний амийг өршөөж 10 жил хорих ял болгон хэлтрүүлж байжээ.

1930 оны 3 дугаар сард Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор дэлхийн эмэгтэйчүүдийн баярын 20 жилийн ойг тохиолдуулан зөвхөн эмэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх зарлиг баталж байжээ. 1937 оны 03 дугаар сард Мартын 8-ны 27 жилийн ойгоор 24 эмэгтэй ялтныг өршөөн сулласан¹ байна. 1941 оны 6 сарын 20-нд “Үндэсний хувьсгал ба ардын хувьсгалт цэргийн 20 жилийн ойн баярыг тохиолдуулан ялтан хэрэгтэн нарт өршөөл үзүүлэх тухай” Улсын бага хурлын тогтоол. 1961 оны 7 сарын 8-нд “Ардын хувьсгалын 40 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг. 1971 онд ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулж, ардын их хурлын зарлиг гаргасан бол 3 жилийн дараа 1974 онд “БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг. 1979 онд “Олон улсын хүүхдийн жилийг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай” АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг. 1981 онд ардын хувьсгалын 60 жилийн ойг тохиолдуулан “БНМАУ тунхагласны 60 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай” АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг. 1987 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Аугаа их Октябрийн хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай” БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг² тус тус гарч

байжээ.

Дээрх бүгдээс харвал: 1921-1987 он ардын хувьсгалаас хойш социализмын үеийн 66 жилийн дотор 12 удаа өршөөл үзүүлжээ. Монгол улс хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулж буй 1991-2015 он хүртэл 6 удаа өршөөл үзүүлсэн бөгөөд нийтдээ 18 удаа өршөөлийн хуулийн зарлиг гаргаж олон арван мянган хүнийг хорих болон бусад төрлийн ялаас чөлөөлжээ. Дээрх 18 удаагийн өршөөлөөс 15 удаагын өршөөлийг нь их ой тохиолдуулан гаргаж байсан байна. Өршөөлийн зарлигаар хорих ялаас чөлөөлөгдсөн нийт хүн 1981 онд 23.6%, 1984 онд 21.5%, 1987 онд 24.2%, 1991 онд 31.3%-иар тус өршөөл үзэн суллагдаж байжээ. 1991 оноос хойш УИХ-аас баталсан өршөөлийн хуулиуд тухайлбал: 1991 оны хууль өршөөлийн хууль нь улс хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуулж, 1996 болон 2006 оны өршөөлийн хуулиуд нь тулгар төр үүсэн байгуулагдсаны 790, 800 жилийн ойг тохиолдуулж, 2000 болон 2009 оны өршөөлийн хуулиуд нь УИХ-ын сонгуулийг тохиолдуулж, 2015 оны хууль анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан тус тус гарчээ. Ийнхүү 18 удаагийн өршөөлийн хууль, зарлиг 3-4 жилийн давтамжтайгаар гарч хорих ял эдэлж байгаа нийт хүний 21.5-31.3%-ийг өршөөн суллаж байсан байна. Үүнээс үзвэл манай улсын хувьд өршөөлийг тэмдэглэлт ойн баярыг тохиолдуулан гаргадаг уламжлалтай гэж үзэж болохоор байгаа юм.

Монгол улсын төрийн өршөөлийн мөн чанарыг хаант засаглалтай байсан үеэс өдгөө хүртэл удаа дараагийн өршөөлийн хууль зарлигаас харахад

¹ Оюунбадам.Р. Хос түүх. УБ., 2006 он. 13 дах тал.

² Өршөөл үзүүлэх тухай хуулийг биелүүлэх журмын тухай сэдэвт судалгааны ажлын тайлагнаас ХЗҮХ.

үндсэн хуульд заасан ёсоор ял шийтгэлийг өршөөх эрхийг төрийн эрх барих дээд байгууллагын эрх мэдлийн асуудал, өршөөл нь ялаас чөлөөлж байгаа нэг хэлбэр гэж үзэж ирсэн. Нөгөө талаар өршөөл нь төрийн ардчилсан шинж чанар, энэрэнгүй бодлогыг илэрхийлсэн эрх зүйн зохицуулалт гэж үзэж байна. Зарим судлаачид Монгол улсад хорих ялын хэмжээ хэт өндөр эрүүгийн хууль нь хатуу ялын бодлого чанга байгаагаас хорих газар хүнээр дүүрч тэднийг багасгах зорилгоор ойр ойрхон өршөөл гаргадаг. Тухайлбал 1986 оны Эрүүгийн хуулийг 2002 оны эрүүгийн хуультай харьцуулахад хоригдлын тоо 46.0%-иар өссөн үзүүлэлт байдаг. Энэ нь нийгмийг үл шоронжуулах, алдаа хийдлийг засах, нийтийн эрх ашгийг хувийн сонирхолд нийцүүлэх үүднээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээний нэгээхэн хэсэг нь өршөөл, уучлал үзүүлэх замаар шорон дахь хүнийг багасгах бодлого баримталж өршөөлийн хууль гаргаж эрүүгийн хуулийн хийдлийг өршөөлийн хуулиар механикжуулан засварлаж байсан¹ гэж дүгнэлт өгдөг судлаачид бий. Миний бие дээрх судлаачдын саналтай нийлэхгүй байна. Учир нь гэмт хэргийн өсөлт дан ганц хуулиас хамаарахгүй маш олон учир шалтгаан бий. Ялангуяа гэмт хэргийн гаралтад нийгмийн байдал, эрүүгийн ялын бодлого, ард олны амьдралын төвшин, ажилгүйдэл, ядуурал, эмх замбараагүй байдал, хүмүүсийн хомхой зан, архи дан согтууралт, хүчирхийлэл, нийгэмд шударга ёс алдагдах гээд олон хүчин зүйлээс хамаардаг юм.

Нөгөө талаар шоронжуулах гэдэг нь олон улсын эрх зүйд "рецидив" гэмт хэрэгтний эзлэх хувийн жин өндөр

байгааг шоронжих шоронжуулах гэж ойлгодог. "Рецидив" гэдгийг хорих ял эдэлсэн буюу хорих ял эдлэж буй этгээд давтан гэмт хэрэг үйлдсэнээр дахин хорих ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн тоо өндөр байгааг ойлгоно.

Шоронжуулах гэсэн үгийн хууль зүйн гол агуулга нь шоронд орсон хүн засарч хүмүүжихгүй, өөрийн үйлдсэн гэмт хэргээ ухамсарлахгүйгээс шалтгаалан хорих газрын дэглэм журмыг сахихгүй зөрчил гаргадаг гэдгээр нь тайлбарладаг. Зарим нь яваандаа хорих газар дасан зохицсон буюу шоронгоос айхгүй болсон гэсэн үг юм.

Өнөөгийн байдлаар хорих газар ял эдэлж байгаа нийт хүний 30 шахам хувь түүнээс ч өндөр хувийг давтан гэмт хэрэгтнүүд эзэлж байна. Практик дээр эрэгтэйчүүдээс гадна эмэгтэйчүүдийн дунд гэмт хэрэг 5 болон 10 удаа давтан гэмт хэрэг үйлдэгчид байсан үе бий. Одоо цагт энэ байдал харьцангуй багассан ч гэлээ өндөр хэвээр байна.

Ингээд үзэхээр хоригдлын тоо олшроод ирэхээр нийгмийг шоронжуулж байна гэж үзээд ойр ойрхон өршөөл үзүүлж ялаас чөлөөлөх нь тийм ч оновчтой бодлого байж чадахгүй. Дэлхийн бусад улс оронд хоригдлын тооны өсөлт ямар байгааг өөрийн улстайгаа харьцуулан үзэх зорилгоор дэлхийн 159 улсын хүн амын доторх гэмт хэрэгтэн, тэр дотроо хоригдож байгаа хүний тоог Монгол улстай харьцуулан Сингапур, Малайз, Индонез, Өмнөт Солонгос, Австрали, Лаос, Камбож, Вьетнам, ОХУ, Хятад гэх зэрэг улсын 100.000 хүн амд ногдох хоригдлыг тоог судлав. Дээр дурдсан Ази номхон далайн улсуудад 100.000 хүн амд ногдох хоригдлын тоо 120-220 байна. ОХУ-д 100.000 хүнд 338 хоригдол

¹ Өршөөлийн хуулиудад хийсэн дүн шинжилгээ бодлогын судалгааны тайлан 2019 он 31 дэх тал.

ногдож байна. Манай улс 100.000 хүн амд 132 хоригдолтой¹ байна.

Өршөөлийн талаар зөвхөн Монгол улсын хэмжээнд судлан үзэж үнэлэлт дүгнэлт өгөх нь учир дутагдалтай тул дэлхийн бусад оронтой харьцуулан судалсан болно. Италийн нэрт эрдэмтэн Ч.Бекериа 1874 онд бичигдсэн “Гэмт хэрэг ба ялын тухай” бүтээлдээ “Хууль төгс бол ял нь зөөлөн бөгөөд гарцаагүй байх ба шүүх нь шударга бол өршөөл үзүүлэх тухай асуудал огт яригдах ёсгүй гэсэн² бол Ж.Бентам “Хэрэв эрүүгийн хууль харгис хатуу бол өршөөл уучлал түүний зайлшгүй нэмэлт болдог. Гэвч энэ нь хор уршиг ихээхэн авчирдаг. Харин сайн хуультай бол түүнийг устгах ид шидийн саваа хэрэггүй” гэжээ.

Аль ч улс өөрийн улсынхаа үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулийн дагуу гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн этгээдэд дахин алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, өөрийн үйлдсэн буруутай үйлдлийн үр дагаврыг ойлгох боломжийг олгодог байна. Европын зарим улсад ял эдлэгчдийг хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх боломжтой зохицуулалт байдаг. Энэ нь төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрээр өршөөл үзүүлэх журмаар бус харин эрүүгийн хуульд заасан нөхцөл журмын дагуу ял шийтгэлийг хөнгөлөх, өөрчлөх, хүчингүй болгох, багасгах, хугацаанаас нь өмнө суллахыг ойлгодог. Латин Америкийн зарим муж улсад төрийн бодлогоосоо хамаараад

өршөөлийг улс төрийн гэмт хэрэгтнүүдэд хамаатай хэрэглэж ирсэн байна. АНУ-ын Техас муж болон Канад улсад “Өршөөл, уучлал” гэдгийг хугацаанаас нь өмнө суллахтай адил утгаар ойлгож хэрэглэдэг³. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нь хэрэгтэн ялтныг хугацаанаас нь суллах өршөөх асуудлыг шийдвэрлэх тусгай зөвлөлтэй байдаг. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Канад улсын таван бүс нутгийн төлөөллөөс бүрддэг байна. Дээрх зөвлөлийн тавигдсан гол шалгуур нь: хэрэгтэн ялтны үйлдсэн гэмт хэргийн байдал, уул хэрэгтэн гэм буруугаа ухаарсан эсэхийг харгалзан үздэг. Заавал хангасан байх ёстой шаардлагын нэг бол гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлсөн шүүхийн зардлыг төлсөн эсэхийг харгалзан үздэг байна.

Канад улсад өршөөл үзүүлэх тусгайлсан хууль байхгүй. Харин өршөөл үзүүлэх асуудлыг эрүүгийн ялаас хугацааны өмнө ялаас чөлөөлөхийг өршөөл энэрэл үзүүлэх хэмжээнд ойлгож хэрэгжүүлдэг⁴ байна.

Франц, Аргентин зэрэг улсын эрүүгийн хууль тогтоомжид өршөөл үзүүлэх тухай зохицуулалт байна. Энд хохирогчийн болон гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй байх тухай зааж өгдөг байна. ОХУ, Казахстан, Куба зэрэг улс манайтай адил үндэсний болон төр, улсын ойн баяр ёслолын үеэр өршөөл үзүүлдэг байна.

ОХУ-д эрүүгийн өршөөлийг ихэвчлэн ижил төрлийн хөнгөн мөн хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн болон эдийн засгийн гэмт хэргүүдэд үзүүлдэг. Үүнд:

- ▶ Өндөр настай иргэд
- ▶ Тэнсэн харгалзах ялтай хүмүүс

¹ Link https://en.wikipedia.org/wiki/List_of_counties_by_incarceration_rate. Нэр томъёоны тайлбар: Шоронгийн рецидив- гэмт хэргийг давтан үйлдэгчид.

² Бекериа.Ч Гэмт хэрэг ба ялын тухай. орч. Г.Эрдэнэбат. УБ., 2009 он Эрлийн Грекийн түүхэн уламжлалд мартаж, орхих, хэлтрүүлэх зэрэг утга санаа бүхий “amnestia” буюу “forgetfulness” хэмээх үгнээс эх сурвалж гаралтай

³ <http://en.wikipedia.org/wiki/Pardon> орж үзнэ ҮҮ.

⁴ http://en.wikipedia.org/wiki/Parole_Board_of_Canada. Мөн вебсйт www.pardons.gc.ca.

- ▶ Хөгжлийн бэрхшээлтэй хэрэгтэн ялтан
- ▶ Насанд хүрээгүй этгээдүүд
- ▶ Хүнд төрлийн гэмт хэрэг үйлдээгүй эмэгтэйчүүд
- ▶ Анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүс
- ▶ Эдгэршгүй хүнд өвчтэй хүмүүс

- ▶ Төрөөс авсан гавъяа, шагналтай хүмүүс, насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийг оруулж өгсөн байдаг.

БНХАУ-ын эрүүгийн ялын бодлогын талаар гарсан нэгэн өршөөлийг энд онцлож байна. Хятад улсын удирдагч Си Жинпин тус улсын боловсролын салбарын 70 жилийн ойн баярыг тохиолдуулан 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдөр өршөөл үзүүлэх шийдвэрт гарын үсэг зурсан байна. Энэхүү өршөөлд: Японы эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцсэн. Дайнд гавьяа байгуулсан болон 75-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан¹ байна.

Япон улсын өршөөлийн тухай нэг зохицуулалтыг онцлож харвал тус улсын үндсэн хуулийн 7 дугаар зүйлд "Эзэн хаан нь сайд нарын танхимын зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр хэсэгчилсэн өршөөл үзүүлэх тухай заалт нь ялыг хөнгөрүүлэх, эрхийг сэргээх, ял хойшлуулах шийдвэр гаргах эрхтэй" гэж заасан.

Монгол улсад нэг нийгэм нөгөө нийгмээр солигдож хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулснаар социалист нийгэм үгүй болж түүнийг дагаад социалист өмч гэх ойлголт ч байхгүй болсон билээ. 1991 оны 3 дугаар сард Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар социалист өмчийг ашиглан шамшигдуулсан

гэмт хэргийн улмаас хорих ялаар шийтгүүлсэн бүх хүнийг нэгэн зэрэг ялаас чөлөөлөх үйл явц болсон билээ. Дээрх үйл явдалтай холбогдуулан нэгэн үйд явдлыг дурдвал: Ерөнхийлөгчийн зарлиг уншигдахын өмнөх өдөр эмэгтэйчүүдийн хорих ангид Улаанбаатар хотын төв бараа баазын нярав байсан "Ж" гэх 50 гаран насны нэг эмэгтэй ЭХ-ийн 63 дугаар зүйлийн "в" гэсэн зүйлчлэлээр 15 жилийн хорих ялтай хорих ангийн хаалгаар орж ирэхдээ "аврал эрсэн харцан дороо нулимс цийлгэнүүлэн" орж ирсэн юм. Маргааш нь Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар суллагдсан олон арван эмэгтэйчүүдийн дунд өчигдөр ирсэн "Ж"-гийн нэр багтсан бөгөөд тэрээр албан хаагч нарын дундуур нүүр буруулан гарч одсон билээ. Энэ баримт өршөөлтэй ямар хамааралтай юм болоо гэх сэтгэгдэл уншигч танд төрж болох юм. Гэмт хэрэг үйлдэж, гэм буруу нь шүүхээр тогтоогдсон хүнийг ямар нэг онцгой тохиолдлын улмаас ялаас чөлөөлөх үед тухайн гэмт хэрэгтэн засрал хүмүүжил олоогүй, өөрийн гэм буруугаа ойлгож чадаагүй гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй байдаг л учир нь байгаа юм. Ингээд үзэхээр хорих ялаас хугацааны өмнө суллагдаж байгаа хэн боловч хамгийн наад зах нь өөрийн гэмт хэргийн хор холбогдлыг ухаж ойлгосон хүмүүжил төлөвшил олсон байх ёстой бөгөөд гэмт хэргийн хохирогчид учруулсан гэм хорын төлбөрийг юуны өмнө төлөх ёстой. Хохирогчийн сэтгэл санааны хохирол гэж бас бий. Үүнийг мөнгөөр төлдөггүй юмаа гэхэд тэдний сэтгэл зүйн байдлыг зайлшгүй бодож үзэх ёстой. Өршөөлд хамрагдагсад төрдөө баярлаж байдаг бол хохирогчдын төрдөө итгэх

¹ <http://russian.news.cn>

итгэл сулрах сөрөг үр дагавар бий болгох талтай.

Өршөөлийн хууль түүний хэрэгжилтийн талаар Судлаач Г.Батчимэг "Өршөөлийн хууль гаргахын өмнө түүний сөрөг үр дагаврыг тооцох нь чухал" гэсэн бол судлаач Г.Оюунболд "Өршөөлийн хуультай холбогдон гардаг хамгийн бэрхшээлтэй асуудал бол гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой асуудал. Би өршөөлд орох гэж байгаа гээд учруулсан хохирлоо төлөхгүй ямар нэг байдлаар аргацааж байгаад өршөөлд хамрагдах, иргэдийг дахин хохироох явдал гардаг" гэж үзээд судлаач цааш нь хорих ял эдэлж байгаа этгээдүүд өршөөлд хамрагдсанаар хохирол нөхөн төлөхгүй байх "эрхтэй" болдог² хэмээн тэмдэглэсэн байна. 1991 онд 1300-1400, 1996 онд 140, 2000 онд 1500, 2006 онд 3500, 2009 онд 3300 орчим, 2002 оны эрүүгийн хуулийн дагуу нийт 2300 орчим хүн өршөөлд хамрагдсан. Үүнээс насанд хүрээгүй 128, эмэгтэй 150 байв. 2009 оны өршөөлийн хуулиар 3271 хүн буюу нийт хорих ял эдлэгчдийн 42.7% нь хамрагдсан бөгөөд насанд хүрээгүй 65, эмэгтэй 150, хорихоос өөр төрлийн ялтай 419, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатны 1075 хүнд холбогдох 729 хэргийг хэрэгсэхгүй болгожээ³ хэмээн судалгаа шинжилгээний тайландаа тэмдэглээд тоо баримтыг олж судлахад ихээхэн хүндрэлтэй байсныг онцолсон байв.

Монгол улсын эрүүгийн эрх зүй дэх Хорих ялын мөн чанар нь: нийгэм иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аюулгүй болгох,

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг (хоригдлын) зан үйлд буй буруу дадал заншлыг өөрчлөх, арилгах, гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх, засах төлөвшүүлэх, гэмт хэрэгтэн (хоригдол) өөрийнхөө гэмт бурууг ухамсарлах зэрэг ажлууд дэс дараатай хийгддэг. Суллагдсан хүн нийгэмдээ дасан зохицож дахин гэмт хэрэг үйлдэхгүй хөдөлмөрлөж гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх амьдралаа аваад явах чадвартай болсон байхад чиглэгдэж байдаг юм. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хорих газраас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд буцаан нэгтгэх гэж үзсэн. Өршөөлийн хуулийг үр дүнтэй болгоход хамгийн чухал нөлөөтэй ажлын нэг бол яахын аргагүй хэрэгжүүлэх арга зам юм.

Өршөөлийн хуулийг хэрэгжүүлж ирсэн арга хэмжээний дотроос нэгэн баримт дурдвал 1984 онд улс тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай зарлигийг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага хүлээж аваад дараах ажил зохиосон юм. Энэ өршөөлийн зарлигт хорих ял эдэлж буй нийт хүний 21.5%-тай тэнцэх хэмжээний хоригдлыг хорих ялаас өршөөн сулласан байдаг. Өршөөлийн хуулийг хэрэгжүүлэх араг хэмжээнээс зарим баримт дурдвал: Өршөөлийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын томоохон хэсэг нь тэр үеийн засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад ногдож том ажил, том баяр болж байв. Би залуу ажилтан байсан болоод ч тэрүү төрийн өршөөл нь аавын хүү, ээжийн охины магнайг тэнийлгэдэг төрийн хайр юм байна гэж ойлгож билээ. Учир нь өршөөл гарангуут төв, хөдөөгийн хорих ангиудаас хорих ялаас чөлөөлөгдсөн олон зуун хүнийг татан авчирч

¹ Батчимэг Г Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. УБ., 2011 он. 37 дахь тал.

² Оюунболд Г Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2009 он. №3

³ ННФ бодлогын судалгааны тайлан 2019 он.

Улаанбаатар хотын Толгойт өртөөний ойролцоо байрлуулсан. Тэнд гэр, майхан барьж, гал тогоо хоолны газар, ажилтнуудын түр байрлах байр, аймаг орон нутаг руу тээвэрлэх хэдэн арван бүхээгтэй ногоон машинуудыг эгнүүлэн байрлуулсан нэгэн өвөрмөц хотхон боссон байв. Тэнд ялаас чөлөөлөгдсөн бүх хүнд улирлын бүрэн хувцас хэрэгсэл олгож замын зардал хүнс бэлдэж байсан юм. Хамгийн гол нь эрх чөлөөний амтыг хүртэж буй ялаас чөлөөлөгдсөн иргэддээ 2-3 хоногийн сургалт зохион байгуулсан явдал чухал арга хэмжээ болж чадсан. Сум, орон нутаг, хороондоо очоод гэр бүл найз нөхөдтэйгээ хэрхэн уулзах, цаашид амьдралаа хэрхэн авч явах, дахин алдахгүй байх тухай сургалтанд нэлээдгүй тодорхой зааж байлаа. Дараа нь алдар цуутай хүмүүс, ахмадууд, захиа даалгавар өгч эрдэмтэн багш нараар хичээл заалгаж, харьяа нутгийн төр захиргааны байгууллагын ажилтнууд нь хорих ялаас чөлөөлөгдсөн иргэнээ хүлээж авахаар ирсэн бөгөөд сургалтыг хамтран зохион байгуулж байсан юм. Энэ ажлыг ЗХХБУГ-ын дарга генерал Ж.Содном гардан зохион байгуулсан төдийгүй хорих ангийн дарга нар болох хурандаа Б.Нацаг, Дорж, Лувсанпэрэнлэй, Банзрагч нар одонгоо зүүж, мондъёороо өмссөн сургалтын үйл ажиллагаатай танилцаж явсан нь их л сүрлэг харагдаж билээ. Энэ бүхнийг товч боловч дурдсан минь өнгөрсөн нийгэм, өмнөх ажилтнуудыг дөвийлгөн магтах гэсэндээ биш. Гагцхүү төрийн өршөөл нь асар нэр хүндтэй өндөр ач холбогдолтой эрх зүйн зохицуулалт болохыг бодит баримтаар жишээ татсанд оршино.

Монгол улс хүмүүнлэг ардчилсан нийгмийг байгуулснаас хойш арав

гаруй жилийн дараа буюу 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан гаргасан Өршөөлийн хуулийг хорих ангиуд дээр хэрхэн зохион байгуулж яаж хэрэгжүүлж байсныг эмэгтэйчүүдийн хорих ангийн жишээг дээрээс бага зэрэг хөндөе. Өршөөлийн хууль батлагдангуут өршөөлд хамрагдагсадыг суллах чөлөөлөх ажиллагааг улсын наадмын өмнөх өдөр багтаан зохион байгуулж хоригдлыг ялаас чөлөөлж гэр оронд хариулах үүрэг наадмын хоёр хоногийн өмнө хорих ангиудад ирэв. Энэ шийдвэрийг эмэгтэйчүүдийн хорих анги хүлээн ялаас бүр мөсөн чөлөөлөгдөх байдлаар өршөөгдсөн эмэгтэйчүүдийг суллахад бэлдэх, олон ажлыг амжуулах өршөөлийн комиссыг хүлээн авах, өршөөлийн зарлиг унших зэрэг арга хэмжээ зохион байгуулах олон ажлыг маш яаруу давчуу цаг хугацааны дотор хийсэн юм. 2006 оны Өршөөлийн хуулийг 1984 оны өршөөлтэй харьцуулахад хорихоос суллагдсан хүмүүсийг хүлээж авах, аймаг сум дүүргийн ажилтнууд байсангүй. Өршөөлд хамрагдсан хүмүүсийн дунд сургалт зохион байгуулах зэрэг олон ажил дутмаг яаруу давчуухан баяр ёслолын байдалтай болоод өнгөрөв.

Өршөөлд хамрагчдын хувьд хорихын хаалга хаагдаж байгаа нь сайхан үйл явдал мөн хэдий ч цаана нь олон хариуцлагатай байхыг шаардах хаалга нээгдэж байгаа нь ойлгомжтой. Гэтэл суллагдаж буй хүмүүсийн талаар ихэнх нь нийгэмдээ хэрхэн дасан зохицох талаар ямарч төсөөлөлгүй байсан. Харин өршөөлд хамрагдаагүй бусад хоригдлыг сэтгэл зүйн хямралыг арилгах, тэдний зүгээс үйлдэгдэх элдэв зөрчлүүдийг таслан зогсоох, гэмт

хэргийн шинжтэй үйлдэл хийж оргох, амиа хорлох, өөрийн бие эрхтнээ гэмтээхэд хүрч болзошгүй нөхцөл үүсдэг тул тэдгээрийг гаргуулахгүй байж хорих ангийг хэвийн горимонд нь хурдан оруулах зэрэг олон ажил тулгамдаж байсан. Тухайн үед өршөөл хүлээсэн олон мянган хоригдлын сэтгэл санаа тогтворгүй болсноос хорих байгууллагын ажилтнуудад ихээхэн хүндрэл бэрхшээл учирч байлаа. Зарим ноцтой учралууд хорих ангиудад гарч байв. Энэ тухай баримт сөхвөл урт удаан бичих хэрэг гарах тул энд дурьдах шаардлагагүй гэж үзэж байна.

Судалгаанаас харвал: Нийт хорих ял эдлэгчдийн 1/3 хүртэл хувь нь өршөөлөөр суллагдаж байсан байна. Өршөөлийн хуулиар өршөөлд хамааруулахгүй гэж заасан нөхцөлөөс бусад бүх гэмт хэрэг үйлдсэн хэдэн мянган хүн суллагдаж байгаа нь ялын бодлогийг алдагдуулдаг талтай.

Ялангуяа гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь өршөөлийн хууль гарах сургаар шалгаж, хянаж байгаа хэрэг нь өршөөлд хамрагдах төлөв байдлаас болоод хэрэг удаашрах эрүүгийн хэрэгт нотолбол зохих ажиллагаа хийхгүй байх, эсхүл хийсэн ажлынх нь үр дүн талаар өнгөрсөнд дургүйцэх, урам хугарах, ажиллах идэвх сулрах байдал бий болох магадлал өндөр байдаг.

Өршөөлөөр ялаас чөлөөлөгдөж байгаа хүн нийгэмд аюулгүй болж очиж чадсан уу. Гэмт хэргээ гэм буруугаа ухамсарлаж чадсан үгүйг болоод засрал хүмүүжил төлөвшил олсон эсэхийг заавал анхаарч авч үзэх ёстой. Монгол улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлагын

зорилго нь гэмт хээрг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүниг нийгэмшүүлэхэд оршино” гэж заасан.

Манай улсын өршөөлийн эрх зүйн зохицуулалт бол хэрэгтэн ялтныг ялаас хугацааны өмнө чөлөөлөх зохицуулалтын нэгэн онцлог төрөл учраас эрүүгийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой зааж өгдөг. Монгол улс 2015 оноос өмнө хорих ангиудаас улирал бүр 2015 оноос хойш сар бүр Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу эдлэх ёстой ялныхаа зохих хувийг эдэлсэн олон арван хоригдлыг хорих ялаас нь шүүхийн магадлалаар чөлөөлж байгаа. Энэ зохицуулалтын ач холбогдол нь хоригдол бүр хорих ангийн дэглэм журмыг чандлан сахидаг, хөдөлмөрт хандах хандлага нь сайн, засрал хүмүүжлээ зан байдлаараа харуулж чадсан гэмт хэргийн улмаас бусдад учруулсан гэм хорын төлбөрийг нөхөн төлсөн байх шаардлагыг заавал хангасан байх ёстой байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай монгол улсын шинэчлэн найруулсан хууль батлагдан гарахаас өмнө өршөөлийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд болон шүүхийн шийтгэх тогтоол гарах үед өршөөл үзүүлж байсныг өршөөл үзүүлэх тухай хуулийн өвөрмөц онцлогоос хамаардаг гэж үзэж болох юм. Гэвч хэрэг нь шүүхээр эцэслэн шийдэгдээгүй хүнд өршөөл үзүүлэх нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлж буй сайн зүйл мөн боловч цаашдаа сөрөг үр

дагавар бий болох талтай. 1991 оноос хойно гарсан удаа дараагийн өршөөлийн хуулийг онол арга зүй, практикийн түвшинд судлан үзэхэд эерэг, сөрөг талууд аль аль нь ажиглагдаж байна.

Эерэг сайн үзүүлэлтийн тухайд: Эрүүгийн өршөөл нь төрийн энэрэнгүй зарчмыг хэрэгжүүлдэг. Иргэдийн төрдөө итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Суллагдсан хүн тэдний гэр бүл, садан төрөл баярлаж олон хүүхэд эцэг эхтэйгээ элэг бүтэн амьдрах боломж олгодог. Төрийн төсөв зардал хэмнэгддэг. Хоригдлын тоо цөөрснөөр хорих ангиудын ачаалал багасдаг гэхчлэн ач холбогдолтой сайн талууд олон байна.

Өршөөлийн хуультай холбогдон гардаг сөрөг үзүүлэлтийн тухайд: Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн барагдуулахгүй байх явдал юм. Нэгэнтээ би өршөөлд орох гэж байсан юм чинь гээд учруулсан хохирлоо төлөхгүй ямар нэг байдлаар аргацааж байгаад өршөөлд хамрагдах, иргэдийг дахин хохироох явдал гардаг нь нэлээд түгээмэл үзэгдэл байдаг. Хохирогчид айдаст автаж болно. "Гараад чамайг алнаа" гэж заналхийлсэн тохиолдол бий. Түүнчлэн төлбөрөө авч чадахгүй хохирсноороо хохироод үлдэнэ гэж сэтгэл нь зовних хүмүүс ч олон. Өршөөгдөж байгаа хүнд өөрт нь ямар ч мэрийлт хүч чармайлт орохгүйгээр сууж байгаад гарч болно гэсэн сөрөг бодол үүсч болох талтай. Иймд Монгол улсын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ялтныг ялаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй шинэчлэх боловсронгуй болгох нь тулгамдсан асуудал болж байна.

Монгол улс эрт үеэс эхлэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай иргэнээ нэг удаа өршөөн хэлтрүүлж ирсэн хүнлэг

энэрэнгүй ёсны түүхэн уламжлалтай улс билээ. Эрх зүйн уламжлалаас зарим ач холбогдолтой зохицуулалтыг хэвээр хадгалах нь шинэчлэлийн суурь болж өгнө. Жишээлбэл: Өршөөл үзүүлж ирсэн уламжлалд эдлэх ёстой ялынхаа тал хувийг эдэлсэн хүнийг хамруулдаг байсныг буцаан хэрэглэх боломжтой. Судалгаанаас харахад манай улсын эрүүгийн өршөөлийн эрх зүйн зохицуулалтыг дэлхийн бусад улстай харьцуулан авч үзэхэд онцлог ялгаа их байна. Дэлхийн бусад улс орны жишээнээс үзвэл өршөөлийг хэрэгтэн ялтныг хугацаанаас нь өмнө ялаас чөлөөлөхтэй адил утгаар авч үздэг байна. Иймээс дараах жишээнүүдийг анхааран үзэж дараа дараагийн өршөөлийн хууль боловсруулахдаа анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

- ▶ Өршөөлийг ихэвчлэн ижил төрлийн хөнгөн мөн хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн болон эдийн засгийн гэмт хэргүүдэд үзүүлдэг.
- ▶ Мөн өндөр настай иргэд, тэнсэн харгалзах ялтай хүмүүс. Хөгжлийн бэрхшээлтэй хэрэгтэн ялтан болоод насанд хүрээгүй этгээдүүд, хүнд төрлийн гэмт хэрэг үйлдээгүй эмэгтэйчүүд, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, эдгэршгүй хүнд өвчтэй хүмүүс, төрөөс авсан гавьяа, шагналтай хүмүүс, насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийг оруулж өгсөн байдаг.
- ▶ Япон улс гэхэд "Эзэн хаан нь сайд нарын танхимын зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр хэсэгчилсэн өршөөл үзүүлэх тухай заалт нь ялыг хөнгөрүүлэх, эрхийг сэргээх, ял хойшлуулах

шийдвэр гаргах эрхтэй” гэж заасан байдаг.

- ▶ Хятад улс орныг нь эзлэн түрэмгийлэхийг санаархагчтай эрэлхэгээр тэмцсэн, дайнд гавьяа байгуулсан болон 75-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан байгаа зэргийг үндэсний онцлог болон хууль тогтоомждоо нийцүүлэн авч болох туршлага гэж харж байна. Монгол улсын их хурал бол хууль тогтоох байгууллага. Мөн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг байгууллага учраас өршөөлийн хуулийг хэрэгжүүлэх ажиллагааг анхааран үзэж хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах олон зүйл байна.

Миний бие судлаачийн хувиар өршөөлийн эрх зүйн хүрээнд судалсан судалгаандаа тулгуурлаж дараах дүгнэлт хийж байна.

Өршөөлийн хуулийн хэрэгжилтийг маш яаруу сандруу богино хугацаанд хийж байсан тухай ч дээр дурдсан. Энэ бүхнээс харвал:

Өршөөлийн хуулийн хэрэгжилтийг заавал ойн баярын өмнө багтааж хийх гэж яарах бус хамгийн гол нь ялаас чөлөөлөгдсөн хүн нийгэм гэр бүлдээ очоод хэрхэн амьдралаа авч явахад, ажил сургуульд зуучлах байгууллага ажилтнуудтай холбоо тогтоох, орон нутгийн засаг захиргааны эрх бүхий ажилтнуудтай уулзуулах тэдний дэмжлэг туслалцаа авах нэг удаагийн тэтгэмж дэмжлэг авах, эрдэмтэн багш сурган хүмүүжүүлэгчдийн сургаал захиа даалгаврыг сонсох, бичиг баримтын зөрчлийг арилгуулах, өршөөлийн хэрэгжүүлэх тухай төсөл төлөвлөгөө

боловсруулах зэрэг ажлуудыг сайтар хийснээр төрийн өршөөлийн нэр хүндийг өргөх ач холбогдолтой юм.

Эрүүгийн өршөөлийн талаар хуульч эрдэмтэн судлаачдын хийсэн онолын томьёоллоос харвал өршөөл үзүүлэн ялаас чөлөөлж байгаа нь хугацаанаас нь өмнө ялаас чөлөөлөх нэг төрөл гэж үздэг. Тэгвэл Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, хуулийн хугацаа болсон ял эдлэгчийн асуудлыг сар тутамд хэлэлцэж хуулийн шалгуурыг хангасан тохиолдолд олон хүнийг хугацаанаас өмнө тэнсэн сулладаг нь тогтсон практик ажиллагаа юм. Иймээс өршөөл үзүүлэхдээ хэт хавтгайруулахгүйгээр ялгавартай хандахыг чухалчлах хэрэгтэй.

Эрдэмтдийн хийсэн өөр нэг томьёолол нь өршөөл үзүүлэх энэрэнгүй ёсны арга хэмжээний зорилго бол ял эдэлж буй хүмүүсийн засарч хүмүүжих гэсэн эрмэлзлийг урамшуулах үйл явдал гэж үзсэн байдаг тул хууль тогтоохдоо энэ агуулгыг багтааж өгөх.

Өршөөлийг гол төлөв гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүдэд ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болоод дайн буюу дайны ажиллагаанд оролцогсод, 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд үзүүлдэг зохицуулалтыг хэвээр хадгалагдах нь зүйтэй юм. Манай улс эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэчлэл найруулсан 2015 оны Эрүүгийн хуульд хөнгөн ба хүнд гэсэн ялын хоёр төрөл байгаа учир зөвхөн хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүмүүсийг өршөөх эсвэл зарим тодорхой төрлийн хүнд гэмт хэрэг үйлдэгчдийг хамааруулах үгүй нь ойлгомжгүй асуудал

үүсч байна. Өмнөх эрүүгийн хуулиудын ялын бодлогод нийгэмд аюултай гэмт хэргүүдийг онц хүнд гэмт хэрэгт багтааж энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцдог байсан нь өнөөгийн эрүүгийн хуулийн хүнд гэмт хэрэгт дээр дурдсан шинжүүд багтаж байгаа учир Өршөөлийн хуульд хэрхэн тусгаж өгөх талаар маш нарийн бодох шаардлага үүсч байна.

Өршөөлөөр суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх механизмтай байх нь чухал байна. Өршөөлийн хууль тогтоомжийн үр нөлөөг судалснаар хууль тогтоогч, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийг судалгаанд суурилсан бодит мэдээлэл, түүнд тулгуурлан гаргасан оновчтой зөвлөмжөөр хангах, өршөөлийн хуулийн хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлох, хуулийн зэрэг, сөрөг талыг харьцуулж харж сөрөг нөлөөллийг бууруулах арга зам болоод бодлогын хувилбарыг тодорхойлох ач холбогдолтой.

ХУУЛЬЧДЫН ЁС ЗҮЙН ҮНЭЛЭМЖ ДЭХ ШИНЖЛЭХ УХААНЫ ЗАРИМ НЭГ ОЙЛГОЛТУУДААС



Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш. Хууль зүйн ухааны магистр Э.Ариунаа



Шихихутуг их сургуулийн Ерөнхий эрдмийн тэнхимийн багш, дэд проф, доктор (Ph.D) Д.Отгончимэг

Товч утга: Аливаа нэг удирдлага, дэг журам, дүрэм нь тодорхой нийгмийн хүрээлэлд ямарваа бие хүн ба хэсэг бүлэг хүмүүс гүйцэтгэж, харин түүгээр дамжин хэрэгждэг тул хүн гэдэг нарийн төвөгтэй бодгалийн мөн чанарт эрт дээр үеэс өнөөг хүртэл судлаачид ихээхэн их анхаарал хандуулсаар ирсэн билээ. Орчин үед хүний хүчин зүйлийг таньж мэдэхгүйгээр шинжлэх ухаан, технологи, цахим ертөнц өндөр хөгжсөн өнөө үед зөв залж чиглүүлэхэд нарийн төвөгтэй болж байна. Учир нь аливаа техник технологи хөгжихийн хирээр сайн муу, ашигтай ашиггүй олон янзын хүчин зүйл урган гарч байгаа учир тэдгээрээс хуульч хүний ёс суртахууны үнэлэмж, үнэт зүйлсийн талаар тодорхой хэмжээгээр дурьдан ёс зүйн тодорхой түүхэн хүрээллийг уг илтгэлд голчлон хэсэгчлэн тусгахыг хичээлээ.

Түлхүүр үг: хуульч, ёс зүй, ёс суртахуун, үнэт зүйлс.

Ёс суртахуун ба ёс зүй, нийгмийн ёс зүйн тогтолцоо ба мэргэжлийн ёс зүйн тогтолцооны тойргуудад хамаарах хязгаарт ёс зүйн үнэт зүйлс, тэдгээрийн хоорондын харилцан уялдаа өнөөдөр үнэ цэнэтэй болж байна. Яагаад гэвэл харилцан ашиг сонирхлын зөрчилдөөн хувь болон мэргэжлийн байгууллага бүрт нэлээдгүй газар авсантай холбоотойгоор нийт ард иргэдэд мэргэжлийн үнэт зүйл, тэдгээрийн ёс зүйн дүрмийн тодорхой мэдлэгтэй болгосноор сая хуульч болоод бусад мэргэжлийн үнэ цэнэ оршино. Иймд ёс зүйн ойлголтыг онолын үүднээс нь авч үзвэл “Ёс зүй” хэмээх ойлголт нь эртний грекийн “Ethos” гэдэг үгнээс гаралтай бөгөөд хамтран амьдрах орон байр, оршин амьдрах газар гэсэн утгыг илэрхийлж байжээ. Хожим энэ ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлийн хэв маяг гэх мэт утга

агуулгаар баяжиж тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлэх болсон байна¹.

Ёс суртахуун ба ёс зүй, нийгмийн ёс зүйн тогтолцоо болоод мэргэжлийн хариуцлагын тогтолцооны тойрог, хүрээ хязгаар, тойргуудад хамаарах үнэт зүйлс нийгмийн харилцаа төлөвшин хөгжихөд зан заншил, уламжлал, улс төр, шашин зэргийг ашиглаж ирсэн.

“Ёс зүй”-н шинжлэх ухаан бол харилцааны тухай, орших ахуйн тухай, зохицон оршихуйн тухай амьдралын утга учрын тухай гүн ухаан бөгөөд ёс зүйг онолын мэдлэгээс ангид биеэ хэрхэн авч явах тухай “практик ухаан”, “ёс зүй бол хүмүүс хоорондын харилцаа, энэ харилцаанаас үүдэн гарах “үүрэг”-ийн тухай шинжлэх ухаан юм² гэж, мөн “хүнд юуг хийх, юунаас татгалзах хэрэгтэйг танихад (сайн, мууг ялгахад) тусалдаг зүйл бол ёс зүй юм³ гэж маш энгийнээр тодорхойлсон байдаг бол Италийн философич Аббаямо гэгч хүн нь “Ёс зүй бол хүний тухай асуултуудын хариу нь байдаг” гэж тодорхой бас товчоор тодорхойлсон байдаг.

Мэдээллийн эрин үед амьдарч буй өнөө цагт цахим ертөнц болон бусад ямар нэг хэлбэрээр мэргэжлийн үнэ цэнийг бууруулах, ёс зүйгүй авир гаргах, өөрийн санаанд багтсан болгоныг хэвлэж нийтлүүлснээр та болон бидний мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүйн хүрээлэлд ихээхэн хор нөлөөллийг учруулдаг билээ.

Ёс зүйн нь нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд хүмүүс хоорондын

харилцаа түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй нийгэм бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааны хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буйгаар тодорхойлогддог бол хуульчийн ёс зүй гэдэг нь хуульчдад олон нийтийн эрх ашиг, үүрэгт холбогдох шийдвэрийг илтгэл найдвартайгаар даатгаж байгаа үйлдлийн хэм хэмжээ, хуульч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд түүний зан үйлд нийгмийн зүгээс тавьж буй ёс суртахууны тусгай шаардлага гэж ойлгож болно.

Иймд: “Албан ы болон мэргэжлийн ёс зүй нь” гэж бусдын нэрийн өмнөөс, тэдний эрх ашгийг хангах үйл ажиллагаагаа явуулахаар эрх /эрх мэдэл/ олж авсан этгээд, эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлын дээгүүр тавьж, эл зан суртлаа албаны /мэргэжлийн/ үйл ажиллагаандаа мөрдлөгө болгохыг ойлгоно” хэмээн тодорхойлсон байна.

Тэгвэл “ёс зүй”-н тойргийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бол ёс зүйн үнэт зүйлсүүд орно. Үүнд:

- ▶ Нийгмийн ёс зүйн үнэт зүйлс
 - ✓ Мэдлэг
 - ✓ Соёл
 - ✓ Туршлага гэж хуваан үздэг⁵.
Лавшруулж тодруулбал:

Хувь хүний ёс зүйн үнэт зүйлс гэдэг нь нийгэм сайн гэж хүлээж авсан , сайн сайхан үр дүн гаргах, бусад хүмүүс дагаж дууриавал зохих биеэ авч явах

¹ Хуульчийн ёс зүй /Гарян авлага/ УБ.2013. х-22

² П.Гольбах 1723-1789

³ Эргийн гүн ухаантан Аристотелийн сургаальд

⁴ “Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох нэлгүүр үндэслэл” Х.Тэмүүжин илтгэлээс

⁵ Д.Отгончимэг “Хүний хөгжил харилцааны ёс зүй” УБ.2020. х-55-56

байдал, бодол санаа, зан чанар юм¹. Тухайлбал: илтгэл даах чадвар, чин үнэнч харилцаа, зарчимч найдвартай байдал, аливаад чин сэтгэлээсээ хандах, нууцыг хадгалах, эелдэг боловсон чанар, ёс журам, хүлцэл, бие даасан байдал, чадварлаг, тэсвэртэй байх, хэрсүү ухаан, ил тод, алагчлахгүй байх, халамжтай хандах, өгөөмөр сэтгэлтэй байх гэх мэт үнэт зүйлс нь суурь ухагдахуун болдог.

Дээрх тодорхойлолтууд нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний ч эх сурвалж болдог тул хуульчид ёс зүйн дүрэм тусгагдаагүй үнэт зүйлсийг ч хувь хүнийхээ хувьд мөрдөх нь зүйн хэрэг.

“Эрх зүй ба ёс зүйн харилцан уялдааны тухай ойлголт” нь: ёс зүйн суртахуун бол эрх зүйгээс өмнө үүсэж нийгмийн харилцааг зохицуулж ирсэн ба “зан үйлээр дамжин амьдрал ахуйд нэвтэрч, бүрэлдэн тогтсон хувь хүний зүгээс нийгэм болон олон түмэнтэй харилцах, тэдний өмнө хариуцлага хүлээх, биеэ авч явах зэрэг **“олон талын харилцааг зохицуулсан хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ”** буюу /бичигдээгүй хууль/ юм.

Нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын түвшин, амьдралын хэв маяг, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон хүчин зүйлсээр тодорхойлогддог бол ЭРХ ЗҮЙ гэж “төрөөс тогтоосон ба түүний албадлагын хүчээр хангагдан хэрэгжих, нийтээр заавал дагаж мөрдөх (позитив эрх зүй), эсхүл төр ба хуулиас дээргүүр оршин байдаг байгаль, хүний оюун ухаан, зайлшгүй шаардлагаас үүдэгдэн гардаг (жам ёсны эрх зүй) нийгмийн хэм хэмжээний (зан үйлийн журмын)

тогтолцоо”-г хэлдэг. Тухайлбал: Монголын эртний улсуудаас улбаатай боловч, Чингис хааны үед хэрхсэнийг нэг, хоёр жишээ баримтаар өгүүлье.

Чингис хаан Найманыг дайлж байх үед дүү Хасар нь нэгэн сонин хүнийг олзолжээ. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцангийн “Алтан товч”-ид: “...Таян ханы аймгаас нэгэн хүн дутаав. Хасар түүнийг амьдаар нь барь хэмээсэнд Бат гүйцээд амьдаар барин ирэв. Үзвээс өвөрт нэгэн тамга буй. Хасар өгүүллүүн: “Танай олон аймаг цэрэг цөм манд болж атал, чи энэ юмыг өвөртөлж хааш одмуй?”. Тэр хүн өгүүллүүн: “Миний бие тушаалын газраа үхтэл сахин аж. Энэ тамгыг хуучин эзний гарт хүргэсүгэй хэмээсэн билээ. Хишиг үгүй болж баригдав”. Хасар өгүүллүүн: “Чи аль овгийн хүн, ямар тушаалд агсан буй?”. Тэр өгүүллүүн: “Би язгуур Уйгар газрын хүн, нэр Тататунга. Миний эзэн энэ тамгыг надад тушааж эд, идшийг гаргах ба оруулах явдлыг надад тушаасан бүлгээ”. Бас асууруун: “Энэ тамгыг юунд хэрэглэмүй?”. Тататунга өгүүллүүн: “Сайн хүнийг сонгох, зарлиг бичиг явуулах, аливаа үйлд хэрэглэмүй”. Хасар сайшааж, шударга элбэрэлт хүн хэмээн Тэмүжинд мэдүүлж, аливаа бичиг явахад хэрэглэхээр тэр тамгыг мөнхүү Тататунга-д тушаав. Хасар Тататунга-г багш барин, бичиг, хууль, цэргийн бодлого тэргүүтэн олон зүйл бичиг утгыг заалгаж, удалгүй сурав”² хэмээсэн байна. Үүнээс үзэхэд, Их Монгол Улсын үеэс багш, шавийн барилдлага төрийн бодлогын зиндаанд тавьж, анхааралдаа

¹ Хуулийн ёс зүй /Гарын авлага/ УБ.2013. х-28

² Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан. Алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ. 2006.Т.71-72.

авч эхэлсэн гэж үзэж болохоор байна.

Монголын Юань улсыг байгуулаад Хубилай хаан бурхны шашныг Монгол газраа хоёронтоо дэлгэрүүлж, төрийн үзэл суртлын хэмжээнд өргөмжлөн, Төвөдийн Пагва Лодойжалцанг (1235-1280 он) Улсын багш болгожээ. Энэхүү ламтан төрийн хоёр ёсыг үндэслэхэд оролцож, дөрвөлжин үсэг зохион, эл үсгийг их гүрэн даяар дэлгэрүүлэхэд хичээнгүйлэн зүтгэж байв. Мөн Монголын бичгийн их хүн Чойжи-Одсэр Юань гүрний Өлзийт хааны үе (1295-1302)-д Улсын багшаар өргөмжлөгдөн, монгол хэл шинжлэлийн гайхамшигт бүтээл, “Зүрхэн толт”-оо зохиож, олон судар ном орчуулж, шавь нартаа билэг эрдмээ харамгүй түгээж байжээ. Энэ үеэс багшийг илүү хүндлэн дээдэлж, харц ардаас хаан дээдэс хүртэл төрийн хүн, багшийг шүтэх ёс нилээдгүй гүнзгийрч байсан байна.

Эрх зүй, ёс суртахуун хоёр нийгмийн харилцааг зохицуулахад нийтлэг шинжтэй ч эрх зүй нь төрөөс тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрхэн хэрэгжиж буйг дээр жишээнээс бэлхнээ харж болно. Гэхдээ заримдаа зөрчилдөх тохиолдолд төрийн албадлага хэрэглэн, хуулийн цээрлэл хүлээлгэдэг байв. “Үндсэндээ ёс суртахуун нь олон нийтийн сэтгэл зүйгээр илэрч тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгждэг”¹.

Нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын түвшин, амьдралын хэв маяг, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон олон хүчин зүйлүүдээр тодорхойлогддог

бол “эрх зүй” гэж төрөөс тогтоосон ба албадлагын хүчээр хангагдан хэрэгжих, нийтээр заавал даган мөрдөх (позитив эрх зүй), эсхүл төр ба хуулиас дээгүүр оршин байдаг байгаль, хүний оюун ухаан, зайлшгүй шаардлагаас үүдэгдэн гардаг (жам ёсны эрх зүй)² нийгмийг бүхэлд нь хамрах хэм хэмжээний зан үйлийн тогтолцоог хэлдэг.

Ёс зүй нь ёс суртахууныг судалдаг ухаан. “Ёс зүй бол итгүүлж үнэмшүүлэх гүн ухаан” гэж И.Кант, “Ёс зүй гэдэг нь хүн юу хийх, юунаас татгалзах ёстойг судалдаг ухааны нэр” хэмээн ёс зүйг үндэслэгч гэгддэг Аристотель хэлсэн нь бий. Ёс суртахуун нь ёс зүйн ухааны судлагдахуун, хүнд байх учиртай, төлөвшүүлэх ёстой сайн сайхан чанаруудын нийлбэр цогц. Хүнийг судалдаг шинжлэх ухаан хэд хэд байдаг ч хүн өөрийгөө танин мэдэх замаар хөгжин дэвших, хүмүүжин төлөвших, хүн шиг хүн болох, хүн байхад туслах зорилготой ганц ухаан нь ёс зүй юм³. Ёс зүй нь судлах зүйлээ онолын хийгээд практик талаас нь авч үзэж, шийдвэрлэж байдаг. Үүний учир шалтгаан нь ёс суртахууны шинжтэй асуудал хүний амьдралын бүхий л салбарт үүсэн бий болж байдаг оршдог. Ёс зүй нь нийгэм-хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой⁴. Ёс суртахуун улс төрийн харилцаанд хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаанд шударга ба

² Хуульчийн ёс зүй /гарын авлага/. УБ. 2013. х—24

³ [ps://www.google.mn/search?ei=tc5eX54306L5BraM-tQAF&q](https://www.google.mn/search?ei=tc5eX54306L5BraM-tQAF&q)

⁴ Д.Отгончимэг. “Монголын ардчилалд улс төрийн боловсролын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол” /Диссертацийн ажил. УБ.2017. х-68

¹ Д.Отгончимэг. Соёлын тухай ойлголт /гарын авлага/ УБ.2016. х-13

шударга бус, оюун санааны харилцаанд үнэнч ба үнэнч бус чанараар илэрч байдаг. Ёс суртахуун нь хүмүүсийн зайлшгүй баримталж хэрэгжүүлэх зарчим, дагаж мөрдөх зүй зохистой хэм хэмжээ юм. Ёс суртахуунлаг байна гэдэг нь зөвийг сурах, түүнийгээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа байнга мөрдөж хэвшүүлнэ гэсэн үг.

Түүхээс эргэн сөхвөл ёс зүйн хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад янз бүрийн үзэл урсгалуудыг өөртөө багтааж хөгжиж ирсэн түүхтэй байдаг. Жишээ нь: Эртний Грекийн философийг бүхэлдээ ёс зүйн сургууль байсан гэж үздэг бөгөөд ёс зүйн сургаалийн анхны том төлөөлөгч Сократын үзлээр “амьдралын утга учир бол жаргал мөн” бөгөөд (ийм үзлийг эвдемонизм гэх) “жаргал бол сайн үйлтэй гарцаагүй холбоотой гэж үйлэнд уран, үгэнд цэцэн, эрхэлхэг зориг, төлөв зан, шударга ёс”-ыг онцолсон байдаг бол Эртний Грекийн “ёс зүйн оргил” Аристотелийн хувьд “этик бол зан суртахууны тухай практик шинжлэх ухаан мөн бөгөөд этикийн гол зорилго бол яавал сайн үйл бүхий байхыг хүмүүст сургахад оршино” гэж тодорхойлсон байдаг билээ.

Платоны “хүний сэтгэлийн элементийн тухай үзэл санаа нь хүн, хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, нөлөө, гүйцэтгэх үүргийг тодорхойлох үндэс, тодруулбал нийгмийн дотор нь анги бүлэг, давхаргад хуваан ангилах суурь үндэс гэж үзэж байсан”¹. Тэрээр мөн “шилдэг улс төр” нь дотроо хамгаалагчид (удирдагч), цэрэг эрс, эгэл хүмүүс гэсэн гурван хэсэгт хуваагддаг.

Төр, улсыг социал бүтцээр нь ингэж хуваах нь шилдэг улс төрийн хэв маяг, эрх зүй тогтолтойгоор оршихуйн жам ёсны шаардлагатай холбоотой. Учир нь шилдэг төрийн удирдан жолоодохын тулд удирдагч, цэцэн ухаант бүлэг, төрийн болон удирдагч нарын аюулгүй байдал, амьдрах нөхцөлийг сахиж хамгаалахын тулд цэрэг эрс, амьдралд зайлшгүй хэрэгцээтэй хоол хүнс, эд зүйлс, материал баялгийг үйлдвэрлэн бүтээхийн тулд эгэл жирийн ажилчин, гар учрууд, үйлдвэрлэгчид байх ёстой. Тэдгээрт онцолсон бодгаль хүний сэтгэлийн тодорхой шинжүүд зохицон тухайн үедээ нийцсэн эрх, эрх зүйн хууль тогтоомжууд байх учиртай. Тухайлбал: удирдагч хүмүүст байх ёстой дүрэм журамд “оюунлаг, сэтгэн бодох шинж чанар, цэрэг эрст бол зориг, сонор сэрэмж, удирдагчдаа үнэнч, дайчин зан чанар, эгэл хүмүүст шунал хүсэл байвч тэдэнд хүсэл ханамжийн сахилга бат, сэтгэлийн эмх журамт байдал, хөдөлмөрч, ажил хэрэгч зан чанар илүүтэй давамгайлж байдаг гэж тодорхойлсноос үзвэл аливаа мэргэжил, тэр дундаа хуульч, эрх зүйч мэргэжилд хувь хүний эток, хариуцлагын тухай бат тогтсон дүрэм журмыг мөрддөг байсан нь түүхээс бэлхнээ харагдаж байна. “Ёс суртахуун нь туйлын утгаар ойлгох явдал нийгмийн сэтгэл зүйлд ноёрхох байр суурьтай байдаг бол ёс суртахуун нь өөрөө харьцангуй хуульд захирагддаг”² билээ.

Иймд “ёс зүй ба эрх зүйн хоёрын харилцан ойлголт”-ын тухай товчлон дүгнэн авч үзвэл: “ёс суртахуун” нь

¹ Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн философи. УБ.2015.х-163

Ц.Батбаяр. “Ёс зүй /сурах бичиг/ УБ.2007. х-82

"эрх зүй"-гээс өмнө үүсэж нийгмийн харилцааг зохицуулж ирсэн байдаг. Энэ нь тодорхой хэмжээгээр амьдрал дээр зан үйлүүдээр дамжин амьдрал ахуйд нэвтэрч, бүрэлдэн тогтсон хувь хүний зүгээс нийгэм болон олон түмэнтэй ямар нэгэн байдлаар харилцах, тэдний өмнө хариуцлага хүлээх, биеэ авч яах зэрэг "олон олон талын харилцааг зохицуулсан хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ" буюу "бичигдээгүй хууль" байсан байна. Өнөөдөр ч дээрх сайхан уламжлал нь хуульчдын орчин, нийгмийн хүрээлэлд үнэ цэнээ алдаагүй хадгалагдсаар, бас улам боловсронгуй болсоор байна.

Ном зүй

1. Хуульчийн ёс зүй /Гарын авлага/ УБ.2013
2. П.Гольбах 1723-1789
3. Эртний гүн ухаантан Аристотелийн сургааль-д
4. "Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур үндэслэл" Х.Тэмүүжины илтгэлээс
5. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан. Алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ. 2006
6. Д.Отгончимэг. Соёлын тухай ойлголт /гарын авлага/ УБ.2016
7. [ps://www.google.mn/search?ei=tc5eX54306L5BraMtOAF&q](https://www.google.mn/search?ei=tc5eX54306L5BraMtOAF&q)
8. Д.Отгончимэг. "Монголын ардчилалд улс төрийн боловсролын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол" /Диссертацийн ажил. УБ.2017
9. П. Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн философи. УБ.2015
10. Ц.Багбаяр. "Ёс зүй /сурах бичиг/ УБ.2007.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛД ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ҮР НӨЛӨӨ

/Хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн асуудал/



Шихихутуг их сургуулийн хууль зүйн ухааны Докторант Ц.Амарсанаа

*Олж харж буй маань биш,
хэрхэн харж байна вэ
гэдэг маань л хавьгүй чухал.
Монтэнь*

ОРШИЛ

Хувь хүний генийн сан нэн баялаг бөгөөд хэчнээн олон хүүхэдтэй болно төдий чинээ олон хувилбараар генийн хоршлууд үр удамдаа аль болох олон удаа дамжих боломж нээгддэг. Гэвч бодит амьдрал дээр хүн бүр өөрийн генийн сангаас тодорхой хувийг дамжуулдаг. Генийн сангаас дараачийн үе удамд дамжиж буй тодорхой хэсгийг “удмын сан” хэмээн нэрлэнэ.

Хэтэрхий цөөнх хүн амтай манай улсын хувьд үндэстний генийн сангаасаа үр удамдаа дамжуулах удмын сангийн юугаар ч үл орлуулах асар их баялаг нөөцийг алдаж буй хэрэг гэдэгт удам зүй, биологийн эрдэмтэд санал нэгддэг байна.

Хувь хүний эцэг эхийн генийн сангаас өвлөн авсан удмын сан бол түүний оюун ухаан, бие бялдрын хөгжил, өвчин эсэргүүцэх, урт наслах чадвар, байгаль, нийгмийн юмс үзэгдлийн мөн чанарыг танин ойлгох, өөрийн авьяас билэг, ур чадвараа нээн илрүүлж, насан туршийн амьдралаа тэтгэх, улс үндэстнийхээ хөгжилд хувь нэмэр оруулахуйц ажил мэргэжлээ зөв онож сонгоход нь тулгуур хөрс болдог

ГАРЧИГ

Оршил

1. Хүний удмын сан буюу генетикийн тухай ойлголт, тулгамдаж буй асуудал.
2. Монгол улсын хүний удмын сангийн аюулгүй байдлын талаарх хууль, тогтоомжоор зохицуулсан байдал.
3. Олон улсад хүний удмын сан, генетикийн талаарх хуульчилсан байдал.
/Харьцуулсан судалгаа/

Дүгнэлт

Ном зүй

ажээ.¹

Монгол Улсын хувьд хүн амын удмын сан буюу генетикийн талаар зохицуулсан төрийн бодлогын баримт бичиг байхгүй байгаа нь цус ойртолтыг бий болгох аюулыг дагуулж байгаа бөгөөд энэ талаар төрөөс зайлшгүй бодлого боловсруулах, эрх зүйн орчин бий болгох хэрэгцээ шаардлага тулгарсан.

Үүний дагуу дээрх судалгааг хийх болсон бөгөөд судалгааны хүрээнд дараах асуудлуудыг хамрах хүрээнд хөндөж тусгасан болно. үүнд:

Хүний удмын сан буюу генетикийн тухай ойлголт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын хүний удмын сангийн аюулгүй байдлын талаарх хууль, тогтоомжоор зохицуулсан байдал

Олон улсад хүний удмын сан генетикийн талаарх хуульчилсан байдал /харьцуулсан судалгаа/ зэрэг юм. Энэхүү судалгааг баримт бичигт дүн шинжилгээ хийх болон харьцуулалтын арга ашигласан болно.

Энэ талаар Монгол Улсад Доктор Ж.Батсуурь, Э.Энхмаа нар дорвитой судалгаа хийсэн байна. Мөн удмын сангийн цус ойртолтоос үүсэх сөрөг үр дагавар болох сэтгэцийн эмгэг, хам шинжийн тархалтын талаарх судалгааг Ш.Дорждамба, С.Бямбасүрэн нар 1984-1992 онуудад хийсэн. Харин 1990 онд Доктор, профессор Л.Наранцэнгэл ерөнхий боловсролын сурагч нарын дунд цус ойртолтоос үүсэх өвчлөлийн

тархалтын талаарх судалгааг хийсэн байна. Энэхүү судалгааны талаар хууль зүйн үүднээс Гэр бүлийн эрх зүйн хүрээнд хийсэн судалгаа байгааг эс тооцвол өөр нарийвчлан хийгдсэн хууль зүйн судалгаа одоогоор байхгүй байна.

Энэхүү судалгааны илтгэлийн үр дүнд Монгол Улсад хэрэгжиж буй хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх, мөн хууль тогтоомжийн хэрэгжилт нь практикт хэрхэн хэрэгжиж буйг тогтоох болон олон улсын авч хэрэгжүүлж буй хууль зүйн арга хэмжээ, туршлагыг өөрийн улсад хэрэгжүүлэх боломжийн талаар тусгах зорилготой юм.

1. ХҮНИЙ УДМЫН САН БУЮУ ГЕНЕТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Ерөнхий ойлголт: Хүн төрөлхтөн гарвал зүйн ухаан буюу генетикийн шинжлэх ухааны үүсч хөгжсөн эхлэлийг 1900-аад онтой холбон үздэг бол Монголчууд түүнээс даруй 700 гаруй жилийн өмнө энэхүү ухааны талаар гүнзгий мэдлэгтэй байсныг түүхийн сурвалжууд гэрчилдэг. Тухайлбал, Их Чингис хаан: “Есөн үеэ мэдэхгүй бол зэрлэг хүн” хэмээн айлджээ. Перс түүхч Рашид-Ад-Дин: “...Монголчуудын заншил бол өвөг дээдсийнхээ удам угсааг санаж, төрсөн үр хүүхдүүддээ удам угсаагаа зааж сургадаг. Ийнхүү тэд уг язгуурынхаа тухай үгсийг хүмүүсийн хүртээл болгодог учраас тэдний дунд яс, угсаа, овог, аймгаа мэдэхгүй хүн ч үгүй бөлгөө”, Д.Гонгор: “Монголчууд ураг төрлийн хүрээний есөн үе өнгөрмөгц тэр ураг удмынхан нийтээр цугларч ургийн мод – түүхэн дуудан сонсоцгоож

¹ “Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа”. Парламентын судалгааны хүрээлэн, УБ., 2021 он 8 дэх тал.

тусгай баяр ёслол үйлдэн, ураг төрлийн холбоогоо хамааралгүй болсноо зарладаг байжээ” хэмээн бичиж байжээ.

Аливаа амьд бие махбодыг эцэг, эхийн шинж тэмдэг үр удамдаа хэрхэн дамжиж удамшдаг зүй тогтлыг судалдаг ухааныг “удамшил зүй”¹ гэх ба хүний генетикийн шинжлэх ухаан юм. Энэхүү шинжлэх ухааны хүрээнд дараах ойлголтуудыг дурдъя.

Ген гэдэг нь хүний удмын мэдээллийг хэдэн үе дамжуулан авч явдаг “ертөнц” юм. Өөрөө хэлбэл, ген амьд организмын удамшлын мэдээллийг агуулсан молекул нэгж буюу материаллаг хэсэг болдог. Хүний бие махбодыг бүтээгч эсийн дотор хромосом хэмээх биенцэр байдаг. Энэ биенцэрийн дотор ген орших бөгөөд ген үеэс үед үр хүүхдэд дамжин хадгалагдана. Эцэг эх хоёроос 50, 50 хувийн ген буюу адилхан хос 23 хромосомыг хүүхэд энэ тэнцүүгээр хадгалан төрөх бөгөөд хүний амьдралын үйл ажиллагаа нь түүний генийн мэдээллийн сангийн шинж чанарт тулгуурлан явагддаг.

Тухайлбал, хүний нүдний өнгө, царай зүс, зан төрх, явдал суудал, оюун ухаан зэргийг хадгалан дамжуулах ген хэдэн зуун жилийн өмнөх өндөр өвөг², эмгээс эхлэн бөлөнцөр³ хүртэл өөрчлөгдөхгүй хадгалагдаж байдаг.

Хувь хүний генийн сан нэн баялаг бөгөөд хэчнээн олон үр төрүүлнэ түүний үрийн санд төдий чинээ үүсдэг олон

хувилбараар үүсдэг генийн хоршлууд үр удамдаа аль болох олон удаа дамжих боломж нээгддэг⁴. Генийн сангаас дараач үе удамд дамжиж буй тодорхой хэсгийг “удмын сан”⁵ хэмээн нэрлэнэ.⁶

Тулгамдаж буй асуудал:

Статистикийн Үндэсний хорооны нэгдсэн мэдээллийн сангийн судалгаагаар Монгол Улс 2019 оны байдлаар 3,296,866⁷ хүн амтай байна. Дэлхийн 195 улсын хүн амын тоогоор⁸ манай улс 135 байрт орсон байна⁹. Энэ тоон үзүүлэлт бол манай улс хэтэрхий цөөн хүн амтай гэх дүгнэлтэд хүрч байна. Үүнээс үүдэн цус ойртох¹⁰ эрсдэл Монгол Улсад бодитоор бий болж байна.

Цус ойртолтоос гарах удамшлын өвчний талаар авч үзвэл: эхийн хэвлийд үр тогтоход эхээс нэг ген, эцгээс нэг ген авч хослон нийлдэг. Эрүүл хүний генийн санд ч удамших өвчин үүсгэх 5-10 ген байдаг. Хоёр эмгэг ген эвсэн нийлбэл удамшлын өвчтэй хүүхэд төрдөг. Өөрөөр

⁴ Хавсралт № 1. Дараа үед өншүүлэх удмын сангийн хувь. Хүснэгтээс үзнэ үү.

⁵ Монгол хэлний их тайлбар толь 2016 он. “Тухайн хүний өвөг дээдэс, эцэг эхийн удамтай холбоотой бүх мэдээллийг багтаасан мэдээллийн сан”

⁶ Ж.Батсуурь, Э.Энхмаа. “Монгол Улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар”. УБ., 2010 он 40 дахь тал.

⁷ https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT-NSO_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect= 1&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect= 1&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2019&viewtype=table

⁸ Хавсралт № 2. “Дэлхийн бүрэн эрхт 195 улсын хүн амын тоо” судалгааг харна уу.

⁹ <https://mn.wikipedia.org/wiki/%D0%A3%D0%B-%D1%81-%D0%BE%D1%80%D0%B-D%D1%83%D1%83%D0%B4%D1%8B%D0%B-D%D1%85%D2%AF%D0%BD-%D0%B0%D0%BE-C%D1%8B%D0%BD-%D1%82%D0%BE%D0%BE>

¹⁰ Нэг эцэг эхээ гаралгай, тэдгээртэй болон өөр хоорондоо ураг холбож гэрлэхийг хүн амын генетикийн ухаанд “цус ойртоон гэрлэлт” буюу товчоор “цус ойртолт” хэмээн нэрлэдэг.

¹ Ж.Батсуурь, Э.Энхмаа. “Монгол Улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар”. УБ., 2010 он 38 дахь тал.

² Монгол хэлний их тайлбар толь 2016 он. “Тав дахь дээд үс, хуланц овгийн эцэг”

³ Монгол хэлний их тайлбар толь 2016 он. “Эгч дүүгийн хүүхэд”

хэлбэл, эрүүл хүн бүрт байх удамших өвчин үүсгэгч 5-10 төрлийн ген нь зөвхөн өөртэйгөө ижил гентэй нийлсэн тохиолдолд өвчтэй хүүхэд төрдөг байна.¹ Цусан төрлийн хүмүүс гэр бүл болоход эмгэг генүүд хоорондоо хослон нийлдгийг үр хүүхэд нь төрөлхийн эрхтэн тогтолцооны гажиг, сэтгэц болон аягийн эмгэг, ой тогтоох чадвар муу, оюуны хомсдол, дархлааны тогтолцоо болон бодисын солилцооны эмгэг зэрэг удамшлын өвчтэй төрдөг. Мөн хүүхдийн бие бялдрын эрүүл чийрэг өсөн бойжих чадвар, өсөлт удааширдаг².

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага жил бүр гаргадаг тайлан мэдээнээс үзвэл дэлхий дээр 4 хүн тутмын 1 нь амьдралынхаа хугацаанд сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэдэг тэргүүлэх 10 өвчний 5 дугаарт сэтгэцийн болон зан үйлийн эмгэг оржээ. Дэлхий дээрх 450 сая орчим хүн сэтгэц болон зан үйлийн эмгэгээр шаналж байгаа бөгөөд 2005 онд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 10%-ийг энэхүү эмгэг эзэлж басан бол 2020 он гэхэд энэ тоо 15% болж нэмэгдэх хандлагатай байгааг тэмдэглэжээ³.

ДЭМБ-ын захиалгаар 2013 онд АНУ-ын Вашингтоны их сургуулийн Нийтийн эрүүл мэндийн судалгааны төвөөс дэлхийн 188 улс орныг хамруулж 1990-2014 он хүртэлх нийт 23 жилийн

мэдээлэлд системчилсэн дүн шинжилгээ хийсэн судалгааны дүнгээс үзвэл 1990 онд оюуны хомсдолтой хүн 118,2 сая, 2013 онд 154 сая болж өсөж, тэдний 104,9 сая хүн нь оюуны хоцрогдолтой /IQ70-84/, оюуны хөнгөн хомсдолтой /IQ 50-69/, 49,1 сая хүн оюуны дунд болон хүнд, гүнзгий түвшний хомсдолтой байсан бөгөөд 61,5% нь шалтгаан тодорхойгүй байна гэж мэдээлжээ⁴.

Манай улсад 1984-1992 онд хийсэн сэтгэцийн өвчний тархалтын түүвэр судалгаагаар сэтгэцийн өвчин 1000 хүн амд 15,5+0,2, үүнээс оюуны хомсдол хүн амын 1-3%-ийг, өөрөөр хэлбэл сэтгэцийн нийт эмгэгийн 49-51%-ийг эзэлж байв. Мөн 1991-1995 онд хийгдсэн тархалтын судалгаанд сэтгэцийн өвчний тархалт 1000 хүн амд 12,65+0,22 /хүн амын 1,26%/ байжээ⁵.

Харин эрүүл мэндийн хөгжлийн төвийн жил бүр гаргадаг статистик, мэдээллийн тайлангаас үзвэл манай улсад сэтгэц болон зан үйлийн эмгэг бүртгэгдсэн нийт тохиолдолд 2000 онд 10.000 хүн тутамд 77,4, 2017 онд 112,3 болсон байна⁶.

Судлаач Л.Наранцэнгэлийн 1990 онд хийсэн ЕБС-д суурилан 1547 хүүхдийг хамруулж хийсэн судалгаанд нийт хүүхдийн 1,3% буюу 1000 хүүхэд

¹ Хавералт № 3. Жирэмсэн эхийн урагт хийгдсэн хромосомын өвчин илрүүлэх шинжилгээний дүн. Хүснэгтээс үзвэл үү.

² "Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа". Парламентын судалгааны хүрээлэн. УБ., 2021 он 7 дахь тал.

³ "Сэтгэцийн эрүүл мэнд-Шинэ өйлөлт шинэ хандлага". Дэлхийн Эрүүл мэндийн тайлан-2011.

⁴ Цус ойртолт ба оюуны хомсдол Монгол улсын хэмжээнд/судалгааны тайлан/. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгаа. УБ., 2020 он 6 дахь тал.

⁵ Ш.Дорждамба, С.Бямбасүрэн, Н.Орёл, Л.Эрэнбаяр. "Хорьдугаар зууны үеийн Монгол Улс дахь сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал". УБ., 1996

⁶ Төрөл ойртолт, түүний хүн амд эзлэх зохицот харьцааны алдагдал, сэтгэл мэдрэлийн өвчтэй, оюуны хомсдолтой хүмүүсийн динамик мэдээ/судалгааны тайлан/.

тутам 13,2 нь оюуны хомсдолтой хүүхэд оношлогдож тэдний 41,7% нь удмын шалтгаантай байжээ.¹

Дэлхийд оюуны хомсдолтойг 1000 хүнд 10 байхад хэвийн гэж үздэг. Тэгвэл оюуны хомсдолтой хүн монголд:

- 1986 онд 1000 хүн тутамд 8,4 хүн,
- 1997 онд 1000 хүн тутамд 11-12 хүн,
- одоо 1000 хүн тутамд 13 байгаа бөгөөд 10 жилд 3,1 хүнээр нэмэгдэж байна
- Монголын удамшлын эмгэгтэй хүмүүсээс:
- Хөнгөн хомсдол дүйнгэ – 72,3%
- Илэрхий мэдэгдэхүйц тэнэг – 19,2%
- Маанаг – 6%
- Усан тэнэг – 0,6%

Оюуны хомсдол хэт өндөр оронд 1000 хүнд 30 хүн байдаг бол манай зарим сум багт 1000 хүнд 30-аас дээш гарсан байна. Оюуны хомсдолын судалгаагаар:

- Дорнодын Матад суманд 1000 хүнд 47,1, Халх гол суманд 35,5
- Өмнөговь Манлай суманд 22
- Дундговийн Адаацагт 19,7
- Баянхонгор Баянлигт 16,2 хүн оюуны хомсдолтой байна².

Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотод 2005-2009 онд шинээр төрсөн хүүхдүүдийн дунд

төрөлхийн хөгжлийн гажигтай³ 689 хүүхэд байжээ. Гэтэл 2015 он, 2016 оны эхний хагас жил буюу нэг жил 6 сарын хугацаанд Монгол Улсад төрөлхийн хөгжлийн гажигтай нийт 1280 хүүхэд төрсөн ба энэ нь шинээр мэндэлсэн хүүхдүүдийн 0,8 хувийг эзэлж байгаагаас үзвэл төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхдийн тоо эрс нэмэгдэж байна⁴.

ДЭМБ-ын баталсан өвчний олон улсын Х ангилал нь хүн төрөлхтний өвдөж буй бүх өвчнийг 19 бүлэг, 202 хэсэгт ангилж хуваасан байдаг. Монгол Улс 1996 оноос эхлэн өвчний олон улсын Х ангиллын дагуу хүн амын өвчлөлийн статистик мэдээллийг гаргадаг болсон. Энэхүү ангилалд багтсан 19 бүлэг өвчин, 32 төрлийн хорт хавдраар монгол хүн өвдөхөд цус ойртолтын өнөөгийн түвшин ноцтой нөлөөлж байгаа нь шинжлэх ухааны судалгаагаар хөдөлбөргүй тогтоогдсон юм⁵.

Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт хийх чиглэлийн дагуу 2015 онд Хүн судлалын төвийн үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн газартай нэгтгэснээс хойш хүн судлалын асуудал хариуцсан чиглэлийн төрийн бодлого орхигдсон байна.

¹ Цус ойртолт ба оюуны хомсдол Монгол улсын хэмжээнд/судалгааны тайлан/Үндэсний аюулгүй байшлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгаа.УБ, 2020 он 11 дэх тал.

² “Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа”. Парламентын судалгааны хүрээлэн/захиалгат судалгаа/УБ, 2021 он 9 дэх тал.

³ Төрөлхийн хөгжлийн гажигийг хэлбэрээр нь авч үзвэл: *Зүрхний гажиг, Уруул сэтгэхий, Уруул, таснай хоёр сэтгэхий, Зөөлөн таснай, хүүхэн хэл хоёр сэтгэхий, Зөөлөн таснайгүй, Хошиого битүү, Хэсийн урд хана хөгжөөгүй, Тархины усжилт, Нүүдэснэг эвэрхий, Олон эрхэн тогтолцооны гажиг* зэрэг 10 төрлийн гажиг шлэрсэн байдаг

⁴ Хүн амын удмын санг цус ойртолтоос хамгаалах тухай хуулийн төслийн танилгат судалгаа. 2017 он.

⁵ Хавсралт № 4 Цус ойртолт ба өвчлөлийн шүтэлгээг хамгарал үзэг үү.

2. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ УДМЫН САНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ, ТОГТООМЖООР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ.

Анх хүний удмын сангийн аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжоор зохицуулагдаагүй зөвхөн уламжлал, соёлын түвшинд хэрэгжүүлж байсан Угийн бичиг хөтөлдөг байсан бөгөөд 1925 онд Монгол Улсын Засгийн Газрын нууц тогтоол гарч монгол хүн овгоо хэрэглэх, угийн бичгээ хөтлөхийг хорьсон төрийн бодлогын баримт бичиг гарсан байдаг.

Үүнээс хойш БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлигаар “БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл”¹ баталсан. Уг зарлигийн хавсралтад “Хүн амын нөхөн үржихүйтэй нийгмийн үйлдвэрлэлийг уялдуулан зохицуулах, хүн амын жилийн дундаж өсөлтийн хэмжээг бууруулахгүй байх, хүн амын бүтэц, харьцааг зөв тогтоох, монгол хүний удмын санг цэвэр ариунаар хадгалах, гэр бүл бүрдэн бэхжих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг төрийн бодлого болгон явуулна”, “Хүний удмын санг цэвэр ариун байлгахыг эрхэмд үзэж, цус ойртохос сэргийлэх гол хэрэглүүр “Угийн бичиг”-ийг айл өрх бүрт хөтлүүлж, хэвшүүлэх, иргэдийн овгийг сэргээн тогтоох явдлыг нэн чухалд тооцно.

Мөн “Удамшлын өвчин, бие эрхтний согог, тахир дутуугаас сэргийлэх зорилгоор гэр бүл-эмнэлэг-удамшлын зөвлөгөө өгөх газруудыг

хот, аймгийн түвшинд зохион байгуулах, ургийн элдэв өвчнийг эхийн хэвлийд оношлон сэргийлэх удамшил зүй, биохимийн орчин үеийн шинжилгээний аргыг өргөн хэрэглэнэ” гэж тус тус заасан байна.

1997 онд Засгийн газраас Угийн бичиг хөтлөх журам баталсан байдаг. 2007 онд уг журмыг шинэчлэн баталсан. Энэ талаар Соёлын тухай хуульд соёлын үнэт зүйл гэдэгт угийн бичгийг хамруулахаар тусгасан ба иргэний соёлын талаарх үүрэг² хэмээсэн. Мөн Гэр бүлийн тухай хуульд угийн бичиг хөтлөх нь гэрлэгчдийн үүрэг³ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас 1996 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого”-ыг хэрэгжүүлж ирсэн ба 2004 оны 21 тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”⁴ батлагдсанаар тус тогтоол хүчингүй болсонд тооцсон.

2004 оны тогтоолд “1.1.1. Хүүхдийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эсэн мэнд, эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж 20-

² Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3г гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдэлж хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх: Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/454>

³ Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3. Гэрлэгчид нь бие биедээ үнэмч байх, хүүхдээ оёгон хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүл шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зорчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг авч хүлээнэ.

⁴ Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай. 2004 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6278?lawid=6278>

¹ БНМАУ-ын Хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийг зөвшөөрөх тухай. 1991 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/692>

39 насны эхчүүдийн 2-3 жилийн зайтай төрөлтийг түлхүү дэмжинэ”, “3.1.8.Гэр бүлд **угийн бичгийг хөтлүүлж, цус ойртох, удамшлын өвчнөөс хүн амыг сэргийлэхэд** дэмжлэг үзүүлнэ” зэрэг зохицуулалт тусгасан.

Мөн Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”¹ энэ талаар Дөрөв “2.3/удмынхаа нэр төрийг дээдлэх, **угийн бичгээ хөтлөх**, ахмадаа хүндлэх, жирэмсэн эхийг энэрэх, үр хүүхдээ амьдрал, хөдөлмөрт бэлтгэх зэрэг өвөг дээдсийн сайн үлгэр дууриаллыг өвлүүлэх үйл ажиллагааг дэмжих” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²-д энэ талаар 3.1.Оршин тогтнохуйн аюулгүй байдал “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, **хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг** хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн”, “3.1.3.4. **Цус ойртолтыг багасгах**, архидаан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж бодлого тодорхойлсон.

¹ Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай.2003 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6281?lawid=6281>

² Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/6163?lawid=6163>

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг³ баталсан байна. Тус тогтоолын хавсралт 1-ийн “2.7.1.хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээнэ”, “2.7.2.цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ”, “2.7.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ”, “2.7.4.хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно” гэж тус тус тусгасан байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь хэсэг “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй...”, Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэг “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэг “...эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах...” гэх зэрэг үндсэн эрхүүдийг хуульчилж өгсөн.

Эрүүгийн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй

³ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. 2020 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/15584?lawid=15584>

тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудаар тус тус хэсэгчлэн зохицуулсан байна. Дараах хэсэгт Монгол улсын хууль болон бусад улс орны хуульд харьцуулалт хийнэ.

3. ОЛОН УЛСАД ХҮНИЙ УДМЫН САН ГЕНЕТИКИЙН ТАЛААРХ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ. /харьцуулсан судалгаа/

Олон улсын түвшинд хүний удмын сантай холбоотой дараах олон улсын гэрээ, тунхаглалууд байна. Тухайлбал: Нэгдсэн Үндэстний байгууллагын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹, Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол, Нэгдсэн Үндэстний байгууллагын 1997 оны Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал², Олон улсын томуугийн хяналт ба авах арга хэмжээний тогтолцоо гэх зэрэг олон улсын гэрээ, тунхаг бичгүүд байна.

Ирланд улсад Цус ойртолтод хүлээлгэх хариуцлагын тухай хууль, Ямаик улсад Цус ойртох үйлдэлд хүлээлгэх хариуцлагын тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг.

Их Британий Нэгдсэн Вант Улс 1999 оноос хүн ам зүйн асуудлыг төрөөс

удирдан зохион байгуулах, зохицуулах тогтолцоо бүхий Хүний генетикийн комиссыг байгуулан хэрэгжүүлж байна.

Угийн бичиг хөтлөлтийн хувьд Исланд Улс 1703 оноос анхны бүртгэлжүүлэлт эхэлсэн бөгөөд тогтвортой, тодорхой байдлаар удмын хэлхээг хадгалсаар ирсэн. Солонгос Улс 2007 оноос Америкийн Нэгдсэн Улсын Юта мужийн “Family search” байгууллагатай хамтран мянга гаруй овгийн угийн бичгийг тоон системд шилжүүлсэн³ бол Шотланд улс 2007 оноос 50 сая гаруй удмын мэдээллийг цахим хэлбэрээр хадгалдаг болжээ⁴.

Хүн амын хөдөлгөөнийг зохицуулах талаар Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан цагаачлалын асуудлыг зохицуулах, зохистой хэмжээний талаар гаргасан зөвлөмжид хүн амд ноогдох албан ёсны цагаачдын хувийг Австрали 0,74%, Канад 0,7%, Франц 0,29%, Итали 0,19%, Шинэ Зеланд 1,2%, Швед 1,13%, Англи 0,41%, Америкийн Нэгдсэн Улс 0,24% хувь байхаар тусгасан байна⁵.

Хүн амын удмын санг бүхлээр нь зохицуулдаг хуультай улс зөвхөн БНХАУ байна. БНХАУ-ын Хүний Генетикийн нөөцийн менежментийн тухай хууль нь 2019 онд батлагдсан ба нийт 6 бүлэг 47

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/1271>

² 1997 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар бно ёс зүйн салбар дахь норман ганц олон улсын баримт бичиг болох “Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг баталсан бөгөөд уг баримт бичгийг 1998 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей дахин баталсан. Эх сурвалж: <https://unesco.mn/mn/social-human-sciences/programmes/ethics/>

³ Хавсралт № 5. Солонгосын томоохон овгийн эдгээ хувь үзэж үү.

⁴ Stefansdottir, V., Johannsson, O. T., Skirton, H., Trygvadottir, L., Tuulinnis, H. & Jonsson, J. J. [2013]. The use of genealogy databases for risk assessment in genetic health service: a systematic review. *Journal of community genetics*, 4(1), 1-7

⁵ Managing Migration-Are Quotas and Numerical Limits the Solution? International migration outlook: SOPEMI 2006 EDITION- ISBN 92-64-03627-X-OECD 2006

зүйл заалттай¹. Тус хуулийн агуулга нь: хүний генетик нөөцийг үр дүнтэй хамгаалах, зохистой ашиглах, нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой.

Бусад улс орны хувьд Удмын сангийн аюулгүй байдлын талаарх харилцааг Эрүүгийн хуулиар зохицуулсан 23 улс, Иргэний хуулиар зохицуулсан 7, Гэр бүлийн хуулиар зохицуулсан 9, Бие даасан хуулиар зохицуулсан 4 улс байна². Эдгээр орнуудад цус ойртолттой холбоотой харилцааг бие даасан хуулиар эсхүл салбарын хоёр, гурван хуулиар зохицуулсан буюу хосолмол зохицуулалттай байна³.

Дээрх улс, орнуудаас Иргэний хуульд доорх байдлаар тусгасан байдал /харьцуулалт/

№	Монгол улс	БНСУ
1	125 дугаар зүйл. Гэр бүлийн хөрөнгө, түүний зохицуулалт	809-р зүйл. Гэрлэх хөрнөтөй тохилдол 1. Хэрэв гэр бүл болох гэж байгаа этгээдүүд нь найман үеийн цусан төрлийн (өргөж авсан этгээд хамаарна) холбоотой бол гэрлэхийг хориглоно ³
2	125.1. Гэр бүлийн хөрөнгө нь гэрлэгчдийн, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэнэ.	Филиппин улс 80-р зүйл. Дараах Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно: (5) 81-д заасан цус ойртсон гэрлэлтийг; 81-р зүйл. Хуулийн дагуу эсхүл хууль бус байхаас үл хамааран дараахь цус ойртсон гэрлэлтийг хүчин үйд тооцно:
	125.2. Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно. ¹	(1) Аль ч үеийн овог дээдэс болон үр удмын хооронд; (2) Төрсөн ах, эгч дүүсийн хооронд эсхүл эцэг болон эх нэгтэй ах, эгч дүүсийн хооронд; (3) Дөрөв дэх үеийн хойын цусан төрлийн холбоотой төрөл садны хооронд ¹

Монгол улсын Иргэний тухай хуульд энэ талаар тусгаагүй. Учир нь Иргэний хуулийн зорилт буюу зохицуулах харилцаа нь эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулдаг. Ийм учир гэр бүлийн хөрөнгө зохицуулалтыг хийсэн. Харин БНСУ болон Филиппин улсад гэрлэлтийг хориглох шалтгаан болгож зохицуулсан байна.

¹ Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа. Парламентын судалгааны хүрээлэн/захиралт судалгаа/УБ., 2021 он 13 дахь тал.

² Хавсралт № 6. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлын талаар бусад орны хуульчилсан байдал. Хүснэгтийг үзнэ үү.

³ Хавсралт № 7. Гадаадын зарим оронд цус ойртолтыг хуулиар зохицуулсан байдлын судалгааг үзнэ үү.

Эрүүгийн хуульд тусгасан байдал /харьцуулалт/

№	Монгол улс	Вьетнам улс
1		150-р зүйл. Цус ойртох гэмт хэрэг Төрсөн ах, эгч, эцэг эсхүл эх нэгтэй ах, эгч зэрэг шууд цусан төрлийн холбоотой этгээдтэй бэлгийн харилцаанд орсон бол 6 сараас 5 жил хүртэлх ял эдэлнэ. ^а
		Канад улс
2		Цус ойртох гэмт хэрэг 155.1.Төрсөн эцэг, эх, хүүхэд, ах, эгч, овоо, эмээ зэрэг цусан төрлийн холбоотой этгээдтэй бэлгийн харилцаанд орох үйлдлийг цус ойртох гэмт хэрэгт тооцно. 155.2.Цус ойртох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 14 жил хүртэл хорих ялаар шийтгэнэ. 155.3.Хэрэв аймган сүрдүүлэх болон хүчээр бэлгийн харилцаанд орсон бол энэ үйлдлийг шүүхээр тогтож, гэм буруугүйд тооцно 155.4.Хуулийн 155.1-д заасан "ах", "эгч" гэсэнд эцэг эсхүл эх нэгтэй ах, эгчийг хамааруулан ойлгоно. ^б
		Малайз улс
3	12.1 дүгээр зүйл. Хүчиндэх 2.3.1-эр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; ^д	Цус ойртох гэмт хэрэг 376а. Хэрэв аливаа этгээд нь хууль, шашин шүтлэг, ёс заншилд нийлгэхгүй, эсхүл хамаарал бүхий талууд этгээдтэй бэлгийн харилцаанд орсон бол цус ойртох харилцаанд оролцсон гэж үзнэ. Цус ойртох харилцаанд оролцогчдоод хүлээлгэх хариуцлага 376б. (1) Цус ойртох харилцаанд орсон аливаа этгээд нь 10-30 жил хорих ял эдэлнэ, мөн ташуурдуулна. ^г
		Швейцар улс
4		213-р зүйл. Цус ойртох гэмт хэрэг 1. Шууд цусан төрлийн харилцаатай салан төрөлтэйгөө, ах, эгчтэйгээ, нэг эцэг эсхүл нэг эхтэй ах дүүс өөр хоорондоо бэлгийн харилцаанд орсон бол харилцаанд орсон этгээд нь гурав хүртэл жилийн хорих ял, эсхүл мөнгөн торгууль төлно 2. Цус ойртох харилцаанд орсон насанд хүрээгүй этгээд уг үйлдлийн санаатай хийсэн бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд насанд хүрээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй ^в
		Шинэ Зеланд улс
5		130.1. Дараах үйлдлийг цус ойртох гэмт хэрэгт тооцно: а. овоо, эмээ, аав, ээж, хүүхэд, ах, дүүгийн (эцэг эсхүл эх нэгтэй ах, дүү хамаарна) хооронд үүссэн бэлгийн харилцаа; б. Ураг төрлийн холбоотой гэдгээ мэдсээр байж бэлгийн харилцаанд орох 130.2. Дээрх үйлдлийг хийсэн 16 ба түүнээс дээш насны этгээдэд 10 хүртэлх жилийн хорих ял ногдуулна. ^з

Монгол улсын Эрүүгийн хуульд Цус ойртох гэх агуулгатай гэмт хэрэг байхгүй бөгөөд зөвхөн Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд "гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг" гэж тусгасан байна.

Харин Вьетнам, Ирланд, Канад, Малайз, Швейцар, Шинэ Зеланд зэрэг улсуудын Эрүүгийн хуульд зааснаар бие даасан гэмт хэрэг гэж тусгасан байна. Мөн тухайн гэмт хэргийг үйлдэхэд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх гэх шалгуурыг тусгаагүй.

Зарим улс орны хувьд тухайлбал, Шинэ Зеланд улсын Эрүүгийн хуульд тухайн хүн ураг төрлийн холбоотой гэдгийг мэдсээр байж бэлгийн харилцаанд орсон бол эрүүгийн хариуцлага тооцохоор тусгасан байна.

Гэр бүлийн тухай хуульд заасан байдал /харьцуулалт/

№	Монгол улс	Вьетнам улс
1	9 дүгээр зүйл. Гэрлэхэд харшлах шалтгаан	5-р зүйл. Гэрлэлт, гэр бүлийн дэглэмийн хамгаалалт 2. Дараах үйлдлийг хориглоно: г) шууд цусны хүмүүс ¹³ , гурван үеийн төрөл садан ¹⁴ , үрчилж авсан эцэг, эх болон үрчлүүдсэн хүүхэд, эсхүл өмнө нь үрчилж авч байсан эцэг, эх болон үрчлүүж байсан хүүхэд, хадам аав болон бэр, хадам ээж болон хүүргэн, хойд эцэг, эх болон дагавар хүүхэд нар хоорондоо гэрлэх, эсхүл нөхөр эхнэрийн харилцаагаар хамтран амьдрахыг; ¹⁵
2	9.1. Дараахь байдал нь гэрлэхэд харшлах шалтгаан болно:	Малайз Хориглох харилцаа 11.(1) Аливаа этгээд нь өөрийн ээж, эмээ, эцэг, эх, хүүхэд, ач, зээ, эх, эгч, авга ах, авга эгч, нагач ах, нагач эгч, үеэл ах, үеэл дүү, үеэл ач дүү, үеэл зээ дүүтэйгээ гэрлэхийг хориглоно. Энэ хориг нь Хинди шашны хуулийн дагуу гэрлэх гэрлэлтэд хамаарахгүй. (2) Аливаа этгээд нь нөхөр, эхнэр, эсхүл салсан нөхөр, эхнэрийн овоо, эмээ, эцэг, эх, хүүхэд, ач зээтэй гэрлэхийг хориглоно. (3) Үрчилж авсан эцэг, эх болон үрчлүүдсэн хүүхэд хооронд гэрлэхийг хориглоно. ¹⁶
	9.1.1. Өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;	ОХУ 13-р зүйл. Гэрлэлтийг үл зөвшөөрөх тохиолдол Дараахь тохиолдолд гэрлэлтийг үл зөвшөөрнө: -торон садны хооронд (овог дээдэс болон үр удам /эцэг, эхтэйгээ, хүүхэдтэйгээ, овоо, эмээтэйгээ, ач, зээтэйгээ/ төрсөн, эсхүл эх нэгтэй ах, эгчтэйгээ) -үрчилж авсан эцэг, эхтэйгээ, үрчлүүж авсан хүүхэдтэйгээ гэрлэхийг зөвшөөрөхгүй. ¹⁷
3	Хуулийн заалт 9.1.2. Гэрлэгчид хобуула, эсхүл хэн нэг нь энэ хуулийн 6.1-д заасан насанд хүрээгүй бол;	
	9.1.3. Төрөл ¹⁰ , садангийн ¹¹ хүмүүс хоорондоо гэрлэх;	
4	9.1.4. харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;	Филиппин улс 37-р зүйл. Талууд хоорондын харилцаа нь хууль ёсны болон хууль бус байхаас үл хамааран дараах цус ойртсон гэрлэлтийг хүчингүйд тооцно: (1) Аль ч үеийн овог дээдэс болон үр удмын хооронд; (2) Төрсөн ах, эгч болон эцэг, эсхүл эх нэгтэй ах, эгчийн хооронд
	9.1.5. үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;	38-р зүйл. Төрийн бодлогын үүднээс дараах гэрлэлтийг хүчин тогтолдор бус гэж үзнэ: (1) Хуулийн дагуу эсхүл хууль бус байхаас үл хамааран дөрөв дэх үеийн холын цусан төрлийн холбоотой төрөл садны хооронд (2) Үрчилж авсан эцэг, эх болон үрчлүүж авсан хүүхдийн хооронд (3) Хадам эцэг, эх болон хүүргэн бэрийн хооронд (4) Үрчилж авсан эцэг, эх болон үрчлүүдсэн хүүхдийн хооронд (5) Үрчилж авсан эцгийн бэлэвсэн эхнэр, эсхүл үрчилж авсан эхийн бэлэвсэн нөхөр болон үрчлүүдсэн хүүхдийн хооронд (6) Үрчлүүдсэн хүүхдийн бэлэвсэн нөхөр, эхнэр болон үрчилж авсан эцэг, эхийн хооронд (7) Үрчлүүдсэн хүүхэд болон үрчилж авсан эцэг, эхийн хууль ёсны дагуу төрсөн хүүхдүүдийн хооронд (8) Нэг эцэг, эхэд үрчлүүдсэн хүүхдүүд хоорондын гэрлэлтийг хүчин тогтолдор бус гэж үзнэ. ¹⁸
	9.1.6. гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хобуула удамших хандлагатай сэтгэцийн архаг өмгтэй бол. ¹²	

Малайз улсын хувьд шашны эрх зүйн холимог тогтолцоотой байгаа улмаас Хинди шашны гэрлэлтэд Гэр бүлийн хуулийн зохицуулалт үйлчилдэггүй онцлогтой байна.

Манай улсын хувьд нийтлэг байдлаар тусгасан ба садан, төрөл хоорондоо, харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоорондоо, үрчлэгч үрчлүүлэгч гэж ерөнхий тусгасан. Бусад улс орны хувьд төрөл, саданг алслалтыг нэмэгдүүлсэн ба хүрээг тэлж өгсөн байна.

Бие даасан хууль, Зөрчлийн хуулиар зохицуулсан байдал.

№	Монгол улс	Ирланд улс
1	5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	1.1. Аль ч эр хүн бүр мэдэээр байж өөрийн ач охин, охин, эгч, дүүс, эсхүл ээжтэйгээ бэлгийн бэлгийн харьцаанд орсон гэмт хэрэг үйлдсэн бол 3-7 жилээр хүнд ажилд цолох эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ялыг албадан хөдөлмөрлүүлэх ялтай хослуулан ногдуулна. 2.1. Цус өйрсөн бэлгийн харьцаанд ороход эмэгтэй нь зөвшөөрсөн байх нь хариуцсан аас чөлөөлөх үндэслэл болохгүй 1) аль ч эмэгтэй хүн өөрийн аав, өвөг эцэг ах, эрэгтэй дүү эсхүл хүүтэйгээ бэлгийн харьцаанд орохоор зөвшөөрсөн бол 3-7 жилээр хүнд ажилд цолох эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ялыг албадан хөдөлмөрлүүлэх ялтай хослуулан ногдуулна 2) Энэ хуульд заасан "ах" бөчөн "эгч" гэдэгт гэрлэсэн эсэхээс үл хамааран эх нэгтэй эсхүл эцэг нэгтэй ах, эгч, дүүг хамруулан ойлгоно. ²¹
	4.1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг; 4.2. хүсэл зоригийнх нь зэрэг тодорхой үйлдэл хийх ¹⁹ , хийхгүй байхыг албадсан; 4.4. "...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл олгогдуулна." ²⁰	Ямайка улс 2. (1) Аль ч эр хүн мэдэээр байж өөрийн ач охин, охин, эгч, дүү, ээжтэйгээ бэлгийн харилцаанд орсон бол гэмт үйлдэл үйлдсэн 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлнэ. Хэрэн энэ зүйлд заасан харилцаанд орсон этгээд нь 12-оос доош насны хүүхэд байвал гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 16 жил хүртэл албадан хөдөлмөр эрхлүүлнэ. (2) Эмэгтэйн зөвшөөрлийн дагуу бэлгийн харилцаанд орсон гэх үйлдэл нь хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй (3) Энэ зүйлийн (1)-д заасан үйлдэл хийхнийг оролдон этгээдэд 2 жил хүртэл албадан хөдөлмөр эрхлүүлнэ. 3. 16 нас ба түүнээс доош насны эмэгтэй нь өөрийн өвөө, аав, ах, хүүтэйгээ бэлгийн харилцаанд гэдгийг мэдэээр байж бэлгийн харилцаанд орохыг зөвшөөрсөн, энэ хүмүүсийн өөрийн нусан төрөл гэдгийг мэдэээр байж бэлгийн харилцаанд орсон бол гэм буруутайд тооцож ба 5 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлнэ. 4. Энэ хуульд заасан ах, эгч гэдэгт эцэг, эсхүл эх нэгтэй ах, эгч хамаарах ба эдгээр хүмүүс хоорондоо гэрлэхийг хориглоно. 5. (1) Хэрэн шүүхээр хүчингийн хэрэг хийсэн нь тогтоогдвол энэ хуулийн дагуу гэм буруутайд тооцож ба зохих шийтгэлийг хүлээлгэнэ. ²²

Дээрх зохицуулалтын хүрээнд албадан хөдөлмөр эрхлүүлэх хариуцлагыг тусгаж өгсөн. Зөрчилд тооцож байгаа үйлдэлд мэдсэн байх гэдэг шаардлага тусгажээ. Манай улсын хувьд Зөрчлийн хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тусгаж өгсөн ба агуулгын хувьд гэр бүлийн гишүүдийг ерөнхий зохицуулалтаар тусгаж өгсөн байна. Мөн Зөрчлийн тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд 7-30 хоног баривчлах болон албадан сургалтанд хамруулах хариуцлага тооцохоор зохицуулжээ.

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд "3.1.1.эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд"; "3.1.2.туслаа амьдарч байгаа төрүүдсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, ах, эгч, дүү.

ДУГНЭЛТ

Монгол улсын хөгжилд эрх зүйн шинэчлэлийн үр нөлөө бий болгох хүрээнд Хүний удмын сан буюу генетикийн асуудлыг төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Хүн амын эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн орчинг бий болгох шаардлага бол улс орны тусгаар тогтнолтой шууд холбоотой асуудал юм. Гэтэл Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт хийх чиглэлийн дагуу 2015 онд Хүн судлалын төвийн үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн газартай нэгтгэснээс хойш хүн судлалын асуудал хариуцсан чиглэлийн төрийн бодлого орхигдсон байна.

Хэдийгээр хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр баримтлах төрөөс баталсан тогтоол, шийдвэрүүд байгаа боловч хууль тогтоомжид тусгасан байдал учир дутагдалтай, энэ талаар төрийн байгууллагын чиг үүрэгт тусгагдаагүй учир хэрэгжилт хангалтгүй байна. Мөн энэхүү чиг үүргийг дангаар хариуцан ажиллах төрийн институт байхгүй байгаа нь хэрэгжихгүй байх нэг шалтгаан болж байна.

Бусад улс орны хувьд энэ цус ойртох нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг гэж үзэж хуульд тусган хариуцлага тооцож байна. Мөн бие даасан хууль батлан дагаж мөрдөж байна. Иймд дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуульд Цус ойртох гэмт хэрэг гэж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай¹ гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн зорилго нь хэдийгээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боловч мөн урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг. Тухайлбал, эрүүгийн хуульд тухайн үйлдлийг зааснаар гэмт хэрэгт тооцдог. Иймд нийгэмд тухайн зүйлийг үйлдэх нь буруу гэх ойлголтыг өгөх боломж бүрдэнэ.
2. Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан харшлах шалтгаанд заасан үндэслэл байгаа талаарх төрийн эрх байгууллага хяналт тавих шаардлага нэмэгдүүлэх. Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан улсын бүртгэлийн байгууллага, Дипломат төлөөлөгчийн газарт гэрлэлтийг бүртгэхэд хяналт хийх чиг үүрэг бий болгох. Тухайн чиг үүргийн дагуу мэргэжилтэн орон тоонд оруулах нь уг асуудлыг хянах боломжийг бүрдүүлэх юм.
3. Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулах². Зөрчлийн хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих гэсэн агуулгад үйлдэл буюу хүчирхийллийн хэлбэрийг нэмэх шаардлагатай. Нийгэмд гарч буй ёс зүйгүй үйлдлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээхгүй орхигдох үзэгдэл гарч байна. Мөн Зөрчлийн

¹ Хавсралт № 8. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзнэ үү.

² Хавсралт № 9. Зөрчлийн тухай хуульд оруулах өөрчлөлтийг үзнэ үү.

хуулийн үйлдлийн тооциж хуульчилсан агуулга дутмаг байгаа учир өөрчлөлт оруулж гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг нэмж оруулах шаардлагатай.

4. Хүний удмын сан буюу генетикийн талаарх улсын хэмжээнд сургалт, судалгаа, хяналт, шинжилгээ хийх төрийн бүтэцтэй болох. Монгол улсад Монгол хүн судлалын төв гэх байгууллага энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан туршлага бий. Одоогийн нөхцөлд энэ чиг үүрэг бүхий төрийн институцийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд байгуулах боломжтой. Учир нь хүний удмын сангийн мэдээлэл, түүнтэй холбоотой шинжлэх ухааны судалгаа шинжилгээг мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалтай шууд хамааралтай бөгөөд нууцлалыг чанд хадгалах шаардлагатай байдаг.

5. Угийн бичиг хөтлөх үүргийн хэрэгжилтийг хангах. Соёлын тухай хууль болон Гэр бүлийн тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолд тусгасан боловч хэрэгжилт тун хангалтгүй байна. Иймд угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлын талаарх Хууль зүйн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын чиг үүрэгтэй тусгаж өгөх.

6. Угийн бичиг хөтлөлтийг цахимжуулах. Солонгос улс болон бусад улсын туршлагаас авч өөрийн улсад

нийцэх цахим санг бий болгох. Энэхүү цахим сангийн мэдээлэл нь Төрийн болон албаны нууцын тухай хууль¹, Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалахаар зохицуулалт оруулах².

7. Төрийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу Улсын Их Хурал³, Засгийн газар, Яам, агентлаг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай шийдвэр гаргах ёстой.

¹ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2.үндэсний аюулгүй байдлын хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл;

² Хавсралт № 10. Хувь хүний нууцын тухай хуульд оруулах өөрчлөлтийг үзнэ үү.

³ Хүн амын удмын сан хамгаалахтай холбоотой УИХ-ын тогтоолын төслийг дараах холбооноос үзнэ үү. <https://lawforum.parliament.mn/draft/53/>

НОМ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн хууль
3. Иргэний хууль
4. Гэр бүлийн тухай хууль
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
6. Зөрчлийн тухай хууль
7. Соёлын тухай хууль
8. Төрийн болон албаны нууцын тухай хууль
9. Хувь хүний нууцын тухай хууль
10. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны зарилгаг."БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл"
11. Монгол Улсын Их Хурлын 1996 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого"
12. Монгол Улсын Их Хурлын 2003 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"
13. Монгол Улсын Их Хурлын 2004 оны тогтоол. "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"
14. Монгол Улсын Их Хурлын 2010 оны тогтоол. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"
15. Монгол Улсын Их Хурлын 2020 оны тогтоол. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
16. Монгол Улсын Их Хурлын 2020 оны тогтоол. "Алсын хараа-2050"
17. Монгол Улсын Засгийн газрын 1997

оны тогтоол. "Угийн бичиг хөтлөх журам"

18. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны тогтоол. "Угийн бичиг хөтлөх журам" шинэчлэн батлах тухай

ГАДААД ОРНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖ:

1. Civil Act of the Republic of Korea (Law No.471)
2. Civil Code of the Philippines. Republic Act No. 386
3. Constitution of the Republic of Korea
4. Criminal Act of New Zeland
5. Criminal Code of Canada
6. Criminal Code of Albama USA
7. Criminal Law of North Carolina USA
8. Law on marriage and family of Vietnam (No 52/2014QH13)
9. Marriage and Divorce Act of Malaysia – 1976.
10. Penal Code of Malaysia (Act 574)
11. Penal Code of Vietnam (No 15/1999/QH10)
12. Punishment of Incest Act of Ireland
13. Swiss Criminal Code
14. The Family Code of the Philippines
15. Семейный кодекс Российской Федерации.

НОМ, СУРАХ БИЧИГ:

1. Ж.Батсуурь, Э.Энхмаа."Монгол улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар".УБ., 2010
2. С.Бямбасүрэн."Сэтгэцийн эмгэг судлал".УБ.,2007
3. Ш.Биндэръяа."Угийн бичиг

багшийн ном".УБ.,2013

ЦАХИМ ХУУДАС:

4. А.Гидденс."Социологи".УБ.,2006
5. Ш.Доржжадамба, С.Бямбасүрэн, Н.Орёл, Л.Эрдэнэбаяр."Хорьдугаар зууны үеийн Монгол улс дахь сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал".УБ.,1996
6. С.Нарангэрэл."Эрх зүйн эх толь бичиг".УБ.,2007
7. И.Пүрэвдорж."Удамшил".УБ.,1991
8. "Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа"Парламентын судалгааны хүрээлэн /захиалгат судалгаа/. УБ.,2021
9. "Цус ойртолт ба оюуны хомсдол Монгол улсын хэмжээнд".Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгааны ажлын тайлан.УБ.,2020
10. "Төрөл ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, сэтгэл мэдрэлийн өвчтэй, оюуны хомсдолтой хүмүүсийн динамик мэдээ" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгааны ажлын тайлан.УБ.,2020
11. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлан.УБ.,2019
12. ШУА, ЕБСБХүрээлэн."Попцляцийн генетикийн үндэс".УБ., 1977
13. ФСЭХ, НХХЯ, НҮБ-ийн Хүн амын сан."Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал". УБ.,2010
1. www.moleg.go.kr
2. www.legislation.govt.nz
3. www.ncga.state.nc.us
4. www.agc.gov.my
5. www.boluathinhsu.com
6. www.irishstatutebook.ie
7. www.chanrobles.com
8. www.consultant.ru
9. www.law2byu.edu
10. www.justia.com
11. www./mn.wikipedia.org/
12. www.legalinfo.mn
13. www.lawforum.parliament.mn
14. www.1212.mn

**ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШЛИЙН ОНОЛ, ИРГЭНИЙ ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ**



Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, магистр Ё.Болормaa

ТОВЧ АГУУЛГА

Өмч, өмчлөх эрх, өмчлөл, эзэмшлийн түүхэн болон онолын зарим асуудлыг тодорхой эх сурвалжуудаас тоймлон авч үзэж, тухайн асуудлын хуулийн зохицуулалтыг онолын үүднээс тодорхойлон авч үзсэн болно.

Өмчлөх эрхийн сэтгэлгээний түүхэн хөгжил, зарим онолуудын талаар.

Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн өнгөрсөн цаг хугацаанд онолчид, сэтгэгчид хувийн өмч, өмчлөх эрхийн талаар ухаан бодлоо уралдуулж, өмч гэж юу болох, энэхүү зүйл чухам хэнд хамаарах ёстой, зүй ёсны шинж байдлаа хэрхэн олдог тухай, нийгмийн харилцааны тодорхой түвшинд юу өмчийн объект болдог, аль нь энэ ойлголтоос ангид байх тухай асуудлуудыг тодорхойлж, түүний агуулгыг нь нээн илэрхийлэхийг зорьж, олон ургалж онол, үзэл санааг

хөгжүүлсээр ирсэн юм.¹

Сэтгэлгээний түүхэн асуудал, Эрх зүйн сэтгэлгээний тодорхойлогдох онцлог нь гол төлөв өмчийн гарал үүсэл, түүний мөн чанарын асуудалд голлон анхаарч ирсэн байх агаад хувийн өмч, нийтийн өмч гэсэн ойлголтууд ямар учир шалтгааны улмаас бий болсон тухайд оюун ухаанаа уралдуулж байв. Мөн хувийн өмчийн оршин тогтнохуй нь чухам хэнд, юунд хэрэгтэй болохыг танин мэдэх, уг өмчийн тусламжтайгаар хүн өмчлөх эрх гэдэг ойлголтонд багтаан ямар эрх эдлэх ёстойг, нийгэм дэх түүний үнэлэмж чухам ямар байх ёстойг ойлгон ухаарахад анхаарч, эргэцүүлэн бодож, марган мэтгэлцэж байсан явдал юм. Энэ үеийн сэтгэгчид эртний Грек, Ромын сэтгэгч Платон /МЭӨ 427-347/, Сократ /МЭӨ 469-399/, Аристотель /МЭӨ 384-322/, Сенека /МЭӨ 54-МЭ39/, Цицерон /МЭӨ 106-43/, Ж.Локк.... нар юм.

Түүнчлэн дундад зууны болон сэргэн мандалтын үеийн Европын өмчлөх эрхийн харилцаа үл хөдлөх эд хөрөнгө болоод газар зэрэг бодит объект дээр төвлөрөн хөгжиж байсан

¹ Г.Агар-Эрэнгэ. Хувийн өмчийн онол. УБ., 2009 он, 13 дахь тал /Тус номоос хүний жам ёсны эрх-өмчлөх эрхийн изрэл хувийн өмчийн талаар эрдэмтэд, онолчдын дэвшүүлэн тавьсан онол, үзэл санаануудын цогцрыг онгөрсөн. одоо үе, түүнчлэн ирээдүй цагийн харилцан холбоонд түүнчлэн сүдэлсантай танилцах, тэдгээрийн ололт амжилт, үнэт зүйлсийг эрх зүйн хөгжлийн орчин үеийн хүрсэн түвшинтэй үзлэхдүг ойлгох, ардчилсан нийгэмд хэлбэржиж буй өмчийн эрх зүйн харилцааны уг үндсийг байх ёстой утга асуулгаар нь ойлгох болно гэжээ/

нь өмчлөх эрхийн сэтгэлгээг харьцангуй бодитой нөхцөл байдалд хандуулах шалтгаан болжээ. Энэ үеийн Европын өмчлөх эрхийн харилцаа нь Ромын эрх зүйгээр зохицуулагдаж, улам төгөлдөржүүлэн хөгжүүлж, өмчлөх эрхийг олж авах анхдагч болон үүсмэл аргыг бий болгосон нь энэ үеийн онцлог юм. Энэ үеийн сэтгэгч нь Фома Аквиний /1125-1274/ юм.

Өмчлөх эрхийн сэтгэлгээний хөгжлийн энэ үед сэтгэгчид, онолчид төрөлх эрхийн болон нийгмийн гэрээний онол, эрх чөлөө, шударга ёсны тухай үзэл санаанд тулгуурласан номлол, эрхийн сэтгэлгээг хөгжүүлж, хувийн өмчийн хууль ёсны байдлыг түүний мөн чанартай хэрхэн уялдуулах, эрх чөлөөний илрэн гарах жам ёсны бөгөөд зайлшгүй хэлбэр нь хувийн өмч, өмчлөх эрх мөн эсэх талаар олон өнцгөөс нь судлан үзэж, үзэл санаагаа дэвшүүлсэн юм. Энэ үеийн төлөөлөгчид нь Т.Хоббс /1588-1679/, Жэймс Харрингтон /1611-1677/, Жон Адамс /1797-1801/, Роберт Филмер /1588-1653/, Ж.Локк /1632-1704/, Жан Жак Руссо /1712-1778/, Уильям Блэкстоуны /1723-1780/, Дэвид Юм /1711-1776/, Жереми Бентам /1748-1832/, Ф.Гегель /1770-1831/, Томас Хилл Грин /1836-1882/, Адам Смит болон Давид Рикардо, Чарльз Комте /нар юм.¹

Мөн түүнчлэн өмчлөх эрхийн онолын талаар, сэтгэгчдийн /А.Харел, У.Хофилд, Т.Макан, Л.Харт, К.Маркс, Р.Тэйлор, Ф.Хайек, Ш.Л. Монтестье, Ж.Болдуин, Ричард М.Вивер, Р.Пайпс, Э.Дэ.Сото нар/ дэвшүүлсэн гол санаа бол хувь хүний бие даасан байдал нь

эрх чөлөөний бодит ахуй мөн бөгөөд үүний үндсэн дээр аливаа хүн өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжтой болдгийг тайлбарласан төдийгүй эрх зүйн сэтгэлгээний түүхэн хөгжлийн үндэс суурь нь болж, өмчлөх эрхийн агуулгыг онолын үүднээс нээн илэрхийлэх ач холбогдолтой юм. Хувийн өмчийн тохиромжтой тогтолцоо орших тухай бодит зарчмуудын гол үзэл санаа, мөн өмчийн ямар тогтолцоо үйлчлэх ёстой талаарх ёс суртахууны хэвшил, заншлын үзэл сэтгэлгээг гарган илэрхийлэхэд чиглэгджээ.²

Ф.Бастия өмч бол хууль тогтоосны үндсэн дээр үүсдэг бус, харин хувийн өмчийг хамгаалж, түүнийг бэхжүүлэхийн тулд хүмүүс хуулийг бүтээсэн гэжээ. Өмч хөрөнгө бол хүний төрөлхөөс заяасан жам ёсны эрх гэдгийг тэрээр хүлээн зөвшөөрч, "Хүн бүр өөрийн бие, эрх чөлөө өмч хөрөнгийг хамгаалах зүй ёсны заяагдсан эрхийг Бурханаас хүртсэн..." хэмээн номлож байв.³ Энэ үүднээс Монгол Улсын Үндсэн хуулиуд⁴ нь эдийн засгийн харилцааны нийтлэг зохицуулалтыг агуулж, ялангуяа өмчлөх эрхтэй холбоотой заалтууд нь Иргэний хууль тогтоомж⁵-ийн үзэл санааг бүрдүүлдэг.


² Мөн тэнд, 101-145 дахь тал /дэлгэрүүлж үзнэ үү/

³ Фредрих Бастия, хууль, орчуулсан Н.Баярбаатар, 2001 он, 2 дахь тал

⁴ Ж.Амарсанаа, О.Багсайхан, Монгол Улсын Үндсэн Хууль /баримт бичиг/, УБ., 2004 он

⁵ З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр /Хамтран/, Монгол улсын иргэний хууль тогтоомж /түүхэн эмхтгэл/ 1206-2012 он., 2012 он

¹ Мөн тэнд, 18-59 дахь тал /дэлгэрүүлж үзнэ үү/



Эрх зүйн үүсэл, хөгжлийн төсөөлөл, сургаал номлолыг судлан үзэхэд өрнө, дорнын сэтгэлгээ, соёл иргэншилд тулгуурласан хоёр хандлага ажиглагдана. Өрнийнх нь сэтгэлгээнд буюу байх ёстой эрх зүйд, дорнынх нь позитив эрх зүй¹ буюу байгаа эрх зүйд илүүтэй тулгуурладаг гэж үзэж болно.² Тус хандлагуудын үүднээс байгаа эрх зүйг буюу хуулийн зохицуулалтыг байх ёстой эрх зүйн түвшинд судлахын тулд онол, философийн суурь бүтэц, загварчлал чухал. Ромын иргэний эрх зүйн үндсэн хэсэг нь дараах институтад хуваагддаг. Үүнд:

1. Өмчийн эрх зүй
2. Үүргийн эрх зүй /гэрээний ба гэрээний бус үүрэг/
3. Гэр бүлийн эрх зүй
4. Өв залгамжлалын эрх зүй³ байгаа нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн системчлэлийн суурь үндэслэл нь гэж үзэж болно.

Эзэмшигч этгээдийг өмчлөгч гэж үзэхгүй байх болон өмчлөлд хадгалагдах эзэмшлийг үгүйсгэх зарчмын ойлголтоос гадна эзэмшлээс тусгаарлан ойлгох ашиглах эрх нь бусдад шилжих боломжтой хийгээд цааш дамжуулагдах боломжгүй талаар, эзэмшигчийн зөвшөөрлөөр ашиглалтын давуу эрхийг хязгаарлах ойлголтууд, хамтран эзэмших эрхийн талаарх⁴ үндсэн ойлголтууд нь Ромын эрх зүй дэх өмчлөл, эзэмшлийн ойлголтын онцлогийг илэрхийлдэг байна. Энэ үндэслэл дээр суурилсан өмчийн болон үүргийн хуваагдал нь Өрнөдийн эрх зүйн тогтолцоон дахь өмчийн эрх зүйн үзэл сэтгэлгээнд ихээхэн нөлөөлсөн гэж үзэж болно.⁵ гэжээ. Эзэмшил, өмчлөх эрх нь эрхийн агуулгаараа ялгагддаг. Түүнчлэн өмчлөх эрх /эзэмших эрх/, эзэмшил /эзэмших эрх/ нь ялгаатай.


¹ О.Амархүү. Эрх зүйн онол. УБ., 2018 он, 66 дахь тал /Позитив эрх зүй бол сэтгэлгээний хөгжил бодит байдал болж бичигдмэл байдлаар бидэнд хүрч ирсэн, судалгаа шинжилгээний биет зүйлс нь болж байдаг эрх зүйн хэм хэмжээний илэрсэн хэлбэр нь юм. Энэ хэлбэр Хятад, Энэтхэг, Монгол зэрэг дорнын улс орнуудад, харин өрнийн улс орнуудад...Английн хаан Жон 1215 оны 6-р сарын 15-ны өдөр Магна харт хэмээх эрх чөлөөний баримт бичгийг /бичигдмэл эрх зүй/ батлан гаргасан түүхтэй гэгжээ./

² Мөн тэнд, 59 дэх тал

³ Т.Одонхүү. Ромын эрх зүй. УБ., 1999 он, 51 дэх тал

⁴ Fritz Schulz. Classical Roman Law. Oxford Clarendon, 1951 431, 444-454p, Wilian W Buckland. A Textbook of Roman Law. Cambridge Univ press, 1963, 269-273.

⁵ Г.Амаржаргалан. "Хувийн эрх зүйн онол". УБ., 2020 он. 141 дэх тал



Өмчийн эрх зүйн онол /Theory of Property law/-ын талаар, Английн эрх зүйн сэтгэгчид Чарлес Дохан, Гланвилл, Брактон Австралийн улс төрийн онолч Кеннет Р.Миног, Стэнфордын хуулийн сургуулийн профессор Томас С.Грей, Оксфордын хуулийн профессор Ж.Гетцлер болон бусад судлаачид дурьджээ. Энд өмчийн нийгмээс өмнө буюу төр, эрх зүйгээс өмнө байсан хүмүүсийн өмчийн эрхийг илэрхийлсэн жам ёсны эрх юм. Энэ хэсэгт Уго Гроциус, Самуал фон Пуфендорф, Жон Локк, Иммануил Кант, Жорж В.Ф. Гегель хамаарна. Мөн Томас Хоббс, Дэвид Хьюм, Адам Смит, Жереми Бентам, Эмил Дюркенхайм, Макс Вебер нарын онолын хүрээнд бататгасан нийгэм, төр, эрх зүйн хүрээнд бий болгосон позитив эрх бүхий нийгмийн өмчийн ойлголт¹ байна. Мөн эзэмшлийн онол /Occupation theory/-ын талаар, Торонтогийн их сургуулийн профессор Питер Бэнсон, хувийн эрх зүйг "juridical" шинжээр тодорхойлогдоно гэж үзээд өмчлөх эрхийн "juridical" үзэл баримтлалын үүднээс 3 чухал шинж чанарыг тодорхойлсон² байна.

Өмч, өмчлөл, эзэмшил ба иргэний хуулийн зохицуулалтын талаар,

"Өмч" буюу property гэдэг үг нь "юмны өвөрмөц шинж чанар эсвэл мөн чанар" болон "өмчлөл" гэсэн утгатай Латин proprietas үгнээс гаралтай бөгөөд энэ утгаар шууд эсвэл франц хэлээр propiete гэдэг үгээр хэрэглэгддэг. Орчин үед property нь өмчлөх эрх буюу эрх зүйн харилцаан дахь эрх, эрхийн объект гэхээсээ илүүтэйгээр өмчийн

¹ Мөн тэнд, 142-146 дахь талд, J.Getzler, Theories of Property and Economic Development, Journal of Interdisciplinary History, XXVI 4 /1996/, 641, J.Waldron, The Right to Private Property, Oxford, Clarendon Press, 1988, S.Munzer, A Theory of Property, Cambridge University of Chicago Press, 1993/.

² Мөн тэнд, 147 дахь тал, Peter Benson, Philosophy of property law, The Oxford handbook of Jurisprudence and philosophy of law, Ed Jues Coleman, Scott Shapiro, 2002, 754, 755, 756. /дэлгэрүүлж үзнэ үү/

эрх зүйн салбар¹ гэсэн ухагдахууныг хийсвэрлэн ойлгох боломжтой өргөн утга агуулгатай болжээ.

Иргэний хуулийн 83.1-д, Аливаа этгээд нь² хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно гэж хуульчилсан.



Эд юмс гэдэг материаллаг ертөнцөд бодитойгоор оршин байгаа бидний хүртэхүйд хүртэгдэж байдаг өөрийн гэсэн бүтэц, хэлбэртэй биежсэн зүйл юм.³ Эд юмсын эрхийн харилцаанд

байгаа объект болох зүйлс өмчийн эрхийн харилцаанд объект болох зүйлтэй харьцуулбал илүү өргөн хүрээтэй байдаг. Учир нь эд юмсын эрхийн харилцаанд юуг эдийн баялаг гэж үзэх, юуг эдийн бус баялаг гэж үзэх талаар Иргэний хуулийн 83-р зүйлд заасан байна. Иймээс эд юмсын эрх илүү өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдана.⁴

Нийгмийн баялаг хэмээх ойлголт манай хууль тогтоомжид тусгалаа олж хуульчлагдсан.⁵ хэмээн иргэний хуулийн 83 дугаар зүйлийг авч үзжээ. Иргэний хуулийн 83.1 нь дараахи эрх зүйд аль алинд нь хамааралтай заалт гэж үзэж болох юм.



Эдийн баялагтай холбоотойгоор нэр томъёонуудыг авч үзвэл, Үүнд:

- Өмчлөлийн зүйл-аливаа субъектын зүгээс тухайн объектыг өмчлөх эрх /эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалах/
- Эд хөрөнгө-аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмс
- Эд юмс- Эд юмс гэсэн ойлголт нь хүмүүсийн материаллаг хэрэгцээг хангаж, ашиглагдаж болохуйц зүйлс гэж ойлгож болох юм.⁶
- Эдийн болон эдийн бус баялаг-

¹ Г.Амаржаргалан. "Хувийн эрх зүйн онол". УБ., 2020 он. 139 дэх тал /Charles Donahue, Jr. Future of the Western concept of Property predicted from its past. Ed J.Roland Pennock and John W.Chapman, Property /1980/, 32./

² Монгол Улсын үндсэн хуулийн 14.2-г "...хүн бүр эрх зүйн этгээд байна..." Эрх зүйн этгээд: Хүн /болгалы/ Монгол Улсын, гадаадын, харьяалалгүй этгээд
Хуулийн этгээд /баг, хороо бие даасан эрх зүйн этгээд болохгүй/
Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага /хуулийн этгээдийн үндсэн шинжийг агуулаагүй, хүмүүсийн болон хуулийн этгээдийн нэгдэл/-СӨХ
Хуулийн этгээдийн эрх эзлэдэггүй байгууллага-салбар, төлөөлөгчийн газар

³ Д.Наранчимэг. "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". УБ., 1999 он. 22 дахь тал

⁴ Ц.Данхарбаяр. "Эдийн баялгийн эрх /эд юмсын эрх". УБ., 2017 он. 14 дэх тал

⁵ О.Амархүү. "Эрх зүйн онол". УБ., 2018 он. 268 дахь тал

⁶ Мон г-нд, 40 дэх тал

эдийн баялаг гэдэгт эд юмс, эдийн бус баялаг гэдэгт оюуны үнэт зүйлс, эрх хамаардаг.

- Эд хогшил-хувь хүн албан байгууллагын эд хөрөнгө, эд зүйл¹
- Эд зүйл-эд юмс нь энгийн, байгалийн шинжээрээ байгаа эд зүйлс байж болдог.
- Нийлмэл эд зүйлс-эд зүйлс байж болно. Жишээ нь, гэр-гэрийг бүрдүүлж буй нэгж хэсгүүд нь түүний бүрдэл хэсгүүд юм. Мөн үүрэн телефон=гар утас+суурин станц
- Эд юмсын нэгдэл-уг нэгдлийг бүрдүүлж буй нэгж хэсгүүд нь дангаараа бие даасан байдлаа алддаггүй. Эд юмсын дагалдах зүйл байж болно.²
- Эдийн бус баялаг нь материаллаг, биет бус шинжтэй байна. Үүнд:
 - Оюуны өмчийн эрх
 - Нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд
 - Хуулийн этгээдийн зохион байгуулалтын харилцаа

Эдийн ба эдийн бус баялгийн эрх нь эзэмшил үүсгэх эзэмших эрх, өмчлөх эрхийн агуулгаар тодорхойлогдоно.

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА хэл зохиолын хүрээлэн "Монгол хэлний их тайлбар толь" эд+хогшил=эд хогшил /хориоо/

² ГТХАН-ээс эрхлэн гаргасан. "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар". УБ., 2010 он. 149 дэх тал

Нийгмийн хөгжлийн аль ч үед хүний амьдралын амин чухал асуудал болох өмчлөл, өмчлөх эрхийн зохицуулалт нь иргэнлэг /civil/ болон нийтлэг /common/ эрх зүйн тогтолцоонд³ томоохон ялгаатай байдгийг хуульчид, судлаачид хүлээн зөвшөөрдөг. Эзэмшил, өмчлөлийн ойлголтыг эрх зүйн өөр өөр тогтолцоонд хэрхэн авч үздэг, эдгээрийн үндэслэл болсон онолын үзэл баримтлалуудыг тоймлон толилуулсныг⁴ харж болно. Эзэмшлийн өмчлөлөөс ялгаатай нь тухайн этгээдийн эд юмст байх хууль ёсны харьяалалд бус, харин бодит харьяалалд үндэслэдэг явдал юм.⁵

Эд хөрөнгийн эзэмшил, өмчлөх эрх нь өөр ойлголт тул агуулгын хувьд тухайн ойлголтын зохицуулалт мөн адил тусгаарлагдсан байдаг. Тухайлбал, Иргэний хуулийн 101.1 дэх хэсэгт заасан туйлын эрх бүхий өмчлөгчийн эсрэг Иргэний хуулийн 104 дүгээр зүйлд зааснаар эзэмшсэн хугацаанаас хамааран өмчлөх эрх үүссэн болохыг тогтоолгох шаардлага гарч болно. Харин ямар нэгэн хөрөнгийг өмчлөгчөөс шилжүүлэн авч эзэмшиж байгаа үед эзэмшлээ тогтоолгох үндэс байхгүй, энэ

³ Ж.Оюунтуулалал: Иргэний эрх зүйн онолын асуудал. УБ., 2018 он 7 дахь тал /Эрх зүйн өөр өөр тогтолцоог эрх зүйн бүл хэмээх ойлголтын хүрээнд авч үзэж, Эх газрын эсхүл Ром-германы, Далайн эсхүл Англосаксоны гэж ангилж прээн нь сүүлийн үед тийм ч тохиромжтой бус хэмээн тооцондож, харьцуулсан эрх зүйд дээрх ангиллаас илүү иргэнлэг эрх зүй буюу civil law system, нийтлэг буюу common law system гэсэн хүрээнд ярих болсон. Дэлгэрүүлж монгол хэл дээр орчуулагдсан К.Е. Осакве-ийн Харьцуулсан эрх зүй сурах бичгээс үзнэ үү./

⁴ Ж.Оюунтуулалал "Шударга ёсны хэмжүүр" сэтгүүл. УБ., 2013 он, №1

⁵ ГТХАН-ээс эрхлэн гаргасан. "Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар". УБ., 2010 он. 156 дахь тал

талаар Иргэний хуульд тусгагдаагүй, гэтэл 89 дүгээр зүйлийг үндэслэн, төрийн өмчийг түрээслэх этгээдийг хууль ёсны эзэмшигчээр тогтоосон байгаа¹ нь онолын үндэслэлд нийцэхгүй юм.

Эзэмшлийн бий болгосон үндэс нь эргэлзээгүй зүй ёсны дагуу байгаа нөхцөлд хууль ёсны эзэмшигчээс хөрөнгийг шаардаж болохгүй /ИХ 93.1/ болохыг хууль тогтоогчоос тогтоосон нь шүүх өмчлөгч бусдын хууль бус эзэмшлээс хөрөнгө гаргуулах маргааны шийдвэрлэхдээ бодитой нөлөөлөл, удирдлагандаа авах байдлаар үүссэн эзэмшлийн үндэс хууль ёсонд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийхээр заасан, үүний эцэст эзэмшилд хөрөнгө үлдэх эсэх нь шийдвэрлэх болохыг анхаарах нь зүйтэй байна.²

Эзэмшлийг хэрэгжүүлэгч субъект болох эзэмшигчтэй холбоотой дараахи ойлголтуудыг авч үзье.



Судлаач, Хууль бус эзэмшигчийг гэм

буруугийн байдлыг үндэслэн шударга ба шударга бус эзэмшигч гэж ангилна. Эд юмсын эзэмшлийг шударгаар олж авах гэдэг нь хөрөнгийн эзэмшлийг бий болгохдоо зохих этгээд шилжүүлж байгааг, зохих аргаар хөрөнгийг олж авч байгаа зэрэгт анхааралтай хандсаны үндсэнд боломжит бүхий л арга хэмжээг авсан, улмаар өөрийгөө эзэмших эрхтэй гэж тооцсон эсэхийг шалгуур болгож үзнэ. Эд юмсыг эзэмшилдээ олж авах үедээ өөрийгөө тухайн эд зүйлийг эзэмших эрхгүй гэдгийг мэдэж байсан, энэ үйлдлээ нягтласан бол мэдэх боломжтой байсан этгээдийг шударга бус эзэмшигч гэнэ.³ гэж тодорхойлсон байна.

Шударга ба шударга бус эзэмшигчийн Иргэний хуулийн 90 дүгээр зүйл болон 94, 95-р зүйл дэхь эрх, үүргийг харьцуулан авч үзвэл,

¹ БЗ, ЧД, СБД-ийн 2015 оны 8 дугаар сарын 18-ны 5474 тоот шүүхийн шийдвэр

² Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх. "Иргэний эрх зүйн онол, практик" /илтгэл, магадлалын эмхтгэл/ УБ., 2017 он. 14 дэх гал

³ Ц.Давхарбаяр. "Эдийн баялгийн эрх /эд юмсын эрх/. УБ., 2017 он. 40 дэх гал

д/д	Хууль ёсны бус эзэмшигч			
	Шударга эзэмшигч		Шударга бус эзэмшигч	
	90.2, 94 дүгээр зүй		95 дугаар зүйл	
	Эрх	Үүрэг	Эрх	Үүрэг
1.	Өөрийн эзэмшлээ авчсан эд хөрөнгөө гурван жилийн дотор шинэ эзэмшигчээс буцаан шаардах эрхтэй.	Эд хөрөнгийг эзэмших эрхгүй буюу эд эрхээ авчсан шударга эзэмшигч нь уг эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан огох үүрэгтэй.	Эд хөрөнгийг хадгалах, арилах, засан сайжруулахад зориулж гаргасан зардал нь эрх бүхий этгээдэд орох ашгийг нэмэгдүүлсэн тохиолдолд дээрх зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.	Эрх бүхий этгээдэд эд хөрөнгө, эсхүл эрхийн үр шимийг буцааж огох үүрэгтэй.
2.	Үр шимийг буцааж огох үүрэг хүлээхгүй, оортоо үлдээх эрхтэй.	-	-	Хэрэв өөрийн буруугаар үр шимийг олж авч чадаагүй бол олох ёстой байсан үр шимийг нөхөн төлөх үүрэгтэй.
3.	Холбогдох зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.	-	-	-
4.	Өөрийн шаардлага хангагдах хүртэл эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцааж огохоос татгалзах эрхтэй.	-	-	-
	Хамгаалалт Иргэний хуулийн 92.17		Хамгаалалт	
	Шударга эзэмшигчийн эд хөрөнгө түүний эзэмшилд нь байгаа боловч эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад болж байвал уг саадыг арилгуулахаар өмчлөгчийн нэгэн адил шаардах эрхтэй.		-	

Дээрх хүснэгтээс шударга эзэмшигч болон шударга бус эзэмшигчийн эрх, үүрэг, хамгаалалтыг харьцуулан харж болно.

Иргэний хуулийн 89.3-т: Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна гэж хуульчилжээ. Тухайлбал, шууд эзэмшигч нь түрээслэгч, хөлслөгч, узуфрукт эзэмшигч, хадгалагч зэрэг эд хөрөнгийг эзэмших эрхийг биечлэн хэрэгжүүлж буй этгээд, харин шууд бус эзэмшигч нь эд хөрөнгийн хувьд эзэмших эрхийг биечлэн хэрэгжүүлээгүй ч эзэмших эрх нь хадгалагдаж буй этгээд буюу түрээслүүлэгч, хөлслүүлэгч, узуфрукт өмчлөгч, хадгалуулагч зэрэг байна.

Шууд эзэмшил нь заримдаа бодит байгаа эзэмшил гэж нэрлэгдэх тохиолдол бий, энэ нь шууд нөлөөлдөө оруулж, удирдаж байгаа нөхцөлд үүсдэгтэй

холбоотой байдаг. Шууд бус эзэмшил /шууд ба шууд бус эзэмшлийг давхар эзэмшлийн онол ч гэж нэрлэдэг. Тус ангилалын агуулга нь нэг эд зүйлийг 2 этгээд эзэмших үүднээс хамгаалалтыг аль аль нь хэрэгжүүлэх боломжтой байдгаас ийнхүү нэрлэгддэг./ гэдэг нь эзэмшлийн агуулгыг хэрэгжүүлэх иргэн объекттой гараар хүрэлцээгүй тохиолдолд ч гэсэн тооцох хуулийн дагуух онол юм.¹

Үндэсний эрх зүйн тогтолцоо, салбар эрх зүй, институт, бүлэг, зүйл, хэсэг бүгд уялдаа холбоотой, гинжин хэлхээтэй. Р.Дворкиний онолоор хууль тогтоомж хоорондоо цуврал роман шиг холбоотой, цул, бүхэллэг чанартай аж.² Хуулийн тогтолцоо нь нэг түвшинд орших харилцан зохицсон хэм хэмжээнүүдээс бүрддэггүй. Харин ч эсрэгээр эрх зүйн цэвэр онолын үүднээс судалж үзвэл харилцан холбоотой, шаталсан хэм хэмжээнүүдийн бүтэц л байдаг. Тиймээс хуулийг тайлбарлахад эрх зүйн хэм хэмжээнүүдийн шатлалын бүтцийг мэдэх нь нэн чухал.³ гэжээ.


Иргэний хуулийн бүтцээс өмчийн эрх зүй, үүргийн эрх зүй, зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүй, хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй гэсэн иргэний эрх зүйн харилцааны тогтолцоог харж болно. Харилцааны тогтолцоотой холбоотойгоор тодорхой бодлого, тохиолдол, маргааныг шийдвэрлэх, хууль зүйн дүгнэлт хийхэд хуулийн системчлэлийн дагуу хуулийн хэрэглээ

нь өөр өөр байна. Өмчийн тогтолцоонд өмчлөгчийн дараахи шаардах эрхүүд хамаарна. Шаардах эрх тус бүр нь хууль хэрэглээний онцлогуудыг агуулж байдаг.

Өмчийн тогтолцоонд өмчлөгчийн холбогдох шаардах эрхүүд хамаардагийг иргэний хуулын системчиллээс харж болно

Чарлес Дохан, Эрх зүй нь эрх, үүргийг хийсвэр байдлаар авч үздэггүй, харин харилцааны асуудлын хүрээнд авч үздэг. Хүн болон эд зүйлтэй харьцах харилцаа нь гүн ухааны ярианд утга агуулгатай байж болох ч энэ нь хууль ёсны хувьд тодорхой агуулгагүй, учир нь тийм эрх шүүхэд нэхэмжлэл гаргаж, түүнийг хамгаалж чадахгүй гэж тэмдэглэсэн байна. Энэ утгаар өмчийн тухай ойлголт нь эрх зүйн харилцааны түвшинд тодорхойлогдон өмчлөгч болон өмчлөгч бус этгээдийн хоорондын эрх, үүргийн хамааралтай байдлаар тайлбарлагдах болов.⁴

Өмчийн эрх зүйн агуулгын илрэл, бүтэц



¹ Ц.Данхарбаяр. "Эдийн баялгийн эрх /эд юмсын эрх/". УБ., 2017 он. 55, 56 дахь тал
² Н.Лүндэндорж. "Шүүх эрх мэдэл" сэтгүүл. УБ., 2015 он дугаар №1, 15 дахь тал
³ Мөн тэнд. 7 дахь тал

⁴ Г.Амаржаргалын. "Хувийн эрх зүйн онол". УБ., 2020 он. 139 дэхь тал /Charles Donahue, Jr. Future of the Western concept of Property predicted from its past. Ed J.Roland Pennock and John W.Chapman, Property /1980/, 31./

Өмнөх эрхийн агуулга нь дараагийн эрхийн агуулгын урьдач нөхцөл нь болохоор байгааг дээрх эрхийн агуулгуудаас харж болно.

Дүгнэлт,

Монгол улс 1992 оны шинэ үндсэн хуулиар хувийн өмчийг анх удаа хүлээн зөвшөөрч, хүний өмчлөх эрхийг баталгаажуулан хэрэгжүүлж байгаа боловч бодит амьдралд өмчлөх эрхийг хууль бусаар олж авах, энэхүү эрхийг зөрчих явдал түгээмэл байхаас гадна Үндсэн хуулийн хувийн өмч, өмчлөх эрхтэй холбоотой заалтууд ч зөрчилтэй байгаа талаар эрдэмтэн судлаачид ярьж хэлэлцсээр байгаа билээ. Энэ нь юуны өмнө хувийн өмч, өмчлөх эрхийн талаарх сэтгэлгээний түвшинтэй шууд холбоотой юм.¹ гэжээ. Судлаачид өмчийн эрх зүйтэй холбоотойгоор онолын үзэл хандлагуудыг өргөн хүрээтэйгээр судлан авч үзжээ.

Цаашид өргөн хүрээнд эдийн болон эдийн бус баялгийн эрхийн онол, үзэл баримтлалуудыг нарийвчлан судалж, холбогдох хуулийн зохицуулалттай уялдуулан авч үзэж, цаашдын онолын хандлагыг тодорхойлох нь чухал юм. Иргэний хуулийн бүтэц, иргэний эрх зүйн харилцааны тогтолцооны дагуу өмчлөх эрхтэй холбоотой өмчийн маргааныг шийдвэрлэхдээ өмч, эзэмшил, өмчлөл, өмчийн эрх зүйн агуулгын илрэл болон бусад өмчийн эрх зүйтэй холбоотой онолын болон философи суурь үндэслэлийг танин мэдсэн байх нь зайлшгүй зүйл. Энэ нь тодорхой үүссэн харилцаанд онолын суурь үндэслэлээр

хандах, улмаар бодитой шийдвэр гарахад эерэгээр нөлөөлнө гэж үзлээ.

¹ Г.Агар-Эрдэнэ, “Хувийн өмчийн онол”, УБ хот, 2009 он, 10-р талд

ЭДИЙН БУС ГЭМ ХОРЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ



Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн магистр
Д.Цолмонгэрэл

Түлхүүр үг: гэм хор, эдийн бус хохирол, эрүүл мэнд, нөхөн төлбөр, хуулийн хийдэл, шүүхийн практик, эрх зүйн шинэтгэл

Удиртгал

Нийгэм өөрчлөгдөн хувьсахын хэрээр хүний хэрэгцээ шаардлага, хууль ёсны эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин өөрчлөгдсөөр байгаа билээ. Хүний эрхийг хангахаар хуульчилсан зохицуулсан, заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээ улам бүр нарийвчлагдсан боловсронгуй болж байна. Монгол Улсын хувьд эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэд хэдэн шат дараатайгаар авч хэрэгжүүлсээр ирсэн. Хуулиар хамгаалсан эрх ашиг хөндөгдсөн үед учирсан хохирлыг хэрхэн барагдуулж ирсэн, тэр дундаа эдийн бус буюу материаллаг бус хохирлыг барагдуулах асуудлыг хуульчлан тогтоогоогүй ч сэтгэл санааны, нэр төрийн зэрэг

хохирол, хор уршгийг тооцож гаргах зайлшгүй шаардлага өнөөг хүртэл тулгамдсан асуудлын нэг байсаар байна. Тиймээс эрх зүйн шинэтгэлд зайлшгүй тусгагдах гэм хорын хохирол барагдуулах талаар зарим хуулинд нарийвчилсан зохицуулалт байхгүйн дээр хуулийн хийдэл, зарим шүүхийн практикт орхигдуулж байгаа бодит байдалд үндэслэн энэхүү өгүүллийг бичихийг зорьсон билээ.

1. Хохирол хэрхэн барагдуулах эрх зүйн уламжлалын талаар авч үзвэл

Төв Азийн цээжинд анхны төрт улсыг байгуулан тулгар төрөө¹ баталгаажуулсан цагаас эхлэн үзвэл улс орны хөгжилд эрх зүйн ач холбогдол маш их. “Ши-Цзи”-д тэмдэглэснээр үзвэл Хүннүгийн баримталдаг хуулиар “Ирт үзүүрт нэг гаргавал цаазаар аваачна. Хулгайн мал ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөн хэрэгтнийг бэрээдэнэ, хүндийг цаазаар авна” хэмээн тэмдэглэснээс үзвэл эрх зүйн эх сурвалж болох хууль цааз гарч, тэдгээрийн заалтыг зөрчвөл гэмт хэрэг гэж үзэн ял шийтгэл оногдуулан эдлүүлж байсан эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэн бий болж, үйлчилж байсныг харуулж байгаа тодорхой баримт мөн.

Их Монгол Улсын үед аж байдлын шинжтэй зарим үйлдэл тухайлбал хүний аж амьдралд хор хохирол

¹ Цолмонгэрэл Д. Үндсэн хууль ба нэгдсэн тулгар төрийн тухай. Хууль дээдгэх ёс сэтгүүл. 2018. №3

² Сүхбаатар Г. Монголчуудын эртний овог Хүннү. УБ., 1992. 89 дэх тал

учруулах үйлдлийг цээрлэн, хориглож байсан бөгөөд хулгай их дээрэмдэх, архи уух, завхайрахыг хориглосон заалт нэгдсэн улсын хуульд байсныг эрдэмтэн мэргэд бүтээлдээ дурдсан. Рашид-Ад-Дины “Судрын чуулган” бүтээлд элгээр садарлах, бусдын юмыг булаан дээрэмдэх, галд хутга дүрэхийг хориглож, тэдгээрийг үйлдэгсэд гэмтэн болох тухай өгүүлсэн байна.¹ Өөрөөр хэлбэл хохирол барагдуулах талаар зааж өгсөн нь “Их Засаг” хууль бол ардчилсан шинжтэй гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж бодлогыг хэрэгжүүлж байсан гэж дүгнэж болохоор байна².

Онолын үүднээс прагматик хувьд ч Монголын нэгдсэн улс Чингис хааны эрүүгийн бодлого нь Монголчуудын нэгдмэл байдлыг хангах, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, нийгэм, төрийн байгууллага, хаан, төрийн түшмэдүүд иргэний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, зан заншил, байгалийн баялгийг гэмт халдлагаас хамгаалахад чиглэж байжээ.

Монголын төрийн түүхэн нэгэн хэсэг болох “Халх журам” хуулийн нэгэн чухал онцлог нь “нохой хуцаж ба зууж хүн үхэхээс хүнд тэмээгээр ор болох мал хүнийг ямраараа л бас тэмээгээр ор босго³” гэж орчиндоо байсан учруулсан гэм хорыг арилгах арга хэлбэрийг

заажээ⁴. Өөрөөр хэлбэл тухайн цаг үеийн нэгтгэх бодлогоор хохирлыг арилгах, барагдуулахаар хууль гарган хэрэгжүүлж байжээ.

Төрийн байдал тогтворгүй байсан зэрэг шалтгаанаас 1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалын үр дүнд Бүгд Найрамдах засаглалыг бүрдүүлэн, Үндсэн хуульт төрийн байгуулалыг бэхжүүлэхийн тулд холбогдох хууль тогтоомжийг боловсруулж нийгмийн байгуулалыг социализм хэлбэрээр хөгжүүлсэн нь хүний эрхийг хэт орхигдуулсан, жам ёсны эрхийг хамгаалах суурь механизм дутагдалтай байсан гэж үзэж болно. Нэг намын тогтолцоотой, эдийн засгийн хувьд хараат төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, социализм суурьтай, хөрш орноосоо хэт хараат, түшмэг улс мэт оршоор ирсэн он жилүүд нь нийгмийн давхраажилтийн эрс ялгарал, тэгш бус хуваарилалтыг бий болгосон гэхэд хилсдэхгүй болов уу.

Монгол Улсад нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд томоохон өөрчлөлт гарч, улмаар 1992 онд шинээр Үндсэн хуулиа баталсан нь эрх зүйн эрс шинэчлэлт хийх эх суурийг тавьсанаас гадна иргэдэд урьд өмнө эдлэж байгаагүй олон эрхээ бодитойгоор эдлэх боломжийг бүрдүүлсэн билээ.

Хуулиар хамгаалагдсан эрх ашиг зөрчигдсөнөөс учирсан эдийн болон эдийн бус хохирол хүлээсэн этгээд өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх буюу сэргээлгэх эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн “...бусдын хууль бусаар учруулсан

¹ Дашням Н. Монгол Улсын төр эрх зүйн түүх. тэргүүн боть УБ., 2005. 147-дахь тал

² Цолмонгэрэл Д. Гэм хор: эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл. Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаан 2020.

³ Ор босгох - а. Ор нохох; б. Худалдах буюу идэх малыг содох гэсэн утгатай. https://mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=68713

⁴ Монхжаргал Т. Монгол Улсын иргэний цаазын товчоон. УБ., 2017. 95-дахь тал

хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” хэмээн тусгалаа олжээ.

“Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлэх болсоноор эрх зүйн шинэтгэлийн бодитой өөрчлөлтүүд явагдсаар ирсэн.

2. Хохирол барагдуулах эрх зүйн зохицуулалтын тухайд

Хохирол гэдэг нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, гэмтээсэн, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэрэг ордог.

1946 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ эрүүл мэндийн ойлголтыг “Эрүүл мэнд гэдэг нь хүн зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын цогц бүрдэл мөн” хэмээн тодорхойлсон байна. Энэ тодорхойлолт бол биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг хамтад нь авч үзсэнийг илтгэж байгаа бөгөөд гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол амссан этгээд зөвхөн сэтгэл зүйгээр төдийгүй бие махбодиороо хохирдог болохыг илэрхийлж хүнд орчин тойрны харилцаа болон бусад этгээдийн үйлдлийн үр дүнд сэтгэл хөдлөл үүсдэг гэдгийг нотлон харуулсан билээ.

Хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээний үнэлгээ тогтоогүй байгаа өнөө үед хохирогчид учирсан хохирлыг арилгах, эрхийг нь нөхөн сэргээхэд зориуд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал байна. Ийнхүү төрөөс тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд төр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх шаардлагатай байна.

Ихэнх тохиолдолд буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх хэсэгт “...хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхийг²” мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч эрх бүхий албан тушаалтны Тэдний хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд “эдийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй³” гэж заасан ч хохирол, хор уршгийг хэрхэн

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Уб., 2017

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Уб., 2017

¹ УИХ-н 1998 оны 1 дүгээр сарын 22-ы өдрийн 18 дугаар тоот тогтоолын хавсралт 1.

тооцож гаргуулах тухай Эрүүгийн болон эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Нөгөө талаар Иргэний журмаар нэхэмжлэл гаргаж, мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжтой ч Иргэний хуульд гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны гэм хорыг арилгах зохицуулалт тусгайлан хуульчлагдаагүй. Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ".....зэрэг зайлшгүй бүх зардал" гэдэгт хамааруулан шийдвэрлэж болох юм.

Эрх зүйн шинжлэх ухаан эдийн бус хохирол байдаг болохыг нэгэнт хүлээн зөвшөөрч хуульчлан шүүхээр шийдвэрлэх болсон энэ үед уг хохирлын хэмжээг хэрхэн тогтоох, үнэлэх гэх мэтчилэн дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэх цаг нэгэнт болжээ.

Гэхдээ үүсэж гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бүгдийг тооцон хохирол хэмээн барагдуулах нь биелэхэд бэрхшээлтэй учир энэ талаар оновчтой хуульчлан зөв үнэлэх явдал ихээхэн ач холбогдолтой байна. Мөн энэ байдлыг төлөвшүүлэн тогтооход бусад орны жишиг, дотоодын эрх зүйн харилцааны зохицуулалт маш чухал юм.

Энэ асуудлыг шийдвэрлэхдээ хохирогчийн сэтгэл зүйд нөлөөлөх боломжийг судалж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд ямар хэмжээний мөнгөн хөрөнгө зарцуулагдахыг тооцох аргачлал гаргаж мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ үйл ажиллагааг эрх зүйн харилцаанд хэвшүүлэхийн тулд гэмт хэргийн улмаас тухайн этгээдэд бий

болсон сэтгэл зүйн хямрал, дарамт, шаналал гэх мэт сөрөг үр дагавар" болон "бие эрхтний өвчин, шаналал, зовиур"-ыг шинжлэх, үнэлж дүгнэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зохих газраас эрх олгож тэдний дүгнэлтийг эрүүгийн хэрэгт нотлох баримт болгох шаардлагатай.

Өнөөдөр Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэргийн улмаас учирсан эдийн хохирлыг арилгах буюу шийдвэрлэх асуудал онол практикийн түвшинд нэг мөр болсон гэж үзэх үндэстэй боловч харин гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг арилгах, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нилээд төвөгтэй байгаа бөгөөд энэ нь хүний эрхийг хангах асуудал болон эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн "Гэмт хэргийн улмаас учирсан хохирол" бодлогын судалгааг 2017 онд хийсэн бөгөөд зөвхөн эдийн хохирлыг барагдуулах талаар судалсан байна. Тиймээс гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг дагнан судалсан судалгаа хомс бөгөөд нарийвчилсан судалгааг хийж эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай.

Хүний зөрчигдсөн аливаа эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Гэтэл Монгол Улсад шинээр батлагдан мөрдөж буй материаллаг болон процессийн хуулиудад эдийн бус хохирлын хэмжээг хэрхэн тодорхойлох болон арилгах арга замыг зааж өгөөгүй, хуулийн заалтууд

нь өөр хоорондоо зөрөөтэй, хэрэглэхэд бэрхшээлтэй байгаагаас онол, практикт энэ талаар нэгдсэн ойлголт бий болоогүй байна.

Эдийн бус хохирлыг эрдэмтэн судлаачид янз бүрийн байдлаар тодорхойлсон байдаг. Тухайлбал,

- ▶ Академич С.Нарангэрэл “.....бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас амссан зан суртахууны ба бие махбодийн зовлон зүдгүүр шаналал” гэж эрх зүйн толь бичигт тодорхойлсон.
- ▶ Хууль зүйн доктор, профессор Т.Мөнхжаргал “Гэм хор гэдэгт хохирол төдийгүй санаа сэтгэлийн болон биеийн зовлон шаналал орно. Эд хөрөнгийн бус гэм хор эд хөрөнгийн бус харилцааг зөрчсөнөөс үүснэ. Тэрхүү зөрчил нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан байдлаар илэрдэг байна” гээд зөрчлийн улмаас санаа сэтгэлийн ба биеийн зовлон шаналал учирдаг тухай авч үзсэн байна.
- ▶ Профессор Д.Наранчимэг “Материаллаг бус гэм хор нь эдийн засгийн агуулгагүй, өртгөөр илэрхийлж болдоггүй, тухайн этгээдээс салшгүй, амин хувийн шинжтэй /зөрчигдсөн/ эрх байна” гээд “амь нас хохирсон, эрүүл мэндийг сарниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг үнэ өртгөөр илэрхийлж болохгүй гэм хор учирсан байх”-ыг үүнд багтаажээ.
- ▶ Судлаач Н.Туяа “Эд хөрөнгийн

бус гэм хор гэдэг нь иргэний төрөлхийн болон хуулиар олгогдсон эд хөрөнгийн бус эрхэд халдсан болон зөрчсөн үйлдлийн улмаас учирсан сэтгэл санаа, бие махбодийн зовлон шаналгааг хэлнэ” хэмээн тодорхойлсон байна.

- ▶ Судлаач Ш.Үнэнтөгс “Эдийн бус, гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно”.
- ▶ Судлаач П.Баянбаатар “Сэтгэл санааны гэм хор гэдэг нь иргэний зан суртахуун, эсвэл хуулиар түүнд олгогдсон эдийн болон эдийн бус баялагт халдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас үүсэж байгаа бие махбодийн болон ёс суртахууны хохирол, зовлон шаналал” гэж тус тус тодорхойлжээ.

Эрдэмтэн судлаачид хэдийгээр эдийн бус хохирлыг янз бүрээр авч үздэг боловч ерөнхийдөө “бусдын хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг зөрчсөнөөс үүссэн сэтгэл зүйн болон бие махбодийн таагүй үр дагавар юм” гэсэн үзэл дээр санал нэгддэг ажээ.

Судлаачийн зүгээс Т.Мөнхжаргал, судлаач Н.Туяа нарын эдийн бус хохирлыг тодорхойлсон тодорхойлолтод шүүмжлэлтэй хандах дараах үндэслэл байгаа юм. Эдийн бус хохирол нь санаа сэтгэл, бие махбодийн таагүй үр дагавар мөн л юм бол зөвхөн эдийн бус эрх зөрчигдсөнөөс бий болохгүй. Жишээ нь: эд хөрөнгөө хулгайд алдсан хүн ч бас санаа сэтгэлийн зовлон шаналалыг эдэлнэ. Жишээ нь: өвөг дээдсээс уламжлан ирсэн үнэ цэнэтэй эд хөрөнгө, эсхүл орон байраа

алдсан этгээдийн эдийн бус эрх биш харин эдийн эрх л зөрчигдсөн боловч тодорхой хэмжээгээр санаа сэтгэлийн зовлон шаналал эдэлдэг.

Иймээс гэмт хэргийн улмаас буй болсон материаллаг бус хохирлыг тооцож гаргадаг олон улсын жишиг хандлагыг авч үзвэл зарим улсад тодорхой өгөгдлийн бүдүүвч ашиглан мөнгөн хэлбэрээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, зарим улсад шүүгчийн үзэмжээр шүүхийн практикт тогтсон жишгийг харгалзан хохирлыг барагдуулдаг байна.

Хохирлыг тооцон барагдуулах хамгийн түгээмэл хэрэглэддэг хүснэгтийн арга бөгөөд тусгай томъёогоор математик аргачлалд оруулж тооцох арга юм. Жишээ нь: Оросын Холбооны Улсад хүснэгт сэтгэл санааны нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход тусгайлсан томъёоны дагуу тусгай хүснэгтэд оруулан учирсан хэмээн үзэж байгаа сэтгэл зүйн хохирлын хэмжээг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, тодорхой гэмт хэрэгт хамааруулан сэтгэл санааны хохирлыг гаргадаг байна.¹

Харин Монгол Улс сэтгэл санааны хохирлыг үнэлэх эрх зүйн орчин, загвар, тооцох аргачлалгүйгээс үүдсэн хор хөнөөлийг харуулсан ганцхан тохиолдлыг дурдъя.

► Завханы Эрдэнэ-Очирын гэх “алдартай” кейс бий. Ч.Эрдэнэ-Очирт гурван удаа цаазын ял сонсгож, 6.8 жил гянданд хориод

цагаатгасан. Түүнчлэн шүүхээс хоёр удаа 24-25 жилийн хорих ялаар шийтгүүлж байв. Энэ их зовиур шаналал, хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохирлыг мөнгөөр үнэлсэн ХЭҮК²-ын төлөөлөн гаргасан нэхэмжлэлд:

Тухайн үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, бусад зардлыг тооцож, цаазаар авахуулах ялтай хүмүүсийг тусгаарладаг тусгай өрөөнд хоносон, гянданд 4.2 жил долоо хоног ял эдэлсэн, нотлогдоогүй, хилс хэрэгт урьдчилан хорих байранд 2.6 жил 16 хоног хоригдсон сэтгэл санаа, эрүүл мэндийн хохиролд нийт 53.699.225 төгрөг нэхэмжилсэн³.

Шүүхээс 53.699.225 төгрөгийн нэхэмжлэлээс 18.010.625 төгрөгийн нэхэмжлэлийг хангаж 35.688.600 төгрөгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзсэн байна. Хууль шүүхийн байгууллага хүн амины хэрэгт хөдөөгийн малчин залууг шалгахдаа гурван удаа цаазын ял сонсгож, 6.8 жил гянданд хорьсон байдаг. Харин эцэст нь Монголын төр гэмгүй иргэнээ хилс хэрэгт хэлмэгдүүлснээ хүлээн зөвшөөрч Улсын дээд шүүхээс цагаатгахдаа энэ хугацаанд амссан зовлон шаналлын өмнө ямар хариуцлага хүлээж, хэдэн төгрөгийн нөхөн олговор олгосныг харуулж байна.

► Улсын Дээд шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 230 дугаартай тогтоолд⁴ М нь танхайн сэдэлтээр, онц

¹ Эрделенский А.М. Компенсация морального вреда: анализ и комментарий законодательства и судебной практики. - 3-е изд., испр. и доп. - М.: Волтерс Клувер, 2004.

² УИХ-н 1998 оны 1 дүгээр сарын 22-ы өдрийн 18 дугаар тоот тогтоолын хавсралт 1.

³ <http://www.zms.mn/a/81504>

⁴ www.shuukh.mn

харгис хэрцгий аргаар хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж хүнийг санаатай алах гэмт хэрэгт холбогджээ. Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүх, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 508 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч М-ээс оршуулгын зардал 3.976.100 төгрөг гаргуулж шийдвэрлэхдээ хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С.Б-ийн гаргасан сэтгэл санааны хохиролд 50 сая төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэхгүй орхигдуулсан буруу байна гэж үзжээ. Улмаар амь хохирогч Э-ийн ар гэрт 3-17 насны гурван хүүхэд үлдсэн ба амьжиргааны түвшин доогуур байдлыг харгалзан шүүгдэгч М-ээс сэтгэл санааны хохиролд тавин сая төгрөг гаргуулах тухай хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С.Б-ийн гаргасан нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ.

- ▶ Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 267 дугаар шийдвэрт¹ Хариуцагч Т.Т нь зам тээврийн осол гарган Д.Б-ийн охин Н.П-ийн амь насыг хохироосон. Д.Б нь сэтгэл санааны хохиролд 25.000.000 төгрөг, талийгаач охин Н.П-ийн хүү П.У-д тэжээгчээ алдсаны тэтгэмжийн зөрүү 1.820.000 төгрөг, П.У-г 18 нас хүртэл нь тэтгэлэг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Иргэний хуулийн 497

дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл/эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй байх ба хариуцагч Т.Т нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн болгоомжгүй үйлдлийн улмаас хохирогч Д.П-н амь насыг хохироосон гэм буруутай болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байх тул хохирогчид учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй байх боловч Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2 дах хэсэгт эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй, гэхдээ гагцхүү хуульд заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр заасан байна. Өөрөөр хэлбэл зөвхөн Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт заасныг үндэслэн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээхээр хуульд тусгайлан заажээ. Иймд хариуцагч Т.Т-с зөвшөөрсөн хэмжээгээр буюу 5.000.000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Д.Б-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 20.000.000 төгрөгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзжээ.

¹ www.shuukh.mn

Дээр дурдсан шүүхийн шийдвэр, тогтоолоос харвал гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг барагдуулахаар шийдвэрлэж буй практик нь харилцаан адилгүй тул сэтгэл санааны хохирлыг үнэлж, хохирлын хэмжээг тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэл санааны хохирлыг тооцож ажиллагаа явуулж тусгай байгууллагын дотор нэгж ажиллуулж болно. Бельги, Швед, Финланд улсын зөвлөмж шиг тодорхой тохиолдлоос хамаарч мөнгөн дүнгийн бага, дээд хэмээг тогтоож өгч болно. Мөнгөн дүнг хатуу гэхээс илүү сонгох боломжтой байдлаар журамлах хэрэгтэй¹.

Дүгнэлт санал

Сэтгэл санааны хохирлыг үнэлэхдээ хуульч, сэтгэлзүйч, шинжээч зэрэг нарийн мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн тусгай нэгж байгуулан, шинжээчийн дүгнэлтээр шүүх шийдвэрээ гаргах боломжтой байдлаар зохицуулж болно. Шүүхийн шинжилгээний байгууллагад сэтгэл санааны хохирлыг үнэлдэг нэгж бий болсноор Иргэний болон Шүүхийн шинжилгээний тухай хуульд тусгахаас гадна бусад улс орон шиг гэм хорын хариуцлагын акт зэргээр бие даасан хуультай болох нь эрх зүйн хамгийн чухал шинэтгэл гэж харж байна.

Иймээс Эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн 19 дүгээр зүйлд "Хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн тухай хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, энэ талаарх

олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол судлах арга хэмжээ авч, хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгоно²" гэж заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх болон иргэний хуулинд тусгагдсан эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг барагдуулах тусгайлан зохицуулалт бий болгох шаардлагатай. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг 2 удаа шинэчлэн найруулсан бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх зохицуулалтын талаар тусгайлан зохицуулаагүй нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хуульчилсан материаллаг хохирлын хэмжээг Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим төрлийн гэмт хэргийн улмаас буй болсон эдийн бус гэм хорыг зөвхөн Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар хязгаарлах бус сэтгэл санаа, бие махбодын хохирол учирсан тохиолдолд мөнгөн хэлбэрээр тооцон, нөхөн төлбөр авах хэрэгтэй байж болохоор агуулгыг өргөжүүлж, өөрчлөлт оруулах нь зүйн хэрэг. Эдийн бус гэм хорыг үнэлэх, нөхөн төлүүлэх аргачлал, журмыг нарийвчлан хуульчлах, Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, мэдээ мэдээлэл тараасантай холбоотой учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой. Харин бусад зөрчлөөс үүссэн эдийн бус, гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг арилгах арга хэлбэрийг тодорхойлсон

² УИХ-н 1998 оны 1 дүгээр сарын 22-ы өдрийн 18 дугаар тоот тогтоолын хавсралт 1.

эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.8, 13.10, 13.11 дүгээр зүйлүүдэд заасан тодорхой гэмт хэргээс бусад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч нарын хувьд өөрт учирсан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх эрх, үүсэх хууль зүйн үндэслэл нь тодорхой бус гэж үзэж болно.

Бодит амьдралд дээр дурдсанаас бусад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч нарын нэхэмжилсэн сэтгэл санааны хохирлыг хууль эрх зүйн орчин бүрдээгүй гэх үндэслэлээр хангахгүй байх нь Үндсэн хуулиар хамгаалсан иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төр хамгаалах, Үндсэн хуулийн суурь зарчмууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгод нийцэх үү гэдэг нь анхаарах ёстой асуудал болоод байна. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.8, 13.10, 13.11 дүгээр зүйлд зааснаас бусад гэмт хэрэгт хохирогчийн сэтгэл санааны гэм хорыг арилгах хуулийн зохицуулалт байхгүй хэдий ч зарим төрлийн гэмт хэргийн хувьд иргэний хувьд Иргэний хуулийн 505.1 дэх хэсэгт заасан зэрэг зайлшгүй бүх зардал гэдэгт хамааруулан шийдвэрлэж болох зэрэг саналыг дэвшүүлж байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, яам, Засгийн газрын бусад байгууллага, бүх шатны Засаг даргын шийдвэр Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах зарчимд

хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулж, хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч, цаашид хууль тогтоомжийн төсөл хүний эрхийг хангах шаардлагад хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийдэг журам тогтоох ажиллагааг тогтмол явуулж байх шаардлагатай байна.

Ашигласан ном зүй:

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Иргэний хууль
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр
5. Эрүүгийн хууль
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Хоёр. Ном сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Ванчигмаа М. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дэхь иргэний нэхэмжлэл. Уб., 2020
2. Дашням И. Монгол Улсын төр эрх зүйн түүх. тэргүүн боть Уб., 2005. 147дахь тал
3. Мөнхжаргал Т. Монгол Улсын иргэний цаазын товчоон. Уб., 2017. 95 дахь тал
4. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг Хүннү. Уб., 1992. 89 дэх тал
5. Төрболд О. Улс орнууд сэтгэл санааны хохирлын сан байгуулж, хуримтлал үүсгэдэг. 2020.11.9. № 216 (6441). Зууны мэдээ сонин
6. Цолмонгэрэл Д. Үндсэн хууль ба нэгдсэн тулгар төрийн тухай. Хууль дээдлэх ёс сэтгүүл. 2018. №3
7. Цолмонгэрэл Д. Гэм хор: эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл. Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаан 2020.
8. Эрделевский А.М. Компенсация

морального вреда: анализ и комментарий законодательства и судебной практики. - 3-е изд., испр. и доп. - М.: Волтерс Клувер, 2004.

9.

Гурав. Цахим эх сурвалж

1. https://mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=68713
2. www.legalindo.mn
3. www.shuukh.mn

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНД ПРОКУРОР ОРОЛЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

(Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд)



Монголын Криминологичдын холбооны
судлаач, Хууль зүйн магистр (LL.M)
С.Номынбаясгалан

Агуулга

I. Оршил

II. Үндсэн асуудал

А. Монгол Улсын (БНМАУ–ын) Үндсэн хууль дахь прокурор “шүүх хуралдаанд оролцох” эрх зүйн үндэслэлийн тухайд

1. Социалист эрх зүйн зохицуулалтаас эх газрын эрх зүйн зохицуулалт руу шилжих “эхлэл” тавигдсан нь
2. “Зарчмын” шинжтэй өөрчлөлт гэсний учир
3. Прокурорын ерөнхий хяналтаас “шүүхийн хяналт” руу
4. Прокурор “албан үүргийн” дагуу оролцогч байсан нь

Б. Прокурор “төрийн нэрийн өмнөөс” шүүх хуралдаанд оролцох эрх зүйн асуудал

1. Эрүү, иргэний хэргийн шүүх хуралдаанаас “захиргааны хэргийн шүүх хуралдаан”-д прокурор оролцох асуудлыг онцлохын учир

2. Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурорын оролцох, оролцоог “үгүйсгэх” тусгай үндэслэлийн тухай товч өгүүлэх нь

3. Прокурорын оролцооны талаархи шүүмж

III. Дүгнэлт

I. Оршил

Захиргааны хэргийн шүүхийн “үндсэн” зорилго нь нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоож, түүний улмаас хохирсон иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах явдал юм.¹ Энэ чиг үүргээ хэрэгжүүлэх замаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд (1.2) заасан “төрийн үйл ажиллагааг хууль дээдлэх зарчим”-д захируулах, түүнчлэн Арван дөрөвдүгээр зүйлд (14.2) заасан иргэн, хуулийн этгээд болон төр, түүний албан тушаалтан хэн боловч “хуулийн өмнө эрх тэгш байх” зарчмыг амьдруулж, “эрх зүйт төрийг төлөвшүүлэх” үйлсэд хувь нэмрээ оруулдаг гэж үздэг байна.² Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны процессын хуульд прокурорыг захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд³

буюу “шүүх хуралдаанд”⁴ ямар нэгэн

“гомдол” гаргасан эсэхээ үл хамааран, холбогдох захиргааны албан тушаалтны гаргасан шийдвэрийн эсрэг прокурор дүгнэлт бичиж, Захиргааны хэргийн шүүхэд “хууль зөрчсөн” гэсэн үндэслэлтэй (хийсвэр хяналт бүхий) хянуулах эрх хэмжээтэй болсон байна. Зорчил шалган шийдвэрлэх тухай хуульд зорчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч нь Эрүүгийн хэргийн шүүхээс гадна “Захиргааны хэргийн шүүх” байх бөгөөд Захиргааны хэргийн шүүх Зорчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, ... дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, “прокурорын дүгнэлтээр” зорчил хянан шийдвэрлэх зохицуулалттай юм. Энэ нь прокурор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд “зорчлийн” хууль тогтоомжийн хэргжилтийг нэг мөр хянуулах үүднээс оролцож байж болох юм. Үүгээс үүдэн “Захиргааны хэргийн шүүх нь Зорчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зорчлийн хэргийг шийдвэрлэх, эсхүл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу ердийн журмаар шийдвэрлэхийн аль нь болох талаар эргэлзэлтэй асуудал үүсэж байх тул механикаар хуульчилсан алдааг залруулах” зөвлөмжийг (ХЗҮХ, Зорчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үндэс), (Судалгааны тайлан), Уб., 2018, 25 дахь талаас үзнэ үү.) гаргасан байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйл (Шүүх хуралдаанд оролцогч)-д “54.1.Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна гээд 54.2.Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч, хэргийн оролцогчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын бусад оролцогч гэнэ” гэж заасан байна. <https://www.legalinfo.mn/law/details/284?lawid=284> (Сүүлд үзсэн огноо: 2021.03.22) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйл (Шүүх хуралдаанд оролцогч) д “77.1.Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 17 дугаар зүйл, 77.2-т заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна. 77.2.Шүүх хуралдаанд оролцож байгаа хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ” гэж заасан. <https://www.legalinfo.mn/law/details/11703?lawid=11703> (Сүүлд үзсэн огноо: 2021.03.22)

Мөн Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “зохигч” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна. Энэ нэр томъёо нь иргэдийн процессын эрх зүйд хэрэглэгдэх учраас прокурор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүрээлэн

¹ Батсуурь М., Монгол Улсын захиргааны шүүхийн туршлага, цаашид анхаарах зарим асуудал, Шүүх эрх мэдэл сэтгүүл, Уб., 2015, №2, 23 дахь талаас үзнэ үү. (Цаашид “Батсуурь М., Дурдсан бүтэц” гэж товчилно. С.11.)

² Батсуурь М., Дурдсан бүтэц, 24 дэх талаас үзнэ үү.

³ Эрх зүйн зохицуулалт талаасаа, Зорчлийн тухай болон Зорчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг батлан гаргасантай холбогдуулан Захиргааны материаллаг, процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт (2017.05.18.) оруулсан. Нийнхүү Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан “энэ” нэмэлт, өөрчлөлтийн үйлчлэлийн хүрээнд хамаарагдах “гомдол” хэмээх нэр томъёог төлөрхийлсн “... Зорчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг ...” гэсэн хэсэг нь үндсэн хуулийг зөрчсөн гэж үзвэл Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэг хүсэлт гаргасан боловч, уг шаардлагыгханга үндэслэл, уялдаа холбоо, шалтгааныг тусгайлан тайлбарлаагүй байх тул Үндсэн хуулийн цэц (МУУХЦ, Дугаар №15/2018.11.21.-ийн үндэслэлээс авав)-ээс энэхүү асуудалд холбогдуулан дүгнэлт хийх боломжгүй” гэж үзсэн байна. Энэ үндсэн дээр зорчил гаргагч

оролцоогүй байхаар зохицуулсан байна. Иймд “хуульд прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зохицуулалт байхгүй” гэсэн үндэслэлээр захиргааны хэрэгт прокурор оролцуулах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх “шүүхийн практик” тогтсон тухай цөөнгүй судалгаанд дурдсан байна.¹ Үүнийг Монгол Улсын захиргааны процессын хуулиудын² түүхэн хөгжлөөс аваад үзвэл, Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцох, оролцооны асуудал “уламжлагдан шинэчлэгдэх хандлагаар бус харин шинэчлэгдэн уламжлагдаж” байгааг харуулж байна.

Гэвч Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09–ний өдөр баталсан Прокурорын тухай хуулийн³ 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэсний “. . . эсхүл өөрийн санаачилгаар

. . .” гэсэн нь ихээхэн анхаарал татсан “зохицуулалт” болсон байна. Энэхүү зохицуулалтад холбогдох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хүрээн дэх ойлголт, агуулгын үүднээс цухас хөндөн бичихийг зорилоо. Энэ асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн “. . . шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно . . .” гэсэн заалтын прокурорын “үндсэн” чиг үүргийн агуулгад холбогдоно. Үндсэн хуульд ийнхүү тодорхойлсон нь прокурор эрүү, иргэний болон “захиргааны” хэргийг хянан шийдвэрлэх (ажиллагаанд болоод) шүүх хуралдаанд оролцох (хууль зүйн) үндэслэл⁴ гэж ойлгож болох юм. (1992 оны) Үндсэн хууль нь социалист чиг баримжаа, тоталитар дэглэмд хамаарах Монголын өмнөх 3 үндсэн хуулиас мөн чанарын ялгаатай өөр буюу “ардчилсан” маягийнх гэж үздэг. Энэ нь түүний гол гол үзэл баримтлалаар тодорхойлогдож байдаг билээ.⁵ Тиймээс энэ илтгэлийн агуулга дээрхи байдлаас хөндийрөхгүй. Мөн түүнчлэн “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” тухай заалтын ойлголтын агуулгыг үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсч байна. Энэ ойлголтын агуулгад юу хамаарах асуудлыг тодруулахад энэ илтгэлийн зорилго бас оршино.

буй орчин, хүүхдийн эрх, нийтийн (нийгэмийн) эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлын хүрээнд “гуравдагч этгээд”-ээр оролцож болох юм. “Гуравдагч этгээдээр оролцуулж болох юм” гэсэн агуулгаар “энд” хэлсэн болохоос “Гуравдагч этгээд болно” гэсэн агуулгаар нигэрхийлэгддгүй болно.

¹ Баттулга Н., Мөнх-Эрдэнэ Т., Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, (Эмхэтгэл 1), УБ., 2018, 65 дахь талаас үзнэ үү.

² “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” болон “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулиудын зохицуулалтыг харьцуулж үнэлэж үү.

³ <https://www.legalinfo.mn/law/details/12702> (Сүүлд үзсэн огноо: 2020.02.20)

⁴ Номынбаясгалан С., Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцох эрх зүйн асуудал. Шүүх эрх мэдэл сэтгүүл, №4, УБ., 2019, 96 дахь талаас үзнэ үү. (Цаашид “Номынбаясгалан С., Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

⁵ Монгол Улсын Үндсэн хуулиуд, гэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, (1924-1992), Эмхэтгэл, УБ., 1998, 122 дахь талаас үзнэ үү.

II. Үндсэн асуудал

А. Монгол Улсын (БНМАУ–ын) Үндсэн хууль дахь прокурор “шүүх хуралдаанд оролцох” эрх зүйн үндэслэлийн тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (2000) хэмээх бүтээлд “. . . Эрүү, иргэний хэрэг, маргааныг хэлэлцэн шийдвэрлэх талаар хуулийн дагуу явуулж байгаа шүүх бүрэлдэхүүний ажиллагааг “шүүх хуралдаан” гэнэ. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно . . .” гэж тэмдэглэсэн¹ бол Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (2009) хэмээх бүтээлд “. . . прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина. Прокурор түүнчлэн шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар прокурор нь эрүүгийн, иргэний болон бусад /захиргааны/ төрлийн хэрэг хянан шийдвэрлэхэд төрийг төлөөлөн оролцдог. Шүүх хуралдаанд прокурор хэрхэн оролцохыг холбогдох хуулиудад . . . тогтоосон байна” гэж дэлгэрэнгүй тайлбарласан байна.² Харин Үндсэн хуулийн ойлгохуй (2017) гэсэн Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбарт прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцохын тухайд “прокурор нь дээр дурдсан чиглэлээр олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэн хуулийн заалт хэрхэн биелж байгаад хяналт тавьж төрийн ашиг сонирхлыг хамгаалахаас гадна төрийн албадлага

хэрэглэгдэж буй хүрээнд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхол зөрчигдөхгүй байхад хяналт тавин ажиллах үүрэгтэй” хэмээн ерөнхий байдлаар тайлбарласан байна.³

Энэ хуулийн Тавин зургадугаар зүйлд “прокурорын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тоочиж тодорхойлсон. Тухайлбал, энд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх, үүрэгтэй гэж ойлгож болно. Тэгэхлээр энэ зүйлд “прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно” гэж заасан нь прокурорын үйл ажиллагааны нэг гол чиг үүргийг тодорхойлсон” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт буюу “тайлбарт” тэмдэглэсэн байна.⁴ Энэ талаар Үндсэн хуулийн маргаан (2012) хэмээх бүтээлд “эрх зүйн шинжлэх ухаанд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох явдал “зөвхөн эрүүгийн процесст” л байх боломжтой

³ Товуусүрэн Ц. Үндсэн хуулиа ойлгохуй. (Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар). Уб., 2017, 166 дахь талаас үзнэ үү.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн заалт зорцот эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 01 дүгээр дүгнэлтийн үндэслэлээс авав. (МУҮҮЦ. Дүгнэлт №01/2003.04.30); Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зорцсон эсэх тухай маргааныг үндсэн шийдвэрлэсэн тухай” 02 дугаар тогтоолын үндэслэлээс авав. (МУҮҮЦ. Тогтоол №02/2003.06.20) Номынбаясгалан С., Үндсэн хуулийн маргаан: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, (Эмхэтгэл), Уб., 2018

¹ Сояд Г., Жанцан Н., Амарсанаа Ж., Жанцан С., Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб., 2000, 228 дахь талаас үзнэ үү.

² Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), Уб., 2009, 250-251 дэх талаас үзнэ үү.

гэж үздэг боловч шинэ үндсэн хуулийн үзэл санаанд прокурор эрүүгийн хийгээд иргэний хэрэг, “шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэгт” төрийн эрх ашгийг хамгаалан оролцох утга агуулагдаж байдаг” гэж тайлбарласан байна.¹

Харин Прокурорын хяналт (2009) хэмээх дагнасан бүтээлд “Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйл нь прокурор эрүү, иргэний болон бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх “шүүх хуралдаанд оролцох эрх зүйн үндэслэл” нь болно” гэж бичсэн байна.² Энэ талаар хууль зүйн зарим тайлбар тольд “. . . 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулиар прокурорын байгууллагыг засаглал хуваарилах онолоор шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулж, прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно . . .” хэмээн төр, эрх зүйн түүхэн талаас тэмдэглэсэн байна.³ Өөрөөр хэлбэл, “шүүх эрх мэдлийг төлөвшүүлэхтэй уялдан эдүгээ прокурорын байгууллагын чиг үүрэгт “зарчмын” шинжтэй нилээд өөрчлөлт орсон”⁴ гэсэн үг.

1. Социалист эрх зүйн зохицуулалтаас эх газрын эрх зүйн зохицуулалт руу шилжих “эхлэл” тавигдсан нь

Юуны түрүүнд төр, эрх зүйн түүхэн хөгжлийн үүднээс Монгол Улсад “захиргаа” нь эрт дээр үеэс өөр өөрийн нийгмийн байгууллаас шалтгаалаад харилцан адилгүйгээр оршин тогтнож ирсэн бөгөөд феодалын нийгмийн үед “уламжлалт төр” байсан гэж үздэг.⁵ Энэ үеийн засаг захиргааны нэгжид захиргааны үүргийг (XIV–XIX зууны сүүл үеийг хүртэл) Монголын улс төр, төрийн байгуулалд “ноёдын чуулган” гүйцэтгэж байсан бөгөөд нийгмийн амьдралын олон талт асуудлыг хэлэлцэн эцэст нь цааз баталж нийтээр дагаж мөрддөг байсан. Харин социалист нийгмийн үед үзэл суртлын гэх нэг намын систем төрийн захиргаанд хяналт тавьж, ажиллаж байжээ. Энэ үед социалист үзэл сурталжсан захиргааны эрх зүй үйлчилж, захиргааны үйл ажиллагааг нэг намын тогтолцоогоор удирдаж, хянадаг байсан учраас “төрийн эрх мэдлийг хуваарилах” болон “харилцан хяналт тавих” тухай ойлголт байсангүй, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байсан байна.⁶ Өмнөх тогтолцооны үед “захиргаатай маргах” нь байж болшгүй зүйл байсан бол Захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаар иргэн, хуулийн этгээд

¹ Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, (Анхны хэвлэл), Уб., 2012, 309 дэх талаас үзнэ үү.

² Цэрэнбалгаан Б., Амарбаясгалан Б., Прокурорын хяналт, (Хянан тохнолдуулсан: Амарсанаа Ж.), Уб., 2009, 255 дахь талаас үзнэ үү. (Цааннид “Цэрэнбалгаан Б., Амарбаясгалан Б., Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

³ Баярсайхан Б., Хууль зүйн тайлбар толь, (Монгол Улсын төр, эрх зүйн түүх), (Хянан тохнолдуулсан: Дашням И., Лүндэндорж Н., ба бусад), Уб., 2003, 146 дахь талаас үзнэ үү.

⁴ Болдбаатар Ж., Лүндэжжанцан Д., Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2011, 438 дахь талаас үзнэ үү. (Цааннид “Болдбаатар Ж., Лүндэжжанцан Д., Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

⁵ 1655 онд Халх монголд 8 хошуу байсан бол 1725 онд 74, 1911 онд 123 хошуу болсон байдаг.

⁶ Өөрөөр хэлбэл, төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу шилжиж байна. Феодалын болон социализмын үед ч төртэй, захиргаатай байсан бол орчин үед ч захиргаатай байна. харин агуулгын болон хэлбэрийн хувьд ялгаатай гэсэн үг. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (Судалгаа, хэрэглээний), Анхны хэвлэл, Уб., 2017, 29–30 дахь талаас үзнэ үү.

захиргаанаас айж эмээлгүй, өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалахаар "нэхэмжлэл" гаргаж, захиргаатай маргах нь хэвийн (жирийн) үзэгдэл болсон бөгөөд үүнд л Захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны ач холбогдол оршиж байна.¹ Тодруулбал,

Монгол Улс орчин цагийн захиргааны суурийг 1992 онд шинэ үндсэн хуулиараа тавьсан бөгөөд хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, хууль дээдлэх зарчмыг тунхаглаж өгснөөр олон намын тогтолцоонд шилжиж, эрх зүйд үндэслэсэн нийтийн захиргааг бий болгох үе эхэлсэн. Ийнхүү төрийн эрх мэдлийг бодит утгаар хуваарилж, харилцан хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, эрх зүйт төрийн хуулийн хяналтыг бий болгох түүхэн үеийг эхлүүлсэн байна. Улмаар захиргааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хуулиудыг баталж, төрийн байгууллага хууль дээдлэн ажиллах, иргэд, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчвөл гаргасан шийдвэр (үйл ажиллагаа) хүчингүй болдог гэсэн хандлагыг Захиргааны хэргийн шүүхийн тусламжтайгаар бүрдүүлсэн байна.²

Энэ талаар онолын сурах бичгүүдэд нийтлэг байдлаар "Захиргааны эрх зүйн судалгааны үндсэн объект нь нийгмийнхээ хөгжлийг даган хувьсан өөрчлөгдөх бөгөөд социализмын үеийн захиргааны эрх зүйд захиргааны байгууллага, түүний бүтэц тогтолцоо,

эрх хэмжээ, тэдгээрийн удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд голлон анхаарч хуулийн зохицуулалт ч мөн үүнд зориулагдаж байсан байна. Орчин үеийн захиргааны эрх зүйн судлагдахууны гол цөм нь захиргаа ба иргэд хоорондын, иргэдэд эрх ба үүрэг бий болгосон харилцааны зохицуулалт бөгөөд энэхүү зохицуулалтыг эрх зүйн хэм хэмжээнд хэрхэн тусгаж өгөх явдалд ихээхэн ач холбогдол өгдөг. Учир нь эрх зүйт төрийн нэг гол зарчим нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байх явдал юм. Энэ нь (захиргаа) давуу байдлаа буруугаар ашиглаж иргэдийн болон нийтийн ашиг сонирхлыг хохироох явдлаас сэргийлэхэд оршино"³ гэж тэмдэглэсэн байх нь бий.

Захиргааны "процессын" эрх зүй нь зорилт, чиг үүрэг, зарчим, хэм хэмжээ, эх сурвалжаараа захиргааны "материаллаг" эрх зүйгээс ялгаатай. Ийнхүү ялган, зааглаж буй шинжлэх ухааны гол шалгуур бол нийтийн эрх зүйн "маргаан"⁴ хэдий ч захиргааны материаллаг болон процессын эрх зүй хоорондоо нарийн сэжмээр хүйн холбоотой гэж үздэг. Ингэж холбож байгаа нэг сэжим нь Захиргааны процессын хууль юм.⁵ Захиргаан хэргийн шүүхийн номлол, үнэт зүйлийг

¹ Батуурь М., Дурдсан бүтээл, 24 дэх талаас үзнэ үү.

² Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (Судалгаа, хэрэглээний), Анхны хэвлэл, УБ., 2017, 31 дэх талаас үзнэ үү.

³ ... Одгэрэл П., Захиргааны эрх зүйн ерөнхий анги, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2008, 34 дэх талаас үзнэ үү.

⁴ Эрдэнэцогт А., Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2012, 58 дахь талаас үзнэ үү.

⁵ Өмнө нь "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль" байсан бол одоо "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль" болно. Эрдэнэцогт А., Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2012, 58 дахь талаас үзнэ үү.

өөртөө шингээсэн энэ хуулийн үйлчлэл нь бусад аль ч салбар эрх зүйгээс илүүтэй захиргааны материаллаг болон процессын эрх зүйн уялдаа холбоог бэхжүүлж байна. Улмаар Үндсэн хууль (1992) батлагдсанаар Монгол Улсын эрх зүйн тогтолцоо социалист эрх зүйн бүлээс эх газрын эрх зүйн бүл рүү шилжих “эхлэл” тавигдсан билээ. Үүний нэг тод илрэл нь 2002 онд анх удаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсан явдал бөгөөд 2004 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болж, үүнтэй уялдан “Захиргааны хэргийн шүүх” шинээр байгуулагдан ажиллаж өнөөг хүрсэн байна. Энэхүү шүүхийн гол зорилго иргэний субъектив (объектив)¹ эрхийг хамгаалах, түүгээр дамжуулан захиргааны үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавихад оршино.² Үүгээр захиргаа ба шүүхийн хоорондын харилцаа нь юуны өмнө Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаатай шууд холбоотой болох нь харагдаж байна.

2. “Зарчмын” шинжтэй өөрчлөлт гэсний учир

Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) хэрэгжилтийн байдалд хийсэн

дүн шинжилгээнд “Төрөөс эрх мэдлээ дур зоргоор ашиглаж буй эсэхэд үр нөлөөтэй хяналт тавих зорилгоор дагнасан шүүх болох Захиргааны хэргийн шүүхийн бүхэл бүтэн сүлжээг бий болгосны шалтгаан нь “олон талтай” байсан гэж үздэг. Үүнд: (1) өмнөх тогтолцоонд ноёрхож байсан социалист эрх зүйн баримтлалаар төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөггүй байсан учраас төрийн захиргааны шийдвэрийг хянах ямар ч боломж шүүхүүдэд (шүүхээс хязгаарлагдмал хүрээтэй цөөн асуудалд хяналт тавьдаг байсан) байгаагүй. Төрийн байгууллага, төрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас болж зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор өргөдөл, гомдол гаргах тогтолцоо байгаагүй. Харин Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдсан нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны дур зоргоор авирлахаас иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн болохыг харуулж байна”³ гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Энэ нь Захиргааны хэргийн шүүх захиргааны үйл ажиллагааг хуульд захируулах “эрх зүйт ёс”-ны үзэл баримтлалыг бодит ажил болгосон төдийгүй дагнасан шүүхийн ач холбогдлыг таниулсан болохыг илтгэнэ.⁴ Улмаар прокурорын “ерөнхий” хяналтыг Захиргааны хэргийн шүүхийн хяналтад

¹ Шинэ болон хуучин захиргааны процессын хуулиудыг харьцуулахад “Өмнөх хууль зөвхөн иргэн, хуулийн этгээлийн өөрийн зөрчигдсөн субъектив эрхээ сэргээхээр шүүхэд ханддаг байсан бол шинэ хуулиар “нийгмийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” объектив эрхийг хамгаалах асуудаар шүүхэд хандах боломжийг баталгаажуулсан. Шинэ хууль тодорхой хүрээнд объектив эрхийг хондсон асуудаар ийнхүү нэхэмжлэх эрхийг нээсэн” байна. Энэ талаар: Номилбаясгалан С., Дурдсан бүтээл, 94 дэх талаас үзнэ үү.

² Одгэрэл Н., Захиргааны эрх зүйн ерөнхий анги, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2008, 61-62 дахь талаас үзнэ үү.

³ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, (Хамтын бүтээл), УБ., 2016, 120 дахь талаас үзнэ үү. (Цаашид “1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, Дурдсан бүтээл” гэж тэмцлэнэ. С.Н.)

⁴ Батсуурь М., Дурдсан бүтээл, 24-25 дахь талаас үзнэ үү.

(Б.Чимид “Захиргааны хэргийн шүүх¹ хуралдаанд прокурор оролцож санал, дүгнэлт гаргадаг байх нь зүйтэй болов уу” гэсэн саналыг гаргасан байна) шилжүүлсэн гэж үзэж болох юм.² Ийнхүү прокурор нь (Захиргааны хэргийн) шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс “дүгнэлт гаргаж” оролцож ирсэн³ байна.

3. Прокурорын ерөнхий хяналтаас “шүүхийн хяналт” руу

Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйл (Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах) гэсний “Прокурор . . . өөрийн санаачилгаар захиргааны . . . хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд . . . оролцоно” гэсэн зохицуулалтыг прокурорын хяналтын “гажуудсан” хэлбэртэй холбон үзэж болох бөгөөд үүний уг сурвалж нь прокурор оролцох, оролцооны талаархи хуурмаг төсөөлөл буюу “прокурор зайлшгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд буюу шүүх хуралдаанд байх ёстой” гэж үзэж байсан (социалист үзэл санаа)—аас улбаатай байж болох юм.

Түүхэн талаас зарим нэг бүтээлээс авч үзвэл “БНМАУ–ын прокурор байгууллага нь хууль ёсыг нэг ойлголттой, нэгдмэлээр биелүүлэхийг хангах ба түүнийг аливаа зөрчилтөөс хамгаалах зорилгоор хуулийг хэрхэн биелүүлж байгаад “дээд хяналт” тавих үүрэгтэй. . . . прокурорын “ерөнхий” хяналтад хамаарагдахгүй байгууллага, иргэд гэж байж болохгүй” гэж

¹ Дээрхээс гадна “Үндсэн хуулийн цэнхэр” гэдгийг нэрлэж онцлон тэмдэглэсэн байна.

² Чимид Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2017, 320 дахь талаас үзнэ үү.

³ Болдбаатар Ж., Лүндэжжанан Д., Дурдсан бүтээл, 438 дахь талаас үзнэ үү.

бичсэн байна.⁴ Улмаар прокурорын оролцооны тухай “Прокурор өөрийн биеэр захиргааны болон олон нийтийн байгууллагын хуралд оролцож болно. Жишээ нь: гүйцэтгэх захиргааны хуралд оролцогч прокурор тэр хурлаас гаргаж байгаа акт хуультай нийцэж буй эсэхийг хянана. Ийм хуралд прокурор “зөвлөх” эрхтэй оролцоно. . . . “ерөнхий” хяналтыг шүүх ба мөрдөн байцаах газруудын практиктэй холбосноор прокурорын байгууллага нь шүүхийн ба мөрдөн байцаах газруудын практикийг нэгтгэн дүгнэнэ” гэсэн байдлаар албан хэрэгцээнд тайлбарлан ойлгуулж байсан байна.⁵ (Б.Чимид “Энэ үүднээс прокурорын хяналт нь төрийн зүгээс тавих хяналтын биеэ даасан нэг төрөл болохын хувьд төрийн бусад хяналт шалгалтаас ялгарах онцлогтой хэмээн өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байсан”). Учир нь “ерөнхий хяналт” нь бүхэлдээ төрийн удирдлагын явцад хууль ёсыг хангахад чиглэгддэг учраас “БНМАУ–ын хууль, зарлиг, сайд нарын зөвлөлийн тогтоол, бусад хэм хэмжээний актыг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, хоршоолол, олон нийтийн байгууллага, ард иргэд хэрхэн нарийн чанд биелүүлж байгаад прокуророос тавих хяналтыг “прокурорын ерөнхий хяналт” хэмээх тодорхойлж үздэг байсан.⁶ Энэ үндсэн дээр прокурор зэрэг

⁴ БНМАУ–ын Сайд нарын зөвлөлийн Зохион зааварлах хэлтэс, БНМАУ–ын Төрийн захиргааны эрх, (Ерөнхий анги), Уб., 1964, 110 дахь талаас үзнэ үү. (Цаашид “БНМАУ–ын Сайд нарын зөвлөлийн Зохион зааварлах хэлтэс, Дурдсан бүтээл” гэж товчилно, С.Н.)

⁵ БНМАУ–ын Сайд нарын зөвлөлийн Зохион зааварлах хэлтэс, Дурдсан бүтээл, 112 дахь талаас үзнэ үү.

⁶ Чимид Б., БНМАУ–ын Захиргааны эрх, Уб., 1973, 395 дахь талаас үзнэ үү.

төрийн бусад байгууллага захиргааны процессын субъект байх тусгай чадвар эзэмшсэн байхын зэрэгцээ “Прокурор нь хяналт тавих үүргийнхээ дагуу захиргааны хэрэг шийдвэрлэхэд биеэр байх, гаргасан актыг хянах зэргээр оролцдог байсан” тухай онолын сурах бичигт тэмдэглэгдсэн байна.¹ Энэ нь “уг ажиллагаанд хууль ёсыг хангах баталгаа гэж үзээд хууль ёсыг улс даяар нэг мөр ойлгож биелүүлэхэд шаардлага, хууль ёсны нэгдмэл байх зарчим нь прокурорын хяналтын онцлогийг нөхцөлдүүлнэ”² хэмээн ойлгож ирсэн түүхэн уламжлалтай холбоотой болов уу.

Энэ талаар БНМАУ-ын Үндсэн хуулийн (1960) улс төр – эрх зүйн дэлгэрэнгүй тайлбарт “БНМАУ-ын бүх яам, тусгай газар, тэдгээрийн харъяа үйлдвэр, албан газар, байгууллага, түүнчлэн орон нутгийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа болон хоршооллын байгууллага, албан тушаалтан, иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд сахин биелүүлж байгаад тавих дээд хяналтыг улсын прокурор гүйцэтгэнэ. Энэхүү хяналт нь тус улсад төрийн эрх барих байгууллагаас бусад төр, олон нийт, хоршооллын бүх байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, ард иргэдийн социалист хууль ёсыг сахин биелүүлж байгаа үйл ажиллагааг хамаарч хэрэгждэг. “Прокурорын хяналт” нь БНМАУ-ын нэрийн өмнөөс, тус улсын бүх нутаг дэвсгэр дээр бүх байгууллага, хүмүүсийн

тухайд хэрэгжихийн чацуу хяналт шалгалтыг эрхэлдэг бусад байгууллагын үйл ажиллагаанд ч нэгэн адил хууль зүйн үүднээс давхар хяналт тавьж байдгаараа “дээд хяналт” гэж нэрлэдэг”³ гэсэн байдлаар бичигдсэн байна.

Тэгвэл 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн тухай судалгаанд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан (энэ ажиллагааны “нэршил”⁴ өөрчлөгдсөн) дахь прокурорын эрх хэмжээ харьцангуй багассан. 1990 оноос өмнө бусад социалист орнуудын нэгэн адил прокурор нь хууль зүйн салбарт хамгийн чухал байгууллага байсан. Тухайн үед прокурор нь зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар хязгаарлахгүй, төрийн бүх байгууллагын үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг өргөн эрх хэмжээтэй байв. Үндсэн хуулийг шинэчлэх явцад прокурорын эрх хэмжээг эргэн харах шаардлага гарсан бөгөөд ийнхүү прокурор нь хяналтын ерөнхий чиг үүргээ алдаж, засгийн газрын байгууллагын хууль зөрчсөн үйлдлийг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэдэг тогтолцоонд шилжсэн” хэмээн тэмдэглэсэн⁵ байна. Өмнөх тогтолцооны үеийнхтэй нь харьцуулж үзвэл, прокурорын байгууллагын чиг

¹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль: Улс төр-эрх зүйн дэлгэрэнгүй тайлбар, Уб., 1988, 185-186 дахь талгаас үзнэ үү.

² Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг “Эрүүгийн хэрэг хянах шийдвэрлэх ажиллагаа” гэж нэрлэн хэрэглэдэг болсон. Монгол Улсын Их Хурлаас (2017.05.18.)-ны одор баталсан Эрүүгийн хэрэг хянах шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.36 дахь заалтыг үзнэ үү. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23

³ 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, Дурдсан бүтээл, 123 дахь талгаас үзнэ үү.

¹ Чимид Б., Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Захиргааны эрх зүй, (Ерөнхий анги), Уб., 1988, 298 дахь талгаас үзнэ үү. (Цаашид “Чимид Б., Дурдсан бүтээл” гэж товчилно, С.Н.)

² Чимид Б., Дурдсан бүтээл, 348 дахь талгаас үзнэ үү.

үүргээс хуулийн биелэлтэд дээд хяналт тавих (ерөнхий хяналт), гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шүүхийн шүүн таслах ажиллагаанд хяналт тавих (шүүхийн хяналт) зэрэг нь хасагдсан¹ байна. Ийнхүү прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд "оролцогч байгууллага"² болсон юм.

Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн буюу "тайлбарын" үүднээс авч үзвэл, Монгол Улсын Үндсэн хуульд шүүх засаглалын хүрээнд прокурорын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тогтоож өгсөнтэй уялдан энэ хуулийн хавсралт хуульд³ (5.3.) заасны дагуу прокурорт мөрдөн байцаах эрх олгож, түүний хяналтын үүрэгт нь багтаж байсан хууль тогтоомжийн холбогдох заалтууд үндсэн хууль батлагдсан үеэс хүчингүй болсон нь "прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлсэн" бодит нөхцөл байдал хэмээн үздэг.⁴ Тиймээс прокурор нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хууль ёсоор оролцож, хууль зүйн үүрэг гүйцэтгэдэг үндсэн хуулийн байгууллага, бие даасан тогтолцоо учраас эрх зүйн байдлыг нь үндсэн хуулиар тогтоосон

байна.⁵ Иймд прокурорын шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх (1) чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн дагуу шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох явдал⁶ гэж үздэг.

4. Прокурор "албан үүргийн" дагуу оролцогч байсан нь

Захиргааны процессын эрх зүйн онолын сурах бичигт прокурорыг "албан үүргийн дагуу оролцогч" гэж үздэг байсан.⁷ Үүнийг "тухайн захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлээд гаргасан шийдвэр нь ". . . прокурор . . ." зэрэг этгээдэд шууд нөлөө үзүүлэхгүй төдийгүй тухайн маргааныг үүсэхэд шууд оролцоогүй, захиргааны маргааны улмаас эрх ашиг сонирхол нь шууд зөрчигдөж хөндөгдөөгүй байдаг учраас "бусад оролцогч" хэмээн үздэг" гэж тайлбарлаж байсан байна.⁸ Иймд бусад оролцогчийн (прокурорын) үйл ажиллагаа нь хөндлөнгийн шинжтэй байхаас гадна мэргэшсэн үйл ажиллагаа байдгаараа онцлогтой.⁹ Тиймээс захиргааны хэрэг хянан хэлэлцэх шүүх

¹ Болдбаатар Ж., Лүндээжанцан Д., Дурдсан бүтээл, 438 дахь талаас үзнэ үү.

² Болдбаатар Ж., Лүндээжанцан Д., Дурдсан бүтээл, 439 дэх талаас үзнэ үү.

³ Монгол Улсын Үндсэн хуулийн "хавсралт" хуулийн Тавдугаар зүйл (5.3)-д "Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, гэдгээрийн заалтыг хүчингүй болгонд тооно" гэж заасан.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Монгол Улсын Ерөнхий прокурор үндсэн хууль зөрчсөн, Прокурорын байгууллагын тухай хууль үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай" 07 дугаар дүгнэлтийн үндэслэлээс авав. (МУУХЦ, Дүгнэлт №07/1994.07.25)

⁵ Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг, Уб., 2008, 333 дахь талаас үзнэ үү.

⁶ Эрдэнэцогт А., Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, (Анхны хэвлэл), Уб., 2006, 176 дахь талаас үзнэ үү. (Цаашид "Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

⁷ Эрдэнэцогт Н., Энхтуяа А., Захиргааны эрх зүй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн ойлголтууд, Уб., 2003, 53-54 дэх талаас үзнэ үү. Эрдэнэцогт А., Захиргааны процессын эрх зүй, (Гарын авлага), Уб., 2013, 32-37 дахь талаас үзнэ үү.

⁸ Монгол Улсын дээд шүүх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2012, 177 дахь талаас үзнэ үү. (Цаашид "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.) Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, (Хамтын бүтээл), Уб., 2004, 107 дахь талаас үзнэ үү.

⁹ Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл, 174 дэх талаас үзнэ үү.

хуралдаанд прокурор оролцохоор заасан нь “өвөрмөц зохицуулалт” байсан гэж үздэг. Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйл (Шүүх хуралдаанд оролцогч)–д “77.1.Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 17 дугаар зүйл, 77.2–т заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна гээд 77.2.Шүүх хуралдаанд оролцож байгаа хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ” гэж зааснаас үзвэл прокурор шүүх хуралдаанд оролцогч биш болох нь тодорхой байна.

Өмнө нь (үйлчилж байсан) захиргааны процессын хуульд прокурор төрийг төлөөлөн оролцоно¹ гэж заасан боловч захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргах үүрэгтэй тул “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн байр суурьтай болох”² нь харагддаг байсан гэж тэмдэглэсэн цөөнгүй хууль зүйн ном зохиол бий. Энэ талаар “үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд (56.1) заасан “төрийг төлөөлөн оролцоно” гэх

ойлголт буюу төрийн ашиг сонирхлыг захиргааны аль нэг байгууллага, албан тушаалтны “хууль бус шийдвэр, үйл ажиллагаа”–тай хутган ойлгож болохгүй юм. Эндээс “төрийн ашиг сонирхол” хэмээх нь илүүтэй нийтлэг (нийтийн ашиг) сонирхолтой гэх агуулгаар ойлгогдох учиртай. Үүнээс прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлнө гэдэг нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд нийтлэг ашиг сонирхлыг илүүтэй илэрхийлнэ гэсэн утгаар ойлгож хүлээн авах нь зүйтэй”³ болов уу.

Б. Прокурор “төрийн нэрийн өмнөөс” шүүх хуралдаанд оролцох эрх зүйн асуудал

Өмнө тэмдэглэснийг нэгтгээд үзвэл, үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд “прокурорын үйл ажиллагааны чиглэлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л “үндсэн эрх, үүрэгтэй” гэж тодорхой тоочиж тодорхойлсон байна. Иймд энэ зүйлд “прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно” гэж заасан нь прокурорын үйл ажиллагааны нэг гол чиг үүрэг” гэж ойлгож болох юм. Энэ үндсэн дээр прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох гэдгийг хууль зүйн үүднээс (1) зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх; (2) эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх; (3) “захиргааны” болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдол хамаарна гэж тайлбарласан байна.⁴ Энэхүү

¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 55 дугаар зүйл (Шүүх хуралдаанд прокурор оролцох)–д “55.1.Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана гээд 55.2.Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдлж, үүрэг хүлээнэ” гэж заасан байна. <https://www.legalinfo.mn/law/details/284?lawid=284> (Сүүлд үзсэн огноо: 2021.03.22)

² Процессийн эрх зүй: Онол, туршлага, (Хамтын бүтээл), УБ., 2014, 125 дахь талаас үгнэ үү.

³ Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл, 177 дахь талаас үгнэ үү.

⁴ Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын

оролцооны цар хэмжээг Прокурорын (байгууллагын) тухай хуульд эрүүгийн болон иргэний ("захиргаанаас бусад") төрлийн хэргийг хянан шийдвэрлэх хуульд заасан журмын дагуу "төрийг" төлөөлөн тус тус оролцохоор тодруулан зохицуулж ирсэн түүхэн уламжлалтай байна.

Хэдий тийм боловч Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно" гэсний "... эсхүл өөрийн санаачилгаар ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтын үзэл санаа болоод агуулгад нь нийцэхгүй байна. Мөн түүнчлэн захиргааны процессын хуулийн хэм хэмжээний үүднээс нийтийн ашиг сонирхлыг прокурор бус хуульд нэрлэн заасан тодорхой шаардлага хангасан

тухайн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага нэхэмжлэн хамгаалах тухай зохицуулсан. Иймд Захиргааны хэргийн шүүхэд прокурор нийтийн (төрийн) ашиг сонирхол зөрчигдсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд оролцох боломжгүй юм.² Үндсэн хуульд "... Төрийн нэрийн өмнөөс ..." гэсэн нь юутай ч төр нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлж хамгаалах утгатай учраас "прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох" чиг үүргийн агуулгыг зөв тайлбарлаж, зохицуулах явдал³ нэн чухал билээ. Тэгэхлээр төрийн нэрийн өмнөөс оролцоно гэдэг ойлголт юуг илэрхийлж байна вэ? Үүнд юуны өмнө ашиг сонирхлын тухай ойлголт хамаарна⁴ гэж үздэг. Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэдэгт төрийн байгууллагын эрх, үүрэг ямар нэгэн байдлаар зөрчигдсөнийг ойлгодог.⁵

Тэгвэл захиргааны хэргийн нэг талд захиргааны байгууллага, албан тушаалтан заавал оролцох учраас түүгээр дамжуулан төрийн ашиг сонирхол ямар нэгэн хэмжээгээр илэрхийлэгдэх боломжтой гэж үзвэл прокурорын оролцоо (Төрийн ашиг сонирхол хөндөгдөхөөс бусад захиргааны хэргийн тухайд прокурорын оролцоо төдийлөн шаардлагагүй гэдгийг хүлээн зөвшөөрнө гэж үздэг⁶) төдийлөн шаардлагагүй.

09-ний одор баталсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлээс үзнэ үү.

¹ Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 12 дугаар сарын 26-ны одор батлагдаж, 2004 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "Шүүх хуралдаанд прокурор оролцох тухай тухайнхэн зохицуулалт" байсан. Уг хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 сарын 04-ний өдөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хүчингүй болгосон.

² Номынбаясгалан С., Дурдсан бүтээл, 96 дахь талаас үзнэ үү.

³ Чимид Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2017, 321 дэх талаас үзнэ үү.

⁴ Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл, 176 дахь талаас үзнэ үү.

⁵ Цэрэнбалдав Б., Амарбаясгалан Б., Дурдсан бүтээл, 273 дахь талаас үзнэ үү.

⁶ Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл, 177 дахь талаас үзнэ үү.

Юуны түрүүнд, захиргааны байгууллага өөрийн гаргасан шийдвэрийг төлөөлөн (хамгаалж), шүүхийн өмнө иргэн, хуулийн этгээдтэй маргаанаа шийдвэрлүүлэх процесст “прокурор” чухам ямар үүрэгтэй болох нь өмнөх захиргааны процессын хуулийг үйлчилж байх үед ойлгомжгүй байсан. Ийм болоод л прокурор оролцох хууль зүйн үндэслэлийг тодорхойлж гаргасан боловч хэрэгжилт нь хангалтгүй байсан¹ нь үүнтэй холбоотой болов уу. Хуульд хэдийгээр төрийг төлөөлж, захиргааны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргахаар чиглүүлсэн боловч, мөн чанартаа уг маргаанд төрийг төлөөлж, шийдвэр гаргасан төрийн “захиргааны байгууллага” нь өөрөө хариуцагчаар татагдан оролцдог² болохыг орхигдуулж болохгүй. Тиймээс захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорыг заавал оролцуулах ёстой буюу зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хэрхэн оролцуулах, хэрэв оролцож байгаа тохиолдолд захиргааны байгууллагаас ялгагдах шинж байдлыг тодорхойлох нь өөрөө “эргэлзээтэй” асуудал юм.

1. Эрүү, иргэний хэргийн шүүх хуралдаанаас “захиргааны хэргийн шүүх” хуралдаанд прокурор оролцох асуудлыг онцлохын учир

Ийнхүү онцлохын учир нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэгш эрх бүхий талууд оролцдог “иргэний процесс”,

эсвэл төрийн зүгээс санкц оногдуулдаг “эрүүгийн процесс”-оос ялгаатай. Энэхүү ажиллагаагаар төрийн үйлдэл буюу захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэхийг хянадаг учраас Захиргааны хэргийн шүүхийн зорилго иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэнэ.³ Иймд энэ шүүхийн үндсэн бүрэн эрх нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хуулиар тогтоосон хүрээ хязгаарт үйл ажиллагаагаа явуулж байгаад “шүүхийн хяналт” хэрэгжүүлэхэд оршдог.⁴ Өөр өгүүлбэрээр илэрхийлбэл, Захиргааны хэргийн шүүхээс нийтийн эрх зүйн хүрээний бүх хэм хэмжээг баримтлан захиргааны байгууллага, албан тушаалтан хууль ёсны үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгах бөгөөд ийнхүү шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан эсэхийг хянахад өөрт нь бас “хязгаарлалт” үйлчилнэ⁵ гэсэн үг. Энэхүү шүүх бол шүүхийн жирийн нэг салаа мөчир, дагнасан шүүхийн загвар төдий зүйл биш юм. Тиймээс энэ шүүх нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмыг хангах замаар төр, иргэн, хуулийн этгээд хуулийн хүрээнд адил тэгш байх үндсэн хуулийн зорилтыг хангадаг. Энэ ч үүднээс тухайн улс ардчилсан эсэх эрх зүйт төр засагладаг эсэх нь Захиргааны хэргийн шүүх тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг эсэхээс

³ Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб., 2016, 58 дахь талаас үзнэ үү.

⁴ 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. Дурдсан бүтээл. 121 дэх талаас үзнэ үү.

⁵ Сүлжид Д., Захиргааны ерөнхий хууль: Үйл баримтлал, хэрэгтэй. Уб., 2017, 19–21 дэх талаас үзнэ үү.

¹ Номынбаясгалан С., Дурдсан бүтээл, 92 дахь талаас үзнэ үү.

² Цогт Ц., Захиргааны хэргийн шүүх, Уб., 2019, 62–63 дахь талаас үзнэ үү.

хамааралтай, хамгийн чухал шалгуурын нэг гэж үздэг¹ болохоор ийнхүү онцлон авч үзсэн билээ.

Энэхүү илтгэлээр хөндөж байгаа асуудлын талаар Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар (2003) хэмээх бүтээлд “. . . Прокурор бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцоно гэдэг нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай ойлголт юм . . .” гэж тайлбарласан байна.² Тэгвэл Прокурорын хяналт (2009) гэсэн бүтээлд “Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд “хуульд заасан” тохиолдолд оролцож болно. Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана” гэж тэмдэглэсэн байна.³ Харин сүүлд хэвлэгдсэн (Банзрагч Г., Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019) бүтээлд “Захиргааны хэргийн шүүх хуралдаанд // процесст прокурор оролцох, оролцоо”-ны талаар тусгагдаагүй байна.

2. Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурорын оролцох, оролцоог “үгүйсгэх” “тусгай” үндэслэлийн тухай товч өгүүлэх нь

Үндсэн хуулинд суулгахдаа л “Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцоно” гээд явах ёстой

чиглэлийг нь өөр зүг рүү гаргачихсан⁴ гэж “зохицуулалт” талаас нь бичсэн байна. Энэ асуудлын талаар “Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн хэсгийг таслалын өмнөх “прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж,” гэсэн үндсэн хэсгээс тусад нь салгаж эрүүгийн хэргээс бусад “шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” мэт агуулгаар өргөжүүлсэн (Үндсэн хуулийн агуулгаас хэтрүүлсэн) хуулийн заалтыг оруулж байсан” гэсэн агуулгаар “шууд” шүүмжлэх тохиолдол бий.⁵ Энэ нь эцсийн эцэст үндсэн хуулийг хэрхэн, яаж, ямар аргаар тайлбарлах вэ гэсэн асуултад тулж очно. Хэрэв энэ мэт “механик” байдлаар тайлбарлахад хүрвэл эргээд үндсэн хуулийн үзэл баримтлалыг (үгүйсгэх) алдагдуулах хууль зүйн эрсдэл үүсч болох юм. Тийм ч болоод тэрүү, энэ Тавин зургадугаар зүйлийн онцлогийг “эрх зүйн шинжлэх ухаанд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох явдал зөвхөн эрүүгийн процесст л байх боломжтой гэж үздэг боловч шинэ үндсэн хуулийн үзэл санаанд прокурор эрүүгийн хийгээд иргэний хэрэг, шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэгт төрийн эрх ашгийг хамгаалан оролцох утга агуулагдаж байдаг” гэж гаргасан байна.⁶ Энд тэмдэглэж байгаа “шаардлагатай тохиолдол” гэсэн утгыг “заавал” оролцуулах мэт агуулгаар

¹ Батсуурь М., Дурдсан бүтээл, 35 дахь талаас үзнэ үү.

² Баясгалан Г., Туяа Н., Цэрэнбалтав Б., Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., 2003, 74 дэх талаас үзнэ үү.

³ Цэрэнбалтав Б., Амарбаясгалан Б., Дурдсан бүтээл, 274 дэх талаас үзнэ үү.

⁴ Тэмүүжин Х., Шүүх эрх мэдэл “прокурор” хэн байх ёстой вэ, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №1, 56 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

⁵ Цогт Ц., Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019, 61 дэх талаас үзнэ үү.

⁶ Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, (Анхны хэвлэл), УБ., 2012, 309 дэх талаас үзнэ үү.

тайлбарлаж болохгүй юм. Иймд үндсэн хуульд тодорхойлогдож буй гол гол үзэл баримтлал, зарчмын үүднээс авч үзэн тайлбарлах нь зүйтэй болов уу.

Шинэ (1992 оны) Үндсэн хууль батлагдсан нь захиргааны процессын тухай өмнөх ойлголтыг өөрчилж, орчин үеийн цоо шинэ салбар эрх зүйн түвшинд хүрч хөгжих үүдийг нээсэн бөгөөд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, эрх зүйт төрийн зарчмуудыг баталгаажуулан төрийн эрх мэдлийг хуваарилсан нь ийм боломж олгосон юм. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд ". . . эрүү, иргэн, "захиргааны" зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно . . ." хэмээсэн нь захиргааг мэргэшсэн шүүхийн хяналтад оруулах үндсийг бүрдүүлсэн хэрэг.¹ Үндсэн хуулийн энэ үзэл баримтлалын дагуу Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг тус тус баталж, 2004 оноос дагаж мөрдүүлсэн тухай өмнө дурдсан билээ. Монгол Улсад төрийн эрх мэдлийг хуваарилахын сацуу эрх мэдэл хоорондын харилцан тэнцлийг хангах механизм (шүүх) ажиллаж эхэлсэн. Ийнхүү үндсэн хуулийн дагуу байгуулагдсан "Захиргааны хэргийн шүүх нь иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах нэг "хэрэгсэл" болохоос гадна үндсэн хуулийн өөрийнх нь дархлаа Захиргааны хэргийн шүүхээс хамааралтай болсон" гэж үздэг.² Улмаар

төрийн болон нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих шүүх байгуулах, эрх зүйт төрийг бэхжүүлэх³ үндсэн хуулийн үзэл санааг тусгасан байна.

3. Прокурорын оролцооны талаархи шүүмж

Өмнө нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох хууль зүйн үндэслэлийг (хуучин захиргааны процессын) хуульд тодорхойлж гаргасан боловч, энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан тухай баримт "цөөнгүй" тэмдэглэгдэн үлдсэн байна.

(1) Захиргааны процессын эрх зүйн (онолын) сурах бичгүүдэд "Захиргааны хэргийн шүүхийн өнгөрсөн практикаас харахад захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцох прокурорын оролцоо тун хангалтгүй байна. Үүний үндэслэл, шалтгааныг судлан үзэж, цаашид нэг мөр ойлголт тогтоох зайлшгүй шаардлагатай болжээ" гэсэн саналыг илэрхийлсэн байна.⁴ Мөн түүнчлэн (2) процессын эрх зүйн (тойм) бүтээлд "Захиргааны хэргийн шүүхийн практикт прокурорыг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан тохиолдол ховор байна. Энэ нь прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэний хүсэлтээр, хэрхэн оролцох талаарх хуулийн зохицуулалт тодорхой бус байгаатай холбоотой" гэж дүгнэсэн

¹ Эрдэнэцогт А., Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2012, 54 дэх талаас үзнэ үү.

² Ийнхүү Монгол Улсын Үндсэн хууль давхар (Монгол Улсын Үндсэн хуулийн нэгтгэл адил) хамгаалалттай болсон гэж үздэг. Эрдэнэцогт А.,

Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, (Хоёр дахь хэвлэл), Уб., 2012, 55 дахь талаас үзнэ үү.

³ Батсуурь М., Дурдсан бүтээл, 21 дэх талаас үзнэ үү.

⁴ Эрдэнэцогт А., Дурдсан бүтээл, 176 дахь талаас үзнэ үү.

байна.¹ Харин **(3)** Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн албан бус тайлбарт “Прокурор нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, төрийн нэрийн өмнөөс оролцдог бол харин иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр оролцож дүгнэлт гаргадаг. Эрүүгийн болон иргэний процессын ажиллагаанд оролцож байсан прокурор нь, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар прокурорын үүргийг шинэ нөхцөл байдалд тодорхойлсон боловч өнөөдрийн байдлаар уг хуулийн заалтыг хэрэгжүүлж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тохиолдол нэг ч алга байна” хэмээн тэмдэглэсэн.²

Харин Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоймоос “Прокурор захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцдоггүй энэ байдал үргэлжилж 2004 – 2016 (07.01–ний өдрийн байдлаар) оны хооронд улсын хэмжээнд нийт 20 захиргааны хэрэгт л прокурор оролцсон судалгаа бий. Энэ нь 2004 – 2013 онуудад захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн нийт 7441 хэргийн тоотой харьцуулбал прокурорын оролцоо бараг байгаагүйтэй адил үзүүлэлт гарна”³ гэсэн дүгнэлтийг **(4)** зарим судалгаанд хийсэн байна. Энэ

үндсэн дээр “захиргааны хэрэг шүүхээр хэлэлцэгдэх шатан дахь прокурорын оролцооны дээрх ойлгомжгүй байдал, энэ талаарх зохицуулалтыг эргэн харж зассан. Ингэхдээ үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сахиулах шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болох прокурор нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагыг хянах эрх хэмжээгүй болохыг эш үндэс болгон захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцогч биш байхаар залруулан зохицуулсан”⁴ гэсэн үндэслэлийг гарган тайлбарлаж байна.

Энэ талаар “Захиргааны хэргийн шүүх” гэсэн (5) бүтээлд “Захиргааны хэрэг шүүхээр хэлэлцэгдэх шатан дахь прокурорын оролцооны дээрхи ойлгомжгүй байдал 2004 оноос практикт захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор бараг оролцоогүй явсаар шинэ захиргааны процессын (Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай) хууль батлагдан гарах хугацаатай золгоход хүргэсэн. Тиймээс шинэ (2016) захиргааны процессын хуульд өмнөх (2002) захиргааны процессын хуулийн прокурорын оролцооны талаархи зохицуулалтыг эргэн харж, зассан юм. Ингэхдээ үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сахиулах шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болох прокурор нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагыг хянах эрх хэмжээгүй гэдгийг иш үндэс болгон захиргааны хэргийн шүүх хуралдаанд

¹ Процессийн эрх зүй: Онол, туршлага, (Хамтын бүтээл), Уб., 2014, 125 дахь талаас үзнэ үү.

² Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Дурдсан бүтээл, 178 дахь талаас үзнэ үү.

³ Цогт Ц., Захиргааны эрх зүй дэх “хууч хамгаалал” буюу “прокурорын хяналт”, Эрх зүй сэтгүүл, Уб., 2018, №3(43), 98 дахь талаас үзнэ үү. (Нашвил “Цогт Ц., Дурдсан бүтээл” гэж товчлоно. С.Н.)

⁴ Цогт Ц., Дурдсан бүтээл, 99 дэх талаас үзнэ үү.

прокурор оролцогч биш байхаар залруулан зохицуулсан” хэмээн тэмдэглэсэн байна.¹ Өмнө дурдагдаж буй онолын сурах бичиг болоод албан бус хуулийн тайлбарт бичсэн зүйлүүдийг нэгтгээд үзвэл “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох, оролцооны талаархи зохицуулалтын агуулгыг үндсэн хуулийн үзэл баримтлал болоод шүүхийн хяналтын үүднээс үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ шаардлагатай үүссэн” болох нь харагдаж байна.

III. Дүгнэлт

Энэхүү илтгэлийн төгсгөлд дараахь цөөн хэдэн дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1/ Монгол Улсын Үндсэн хууль (Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэл)—ийн үүднээс “прокурорын үйл ажиллагааны чиглэлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх, үүрэгтэй гэж тодорхой тоочиж тодорхойлсон байна. Иймд энэ (56) зүйлд “прокурор . . . төрийн нэрийн өмнөөс . . . шүүх хуралд оролцоно” гэж заасан нь прокурорын үйл ажиллагааны нэг гол чиг үүрэг” гэж ойлгож болох юм. Иймд эрх зүйн шинжлэх ухаанд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох явдал зөвхөн эрүүгийн процесст л байх боломжтой гэж үздэг боловч үндсэн хуулийн үзэл санаанд прокурор эрүүгийн хийгээд иргэний хэрэгт, шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэгт төрийн ашиг сонирхлыг хамгаалан оролцох утга

агуулагдаж ирсэн байна. Энэ нь дээрхи асуудалд холбогдох (материаллаг болон процессын) хууль тогтоомжийн түүхэн хөгжлөөс харагдана. Тиймээс “хуульд” заасан үндэслэл, журмын дагуу шаардлагатай (онцгой) тохиолдолд л (хязгаарлагдмал хүрээнд) оролцох агуулгатай болохоос биш прокурорын оролцоог шууд (эрс) үгүйсгэж болохгүй. Хэрэв ингэхэд хүрвэл үндсэн хуулийн (56.1—ийн) үзэл санаанд нийцэхгүй байж болох юм. Ийнхүү прокурор нь (Захиргааны хэргийн) шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс “дүгнэлт гаргаж” оролцож ирсэн байна.

2/ Дээрхи асуудлыг үндсэн хуулийн (48.1—ийн) үзэл санаа болох захиргааг мэргэшсэн шүүхийн хяналтад оруулах тухай “эрх зүйт төрийн зарчим” хэрэгжих механизмтай холбон авч үзэх нь зүйтэй юм. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд “. . . “захиргааны” зэрэг шүүх таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “төрийн үйл ажиллагааг хууль дээдлэх зарчим”—д захируулах, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн этгээд болон төр, түүний албан тушаалтан хэн боловч “хуулийн өмнө эрх тэгш байх” зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл боломж хангагдсан эсэхэд холбогдох юм. Иймд энэ асуудал үүнээс хөндийрэх учиргүй.

3/ Үндсэн хуулийн үзэл санаанд шүүх хуралдаанд прокурор оролцох, оролцоо агуулагдаж байгаа боловч Прокурорын тухай хуульд (20.1) заасны дагуу прокурор өөрийн санаачилгаар захиргааны хэрэг шүүхээр хянан

¹ Цогт Ц., Захиргааны хэргийн шүүх, Уб., 2019, 64 дэх талаас үзнэ үү.

шийдвэрлэх ажиллагаанд оролцох "зохицуулалт" нь үндсэн хуулийн үзэл санааг алдагдуулж байна. Улмаар үндсэн хуулиар халсан прокурорын ерөнхий хяналтыг сэргээн, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд "оролцогч" болох прокурорын үндсэн чиг үүргээс халин, прокурорын ерөнхий хяналтаас шүүхийн хяналтад шилжүүлэн тогтоосон агуулгаас хэтрэн гажуудуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

IV. Ашигласан материал

I. Эрх зүйн эх сурвалж:

Монгол Улсын Үндсэн хууль (1992.01.13), Төрийн мэдээлэл (цаашид "ТМ" гэх), №1

Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хууль (1992.01.16), ТМ, №1

Прокурорын байгууллагын тухай хууль (2017.06.09), ТМ, 2017, №24

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016.02.04), ТМ, 2016, №9

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002.12.26), ТМ, 2003, №3

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017.05.18), ТМ, 2017, №24

II. Монгол эх сурвалж:

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), УБ., 2000, (2009)

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (Судалгаа, хэрэглээний), УБ., 2017

Монгол Улсын дээд шүүх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн тайлбар, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2012

Чимид Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2017

Ганзориг Д., Захиргааны эрх зүйн тайлбар толь, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2003

Эрдэнэцогт А., Монгол Улсын захиргааны процессын эрх зүй, УБ., 2006, (2012)

Одгэрэл П., Захиргааны эрх зүйн ерөнхий анги, (Хоёр дахь хэвлэл), УБ., 2008

Цэрэнбалтав Б., Амарбаясгалан Б., Прокурорын хяналт, УБ., 2009

Баясгалан Г., Туяа Н., Цэрэнбалтав Б., Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., 2003

Процессийн эрх зүй: Онол, туршлага, (Хамтын бүтээл), УБ., 2014

Кристофер Осакве., Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги, УБ., 2005

Банзрагч Г., Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019

Цогт Ц., Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019

Цогт Ц., Захиргааны эрх зүй дэх "хууч хамаарал" буюу прокурорын хяналт, Эрх зүй сэтгүүл, №3(43), УБ., 2018

Номынбаясгалан С., Захиргааны хэргийн шүүх хуралдаанд прокурор оролцох нь, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №4, УБ., 2019

Номынбаясгалан С., Захиргааны

хэргийн шүүх хуралдаан: Прокурор оролцох, оролцооны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд, Эрх зүй сэтгүүл, №1, Уб., 2020

Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, (Эмхэтгэл I), Уб., 2018

ХЗҮХ, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ, (Судалгааны тайлан), Уб., 2018

Өмгөөллийн "Монгол өмгөөлөгч" ХХН, МУИС-ийн "Эрх зүй судлал" клуб, Үндсэн хуулийн маргаан: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, (Хянасан: Амарсанаа Ж., Зөвлөсөн: Сүхбаатар З., Боловсруулсан: Номынбаясгалан С.), Уб., 2018

Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, (1924–1992), Уб., 1998

III. Үндсэн хуулийн маргаан (Кейс):¹

МУҮХЦ, Дүгнэлт №07/1994.07.25.

МУҮХЦ, Дүгнэлт №01/2003.04.30.

МУҮХЦ, Тогтоол №02/2003.06.20.

МУҮХЦ, Дүгнэлт №15/2018.11.21.

¹ Дээрхи товчоолын "МУҮХЦ" гэснийг "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц" гэж ойлгоно. Н.С.

**УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

/Төрийн болон орон нутгийн өмчит, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хүрээнд/



Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш. Хууль зүйн ухааны доктрант.

Г.Батнасан



Шихихутуг их сургуулийн Удирдахуйн ухааны тэнхимийн багш. Эдийн засгийн ухааны доктрант.

Г.Гантөгс

УДИРТГАЛ

НЭГ. Уул уурхайн салбар дахь худалдан авах ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалтын асуудал

1.1 Уул уурхайн салбар дахь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ойлголт, худалдан авах ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалт

1.2 Уул уурхайн салбар дахь худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бусад улс орнуудтай харьцуулан судлах нь

ХОЁР. Уул уурхайн салбар дахь худалдан авах ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам

2.1 Уул уурхайн салбар дахь худалдан авах ажиллагааны ил тод байдлын эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудал, боловсронгуй болгох санал

Дүгнэлт

Ном зүй

Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

		Сэдэв	сонгосон	үндэслэл:
IFRS	Олон Улсын Санхүүгийн Тайлангийн Стандарт			Байгалийн баялаг ихтэй улсуудад төрийн өмчит хуулийн этгээдээр /компаниар/ дамжуулан эрдэс баялгийн томоохон ордуудыг ашиглах явдал түгээмэл байна. Тэдгээр компанийн үйл ажиллагаа нь улс орны нийгэм, эдийн засагт бүхэлд нь нөлөөлж байдаг онцлогтой. Тиймээс ажиллагааных нь үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд уг компаниудад засаглал, ил тод байдлын хувьд харьцангуй өндөр шаардлага тавигддаг. Ялангуяа худалдан авалтын ил тод байдлыг хангах нь өндөр үнийн дүнтэй, их хэмжээний худалдан авалт хийдэг төрийн өмчит компаниудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой юм. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд дунджаар жилд 1 их наяд ам.долларыг ханган нийлүүлэгчдэд зарцуулдаг байна. ¹ Харин Монгол Улсын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой томоохон уул уурхайн хуулийн этгээдүүд /компаниуд/ 2020 оны хувьд ойролцоогоор 3 их наяд ² гаруй төгрөгийн худалдан авалт хийжээ. Энэхүү ханган нийлүүлэлтийн сүлжээг амжилттай болгох гол хүчин зүйлс нь:
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс			
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн			
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал			
МХБ	Монголын хөрөнгийн бирж			
ОУВС	Олон Улсын Валютын Сан			
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга			
ОХУ	Оросын Холбооны Улс			
ТӨК	Төрийн өмчит компани			
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар			
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар			
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл			
ХАТ	Худалдан авах төлөвлөгөө			
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар			1. Компанийн үр дүнтэй дотоод удирдлага, хяналтын тогтолцоо
ХК	Хувьцаат компани			2. Олон нийтийн хүчтэй хяналт
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага			3. Сайн засаглал, ил тод байдал юм.

¹ Robert Pitman and Kaisa Toroskainen, *Beneath the Surface: The Case for Oversight of Extractive Industry Suppliers*. NRGi (2020) дам шилэв.

² Шилэв дансанд 6 компанийн байршуулсан 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон Оюутолгой ХХК-ийн 2020 оны 4-р улирлын тойм мэдээ (2021) дам шилэв.

Дээрх хүчин зүйлсийг бий болгоогүйгээс цөөнгүй асуудал үүсдэг ба хамгийн уршигтай нь авлигын эрсдэлийг дагуулдаг байна. Төрийн өмчийн болон нийтийн хөрөнгөөр хийх худалдан авалт ч дээрх эрсдэлийг дагуулдаг. Энэ нь зөвхөн хөгжиж буй улс орнуудаар хязгаарлагдахгүй өндөр хөгжилтэй улс оронд ч түгээмэл эрсдэл юм. Төрийн өмчит уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниуд нь бусад салбартай харьцуулахад авлигад хамгийн их өртөмтгий салбар.¹ Учир нь худалдан авалтдаа ихээхэн хөрөнгө зарцуулахаас гадна өндөр үнийн дүнтэй худалдан авалт тогтмол хийдэг нь шийдвэр гаргагчид болон холбогдох албан тушаалтнуудыг авлигад өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.²

Сэдвийн судлагдсан байдал: Энэхүү сэдвийн хүрээнд нарийвчлан судалсан судалгааны ажил ихээхэн биш байна. Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл, Нээлттэй нийгэм форумаас гаргасан /судалгааны багийн ахлагч О.Батболд, судлаачаар Г.Батнасан, С.Болд-Эрдэнэ, Б.Зоригтхүү нар/ Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компани худалдан авалтын үйл ажиллагааны ил тод байдал сэдэвт тайлан байна.

Судалгааны зорилго: Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн худалдан авалтын ил

тод байдлыг нэмэгдүүлэхэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох нь энэхүү судалгааны зорилго юм. Уг зорилгын хүрээнд дараах үр дүнд хүрэхийг зорьж ажиллалаа. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны ил тод байдалд холбогдох хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг арилгахад чиглэсэн санал гаргах.

Судалгааны ажлын арга:

Харьцуулан шинжлэх арга: Харьцуулалт бол танин мэдэхүүд түгээмэл хэрэглэгддэг аргуудын нэг юм. Эрх зүйн юмс үзэгдлийг нэгийг нөгөөтэй нь зэрэгцүүлэн жишиж, адил төстэй ба ялгагдах шинжийг нь илрүүлж үр ашигтайгаар судлах арга юм.³ Иймээс судлах зүйлсийн хоорондын холбоо нь хэрхэн илэрч байгааг жишиж нягтлах замаар танин мэдэхэд оршино.

Системчлэн судлах арга: Эрх зүйн онолын судлагдахууны бүхий л объектыг задлан нэгтгэх, холбон уялдуулах замаар нэгдсэн тогтолцоо, дэс дараалалд оруулж, эмх цэгцтэй, тодорхой зорилго дор судлах мэдэхэд чиглэнэ. Судалгааны ажилд харьцуулан шинжлэх арга, системчлэн судлах арга болон шинжлэх ухааны суурь арга зүйг ашиглах болно.

¹ EITI (2018) Upstream Oil, Gas and Mining State-Owned Enterprises дам ншлэв

² Top 5 Procurement Best Practices in 2021 to Up your Game: <https://kissflow.com/procurement/procurement-best-practices/> дам ншлэв

³ Д.Баярсайхан – Эрх зүйн онол УБ хот 2010 он 20 дах тал

НЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

1.1 УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн этгээдийг Иргэний хуулийн 25 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлсон байна. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. Иргэний хуулинд зааснаар хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байхаар зохицуулсан байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн тухай ойлголт

Уул уурхайн салбарийн төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай

хуулиар зохицуулж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар төрийн өмчит хуулийн этгээдийг дараах байдлаар ангилж, тодорхойлж байна.

Хүснэгт №1 Төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал

Хуулийн заалт	Ангилал
13 дугаар зүйл Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал	Тор чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: 1. Төрийн байгууллага, албан газар; 2. Төрийн өмчит үйлдвэрийн газар; 3. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмгээг, нэгдсэн эмгээг.
15 дугаар зүйл Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал	1. Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.
21 дүгээр зүйл Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог	1. Төрийн өмчийн хувьцаатай буюу тор хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ.

Мөн “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” журмын 1.2-т Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг дараах байдлаар тодорхойлжээ. **Үүнд:**

- 1.2.1. нийт гаргасан энгийн хувьцааг нь 100 хувь төр

эзэмшдэг компани;

- 1.2.2. нийт гаргасан энгийн хувьцааны тодорхой хувийг нь төр эзэмшдэг, энэ журмын 1.2.1-д зааснаас бусад компани хэмээн заажээ.

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой “хуулийн этгээд”-ийн талаар эдгээрээс өөр тодорхойлолт, ангилал байхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Судалгааны ажлын хүрээнд дүн шинжилгээ хийсэн 10 хууль, 13 журмаас¹ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалт бүхий гол хууль, тогтоомж нь:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль

зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулж байна. Цахим тендер зарлах, үр дүнг олон нийтэд мэдээлэх, хяналт тавих, тендерт оролцогчийн санал бусад оролцогчдод нээлттэй байх талаар тодорхой зохицуулалтууд тусгагджээ. Уг хуулийн хэрэгжилтийг хангах “Худалдан авах ажиллагааны цахим систем” буюу www.tender.gov.mn сайтыг 2017 онд ашиглалтад оруулсан. Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй төрийн өмчтэй холбоотой бүх тендер шалгаруулалтын урилга, үр дүнгийн мэдээллийг олон нийтэд нэгдсэн байдлаар хүргэж, ил тод мэдээлэх үүрэгтэй уг системийг Төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцан хөгжүүлж байна. Тус системийн үйл ажиллагаа жигдрэн тогтмолжсоны зэрэгцээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зар, тендерийн үр дүн, шалгарсан хуулийн этгээд болон бусад оролцогчийн үнийн дүнг ил болгоод зогсохгүй хар жагсаалтад орсон хуулийн этгээдийн мэдээлэл, худалдан авах ажиллагаатай холбоотой сургалтын материалууд оруулж, хүний нөөцийн хөгжилд анхаарал тавьсан нь онцлог байлаа. Мөн тендерт шалгарсан хуулийн этгээдийн саналтай танилцах боломж бусад оролцогчдод нээлттэй байдаг. Тендерийн шалгаруулалт бодитой, шударга болсныг бусад оролцогч хянах, танилцах боломжийг ийнхүү нээж өгснөөр тендертэй холбоотой үүсдэг байсан үндэслэл муутай гомдол, маргаанууд үндсэндээ цэгцэрсэн байна. Хэрвээ олон нийтэд ил тод болгохыг үүрэг болговол

¹ Хавсралт №1 Худалдах авах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах талаарх төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд, үйлдвэрийн газрын хүлээх үүрэг, Ил тод байдлыг хангах болон компанийн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих төрийн байгууллага, тэдгээрийн хүлээх үүргийн харьцуулалтыг үнэ үү?

системийн хувьд бүрэн боломжтой. Түүнчлэн гэрээнүүд болон гүйцэтгэлийн үйл явцыг уг системд мэдээлж, Төрийн худалдан авах ажиллагааны газар хянадаг. Гэхдээ эдгээр мэдээлэл нь нийтэд ил биш байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиар нарийвчлан зохицуулна гэжээ. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9.1-д зааснаар улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна гэжээ. Иймээс төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нарийвчлан зохицуулсан хууль нь Шилэн дансны тухай хууль болно.

Шилэн дансны тухай хууль

Уг хууль 2014 онд батлагдан 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээр төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн мэдээллийг нийтэд ил болгон мэдээлэх эрх зүйн орчин бий болсон. Мөн www.shilendans.gov.mn цахим хуудастай. Шилэн дансны тухай хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд

олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байна. Үүнд төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилго багтаж байна.

Шилэн дансны тухай хуульд хамаарах этгээдийг уг хуулийн 3.1-д зааснаар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

3.1.1. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2. төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3. хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5. төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нар хамаарч байна.

Эдгээрээс 3.1.3-т “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” журам болон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах

тухай хууль"иудад тусгагдаагүй нэр томъёо байна. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн хуулийн этгээдийн худалдан авалтын ил тод байдлын гол зохицуулалт нь Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам болно. Уг журмын 4 дүгээр зүйл болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд хамаарах этгээдийг дараах байдлаар ангилан, ил тод болгох мэдээллийн үзүүлэлтийг ялгамжтай гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагалдах журмын 2.1-ийн дагуу байгууллага бүр өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэстэй байх бөгөөд шилэн дансны цэс нь:

- төсөв/гүйцэтгэл;
- хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт;
- бусад;
- Сангийн яамны мэдээлэл гэсэн дөрвөн дэд цэстэй байна.

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын дэд цэс нь дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

- худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
- худалдан авах ажиллагааны тайлан;
- хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл;
- хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн

ерөнхий мэдээлэл;

- таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
- улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл;

Эдгээрээс 5 нь худалдан авалттай шууд холбоотой байна. Тендертэй холбоотой нарийвчилсан мэдээллийг (тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалт явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан) Шилэн дансны тухай хууль болон дагалдах журамд нийтэд ил болгохоор заасан ч Шилэн дансны цэсэд уг агуулга тусгагдаагүй байна. Харин уг мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэд ил тод болгож байна. Иймээс Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон Шилэн данс хоёрыг уялдуулан линкээр холбож өгвөл худалдан авалттай холбоотой мэдээллийг нэгдсэн байдлаар харах боломж бүрдэх юм.

1.2 УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БУСАД УЛС ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

Улс орнууд байгалийн баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулахдаа аж ахуйн өмчлөлийн хэд хэдэн хэлбэрийг ашиглаж байна. Бразил, Чили, Норвеги зэрэг улсуудад хувийн хэвшлийн, нээлттэй, төрийн өмчийн эсвэл төр хувийн хэвшлийн хамтарсан компанийн хэлбэрүүд байгаа бол Канад болон Австрали зэрэг улсуудын хувьд уул уурхайн төслүүдийг дотоод болон гадаадын хувийн хэвслээр гүйцэтгүүлэхийг илүүд үзэж, төрийн зүгээс хяналт шалгалтыг өндөр түвшинд тавьдаг байна. Судлаач миний бие уул уурхайн салбартаа төрийн өмчийн менежментийг хэрэгжүүлж буй Чили, Бразил, Норвеги, Перу, Мексик зэрэг таван улсыг сонгон сайн туршлагыг судаллаа.

ЧИЛИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС: Тус улсад ТӨК-ийн тоо цөөн ч эдийн засаг дахь хувь нэмэр өндөр. Тэр дундаа уул уурхайн компаниуд ДНБ-ий 10 хувийг бүрдүүлдэг байна. Зэсийн CODELCO, газрын тосны ENAP компаниуд улсын төсвийн 90 орчим хувийг бүрдүүлдэг.¹ Ил тод байдлын хууль (The Transparency Act)² нь төр, хувийн хэвшил гэж ялгалгүй үйл ажиллагаа, санхүүгийн мэдээллээ стандартын дагуу нийтэд ил болгохыг шаарддаг. Чили Улс нь ТӨК-ийн санхүү,

аудитын мэдээллийг нийтэд ил тод болгох стандарттай.³ ТӨК-иуд сар бүр төсвийн гүйцэтгэлийн тайланг SEP⁴ болон Сангийн яамны төсвийн хэлтэст гаргаж өгөх үүрэгтэй. Мөн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг улирал тутамд SEP-ээр хянуулах ба жилийн эцсийн тайлангаа нийтэд ил болгох үүрэгтэй. SEP нь ТӨК-иудын ирүүдсэн тайланг хянаж нэгтгээд Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох байгууллагуудад хүргүүлдэг. Компаниуд сар, улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлангаа компанийн өөрийн болон SEP-ийн цахим хуудаст компани тус бүрээр оруулдаг.

ТӨК нь дотоод аудитын хэлтэстэй байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-дөө шууд харьяалагдана. Аудитын тайлангууд ТУЗ болон SEP-ээр хянагдана. ТӨК жилд нэг удаа хөндлөнгийн аудитаар хяналт хийлгэх үүрэгтэй. Хөндлөнгийн аудитыг ТӨК-ийн ТУЗ болон SEP сонгож, сонгогдсон аудит тухайн компанид 4 хүртэлх жилд аудит хийдэг. Эцэст нь ТӨК хууль эрх зүйн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьдаг Хяналтын ерөнхий газрын (Office of Comptroller General)⁵ аудитаар ордог.⁶ Тус улсын ТӨК болон төрийн албан хаагчид нь "Ил тод байдал ба

³ United Nations, Chile: Anti-corruption and transparency in public administration: <https://www.un.org/ruleoflaw/blog/portfolio-items/chile-anti-corruption-and-transparency-in-public-administration/> орчуулга

⁴ State-Owned Enterprises System (SEP) – Төрийн мэдлийн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг зөвлөл. SEP-ийн үндсэн чиг үүрэг нь ТӨК-ийн удирдлагыг санал болгох, томилгох, компаниудын стратеги төлөвлөгөөнд хяналт тавих, батлах, мөн ТӨК-ийн удирдлага болон санхүүгийн менежментэд хяналт тавих.

⁵ Office of Comptroller General, the agency that supervises compliance with administrative regulations орчуулга

⁶ The World Bank (2014).. 91 орчуулга

¹ The World Bank (2014) Corporate Governance of State-Owned Enterprises in Latin America орчуулга

² The Transparency Act - 2009 оны 4 дүгээр сард батлагдсан хууль орчуулга

олон нийтийн мэдээллийн хүртээмжийн тухай”¹ хуулийг мөрдөж ажилладаг. Уг хуулийн дагуу эрх бүхий албан тушаалтан шаардлагатай мэдээллийг тогтсон хугацаанд нийтэд ил тод болгоогүй тохиолдолд сарын цалингийнхаа 25-50 хувь хүртэлх хэмжээнд мөнгөн торгууль хүлээдэг. Мөн ТӨК-ийн ТУЗийн гишүүдийн урамшууллын мөнгөн дүнгээс хасдаг. Тус улсын ямар ч иргэн төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал, худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох албан тушаалтан, газар нэгжээс шаардан авах эрхтэй бөгөөд тухайн субъект нь уг мэдээллийг 5 хоногийн дотор нийтэд ил болгодог байна.

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ

БРАЗИЛ УЛС: ТӨК-ийн нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө өндөр. ТӨК-иудын 43 хувийг газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын компаниуд эзэлнэ. ТӨК-ийн үйл ажиллагаанд DEST² гэх төрийн агентлаг SIEST³ нэртэй мэдээллийн системийг ашиглан хяналт тавьдаг. SIEST нь ТӨК-иуд төсвийн зарцуулалтаа сар тутамд мэдээлдэг нэгдсэн систем юм. Уг системд оруулсан санхүү, зардлын мэдээллийг DEST хянаад ТӨК бүрийн төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын тайланг цахимаар нийтэд ил байршуулна.⁴ ТӨК-ийн гүйцэтгэх захирал санхүүгийн тайлангаа ТУЗ-д тогтмол

тайлагнахаас гадна дотоод аудитын газар шалгадаг. ТӨКийн ТУЗ нь төрийн хяналт шалгалтын хэд хэдэн агентлагт жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хүргүүлэхийн зэрэгцээ цахимаар нийтэд ил болгох үүрэг хүлээнэ.

ТӨК-иуд хараат бус аудит хийлгэх үүрэгтэй. Нягтлан бодох бүртгэлийн хороо (The Accounting Court), Хяналтын ерөнхий газар (Office of the Comptroller General) нь ТӨК-д хараат бус аудит хийх эрхтэй. Мөн ТӨК-ийн ТУЗ хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон жил бүр аудит хийлгэнэ. Аудитын тайланг цахимаар нийтэд ил болгож, төрийн хяналтын байгууллагуудад хүргүүлдэг.⁵ ТӨК-ийн худалдан авалт нь “Төрийн өмчийн худалдан авалтын тухай”⁶ хуулиар зохицуулагддаг. Уг хуулиар дараах мэдээллийг тухайн ТӨК, холбогдох төрийн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн хэрэгсэлд нээлттэй байршуулдаг. Үүнд:

- Захиалагч талын мэдээлэл
- Хийгдэх ажил, гэрээний хамрах хүрээ
- Гэрээний багцаа үнийн дүн
- Хууль эрх зүйн үндэслэл
- Тендерт оролцох санал боловсруулахтай холбоотой гэрээний загвар зэрэг нэмэлт мэдээлэл авах эх сурвалжийн мэдээлэл
- Санал өгөх эцсийн хугацаа
- Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд

¹ Law 20285, Law on Transparency and Access to Public Information орчуулга

² Department of Coordination and Control of State Enterprises (DEST). Бразил Улсын Төлөвлөлтийн яамны харьяа агентлаг бөгөөд төрийн өмчит компани үйлдвэрийн гаруулах төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаг

³ ТӨК-иуд нь төсвийн зарцуулалтаа сар тутамд ил тод болгохдоо SIEST мэдээллийн системийг ашигладаг

⁴ The World Bank (2014), 76 орчуулга

⁵ The World Bank (2014), 78 орчуулга

⁶ Public Procurement Act of Brazil: <https://practice-guides.chambers.com/practice-guides/public-procurement-government-contracts-2020/brazil-орчуулга>

Сонгон шалгаруулалтад оролцогчдод тендерт шалгараагүй үндэслэлийг ил тод мэдээлнэ. Амжилтгүй оролцсон оролцогч ажлын 5 өдөрт багтаж давж заалдах эрхтэй.

НОРВЕГИЙН ВАНТ УЛС: 1960-аад оны үед ТӨК-ийн талаар баримтлах бодлоготой болж, Аж үйлдвэрийн яамны харьяанд Төрийн өмчийн хэлтэс байгуулжээ. 1970-аад оны сүүлээр төрийн өмчит "Statoil" буюу одоогийн "Equinor" газрын тос, байгалийн хийн хамгийн том компанийг байгуулсан. Өмчийн хэлбэр үл харгалзан компанийн үйл ажиллагааг Хувь нийлүүлсэн компанийн тухай хуулиар зохицуулдаг. ТӨКийн үйл ажиллагаа, зардал, худалдан авалт, тендерийн мэдээллүүд цахим орчинд нийтэд ил байдаг. Төрийн өмчийн хэлтсээс ТӨК-иудын нэгдсэн тайлан, Захирлуудын зөвлөл, ТУЗ-ийн талаарх мэдээллийг жил бүр шинэчлэн www.dep.no/nhd/ сайтад нээлттэй болгодог. Жилийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсон хөндлөнгийн аудитаар шалгуулж, тайланг төрийн яамны дотоод хяналтын алба хянаж хэлэлцэнэ. Төрийн өмчийн хэлтсийн үйл ажиллагааг Улсын ерөнхий аудитын газар шалгаж, тайлангаа жил бүр Парламентдаа танилцуулна.

БҮГД НАЙРАМДАХ ПЕРУ УЛС: ТӨК-иуд нь улсынхаа эдийн засагт чухал нөлөөтэй. Засгийн газрын агентлаг FONAFE¹ нь ТӨК-д хяналт тавих үүрэгтэй. FONAFE нь ТӨК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, тендерийн тайлангуудыг

багтаасан SIED² нэгдсэн системтэй. Энэ нь мэдээллийн ил тод байдлыг хангахын зэрэгцээ ТӨК-иуд мэдээлэл, баримт бичгээ солилцох боломжийг бүрдүүлдэг нэгдсэн систем юм. FONATE-аас "Төрийн өмчит компанийн менежментийн ил тод байдал"³ гэх заавал мөрдөх тогтоол гаргаж, хэрэгжилтийг хянадаг. ТӨК-иуд санхүүгийн тайлан, төсвийн зарцуулалтын мэдээллээ сар, улирал, жилээр FONAFE-д гаргаж өгөхийн зэрэгцээ жил бүр аудитын тайлан, компанийн сайн засаглалын тайланг гаргадаг. ТӨК-иудын тайлан, аудитын мэдээллийг компанийн вэбсайт болон FONAFEийн вэбсайтад нээлттэй байршуулдаг. "Ил тод байдал ба олон нийтийн мэдээллийн хууль"-иар салбарын болон үндэсний аюулгүй байдалд хамаарахуйц нууцын зэрэглэлтэй мэдээллээс бусад бүх мэдээллийг нийтэд ил тод болгох үүрэгтэй. Хэрэгжүүлээгүй тохиолдолд тус хуулийн 377 дугаар заалтын дагуу холбогдох албан тушаалтнуудад 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял онооно.⁴ 2008 оноос ТӨК-иудад Хяналтын ерөнхий газраас⁵ баталсан дотоод хяналтын систем нэвтрүүлэн, хэрэгжилтийг байгууллагын хяналтын алба⁶ хянадаг. Ийм алба ТӨК бүрт

² Electronic Document Exchange System. SIED <https://www.fonafe.gob.pe/empresasdelacorporacionоруулага>

³ Transparency in the Management of State Owned Enterprises under FONATE: Approved by Executive Direction's Resolution No. 010-2009/DE-FONAFE. published on February 11th, 2009

⁴ Peru: Código Penal (Decreto Legislativo N°635 del 3 de abril de 1991) https://www.legal-atlas.net/sites/default/files/law/Peru_CriminalCode_1991.pdf

⁵ Office of the Comptroller General

⁶ Institutional Controller Office: Төрийн өмчит компани бүр дотоод хяналтын албатай бөгөөд энэ алба нь зөвхөн ТУЗ-д захирагдаж, ажил үүргээ тайлагнадаг.

¹ National Fund for Financing State Business Activity - Төрийн өмчит компаниудын санхүүжилтийн үндэсний сан

байх ба төсөв санхүү, өмч хөрөнгийн зарцуулалтыг давхар хянаж ТУЗ-д тайлагнах үүрэгтэй. ТӨК-иуд жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа хараат бус аудитаар шалгуулдаг. ТӨК-ийн эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигчид шаардлагатай гэж үзвэл нэмэлт аудитын шалгалтыг хэдийд ч хийлгэх боломжтой.¹

МЕКСИКИЙН НЭГДСЭН УЛС: Тус улсын хамгийн том төрийн өмчит компани нь газрын тос, байгалийн хийн PEMEX компани юм. Засгийн газрын нийт орлогын 30 орчим хувийг бүрдүүлдэг. Тус улсын ТӨК-иуд сар, улирал бүр санхүү, төсвийн зарцуулалтын тайланг холбогдох байгууллага, ТУЗ, олон нийтэд ил болгодог. Тайланд борлуулалт, татвар, төсвийн зарцуулалт, худалдан авалтын мэдээлэл багтдаг. Мөн жилийн эцсийн тайланг хөндлөнгийн аудитын тайлантай хамт нийтэд мэдээлнэ. ТӨК-ийн дотоод аудитын шалгалтыг Ил тод байдал ба хариуцлагын хороо, Аудит ба гүйцэтгэлийн үнэлгээний хороо² гэсэн ТУЗ-өөс томилсон хоёр хороо тус тусдаа гүйцэтгэнэ. Дотоод аудит авлигатай тэмцэх асуудалд төвлөрч хяналт шалгалт хийдэг. Бие даасан, хөндлөнгийн аудитыг ASF гэх конгрессын дэргэдэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн хяналтын байгууллага хийнэ. Хараат бус хөндлөнгийн аудит шаардлагатай гэж үзвэл нэмэлт хяналтыг хэдийд ч хийж болох ба компанийн ТУЗ-өөс зөвшөөрсөн байх шаардлагатай. Доорх хүснэгтэд судалгаанд хамрагдсан 5 улс болон Монгол Улсын ТӨК-ийн ил тод байдлыг сайжруулах хяналтын нийтлэг арга барилыг хураангуйлан оруулав.

¹ The World Bank (2014), 118

² The Transparency and Accountability Committee and the Audit and Performance Evaluation Committee

Хүснэгт №2 Улс орнуудын төрийн өмчит хуулийн этгээдийн хяналтын тогтолцоо

№	Ил тод байдлыг сайжруулах механизмүүд	Чили	Бразил	Норвеги	Перу	Мексик	Монгол
1	Үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа ил тод мэдээлдэг	✓	✓	✓	✓	✓	✓ ³
2	Дотоод аудитын нэгжтэй	✓	✓	✓	✓	✓	✓ ⁴
3	Хөндлөнгийн аудитаар шалгуулах үүрэгтэй	✓	✓	✓	✓	✓	✓ ⁵
4	Олон улсад хүтээн зөвшөөрсөн санхүү, нягтлан бодох бүртгэлийн стандарттай	✓		✓			✓ ⁶
5	Тайлангууд нь компани болон ТӨК-ийг харуусан хяналтын агентлагийн вэбсайтад давхар тавигддаг	✓	✓	✓	✓		
6	Дотоод аудитын нэгж нь компанийн ТУЗ-д шууд тайлагнадаг	✓			✓		✓ ⁷
7	Хөндлөнгийн аудитыг компанийн ТУЗ эсвэл холбогдох төрийн агентлагаас томилдог	✓	✓	✓			✓ ⁸
8	Төрийн дээд шатны хяналтын агентлаг, хороогоор давхар хянагддаг	✓	✓	✓	✓	✓	✓ ⁹
9	Санхүү, худалдан авалт, тендер, тайлангийн мэдээллийг ил тод болгох стандарт бүхий нэгдсэн мэдээллийн системтэй	✓	✓	✓	✓	✓	✓
10	ТӨК нь хувийн хэвшлийн компанитай ижил эрх, үүрэгтэйгээр зохицуулсан хууль эрх зүйн тогтолцоотой	✓		✓			✓ ¹⁰

ХОЁР. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

2.1 УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ

Шилэн дансанд бүртгэлтэй 7,944 байгууллага, хуулийн этгээд байдаг ба 5,811 нь төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байна.¹ Үүнээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяанд уул уурхайн олборлолт, хайгуул, менежмент, дэд бүтэц, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр ажилладаг хувь оролцоотой болон төрийн өмчит хувьцаат компани 11,

¹ Үндэсний аудитын газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан” <https://www.montsame.mn/mn/read/244601>

Төрийн өмчит үйлдвэрийн газар 7, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 1 Шилэн дансанд бүртгэлтэй байна.¹

Хүснэгт №3 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа шилэн дансанд бүртгэлтэй хуулийн этгээдийн мэдээлэл.²

№	Хуулийн этгээдийн нэр	Цахим хаяг
1	Багануур ХК	https://www.baganuarmine.mn/
2	Геологийн судалгааны тов ТӨҮГ	----
3	Геологийн төв лаборатори ТӨҮГ	http://cengeolab.com/
4	Мон-Атом ХХК	----
5	Монголросцветмет ТӨҮГ	http://www.mongolros.mn/
6	Монголын Газрын төс боловсруулах үйлдвэр ТООАНБ	http://www.mongolrefinery.mn/
7	Тавантолгой төмөр зам ХХК	http://www.ttz.mn/
8	Тавантолгой түлэн ХХК	----
9	Шивээ-Овоо ХК	http://shivce-ovoо.mn/
10	Шингэн түлц шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	http://ptf.mn/
11	Эрдэсүлж ХХК	https://erdsulj.erdenetmc.mn/
12	Эрдэнэс Ассет Менежмент ХХК	http://erdenesasset.mn/
13	Эрдэнэс Ал Ресурс ХХК	----
14	Эрдэнэс Метан ХХК	http://erdenesmethane.mn/
15	Эрдэнэс Монгол ХХК	http://erdenesmongol.mn/
16	Эрдэнэс Оюутолгой ХХК	http://eot.mn/
17	Эрдэнэс Тавантолгой ХК	https://ett.mn/
18	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	https://www.erdenetmc.mn/
19	Эрэнс Ойш ХХК	----

Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж, удирдлага, зохицуулалтаар хангах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар. Гэхдээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын хувьцаа эзэмших эрхийг өөр өөр байгууллагууд хэрэгжүүлж байна. Тухайлбал ТӨБЗГ “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет”-ийн удирдлага, хувьцааны эрхийг хэрэгжүүлж буй бол “Эрдэнэс Тавантолгой”-г Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэс Монгол”-ын хувьцааны эрхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар хэрэгжүүлж байна. Гэтэл Шилэн дансны цэс дээр бүгд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяанд бүртгэгдсэн байна. Уг системийн төсвийн ерөнхийлөн захирагч гэсэн сонголтод ТӨБЗГ байхгүй байна. Харин худалдан авах ажиллагааны цахим системд “Монголросцветмет”, “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Силвер Ресурс” зэрэг компанийн Төсвийн ерөнхийлөн захирагчаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг бүртгэжээ. Харин Шилэн данс дээр “Эрдэнэс Силвер Ресурс”-ийн төсвийн ерөнхийлөн захирагч нь

¹ Шилэн дансны цэсэд бүртгэлтэй Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд харьяалагдаж буй байгууллагууд /2020 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар/ <https://shilendans.gov.mn/org/tez/18>

² Тогтвортой хөгжил, нийгмийн харнуулалтын зөвлөл, Нэгдлтэй нийгэм форумаас гаргасан /судалгааны багийн ахлагч О.Батболд, судлаачаар Г.Баттасан, С.Болд-Эрдэнэ, Б.Зоригтхүү нар/ Төрийн болон орон нутгийн өмчиг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн хэлтэс худалдан авалтын үйл ажиллагааны нэг тод байдал эхлэвт тайлан 32 дах тал

бүртгэгдээгүй буюу хуулийн этгээдийн нэр хоосон байна.¹ Мөн орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын бүртгэлийг нягтлахад ч тодорхойгүй зүйлс цөөнгүй байна. Жишээ нь, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг “Тавантолгой” ХК-ийн хувьд Худалдан авах ажиллагааны цахим системд Төсвийн ерөнхийлөн захирагч нь Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар² гэж бүртгэгдсэн байгаа бол Шилэн дансанд Төсвийн ерөнхийлөн захирагч Өмнөговь аймгийн Цогтцэций³ сум гэжээ. Иймэрхүү бүртгэлийн зөрүүтэй байдал судалгааны явцад түгээмэл давтагдаж байв.

Шилэн дансны тухай хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэн ч шилэн дансны хөтлөлт ТӨК бүрт харилцан адилгүй түвшинд байна. Мэдээллийн бүрдэл, хүртээмж, баталгаажсан байдлын хувьд “Эрдэнэтүйлдвэр”, “Монголросцветмет”, “Эрдэнэс Тавантолгой” компаниудын Шилэн данс хөтлөлт харьцангуй сайн байгаа бол бусад компанийн хувьд мэдээллээ байршуулж байгаа ч бүрэн гүйцэд биш байна. “Оюутолгой” компани шилэн данс хөтөлдөггүй, “Могойн гол” компани шилэн дансанд бүртгэлтэй ч мэдээлэл байршуулаагүй, “Эрдэнэс Силвер Ресурс” компани маш хангалтгүй мэдээлэл оруулсан байна.

Энэ нь хууль журмын зохицуулалт бүрэн хэрэгжихгүй, хэрэгжилтэд хяналт тавих механизм болон хууль зөрчсөн тохиолдолд тооцох хариуцлагын механизмыг хангалттай сайн зохицуулаагүйтэй холбоотой. Төрийн өмчит уул уурхайн компаниудын Шилэн данс болон Худалдан авах ажиллагааны цахим систем дэх бүртгэлүүд маш их зөрүүтэй байна. Шилэн дансанд 2020 оны ХААТ-гөө байршуулсан 6 компани 2020 онд нийт 2 их наяд 161.3 тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөжээ. Худалдан авалтын хүрээнд эргэлдэж буй ийм өндөр дүнтэй мөнгөний урсгалын ил тод байдлыг хангах нь авлига, үр ашиггүй зарцуулалт, төрийн муу менежментээс сэргийлэх чухал ач холбогдолтой. Компаниуд нь ХААТ-г ил тод байршуулж байгаа ч худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүд шаардлага хангахуйц биш дутуу, иж бүрэн биш байх явдал нийтлэг байна. Хуульд заасан хугацаанд мэдээллээ байршуулдаггүй, өөрчлөлтийг тогтмол шинэчилдэггүй, холбогдох шийдвэрийн хуудсыг хавсаргадаггүй зэрэг дутагдал түгээмэл байна. Энэ нь үр ашиггүй зарцуулалтыг хянах боломжийг хязгаарласаар байна.

Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд, улсын үйлдвэрийн газар, хяналтын багцыг төр эзэмшдэг компаниудын ил тод болгох мэдээллийг ялгамжтай тогтоосон. Ингэж ялгамж тогтоохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн

¹ “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн шилэн данс 2021 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар <https://shilendans.gov.mn/org/13701>

² Тавантолгой ХК-ийн Худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, 2021 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар <https://www.tender.gov.mn/nm/client/detail/1541986155399>

³ Тавантолгой ХК-ийн Шилэн дансны бүртгэл, 2021 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар <https://shilendans.gov.mn/org/7174>

оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 1.2-т зааснаас өөрөөр ТӨК-иудыг ангилсан байна. Энэ нь мэдээллийг хангалттай хэмжээнд нээлтэй болгохгүй байх нөхцөл бүрдүүлэхээс гадна ТӨКиудыг төөрөгдүүлэх, хуулийн хэрэгжилтээс зайлсхийх асуудал үүсгэх талтай юм. Шилэн дансны тухай хуульд зааснаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэх ёстой. Олон улсын нийтлэг туршлагын дагуу дотоод аудит болон дээд шатны байгууллага, төрийн аудит, олон нийтийн гээд хяналтын давхар зохицуулалтууд тусгагдсан ч хоорондын уялдаа холбоо байхгүй байна.

Төрийн аудитыг өөрийн санаачилгаар гэсэн нь мэргэшсэн хяналтын байгууллагын тогтмол хяналт тавих боломжийг сулруулсан тал байна. Түүнчлэн Үндэсний аудитын газраас Шилэн дансны хэрэгжилтэд хийсэн шалгалтын дүнд, шилэн дансны хөтлөлт хангалтгүй байгууллагуудад шилэн дансаа хөтлөхийг үүрэг болгох, тэдэн байгууллага шилэн данс хөтөлсөн, хөтлөөгүй гэх дүгнэлтээс хэтрэхгүй, аудитын мөрөөр ямар арга хэмжээ авч, ямар үр дүнд хүрсэн, хэрхэн хариуцлага тооцсон нь ойлгомжгүй өнгөрч байна.

Нэр бүхий уул уурхайн салбар дах ТӨК-иудад ИТХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавьсан тохиолдол гараагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуульд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хэрхэн хяналт тавих, ямар давтамжтай хийх нь тодорхойгүй, хяналтын мөрөөр ямар арга хэмжээ авах, нийтэд мэдээлэх талаар тодорхой зохицуулаагүйтэй холбоотой. Нөгөө талаар ИТХ-ын хувьд хяналт тавих чадамж хэр байгаад анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна. Улмаар төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанид хөндлөнгийн хяналт тавих байгууллага нь шат шатны ИТХ байхаар зохицуулсан нь төдий л оновчтой зохицуулалт болж чадаагүйг харуулж буй. Хариуцлагын зохицуулалтын хувьд Шилэн дансны тухай хуулийн 10.1-д¹ зааснаар хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээхээр заажээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаардаггүй ТӨК болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох бололцоогүй байдлыг үүсгэж байна.

Иймд судлаач миний бие дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ТӨК-ийн мэдээллийг ил тод болгох явцад ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэж буй дараах зүйлсийг нэг мөр цэгцэлж, бусад хууль, журам болон Шилэн данс болон Худалдан авах ажиллагааны цахим системтэй уялдуулах шаардлагатай байна. Үүнд:
 - эрх зүйн ангилал
 - нэр томъёоны тодорхойлолт

¹ Энэ хуулийн зорчсон албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

- бүртгэл
2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу <https://www.tender.gov.mn/>-ийг Шилэн данстай холбох шаардлагатай.
 3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанид хөндлөнгийн хяналт тавих байгууллага нь шат шатны ИТХ байхаар зохицуулсан оновчтой зохицуулалт болж чадахгүй байна. Иймд ТӨК-ийн дотоод хяналтын нэгжийг үр дүнтэй ажиллуулж, тэрхүү хяналт нь дээд шатны байгууллага, төрийн хяналтын байгууллага болон хараат бус хөндлөнгийн аудитаар дахин хянагддаг, түүнийг олон нийтэд мэдээлдэг үр дүнтэй тогтолцоо бий болгох шаардлагатай.
 4. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлж буй эрх бүхий дээд байгууллага, Орон нутгийн захиргаа, холбогдох байгууллагууд хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай.
 5. Шилэн дансны тухай хуульд зааснаар байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно хэмээн заасан тул байгууллага,

албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийсний дараа үр дүнг мэдээлдэг байх шаардлагатай.

6. Тухайн төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн /компанийн/ эрх бүхий албан тушаалтан шаардлагатай мэдээллийг тогтсон хугацаанд нийтэд ил тод болгоогүй тохиолдолд сахилагын шийтгэл ноогдуулдаг хариуцлагын механизм бий болгох.
7. Иргэний мэдэх эрхийн хүрээнд иргэн төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал, худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг холбогдох албан тушаалтан, газар нэгжээс шаардан авах эрхийг холбогдох хуулинд тусгаж өгөх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын удиртгал хэсэгт дурдсанаар байгалийн баялаг ихтэй улсуудад төрийн өмчит хуулийн этгээдээр /компаниар/ дамжуулан эрдэс баялгийн томоохон ордуудыг ашиглах явдал түгээмэл байна. Тэдгээр компанийн үйл ажиллагаа нь улс орны нийгэм, эдийн засагт бүхэлд нь нөлөөлж байдаг онцлогтой. Тиймээс ажиллагааных нь үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд уг компаниудад засаглал, ил тод байдлын хувьд харьцангуй өндөр шаардлага тавигддаг. Ялангуяа худалдан авалтын ил тод байдлыг хангах нь өндөр үнийн дүнтэй, их хэмжээний худалдан авалт

хийдэг төрийн өмчит компаниудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой юм. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд дунджаар жилд 1 их наяд ам.долларыг ханган нийлүүлэгчдэд зарцуулдаг байна.¹ Харин Монгол Улсын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой томоохон уул уурхайн хуулийн этгээдүүд /компаниуд/ 2020 оны хувьд ойролцоогоор 3 их наяд² гаруй төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Чухамдаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд худалдан авалтдаа ихээхэн хөрөнгө зарцуулахаас гадна өндөр үнийн дүнтэй худалдан авалт тогтмол хийдэг нь шийдвэр гаргагчид болон холбогдох албан тушаалтнуудыг авлигад өртөх эрсдэлийг бий болгосоор байна. Энэ нь эдийн засгийн хувьд хөгжиж буй манай улсад эрсдэлтэй зүйл юм. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн албаны эрх мэдлээ ашиглан ТӨК-д бараа, ажил, үйлчилгээ өндөр үнээр шахах, тулгах, нийлүүлэх эрсдэл бий. Үүнээс болж компанийн эдийн засгийн чадамж буурах, цаашлаад ашиггүй ажиллах, төрөөс татаас авах зэрэг сөрөг үр дагавар гарах юм. Иймээс эрсдлээс сэргийлж төрөөс тодорхой эрх зүйн зохицуулалт бий болгосон байна.

Төрийн өмчийн санхүүгийн ил тод

байдлыг хангах чиглэлээр олон улс дахь сайн туршлага, жишээнүүд Монгол Улсад ч мөн нэвтэрч, хэрэгжиж байна. Монгол Улс нь төрийн өмчийн санхүүгийн ил тод байдлыг хангахыг шаарддаг хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн улс орны нэг юм. Төрийн өмчийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулж байгаа бол ил тод байдлыг хангах үндсэн зохицуулалт нь Шилэн дансны хууль болон дагалдах журам юм. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу <https://www.tender.gov.mn/> вэбсайтад тендертэй холбоотой бүхий л мэдээллийг ил болгож, мэдээллийн ил тод байдалд хувь нэмрээ оруулж байна. Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээр Шилэн дансны цахим систем <https://shilendans.gov.mn/>-д ТӨК иудын худалдан авалттай холбоотой мэдээллийг ил тод болгосон нэгдсэн мэдээллийн систем бий болж буй нь бусад улс оронд төдийлөн байхгүй сайн жишээ юм. Бид олон улсад жишиг болгож болохуйц сайн туршлага бүхий систем бий болгоогүй байгаа ч эрх зүйн зохицуулалтын хувьд олон улсад давуу байгаа юм. Иймээс өнөөдрийн бий болгосон эрх зүйн зохицуулалт болох Шилэн дансны тухай хуулийг олон улсын сайн жишгээр улам боловсронгуй болгох, сайжруулах шаардлагатай юм. Мөн иргэний мэдэх эрхийн хүрээнд иргэний хяналтын сайжруулж, төрийн байгууллагын уялдаа холбоог ойлгомжтой болгох шаардлагатай байна.

¹ Robert Pitman and Kaisa Toroskainen, *Beneath the Surface: The Case for Oversight of Extractive Industry Suppliers*, NRG1 (2020) дам ншлэн.

² Шилэн дансанд 6 компанийн байршуулсан 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон Оюутолгой ХХК-ийн 2020 оны 4-р улирлын тойм мэдээ (2021) дам ншлэн

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ



Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш. Хууль зүйн ухааны доктрант Э.Анхбаяр

"Газар бол улсын үндэс мөн" Хүннү гүрний хаан Маодунь¹

Монгол улс дахь газар өмчлөх эрхийн уламжлал, шинэчлэлийг судлахын тулд газрын талаарх эрх зүйн зохицуулалтуудыг судлахын зэрэгцээ "ГАЗАР" түүний мөн чанар, онцлогийг дурьдахуй орхигдуулж боломгүй мэт. Учир нь "Төр улс оршино гэдэг нь газар нутаг эзэмшинэ гэсэн үг. Ийм учраас "газар нутаг", "төр" гэсэн хоёр ойлголтыг адилтгах явдал түүхэнд цөөнгүй байсан ба одоо ч байсаар байна. Ингэхээлээр нутаг дэвсгэр нь төрийн нэгэн салшгүй шинж мөн"².

Манай улсын хувьд монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа дараах байдлаар тодорхойлсон байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол

Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ³.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд:

- ✓ Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох
- ✓ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал
- ✓ Нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал
- ✓ Үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал
- ✓ Эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана⁴ хэмээн тусгасан байна

Мөн 1992 оны ардчилсан Үндсэн хуульд дараах байдлаар тунхагласан байна.

"Монголын ард түмэн бид:

- ✓ **улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,**
- ✓ хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- ✓ төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- ✓ хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- ✓ эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол

¹ Боллбаатар.Ж., Лүндэжжанцан.Д., "Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал", УБ., 2011 он., 21 дэх тал

² Лүндэндорж.Н., Төрийн онол., УБ., 1997., 34 дэх тал

³ <https://www.legalinfo.mn/annex/details/8070?law-id=6163>

⁴ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол улсын үндэсний аюулгүй байдалын үзэл баримтлалын 1.1.2 зүйл

Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна”¹

“Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж” гэж эхэлсэн нь эх орноо өнө баг оршин тогтохын үндэс суурийг бэхжүүлэн заасан байна. Түүнчлэн Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхолд нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал багтана гэж бэхжүүлэн өгсөн нь улсын тусгаар тогтнолын салшгүй хэсэг бол “ГАЗАР” болох нь харагдаж байна.

“Газар” нь төр улсын тусгаар тогтнолын салшгүй хэсэг болохын зэрэгцээ эрх зүйн шинжлэх ухааны онол ойлголтууд, хөгжлийн чиг хандлага, дархлаатай шууд холбогддог онцлогтой. Үүнээс шалтгаалан газрыг эрх зүйн шинжлэх ухаан, эдийн засгийн гээд бүх талаас судлах тайлбарлах оролдлого хийдэг байна.

Үг зүйн хувьд “Газар” гэдэг нь газрын гадаргуу түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхарга гэж тодорхойлоод Байгалийн нөөцийн үндсэн төрлийн нэг, хөдөө аж ахуйн үйлдвэрийн гол хэрэгсэл. Хойч үеийнхний ашиг сонирхлын тусын тулд газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх явдлыг хангах эрх зүйн онцгой статус бүхий иргэний явдлыг хангах эрх зүйн онцгой статус бүхий иргэний эрх зүйн объектын нэг². “Газар ийнхүү нэгдмэл орчин, орон зай болдог учир аж ахуйн эргэлт, иргэний гүйлгээнд орохдоо гадаргуу, хөрс хэвлий төдийгүй

бусад зүйлсийг ч хамарна”³

Газар болон байгалийн бусад нөөц баялаг. Газар нь өргөн угтаар хүн төрөлхтний иргэншил, соёлын оршин амьдрах орон зайг хамаарах бөгөөд дээрх болон доорх баялгаа багтаасан ойлголт боловч Монгол Улсын хуульд “газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий зохих орон зайн давхаргыг хэлнэ”⁴

Мөн “Аливаа эрхийн үндсийн үндэс болсон өмчлөх эрхийн язгуур үндэс нь үл хөдлөх хөрөнгө буюу газартай эцсийн эцэст шууд холбогддог нь шинжлэх ухаанаар нотлогдсон төдийгүй амьдралаар батлагдсан алтан хууль гэж үзэж болно”⁵. Газар өмчлөгч гэж тухайн газрыг захиран зарцуулах эрх бүхий этгээдийг ойлгож болно. Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газрын өмчлөгч нь төр байхаар эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл газар өмчлөл нь тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах⁶ “Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмчид байна”⁷

“Эрх зүйн харилцаанд өмчлөгч нь өмчлөгч биш этгээдээс халдашгүй шинжтэй олон давуу эрхтэйгээр оролцох бөгөөд өөрийн эрхээ хуулиар хориглоогүй бүхий л арга замаар хэрэгжүүлнэ”⁸ “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг төрөөс

¹ Цэрэнжээ.Ц., “Өмчийн эрх зүй., УБ., 2000 он., 46 дахь тал

² Газрын тухай хууль., Хоёрдугаар зүйл.,

³ “ Шихихутуг” сэтгүүл., УБ., 2004 он., 3 дахь тал

⁴ Нарангэрэл.С., “Эрх зүйн эх” толь бичиг., УБ., 2001 он., 104Т дахь тал

⁵ Газрын харилцааны эрх зүйн актын эмхтгэл., УБ., 2012 он., 94 дэх тал

⁶ Цэрэнжээ.Ц., “Өмчийн эрх зүй., УБ., 2000 он., 27 дахь тал

¹ Монгол улсын үндсэн хууль., УБ., 1992 он., Үндсэн хуулийн оршил

² Нарангэрэл.С., “Эрх зүйн эх” толь бичиг., УБ., 2001 он., 103 дахь тал

баталгаажуулж гэрчилгээ олгоно. Гэрчилгээ өмчлөгчийн өмчлөх, эзэмших ашиглах эрхийн гэрч төдийгүй уг эрхийг төрөөс хамгаалалтад авсны баталгаа мөн¹. Иргэнийг газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бусад этгээд аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно².

Монголчуудыг төр эрх зүйн түүхэн талаас нь нь судалсан судлаачид: "Хүннү хэмээх Монгол угсаатны улс байгуулагдсанаар Монгол төрийн түүх эхэлсэн"³ гэж үзсэн байна. Хүннү гүрний эзэн хаан Маодунь шанью "Газар бол улсын үндсийн үндэс мөн" гэж зарлиг буулгаж байжээ. Мөн Чингис хаан төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүст газар нутгийг хувь өмч болгон өгч байгаагүй, харин эзэмшүүлэх онцгой эрх олгож байсан тухай "Сорхон – ширад нутаг дархалж, мэргэдийн газар сэлтээр ургийн урагт хүртэл нутаг орноо эзэмшсүгэй"⁴ хэмээсэн байдаг.

Газрын талаарх өв уламжлалыг цааш судлаад үзвэл: Эзэн Чингисийн "Их засаг хууль"-д малын бэлчээрийг онцгойлон үзэж түүнийг сүйтгэх явдлаас хамгаалахыг чухалчлан зааж байжээ.

Халхын үйсэнд бичсэн цааз эрхэмжийн бичиг"-т мод хатгасан газарт мэдэж байж бууваас гурван ёст буй. Эс мэдэж бууваас нэгэн морь ав гэсэн нь тухайн үедээ газрын харилцааны өвөрмөц зохицуулалт байсан бол 1921 онд ардын хувьсгал ялснаар газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын хувьд газрыг улсын

өмч, нийтийн хүртээл болохыг анх удаа хуульчилсан байна. Тухайлбал ".....тус улсын бүх газар шороог үүнээс хойш гадаад, дотоодын хүмүүс миний хэмээн түрэмгийлэн эзлэхийг үүр зогсоохоор"⁵ эрх зүйн зохицуулалт хийгдэж байжээ. Уг эрх зүйн зохицуулалт нь 1924 онд батлагдсан "БНМАУ-ын анхдугаар үндсэн хуульд тусгалаа олсон байна. Тухайлбал: "БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар нь уурхай хийгээд ой мод, ус тэдгээрийн баялагууд нь ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно"⁶ гэж бэхжүүлсэн байна. Мөн "Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он дөрвөн сарын 21 бөгөөд европын 1921 он таван сарын 21-ний өдөр Монгол улсын хэмжээт цаазат ардын засгийн эрхлэх товчооны гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтооснон 19-р тогтоолд:

✓ **Нэг** Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино"⁷ гэж тусгаж байсан байна.

БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор засгийн газраас гарч байсан зарим эрх зүйн зохицуулалтуудыг судлахад 1926 онд "Ард олны дотор бие, биесийг нутаг бэлчээр, өвөлжөө бууц зэргээр гачигдуулан хохироож, маргаан будлиан үүсгэн, илүү нутаг эзэрхэх явдал гарч байгааг зогсоон гагцхүү, олон онд нутаглаж, хүн мал идээшсэн, хөрөнгө малын олон цөөнд тохируулан аль бололцоот бууц бэлчээрийг нутгийн эрх

¹ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 22 дугаар зүй

² <https://www.legalinfo.mn/law/details/346>

³ Дашням, И., Монгол улсын төр эрх зүйн түүх., УБ., 2011 он., 24 дэх тал

⁴ Болдбаатар, Ж., Лүндээжанцан, Д., "Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал.. УБ., 2011 он., 90 дэх тал

⁵ 1921 оны 5 дугаар сарын 21-ний өдөр баталсан Ардын түр засгийн газрын 19 дүгээр тогтоол

⁶ 1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар үндсэн хууль

⁷ Газрын харилцааны хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл., УБ., 2018 он., 175 дахь тал

баригчдаас зүй зохисоор заан олгуулж байх”¹ гэсэн зохицуулалт хийж байсан бол улмаар 1928 онд “Олон ардууд эрх биш өөр өөрийн нутгийн хязгаар нутаг дотор нутаглавал зохих, шалтгаангүйгээр бусад хошууны нутагт нүүдэллэн орохыг хязгаарлах, хэрэв хил тодорхойгүй бол түүнийг шинэчлэн тодорхойлох, ган зуд тохиолдох үед өөр өөрсдийн захиргааны байгууллагаар уламжлан урьдаас зөвшөөрүүлж байх”², 1935 онд “Тус улсын харьяат нар, улсын ба хоршоо, аж үйлдвэр, олон нийтийн байгууллагууд бэлчээр усыг үнэ төлбөргүй, хугацаагүй эдлэх бөгөөд гадаадын харьяат нарт түрээсээр эдлүүлэх”³ тухай эрх зүйн зохицуулалтууд хийгдэж байжээ.

1940 онд батлагдсан БНМАУ-ын 2 дахь удаагийн үндсэн хуульд “Бүх газар, ой мод, ус тэдгээрийн баялаг улсын өмч буюу ард түмний хөрөнгө мөн” гэж заан анхдугаар үндсэн хуулийн заалтыг хэвээр бататгасан байна. 1942 онд Газар эдэлбэрийн тухай хууль гарч түүнд газар эдэлбэрийн эрхийг хувийн аж ахуйтнуудын хөдөлмөрийн газар эдэлбэрийн эрх, Артель ба олон нийтийн газар эдэлбэрийн эрх, Улсын аж ахуйтан ба станц, аж үйлдвэр, албан байгууллагын газар эдэлбэрийн эрх гэж ангилсан байдаг.

1960 онд батлагдсан БНМАУ-ын гурав дахь Үндсэн хуульд өмнөх үндсэн хуулийн /1940 оны / заалтыг бататгасны дээр “Хөдөө аж ахуйн нэгдэлд газрыг үнэ төлбөргүй, байнга эдлүүлнэ” гэж хэм хэмжээ тогтоожээ. Үүний зэрэгцээ “газрын нэгдсэн сангийн ангиллыг бий

болгож, газар эзэмшигчид, тэдний эрх үүрэг, газар олгох авах журам, газрын бүртгэл, хяналт, газарзохионбайгуулалт, маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тухай эрх зүйн зохицуулалт”⁴ бий болсон байна.

Дээрх судалгаанаас газар өмчлөх эрхийн түүхэн уламжлалуудыг харж болно.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс гэдгийг түүхийн аль ч үед чухалчилж байсан уламжлалтай байна. Манай улс нэрт судлаач эрдэмтэн Б.Чимид багшийн минь хэлснээр: Монгол улс

- ✓ Эзэн Чингисийн үндэслэсэн төрт ёс, соёл, иргэншлийн олон зууны түүхтэй
- ✓ Өгдгөө 3 сая гаран хүн амтай
- ✓ **1 сая 564,1 мянган ам км нутаг дэвсгэртэй**
- ✓ Хангай, говь, хээр тал хосолсон
- ✓ Эх газрын хэвлийд нь эрдэс баялаг чихэлдсэн
- ✓ Цэвэр агаар, цэнгэг ус, онгон байгальд сая сая мал бэлчээрлэсэн
- ✓ Орчин цагийн үйлдвэр, үйлчилгээний сүлжээ хөгжиж, соёл түгсэн **мөнх хөх тэнгэрийн орон билээ**⁵. Энэ сайхан орны минь “Төрийн шинжийг бүрдүүлж байгаа нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг эрх мэдэл бол төр улс орших үндэс мөн. Аль нэг шинжийг нь алдвал төр улс оршихуйн болон хууль

¹ “Газар бэлчээрийг эдлэх тухай” Засгийн газрын эрхлэх товчооны 1926 оны 227 дугаар тогтоол

² Засгийн газрын 1928 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар хурлын тогтоол

³ Улсын бага хурлын тэргүүдэгчид, Сайд нарын зөвлөл 1935 оны 9 дүгээр сарын 25-нд бэлчээр усыг эдлэх тухайн дүрэм

⁴ 1971 онд БНМАУ-ын АИХ-ын тогтоолоор баталсан БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль

⁵ Чимид.Б., “Үндсэн хуулийн мөхлөг”, УБ., 2008 он., 33 дахь тал

зүйн үндэсгүй болно”¹

1992 оны Үндсэн хуульд Монгол улсын газрыг анх иргэндээ өмчлүүлэхээр хуульчилсан бөгөөд эрдэмтэн Б.Чимид Монгол улсын шинэ үндсэн хууль, түүний үзэл баримтлалыг үнэлэн дүгнэхдээ: “Шинэ Үндсэн хууль Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлж эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгын дор замнан хөгжихийн үүд хаалгыг нээсэн бөлгөө гэж тэмдэглэсэн байна.

Үндсэн хуулийн дээрх заалтууд нь газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх эрх зүйн үндсийг тавьж өгсөн байна. Улмаар 1994 онд “Газрын тухай” Монгол улсын хууль батлагдсан. Тухайн хууль нь Ардчилсан Үндсэн хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хууль байсан бол Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль нь “200 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдаж, 2003 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн байна.

“Өмчлөх эрхийн жинхэнэ утга нь хувийн өмчид байна” Иймээс газрын эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн хүрээнд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзвэл:

Газрыг өмчлүүлэх зориулалтаар нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар / зөвхөн нэг удаа үнэгүй өмчлүүлнэ/, аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар өмчлүүлж болно.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар:

✓ Хот тосгон, бусад суурины

нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газар/гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай/

✓ Ойн болон усны сан бүхий газар

✓ Тусгай хэрэгцээний газар

✓ Зам, шугам сүлжээний газраас бусад газарт газар өмчлүүлнэ. Гэхдээ уг өмчлөх газар нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгагдсан, тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрт иргэнд өмчлүүлэхээр заасан газар байх шаардлагатай.

✓ Бэлчээр

Аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар өмчлүүлж болно.

Давуу эрхээр худалдан авах/ тухайн газрыг хууль тогтоомжийн дагуу эзэмшиж байгаа иргэн өмчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд түүнд давуу эрхээр худалдах замаар өмчлүүлж болно/

Дуудлага худалдаагаар худалдан авах /Газрын тухай хуульд заасны дагуу аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар тухайн газрыг эзэмшээгүй иргэн дуудлага худалдаагаар худалдан авч өмчилж болно/ гэсэн үндсэн 2 хэлбэрээр дээрх зориулалтын дагуу газрыг өмчлөх боломжтой юм.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмших газрын хэмжээ

✓ Нийслэлд 0,07 га хүртэл

✓ Аймгийн төвд 0,35 га хүртэл

✓ Сумын төв, тосгонд 0,05 га хүртэл

✓ Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт 0,07 га хүртэл

¹ Лүндэндорж, Төрийн онол, УБ., 2005 он., 37 дахь тал

Аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх газрын хувьд газар эзэмших гэрээний дагуу эзэмшиж байгаа тохиолдолд тухайн эзэмшиж буй газрын хэмжээгээр харин дуудлага худалдаагаар худалдан авч байгаа тохиолдолд тухайн дуудлага худалдаагаар худалдаж буй газрын хэмжээгээр өмчилж болно.

Өмчийн газраа, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэхийг хориглоно. Газар өмчлөгч иргэн Монгол Улсын харьяатаас гарснаар газар өмчлөх эрх дуусгавар болох нэг үндэслэл болдог байна¹. Үүнээс үүдэн **“ГАЗАР”**–ын эрх зүйн зохицуулалт түүн дотроос “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх” эрхийн зохицуулалтуудыг онцгойлон ач холбогдол өгөн судлах шаардлага урган гарч байна.

1994 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1995 онд гарсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1997 онд Газрын төлбөрийн тухай хууль, 1998 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд тус тус батлагдсан нь газрын харилцаатай холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн, эрх зүйн орчинг боловсронгуй болгосон зохицуулалтууд мөн боловч нарийн судлаад үзэхээр газрын үнэ цэнэ уламжлагдсан ирсэн уламжлал соёлоо умартан эдийн засгийн ач холбогдол талаас илүү харсан эрх зүйн шинэчлэл болсон байна.

Эрх зүйн харилцаан доторх хэрэгжилт гэж зохих субъект хуулиар олгосон эрхээ эдэлж. Хүлээсэн үүргээ

биелүүлэхээр заавал эрх зүйн тодорхой харилцаанд оролцож, бусадтай харилцаж байж хэрэгжүүлдэг зан үйлийг хэлнэ”², Тухайлбал: “Газар өмчлөгч эрхээ хэрэгжүүлэхдээ хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй”³ Үүнээс дүгнэж үзвэл “Өмчлөгч зөвхөн эрхтэй төдийгүй үүрэг, хариуцлага хүлээж байдаг”⁴

Иргэд газраа өмчлөх харилцаанд шилжсээр эхний ⁵ жилд улсын хэмжээнд нийт өрхийн 28,14 хувь нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилж авсан талаарх судалгаа байгаа бол 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт иргэдийн 18,3 хувь, нийт өрхийн 62,54 хувь нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг үнэгүй өмчилж авсан байна. Мөн иргэд цахимаар нийт 44 байршилд 68869 иргэнд газар өгсөн байна.

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх” болон “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийг дагаж мөрдөх журмын тухай, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, Нийслэлийн Газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөө, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын албаны үндсэн чиг үүрэг, зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор хийгдсэн ажлуудаас судалж үзэхэд

“Улаанбаатар хотод газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулан явуулахдаа өмчлөгдөх газрын байршил, зориулалт,

² Амархүү.О., Эрх зүйн онол., УБ., 2018 он., 245 дахь тал

³ Газрын харилцааны эрх зүйн актын эмхтгэл., УБ., 2012 он., 94 дэх тал

⁴ Цэрэнжэв.Ц., “Өмчийн эрх зүй”, УБ., 2000 он., 23 дахь тал

¹ <https://www.legalinfo.mn/law/details/346>

хэмжээг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлуулж тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэн ажилладаг байна”¹ Үүний дотроос Баянзүрх дүүргийн хүрээнд жишээ болгон авлаа: Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 2020 оны тайлант хугацаанд эзэмшиж буй газрыг өмчлөх иргэдийн хүсэлтийн дагуу нийслэлийн Засаг даргын

- ✓ 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/25 дугаар захирамжаар 114 иргэний 6.3 га газрыг,
- ✓ 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/395 дугаар захирамжаар 66 иргэний 3.7 га газрыг,
- ✓ 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/731 дүгээр захирамжаар 56 иргэний 3.18 га газрыг,
- ✓ 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/849 дүгээр захирамжаар 75 иргэний 4.28 га газар,
- ✓ 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/1013 дугаар захирамжаар 11 иргэний 0.163 га газрыг,
- ✓ 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/1160 дүгээр захирамжаар 14 иргэний 0,0842га газрыг,
- ✓ 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/1175 дугаар захирамжаар 8 иргэний 0,496га газрыг өмчлүүлсэн ба нийт 378 иргэний 20,97 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн байна.²

Дээрх судалгаа нь Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх эрх зүйн

зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг харж, дүгнэх боломжийг бүрдүүлж, Монгол улсын иргэн газар өмчлөх эрхээ бодитоор нь эдэлж байгааг илэрхийлэх боловч үүний цаана манай улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал давхар хөндөгдөж байгаа учраас газар өмчлөх эрхийн уламжлал сэтгэлгээний чиг хандлагыг судлах, иргэдийнхээ газар өмчлөх эрхийн талаарх сэтгэлгээг түүхэн уламжлалтай нь уялдуулах шаардлагатай байгааг дурдах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл **“Монгол улс бол зуун зууныг зулсан төр ёсны түүхэн уламжлалтай”³** улс бөгөөд түүхийн шаргал хуудаснуудаас харахад бидний өвөг дээдэс газар шороогоо бидний өмч гэж үзэлгүйгээр Монголын “тусгаар тогтнол”, үр ач минь “эд баялаг” хэмээн өөрийн амь бие, нэр төрөөрөө хайрлан хамгаалж, хойч үедээ үлдээсэн түүхтэйг марталгүй газрыг өмчлөх талаар эрх зүйн шинэчлэл хийхдээ түүхэн уламжлалаа эрх зүйн шинэтгэлдээ шингээх, иргэдийн эрх зүйн сэтгэлгээнд дархлаа суулгах хэрэгтэй байна

“Миний Монголын газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг”⁴

¹ <https://land.ub.gov.mn/index.php/about/2021-04-02-07-06-07/districts/2017-02-01-05-56-37>

² <https://land.ub.gov.mn/index.php/about/2021-04-02-07-06-07/districts/2017-02-01-05-56-37>

³ Шихихузууг сэтгүүл., УБ., 2004 он., 3 дахь тал

⁴ <https://forum.asuult.net/viewtopic.php?t=188323&start=26>

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН
УЛСЫН ТУРШЛАГА¹**



Хуульч, Монголын хуульчдын холбооны
гишүүн С.Асланбек

Оршил

Байгалийн баялаг ихтэй орнууд баялагтаа тулгуурлан хөгжлийн өндөр түвшинд хүрдэг бол зарим нь ядуу, буурай хэвээр байдаг. Энэ нь 1/Баялгийн хараал ба 2/Голланд өвчин гэсэн хоёр ойлголттой холбоотой гэж судлаачид үздэг. Их энгийнээр хэлэхэд, эхний ойлголт нь байгалийн баялгийн хэмжээнээс хамаарч иргэний дайн, дотоод зөрчилдөөн, бусад улс орнуудын сөрөг ашиг сонирхол зэрэг асуудлууд нэмэгдэж, хөгжих боломж бага байдаг тухай авч үздэг бол удаах ойлголт нь уул уурхайн салбарын хөгжил нь бусад салбарын хөгжлийг зогсонги байдалд оруулах магадлалтай гэж үздэг. Үүнийг даван туулах арга зам буюу шинэ ойлголт, судлагдахууныг саяны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр анх удаа

оруулж өгсөн гэж болно. 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

*“Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг **Үндэсний баялгийн санд** төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ ... Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх **эрх зүйн үндсийг хуулиар тогтооно**”*

Дээрх зохицуулалт нь төр байгалийн баялаг ашиглах урт хугацааны бодлоготой байна, ингэхдээ иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангаж, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахад иргэдэд өгөөжийг хүртээх зорилго бүхий “Үндэсний баялгийн сан”-тай болох, түүнийг зохицуулсан бие даасан органик хуультай болохоор зохицуулагдсан байна. “Үндэсний баялгийн сан” буюу олон улсад “Sovereign Wealth Fund” гэж хэрэглэгддэг энэ ойлголтыг байгалийн баялгийн нөөц ихтэй 40 гаруй орон

¹ С.Асланбек, Судлаач, “Эрэмжс Монгол” ХХК-ийн Хуулийн мэргэжилтэн

баялгийн сан байгуулан, уул уурхайн орлогыг үр ашигтай ашиглах хэрэгсэл болгон ажиллуулж¹ байна. Олон улс оронд нотлогдсон зүйл болох нь маргаангүй л бол Үндсэн хуулийг ямар нэг хэрэглээний заавар, дэг журамчлага /процедур/ шиг ойлгож гоочилдгоо болих цаг болсон² хэмээн Чимид багшийн хэлсэн нь баялгийн сангийн шинэ зохицуулалтыг Үндсэн хуульд оруулж өгсөнтэй нийцэх болов уу.

Монгол Улсад баялгийн сангийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоход олон улсын сайн туршлага, жишиг зохицуулалтыг өөрийн орны өнөөгийн байдал, тулгамдсан асуудалтай холбож, харьцуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил чухал үүрэг гүйцэтгэх учир, энэхүү судалгааны ажлаар Үндэсний баялгийн сангийн 1/онолын асуудал, ерөнхий ойлголтуудыг судалж, 2/олон улсын чиг хандлагад тулгуурлан, гадаад улсуудын баялгийн сангийн тогтолцоог харьцуулан судалж, жишиг болохуйц туршлагыг илрүүлэх замаар 3/дотоодын эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэсэн 4/дүгнэлт, санал боловсруулахыг зорилго болгов.

1. Онолын асуудал

Энэ хэсэгт “Sovereign Wealth Fund” буюу “Үндэсний баялгийн сан”³-ийн тухай тодорхойлолт, түүхэн чиг

хандлага, ангилал, төрөл, хэлбэрүүд, олон улсын байгууллагууд хэрхэн тодорхойлсон байдал, хөгжлийн чиг хандлага зэргийг хэт ерөнхий байдлаар авч үзэв. Энэ ойлголт өөрөө асар олон судалгааг өөртөө агуулдаг учир ганц энэ судалгааны ажлаар бүхэлд нь дурдагдах боломжгүй.

“Үндэсний баялгийн сан” гэсэн нэр томъёог эрдэмтэн, судлаачид бүрэн хэмжээнд, нэгдсэн байдлаар тодорхойлохыг оролдож ирсэн боловч эрдэмтдийн дунд нэг мөр ойлголт, тодорхойлолт одоогоор байхгүй байна. Жишээлбэл, 1/Үндэсний баялгийн сан нь Засгийн газрын хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд энэ нь эцсийн цор ганц өмчлөгч болох Засгийн газартаа ямар нэгэн хариуцлага хүлээлгэдэггүй, гадаадын хөрөнгө босгох том хөшүүрэг болоод урт хугацааны хөрөнгө оруулалт юм;⁴ 2/Үндэсний баялгийн сан нь Засгийн газрын өмнөөс хөрөнгө удирдах хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хөрөнгө оруулалтын капиталыг ихэвчлэн газрын тосны орлогоос авдаг. Жич: Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөлийн бүсийн сан, ОХУ болон Норвегийн сан гэх мэт;⁵ 3/Үндэсний баялгийн сан нь гадаад валютын нөөц болон байгалийн баялгийн экспортыг нэмэгдүүлэх зорилгоор байгуулсан төрийн өмчийн хөрөнгө оруулалтын сангууд бөгөөд энэ төрлийн сангийн нэг жишээ төрийн

¹ Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн. “Уул уурхайгаас авах эх үүсвэр бүхий тусгай сангийн эрх зүйн зохицуулалт”, 3.

² Б.Чимид. “Үндсэн хуулийн дэвдэр нүгтж ёс”, УБ., 2006. 113.

³ Үндсэн хууль дахь “Үндэсний баялгийн сан” эсхүл “Баялгийн сан” гэх нэр томъёогоор орчуулж хэрэглэв.

⁴ Kotter, J., Leif, U., 2011, Friends or foes? Target selection decisions of sovereign wealth funds and their consequences, *Journal of Financial Economics*, doi:10.1016/j.jfineco.2011.03.007, p.3.

⁵ Dewenter, K. L., Han, X., Malatesta, P. H., 2010, Firm values and sovereign wealth fund investments, *Journal of Financial Economics*, p.1-2.

өмчийн тэтгэврийн сан болно;¹ 4/ Үндэсний баялгийн сангийн үндсэн нөхцөл нь төрийн өмчийн эсхүл төрийн өмчийн оролцоотой сангаас идэвхтэй хөрөнгө оруулалт хийж байгааг ойлгоно² зэргээр тодорхойлсноос үзвэл дараах үндсэн зорилго, шинжтэй болох нь харагддаг. Үүнд³: -Төсөв, эдийн засгийг импорт/экспортын хэт тогтворгүй байдлаас хамгаалж, тогтворжуулах; -Сэргээгдэх бус түүхий эдийн экспортыг төрөлжүүлэх; -Гадаад валютын нөөцөөс илүү их ашиг олох; -Ирээдүй хойч үеийнхээ хадгаламжийг нэмэгдүүлэх; -Нийгэм, эдийн засгийн хөгжлийг санхүүжүүлнэ; -Зорилтот улс орнуудын урт хугацааны хөрөнгийн тогтвортой өсөлт; -Улсын урт хугацааны стратеги, төлөвлөгөөг дэмжих зэрэг байна.

2007 онд Олон улсын валютын сангийн гишүүн 185 орон ажлын групп байгуулж, баялгийн сангийн хөрөнгө оруулагчид болон сангийн хөрөнгө ашиглагч нарт тулгарч буй үндсэн асуудлуудаар судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, уг ажлын хэсэгт баялгийн сан бүхий 26 орны төлөөлөл оролцож, баялгийн сантай холбогдсон "Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, практик" гэсэн эмхэтгэл гаргаж, баялгийн сангийн хөрөнгө оруулалтын зорилгыг тодорхойлон, "Сантьягогийн зарчим"-ыг баталжээ. Сантьягогийн

зарчимд үндэсний баялгийн санг "... засгийн газрын эзэмшилд байдаг, тусгай зорилго бүхий хөрөнгө оруулалтын сан байна. Макро эдийн засгийн зорилгоор төв засгийн газраас байгуулж, үндэсний сан эзэмшиж, удирдаж, санхүүгийн зорилгоо биелүүлэх зорилгоор хөрөнгийг удирдаж, гадаадын санхүүгийн хөрөнгөд хөрөнгө оруулах зэргээр хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлдэг. Үндэсний баялгийн санг ихэнх тохиолдолд төлбөрийн балансын илүүдэл, албан ёсны валютын үйл ажиллагаа /тоглолт/, хувьчлал, санхүүгийн илүүдэл, барааны экспортын орлого зэрэгт үндэслэн байгуулна"⁴ хэмээн тодорхойлсон бол 2007 оны 10 дугаар сард ОУВС үндэсний баялгийн санг албан ёсоор тодорхойлох оролдлого хийсэн бөгөөд "үндэсний баялгийн санг ерөнхийд нь засгийн газраас урт хугацааны зорилгын хүрээнд гадаад хөрөнгийг эзэмших зорилгоор бий болгосон, засгийн газраас эзэмшдэг тусгай хөрөнгө оруулалтын сан гэж тодорхойлж болно"⁵ хэмээн томъёолжээ. Дээрх тодорхойлолтуудаас үзвэл, товчхондоо, байгалийн баялаг болоод бусад зүйлээс олж буй орлогоо хуримтлуулж, ямарваа хэлбэрээр үр хойчдоо үлдээх зорилго бүхий төрийн өмчийн санг Үндэсний баялгийн сан гэж тодорхойлж байна.

¹ Zhang, M., He, F., 2009, China's sovereign wealth fund: weakness and challenges. *China and World Economy*, p.2.

² Helleiner, E., Lundblad, 2008, The geopolitics of sovereign wealth funds: An introduction, *Geopolitics*, p1.

³ Баялгийн сангийн чиглэлээр судалгаа хийдэг бие даасан, хараат бус байгууллага болох "Sovereign Wealth Fund Institute"-ээс хийсэн сүүлийн судалгаа, <https://www.swfinstitute.org/research/sovereign-wealth-fund> 2019 оны 12-р сарын 10-ний өдөр хандав.

⁴ International working group of Sovereign Wealth Funds, "Sovereign Wealth Funds: Generally accepted principles and Practices, Santiago Principles", October 2008, p27. https://www.ifswf.org/sites/default/files/santiagoprinciples_0_0.pdf. 2019 оны 12-р сарын 15-ний өндөр ханцлав.

⁵ International Monetary Fund, "Global Financial Stability Report: Financial Market Turbulence: Causes, Consequences and Policies" (Washington DC: International Monetary Fund, 2007).

Үндэсний баялгийн сангийн тухай ойлголт зуун жилийн түүхтэй гэж үздэг бөгөөд 2000 онд хэд хэдэн баялгийн сангуудын үсрэнгүй хөгжил бий болсон гэдэг. Хамгийн анхны баялгийн санг 19 дүгээр зууны дунд үед Америк улс /АНУ биш/ төрийн нийтийн зориулалттай үйлчилгээнд зориулж байгуулж байсан¹ бол түүхэн дэх анхны том баялгийн сангаар Кирибати улсын орлогыг тэнцүүлэх нөөц сан бүртгэгдсэн байна. Тус сан нь 1956 онд байгуулагдаж байсан ба 2007 оны байдлаар 520 сая ам.долларын хөрөнгөтэй² байна. 2008 оны эхэн үеэс 2012 оны эцэс хүртэл баялгийн сангийн хөрөнгө 59.1% -иар өссөн бол 2005 оноос 2012 он хүртэл 32 гаруй улсын баялгийн сангууд³ байгуулагдсан байна.

Онолын хувьд баялгийн сантай холбоотой эрдэмтэн судлаачдын 10 гаруй онол, үзэл баримтлал байдаг. Тодруулбал 1/International trade theory буюу Олон улсын худалдааны онол, 2/Financial management theory буюу Санхүүгийн удирдлагын онол, 3/Economics theory буюу Эдийн засгийн онол, 4/Agency theory буюу Агентлагийн онол, 5/Stewardship theory буюу хөрөнгийн хариуцлагын онол, 6/Stakeholders management theory буюу хувьцаа эзэмшигчдийн менежментийн онол, 8/Isomorphism view буюу

изоморфизм, 9/Resource based view (RBV) and resource dependency view буюу баялагт суурилсан үзэл (БСҮ) болон баялгаас хамаарсан үзэл гэх мэт.

Эдгээр онолын ихэнх нь салбарын хувьд эдийн засаг, менежмент болон засаглалын чиглэл учир хууль зүйн салбарын судлаач хүнд зарим онолыг ойлгоход хүндрэлтэй байсныг тэмдэглэхийн сацуу баялгийн сан үүсэх болсон гол онолын зарим үндэслэлийг дурдвал, БСҮ нь боломжит баялаг нь өрсөлдөгчдийг ялах стратегийн байр суурийг бий болгоно гэж үздэг бөгөөд гол зарчим нь "аливаа этгээд боломжтой байгаа нөөцийг ашиглан өрсөлдөөний давуу талыг бий болгож, тогтвортой байлгаж чадна"⁴ гэдэгт суурилдаг, нөөцүүд нь байгалиасаа ялгаатай, хөдөлгөөнт биш бол богино хугацааны давуу талыг компанийн урт хугацааны өрсөлдөх давуу тал болгон хувиргаж чадна⁵ гэж үздэг нь байгалийн баялгийг сан бий болгох замаар зохистой ашигласнаар давуу байдал бий болгож, тогтвортой эдийн засгийг авчирна гэх санааг илэрхийлсэн байна. Харин хувьцаа эзэмшигчдийн менежментийн онолоор аливаа байгууллагын гол үүрэг нь ханган нийлүүлэгч болон ажилчдад таатай нөхцөл бүхий процессын дагуу хувьцаа эзэмшигчдэд үнэ цэнийг бий болгох ёстой⁶ гэж үздэг нь баялгийн сангийн засаглал, түүний зорилгыг харуулахад

¹ M. Nicolas J. Firzli and Joshua Franzel: 'Non-Federal Sovereign Wealth Funds in the United States and Canada', *Revue Analyse Financière*, Q3 2014

² "The world's most expensive club". *The Economist*. 24 May 2007.

³ Баялгийн сангийн чиглэлээр судалгаа хийдэг бие даасан, хараат бус байгууллага болох "Sovereign Wealth Fund Institute"-ээс хийсэн сүүлийн судалгаа. <https://www.swfinsitute.org/research/sovereign-wealth-fund> 2019 оны 12-р сарын 10-ний өдөр хандав.

⁴ Wernerfelt, B., 1984, A resource based view of the firm, *Strategic Management Journal*, p.5.

⁵ Peteraf, M. A., 1993, The cornerstones of competitive advantage: A resource-based view, *Strategic Management Journal*, p.14.

⁶ Freeman, R. E., 1984, *Strategic Management: A stakeholder approach*. Boston: Pitman publications

чиглэсэн байна. Олон улсын худалдааны онол үзэхдээ, улсууд хоорондоо бараа, ажил, үйлчилгээ солилцох замаар хөрөнгийг бий болгодог, энэ нь дотоодын нийт бүтэгдэхүүн /ДНБ/-ээр илэрхийлэгддэг байна. Олон улсын худалдаа байхгүй бол хязгаарлагдмал нөөц дотор хөрөнгө бий болгохгүй. Хөрөнгөгүй бол улс болгон хомсдолд орох эрсдэлтэй учраас энэ бүгдийг зохицуулах, удирдах зорилгоор газар нутаг, бусад сонирхлоосоо хамаарч улсууд бүс нутгийн эсхүл өөр байдлаар нэгдэж зөвлөл, холбооны дор сан бий болгож хөрөнгө хадгалж эрсдэлээс сэргийлдэг¹ байна.

Дээрх тодорхойлолт, онолоос үзвэл сангуудын орлого, зарлагаас хамаарч зорилго, төрлөөрөө сангууд ялгаатай байна. Үндэсний баялгийн сангуудыг хамгийн ерөнхий байдлаар 1/бүтээгдэхүүнээс эх үүсвэр бүхий баялгийн сан ба 2/бүтээгдэхүүний бус эх үүсвэр бүхий баялгийн сан² гэж хоёр ангилдаг. 1/Бүтээгдэхүүнээс эх үүсвэр бүхий сан гэдэг нь тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын орлогоос эх үүсвэр бүхий сангууд байдаг бол 2/бүтээгдэхүүний бус эх үүсвэр бүхий сан нь цэвэр валютын нөөцөө ашиглах зорилгоор бий болгосон, валютын илүүдэл нөөцийг эргэлтэд оруулж арвижуулах зорилго бүхий сангууд болон татвар, хувьчлалын

орлогоос бий болгосон, засгийн газрын санхүүгийн орлогоос эх үүсвэр бүхий сангууд байдаг.

Байгалийн баялаг буюу уул уурхайгаас олох орлого бүхий сан нь бүтээгдэхүүнээс эх үүсвэр бүхий сан бөгөөд уул уурхайн орлогоос эх үүсвэр бүхий сангуудын үндсэн онцлог нь байгалийн хязгаарлагдмал, дахин үл сэргээгдэх, шавхагдах баялгийг ирээдүй үетэйгээ хуваалцах зорилго, утга санаа, анхдагч үндсийг илэрхийлж байна. Эндээс үүдэн сангуудын зорилго, төрөл болон түүний ажиллах журам зэрэг нь өөр өөр болохыг харж болно. Энэ асуудлаар хийгдсэн судалгаагаар баялгийн сангуудыг дараах төрөлтэй гэж үзсэн байна.³ Үүнд:

¹ Park, D., Estrada, G. E., 2011. Developing Asia's sovereign wealth funds: The Santiago principles and the case for self regulation, *Asian Journal of International Law*, 12, doi:10.1017/S2044251310000445

² Steffen Kern, "How to Spend it: Commodity and Non-Commodity Sovereign Wealth Funds", Deutsche Bank Research, Working Papers Series, Research 28, 18 July 2008. <http://www.oecd.org/dataoecd/62/33/41212577.pdf>

³ Abdullah Al-Hassan, Michael Papaioannou, Martin Skancke, and Cheng Chih Sung, 'Sovereign Wealth Funds: Aspects of Governance Structures and Investment Management', IMF, 2013.

Хүснэгт 1¹

Сангийн төрөл	Зорилго
Тогтворжуулалтын сан (Stabilization fund)	Эдийн засгийн хямрал болон түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн гарах эрсдлээс хамгаалан улсын төсвийн орлогын тогтворжилтыг хангах
Хадгаламжийн сан (Savings fund)	Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ирээдүй хойч үедээ тэгш хуваарилахын тулд улсын орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх
Хөгжлийн сан (Development fund)	Нийгмийн хөгжлийг хангах тэр дундаа улс орны дэд бүтцийг хөгжүүлэх
Тэтгэврийн сан (Pension reserve fund)	Өсөн нэмэгдэж буй тэтгэврийн зардлыг ирээдүйд тогтвортой хангах
Хөрөнгө оруулалтын сан (Reserve investment fund)	Гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд уг нөөцөөр урт хугацаагаар хөрөнгө оруулалт хийх

Дээрхээс дүгнэвэл, Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ... одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж ... байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан нь орлогын хувьд “бүтэгдэхүүнээс эх үүсвэр бүхий сан”-д багтаж байгаа бөгөөд энэ төрлийн орлого бүхий сангийн төрөл, зорилго нь “хадгаламжийн сан”-д багтахар байна.

2. Олон улсын чиг хандлага

Энэ хэсэгт баялгийн сангуудын 2.1/Төрөл, 2.2/Дэлхийд хамгийн их хөрөнгөтэй сан болон түүний онцлогийг авч үзэх бөгөөд түүнчлэн 2.3/Олон улсын практик болсон “Сантьягогийн зарчим”-ыг авч үзэх болно.

2.1. Хавсралт нэгт заасан, судалгаанд хамрагдсан 36 баялгийн сангийн төрлөөр нь харьцуулж үзэхэд дийлэнх олонх буюу 26 улс

“Хадгаламжийн сан” төрөлтэй бол удаа дараах нь “Тогтворжуулалтын сан” байна.² Үүнээс үзвэл, Дэлхийн хандлага баялгийн санг “Хадгаламжийн сан” төрлөөр байгуулдаг буюу нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаас олсон ашгийг ирээдүй хойч үедээ тэгш хуваарилахын тулд улсын орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэн хадгалдаг байна.

2.2. Хараат бус судалгааны байгууллага болох “Sovereign Wealth Fund Institute”-ээс хийсэн судалгааг үзэхэд дэлхийд сангийн нийт хөрөнгөөрөө “Norway Government Pension Fund Global” буюу Норвеги улсын Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан тэргүүлж байна. Урт хугацааны бодлогод суурилан байгалийн нөөцөө зөв удирдахын тулд Норвегийн баялгийн санг 1990 онд байгуулжээ. Норвеги улсын парламент Засгийн Газрын Тэтгэврийн Сангийн Тухай хуулийг баталж тус хуулиар энэ санг Сангийн сайд нь хариуцах ба Сангийн яам нь шаардлагатай бүхий л шийдвэр гаргах бүрэн эрх мэдэлтэй болжээ. Сангийн яам нь Тэтгэврийн санг удирдах эрх мэдлийнхээ хүрээнд

¹ Хүснэгтнийг <http://www.juraguide.com/article/bay-algim-san-2sh5sh-oid> -оос, 2019 оны 12-р сарын 11-ний өдөр хандан.

² Abdullah Al-Hassan, Michael Papaioannou, Martin Skancke, and Cheng Chih Sung, *мон эх сурвалж, Хавсралт 1-ээс харна уу.*

баялгийн сангийн хөрөнгийг удирдах, Сангийн яамнаас хараат бусаар хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах эрхийг Норжес банкинд (Norges Bank)¹ олгожээ. Тус хуулиар мөн адил үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байх, улирлын болон жилийн тайланг тогтмол гаргахыг заахаас гадна сангийн яамтай яаж харилцахыг тодорхой оруулжээ.

Хүснэгт 2²



Дээрх зурагт харуулсанчлан, Норвегийн баялгийн сан хяналтын механизмаараа жишиг болохуйц сан гэж үздэг байна. Тус сангийн зарим нэг онцлогийг дурдвал, хөрөнгө оруулалтын ёс зүйн удирдамжтай бөгөөд тус удирдамжаар хүний эрх, хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн, хүрээлэн буй орчинд аюултай үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад хөрөнгө оруулалт хийхийг хориглодог байна. Дээр нь, энэ сан нь төрийн эзэмшилд байдаг учир олон улсын мэргэжлийн зөвлөх ажиллуулахын

сацуу аливаа харилцаанд давуу эрх эдлэх, хөрөнгө оруулалтын шийдвэрт нь улс төрийн зорилго агуулагдаж болзошгүй зэрэгт асуудал, шүүмжлэл гардаг тул хөрөнгө оруулалт хүлээн авагч орны зүгээс баялгийн санг хувийн компанитай ижилд тооцож хөрөнгө оруулалтыг нь хүлээн авах шийдвэрийг гаргуулахын тулд зарим төрлийн ёс зүйн хязгаарлалтуудыг хөрөнгө оруулалтын зарчимдаа тусгадаг³ байна.

Улс бүрийн онцлог, сангийн зорилгоос хамааран сангийн удирдлага олон янз байгаа ч нэгтгэн авч үзвэл дараах удирдлагын тогтолцоонууд зонхилж байна. Үүнд: 1/Ерөнхийлөгч сангийн үндсэн зарчмын асуудлаар шийдвэр гаргах, ТУЗ байгуулах /Казакстан/; 2/ Сангийн яам санг эзэмшиж удирдлагаар хангах /Норвеги, Орос, Чили/; 3/ Сангийн яам үндсэн асуудлуудыг хариуцаж, шийдвэр гаргах ба төв банканд зарим асуудлууд, ихэвчлэн хөрөнгө оруулалтын менежментийн асуудлыг хариуцуулах /Норвеги, Орос, Чили/; 4/Төв банк сангийн яамтай гэрээ байгуулан санг удирдах, сангаас зохих шимтгэл авах /Чили/; 5/Сангийн удирдах зөвлөл бүх асуудлыг бие даан шийдвэрлэх /Кувейт/.

2.3. Онолын хэсэгт дурдсанчлан, 2007 онд 185 орноос бүрдсэн ажлын хэсэг баялгийн сантай холбогдсон “Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, практик” гэсэн эмхэтгэл гаргаж, баялгийн сангийн хөрөнгө оруулалтын зорилгыг тодорхойлон, “Сантьягогийн зарчим”-ыг баталжээ.

¹ Д.Жаргалсайхан, “Баялгийн сан 2050 онд”, <http://www.jarгалdefacto.com/article/bayalgin-san-2sh5sh-ond> 2019 оны 12-р сарын 11-нд хандав.

² Хүснэгтийг Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн мөн бүтээгээс авав. 2019 оны 12-р сарын 11-нд хандав.

³ Хууль зүйн Үндэсний хүрээлэн, мөн бүтээл, 30.

⁴ Хууль зүйн Үндэсний хүрээлэн, мөн бүтээл, 66.

Сантьягогийн зарчим нь нийт 24 зарчим, практикаас бүрддэг бөгөөд 3 үндсэн хэсэгт хуваагддаг. Нэгдүгээр хэсэгт 24 зарчмыг тоочсон байдаг бол хоёрдугаар хэсэг нь зарчим тус бүрийн товч тайлбар, гуравдугаар хэсэг нь үндэсний баялгийн сангийн тодорхойлолт ба гишүүн орнуудын жагсаалт зэргийг багтаасан байдаг. Баримт бичигт эрх зүйн хүрээ, зорилт, макро эдийн засагтай уялдах байдал, институцийн хүрээ ба удирдлагын бүтэц, хөрөнгө оруулалт болон эрсдэлийн менежмент гэсэн 3 үндсэн бүлэг асуудлыг тусгасан ба удирдлагын бүтцийн нэгдсэн загварыг санал болгоогүй боловч түүний тогтвортой байдал, үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлох тухай, институцийн хүрээнд сангийн үйл ажиллагаанд үндэсний болон олон улсын стандартын дагуу аудит хийх, мэргэжлийн болон ёс зүйн стандарт тогтоох тухай, хөрөнгө оруулалт ба эрсдэлийн менежментийн хүрээнд сангийн санхүүгийн тогтвортой байдал, улс төрийн хараат бус байдлын тухай чухал асуудлуудыг зарчмын чанартайгаар тусгасан. Тухайлбал “Үндэсний баялгийн сангийн бодлогын зорилгыг нарийн тодорхойлж, олон нийтэд ил тод зарлана”¹, “Удирдлагын хүрээ нь тогтвортой байх ба үүрэг, хариуцлагын талаар тодорхой, үр дүнтэй заалтуудыг бий болгоно”² гэх зэрэг ил тод нээлттэй байх, хариуцлагатай байх талаар тусгасан заалтууд орсон байдаг.

Сантьягогийн зарчмыг бүхэлд нь үзэхэд³, баялгийн санд дараах нэгдсэн

зарчмын шаардлагуудыг тавьсан байна. Үүнд:

- Нээлттэй, ил тод байх шаардлага: 1/Сангийн бүтэц, эрх зүйн үндэс, бодлого, зорилго, гүйлгээ, зарлага, үйл ажиллагааны ерөнхий арга нээлттэй байна. 2/Засгийн газраас ямар хэмжээнд хараат байгаа байдал, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын бодолго, шийдвэр нь ил тод байна.
- Сангийн тайлагнал буюу хариуцлага хүлээлгэх шаардлага: хэнд, хэрхэн, яаж тайлагнаж, хэн, хэрхэн, яаж хариуцлага хүлээх эсэх асуудал
- Сангийн эдийн засгийн ашиг сонирхол: Сангийн шийдвэр хөрөнгө оруулалтын бодлогын дагуу эдийн засаг, санхүүгийн үндсэн дээр суурилсан, эрсдэлийг тооцож, олох ашгийг боломжит дээд хэмжээнд хүргэх зорилгоор хийгдсэн байх ёстой

Дээрхээс дүгнэвэл, Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Үндэсний баялгийн санг ... хуулиар зохицуулна” гэж заасны дагуу бие даасан хууль гарахаар бол Сантьягогийн зарчимд суурилсан бөгөөд Норвеги, Хятадын хөрөнгө оруулалтын сан гэх мэт олон улсын томоохон сангуудын сайн жишгийг дагах ёстой байна.

3. Дотоодын эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудал

Баялгийн санг бусад улс орнуудад 1/Үндсэн хууль, түүнийг дагасан бие даасан хууль⁴, 2/Төсвийн тухай хууль,

⁴ Жич: Австралийн Ирээдүй сан, Кувейтийн хөрөнгө оруулалтын сан, Солонгосын хөрөнгө оруулалтын

¹ Сантьягогийн зарчим 2

² Сантьягогийн зарчим 6

³ <https://www.ifswf.org/santiago-principles-landing/santiago-principles> энэ линкнээ үзэж болно. 2019 оны 12-р сарын 15-ний өдөр хандан.

3/Компанийн хууль, 4/Бусад хууль, журмаар¹ үүсгэн байгуулдаг байна. Юуны түрүүнд, Монгол Улсад байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа сангуудыг эх үүсвэрийн хувьд², 1/тусгай хуулиар зохицуулах сан, 2/100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан, 3/зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан, 4/өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар буюу эх үүсвэр нь буцалтгүй тусламж, хандиваар зонхилох хэсгийг нь бүрдүүлдэг сан хэмээн ангилдгийн дурдъя. Эдгээр сангууд эрх зүйн байдлын хувьд Засгийн газрын тусгай сангийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулагдаж байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зохицуулалт нь дээр онолын болон олон улсын чиг хандлагын хэсэгт дүгнэсэнчлэн “бүтээгдэхүүнээс эх үүсвэр бүхий буюу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэх эх үүсвэрээс баялгийн санг үүсгэн байгуулах шинжийг агуулсан учир зөвхөн түүнд хамаарах дотоодын хууль тогтоомжийг судлах болно. Өнөөдөр Монгол улсад үйлчилж буй 700 гаруй хуулиас дээрх шинжийг агуулсан ганц хууль байгаа нь “Ирээдүй өв сангийн тухай хууль” /

корпорац, Азербайжаны Үндэсний газрын тосны сан зэрэг нь Үндсэн хуульд ерөнхий заалт оруулж, бие даасан хуультай болно гэж манайхтай адилхан байдлаар зохицуулсан.

¹ <https://www.swfinstitute.org/research/sovereign-wealth-fund> 2019 оны 12-р сарын 16-ний өдөр хандав.

² Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Цаашид “ИӨСТХ” гэх/ байна.

ИӨСТХ-ийг УИХ-аас 2016 онд баталсан бөгөөд нийт 7 бүлэг, 33 зүйлтэй нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, Сангийн өгөөжийг хуваарилах, Сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах³ зорилго бүхий хууль байгаа нь Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эх үүсвэрийн Үндэсний баялгийн сан” гэдэгт нийцэхээр харагдаж байна. Ингэхдээ, дараах хоёр асуудал үүснэ, 3.1/Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан үндсэн зарчмын асуудлууд тус хуульд тусгагдсан уу?, 3.2/Хэрвээ тусгагдаагүй бол Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан шаардлагыг уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хангах уу? эсхүл уг хуулийг хүчингүй болгож шинэ хууль батлах замаар хангах уу? гэх.

3.1. Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэг дахь зохицуулалтыг үгчилсэн аргаар тайлбарлавал, Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлоготой байна. Энэ бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлого бөгөөд, тус бодлогод:

- “одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах” гэх

³ Ирээдүй өв сангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

хэсэг нь онолын хэсэгт дурдсан "Хөгжлийн сан"-ийн зорилгод нийцэж байна.

"газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж" гэх хэсэг нь онолын хэсэгт дурдсан "Хадгаламжийн сан"-ийн зорилгод нийцэж байна.

"тэгш, шударга хүртээхэд чиглэнэ" гэх хэсэг нь баялгийн сангийн олон улсын практикт дурдагдсан зарчмыг агуулсан байхыг шаардсан байна.

Тус зохицуулалтын гурав дахь мөр эхний хэсгийн үндсэн зорилгыг хоёр байдлаар хуульчилсан нь харагддаг. Байгалийн баялаг түүн дотор "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа:

- байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн
- түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх" гэх хэсэг нь байгалийн баялаг дотор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг¹ ашиглахад 1/Ард түмэнд үр өгөөжийн дийлэнх нь ногдож, 2/ ард түмний мэдэлд байх тусгай хоёр шаардлагыг тавьсан байна. "Үр өгөөж", "Дийлэнх", "Мэдэлд байх", "Ард түмэн" зэргийг тухайн үед энэ заалтыг хэлэлцэгдэж байсан протоколыг үндэслэл болгож

¹ Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.12 дахь хэсэг "стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ.

тайлбарлах учиртай. Тодруулбал, Доктор О.Мөнхсайхан "Үр өгөөж гэдэгт ордыг ашигласнаас төрд төлж байгаа татвар, ашигт малтмалын хураамжаас гадна монгол ажилчдын тоо, Монголын компани, хувь хүмүүсээс авч байгаа бараа үйлчилгээ, нийгэм, эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр зэргийг томоор нь тооцох үзэл баримтлал явж байгаа. Үндсэн хуулийн 5.2, 5.4, 16.4 зэрэгт "нийтийн болон хувийн өмч," "өмчлөгчийн эрх," "аж ахуйн бүх хэвшил," "хувийн аж ахуй эрхлэх эрх" зэрэг зарчмыг хүлээн зөвшөөрч хамгаалсан. Тиймээс, эдгээр зарчимд нийцүүлэн "үр өгөөжийн дийлэнх, "ард түмэн" гэж юу вэ гэдгийг УИХ хуулиар тогтоох ёстой. Аль нь илүү үндэслэлтэй тайлбар вэ гэдгийг ярилцах шаардлага үүснэ. Ямар ч байсан энэ заалтад ашгийн 51 хувиас дээшхийг төр авна эсхүл иргэдэд шууд тараана гэсэн утга байхгүй гэдэг санааг УИХ-ын хуралдааны протоколуудад тодорхой тусгасан"² гэж тайлбарлаж, энэ утгаар баталсан гэж үзвэл эдийн засгийн болон бусад сөрөг үр дагаваргүй байдлаар мөн зохицуулалтын сүүлийн өгүүлбэрт дурдагдсанаар эрх зүйн үндсийг "Үндэсний баялгийн сан"-ийн тухай хуулиар нарийн зохицуулахаар байна.

² О.Мөнхсайхан, "УИХ-ын сонгуультай ард нийтийн санал асуулгыг хамт явуулбал Үндсэн хуулийн оорчлолт унах магадлалтай", <https://ikon.mn/opinion/lobi>

3.2. Дээр дурдсан зарчмууд ИӨСтХ-д тусгасан эсэхийг нягталж үзэхэд дараах асуудлууд харагдаж байна. Үүнд:

ИӨСтХ-ийн гуравдугаар бүлэгт 1/ Сангийн хөрөнгийн удирдлагын мандат батлах, Хяналтын зөвлөл, удирдах зөвлөлийг томилох, гэрээ байгуулах, хянах нэр дэвшүүлэх хороо, гүйцэтгэх удирдлагыг сонгох зэрэг бүхий л эрх мэдлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосон нь, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 2/сангийн корпорацыг Засгийн газар дангаар татан буулгах эрхийг олгосон нь, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт 3/сангийн хөрөнгийн хэмжээ тухайн төсвийн жилийн эхний хэмжээнээс 50 болон түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд сайдад мэдэгдэл хүргүүлэхээр тус тус хуульчилсан нь Улсын их хурал болон Засгийн газрын хяналтыг үгүй болгосон буюу Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан “Ард түмний мэдэлд” байх зарчим хангагдаагүй харагддаг.

ИӨСтХ-ийн 9 дүгээр зүйлийн 5 болон 6 дахь хэсэгт¹ заасны дагуу санд төвлөрсөн хөрөнгийг захиран зарцуулах бололцоог 2030 он хүртэл хаасан нь баялгийн сангийн үндсэн зорилго болон Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан “Ард түмэн дийлэнх үр өгөөжийг хүртэх” гэсэнтэй нийцэхгүй байна.

ИӨСтХ-ийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу 2030 оноос

¹ ИӨСтХ-ийн 9.5 дахь хэсэг: “Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл энэ хуулийн 9.1-д зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно”, 9.6 дахь хэсэг “2030 оноос эхлэн Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлнэ”

эхлэн сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлэхээр заасан нь баялгийн сангийн үндсэн зорилгод нийцэхгүй буюу сангийн хөрөнгийг зориулалтын бус ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн харагдаж байна.

ИӨСтХ-д уул уурхайн орлого гэнэт зогссоноос үүсэх үр дагаврыг хэрхэх талаар зохицуулаагүй байна. Онолоор бол² төсвийн тогтворжуулалтын сан нь тодорхой хэмжээнд хүрч томорсон тохиолдолд уг асуудлыг шийдэх зориулалттайгаар байгуулагдсан.

Олон улсын чиг хандлага хэсэгт дурдсанчлан, “нээлттэй, ил тод байх” зарчим баялгийн санд маш чухал болно. Энэ асуудлыг ИӨСтХ-д тусгаж өгсөн ч эзэмшиж буй тодорхой активуудын жагсаалт, уул уурхайн орлогын төсөөлөл, удирдах хорооны гишүүдийн нэрс, сангийн материаллаг шилжүүлгүүдийн мэдээлэл нээлттэй ил байхаар хуульчлаагүй бөгөөд эдгээрийг нээлттэй болгох ёстой, мэдээллийг нийтэд түгээхдээ чөлөөтэй ашиглаж болох хэлбэрээр вэб хуудсанд байршуулах хэрэгтэй.

Баялгийн сангийн үйл ажиллагаанд гол төлөв гурван төрлийн хязгаарлалт тавьж өгдөг. Эдгээр нь орлого хуримтлуулах дүрэм (санд орох орлогын төрөл, хугацаа), зарлага хийх дүрэм (төсөвт хийх шилжүүлгийн давтамж, хэмжээ, шаардагдах зөвшөөрөл) болон хөрөнгө оруулалтын дүрэм (сангийн

² Natural Resource Governance Institute, ‘Discussion of Mongolia’s Draft Future Heritage Fund Law’, 29 June 2015. <https://resourcegovernance.org/analysis-tools/publications/discussion-mongolias-draft-future-heritage-fund-law-0> 2019 оны 12-р сарын 15-ний өдөр хандав.

хөрөнгө оруулалт хийж болох актив) юм. Түүнчлэн удирдлагын тодорхой бүтэц, ил тод байдлын нарийн шаардлага, хөндлөнгийн хүчтэй хяналттай¹ байдаг. Эдгээр асуудлууд, бусад онолын болон олон улсын чиг хандлага хэсэгт дурдсан асуудлууд болон Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан зарчмын шаардлагууд ИӨСтХ-д тусгагдаагүй байна.

4. Дүгнэлт, санал

Энэхүү судалгааны ажлаар Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Үндэсний баялгийн сан"-ийн онолын асуудлуудыг хөндөж, түүний олон улсын чиг хандлагыг тодорхойлж, одоогийн хүчин төгөлдөр "Ирээдүй өв сангийн тухай" хуульд анализ хийв. Тус хуульд дээр дурдсан зарчмын болон бусад шаардлагууд тусгагдаагүй болохыг судалгааны хэсэг бүрд дүгнэсэн болно.

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг тусгайлан зохицуулах хууль батлах нь зүйтэй бөгөөд тус хуульд сангийн зориулалт, зарцуулалт, орлогын эх үүсвэр, удирдлага, хяналт зэргийг нарийвчлан тусгах шаардлагатай юм. Тусгайлсан хууль батлах, баялгийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, сангийн бүтцийг шинэчлэн зохион байгуулахдаа Сантьягогийн зарчимд тусгагдсан үндсэн асуудлууд, зарчмуудыг тусгах нь чухал ач холбогдолтой. Тухайлбал сангийн хөрөнгө оруулалтын

үйл ажиллагаа, шийдвэр гаргалтын талаарх ил тод, нээлттэй байдал, хариуцлага хүлээлгэх зарчим, эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл зэргийг тодорхой тусгах нь үр нөлөөтэй байх болно.

¹ Natural Resource Governance Institute, 'Natural Resource Funds: Managing the public trust: How to make natural resource funds work for citizens', 2014.

https://resourcegovernance.org/sites/default/files/NRF_Complete_Report_EN.pdf

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА, ТҮҮНД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Г.Халиунаа



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан
Б.Ариунжаргал

Түлхүүр үг: Эрүүгийн хууль, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, эрх зүйн хийдэл

Товч агуулга: Энэхүү өгүүллээр “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-г Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хэрхэн тусгасан, уг зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад учирч буй хүндрэлтэй асуудлыг тодорхойлох, хуулийн зохицуулалт хүний эрхэд хэрхэн нөлөөлж буйг судлан, хуулийг цаашид боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорив.

Оршил

Эрүүгийн хууль хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой хууль юм. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь хүний

эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэн хуулийн дагуу хариуцлага хүлээж буй этгээдийн эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг. Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладаг Эрүүгийн хууль нь эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал энэ нь эргээд нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож, хүний эрхийг хязгаарлах гол хэрэглүүр болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй юм.

Хууль шударга ёсыг тогтоох хэрэгсэл гэтэл эсрэгээрээ шударга бус зүйлийг бий болгох эх уурхай болж болохгүй гэдгийг санах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад

нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж¹ улмаар Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Уг хуульд эрх зүйн шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэн, хуучин хуулийн эрх зүйн хийдлийг арилгахад чиглэгдсэн олон зүйл, заалтууд шинээр тусгагдсан хэдий ч зарим нь хүний эрхийг зөрчин, хэрхэн хэрэглэх нь эргэлзээтэй байдлыг бий болгоод байсан юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох” зохицуулалт нь практикт ажиллаж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч болон судлаачдын дунд ихээхэн маргаан дагуулаад байсан.

Иймд тус эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. Гэвч энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг бүрэн арилгаж чадаагүй гэж үзэж болохоор байгаа юм. Иймд энэхүү өгүүллийнхээ хүрээнд дээрх зохицуулалтыг судлаж, өмнөх зохицуулалттай харьцуулан үзэхийг зорьсон болно.

Үндсэн хэсэг

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/ нь хамааруулан тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн

хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон ялын дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээдгүй ахиц дэвшлийг авчирсан нь сайшаалтай хэдий ч зарим гэмт хэргүүд дээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагджээ.

Шинэ батлагдсан Эрүүгийн хуульд 209 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсанаас 83²-н гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй, ойлгомжгүй байдлыг үүсгээд байсан. Учир нь Эрүүгийн хуулийн **1.10 дугаар зүйлд “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-г хуульчлахдаа “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй”**:

1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж хуульчилсан байсан нь эрх зүйн хийдлийг бий болгоод байсан юм.

¹ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

² Дэлгэрэнгүй хүснэгт 1 болон 2-оос үзнэ үү.

³ Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

Эрүүгийн хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял бусад нь үндсэн ял.¹ Гэтэл хууль тогтоогч хорих болон зорчих эрхийг хязгаарлах гэсэн 2 төрлийн ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчлан өгчээ. Өөрөөр хэлбэл, энэ хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан торгох ялтай гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолохыг зохицуулаагүй байсан юм.

Энэ мэтчилэн эргэлзээтэй, хийдэлтэй зохицуулалтын улмаас хүний эрхийг зөрчих нь хуулийн зорилго, ач холбогдлыг алдагдуулж байсан юм. Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан эрх зүйн хийдлийг арилгах, засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн томоохон алхам болсон гэж үзэж болох ч зарим хийдэлтэй зохицуулалт байсаар байна. Өөрөөр хэлбэл, тус зохицуулалттай холбоотой эрх зүйн хийдлийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр бүрэн арилгаж чадаагүй, харин эрх зүйн хийдлийг арилгах эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.²

Иймд энэхүү өгүүллийнхээ хүрээнд 2015 оны Эрүүгийн хууль болон 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийг харьцуулан дараах асуудлыг сэдвийн хүрээнд дэвшүүлэн тавьж байна.

Асуудал 1.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан /хүснэгт 1-д дурдсан/ хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргүүдийн хувьд ялын хэмжээгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэсэн асуудал бий болж байсан.

Учир нь 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээ нь 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар хуульчилсан боловч дээрх гэмт хэргүүдийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сараас эхэлж байсан нь тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалт нь хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ болох 1 жилд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын доод хэмжээ нь 1 жил хүрэхгүй байгаа учраас энэхүү заалтаар хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байсан.

Мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 жил байхаар тогтоосон. Гэтэл зарим гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сараас эхэлж байгаа ч ялын дээд хэмжээ нь 5 хүртэл жил байгаа нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 эсхүл 5 жилийн аль хугацаагаар тоолох нь эргэлзээтэй байдлыг бий болгож байлаа.

Энэхүү асуудал нь Эрүүгийн хуульд эрх зүйн хийдлийг бий болгож, зайлшгүй засаж сайжруулах

¹ Шингэлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

² Дэлгэрэнгүйг хавсралт хэсгээс үзнэ үү.

шаардлагатай зохицуулалтын нэгд зүй ёсоор тооцогдох болсон. Тиймээс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. /Дэлгэрэнгүйг "Хүснэгт 1"-ийн тайлбар хэсгээс үзнэ үү

Хүснэгт 1.

2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт			
Д/д	Зүйл, заалт	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
1	10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
2	11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
3	11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
4	11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	3 жил
5	11.7 дугаар зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	2 жил
6	12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
7	12.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
8	13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
9	14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
10	15.1 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
11	17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
12	17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
13	17.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
14	17.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
15	18.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
16	18.4 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
17	18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
18	18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
19	18.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
20	18.16 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
21	19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
22	19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
23	19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил

Тайлбар
2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д "...энэ хуулийн тусгай ангийг хорих ялын доод хэмжээг дурган сараас дэвш, дээд хэмжээг дурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эхэл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг дурган сараас дэвш, дээд хэмжээг дурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэдэг хэрэг үйлдснээс хойш дурван жил өнгөрсөн" нь зөв тооцогдох ялгагдлагаар татаж болохгүй гэж нэмж хуулиндсан байна.

Ийнхүү тус заалт Эрүүгийн хуульд нэмэгдсэнээр 1 эхэл 5 жилийн алианаар нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь эргэлтээтэй байдал үүсгэх байсан 53 зохицуулалтаас 50 зохицуулалт нь 3 жилийн хугацаагаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжийг бүрэлдсэн юм.

Энэхүү эрх зүйн хийдэл бүхий 53 хэргээс онцгой 1 хэргийг тусгайлан тайлбарлав:

2015 оны Эрүүгийн хуульд заасан хорих ялгүй, зорчих эрхийг хязгаарлах ялтай нийт 48 хэрг байснаас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлтээтэй нэг хэрг байсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Эмэгтэйн тусламж үзүүлэхгүй байх" гэмт хэрг юм.

Учир нь тус хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...эхэл дурган сараас дурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял нийтлэнэ..." гэж заасан. Өөрөөр хэлбэл илгэхүү зохицуулалт нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтад аль яшид нь хамаардаггүй байсан юм.

Харин 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д "... эхэл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг дурган сараас дэвш, дээд хэмжээг дурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэдэг хэрэг үйлдснээс хойш дурван жил өнгөрсөн" гэсэн заалт нэмж хуулиндснаар тус зохицуулалтад тоолох хөөн хэлэлцэх хугацаа 3 жил болсон юм

24	19.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
25	19.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
26	19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
27	19.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
28	20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
29	21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
30	21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
31	21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
32	22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
33	22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	6 сар	3 жил
34	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
35	22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
36	22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
37	22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
38	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
39	23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
40	23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
41	23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
42	25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
43	25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
44	25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
45	25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
46	26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
47	27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
48	27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт	6 сар	3 жил
49	28.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил

50	13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	3 сар	2 жил	Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 сар байхаар хуульчилж өгсөн байсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "... 6 сараас 20 жил хүртэл хугацаагаар ... хорих ялыг эдгүүрэг" гэж заасантай зөрчилдөж байсныг 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж хорих ялын доод хэмжээг 6 сар болгон ХХЕА-ийн зохицуулалтад шийшүүлсэн байна.
51	17.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	Энэхүү 3 зохицуулалтын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 1 сэхүя 5 жилийн аль алинд нь хамаарсан хэвээр байгаа юм.
52	17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	
53	17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	5 жил	

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан асуудлыг засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй хэвээр байгаа юм.

Учир нь тус зохицуулалтууд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад заасан "...хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээ найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон..." гэсэн заалтад мөн 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д "...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон," гэж нэмж хуульчилсан заалтад ч хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх 3 зохицуулалт нь одоог хүртэл эрх зүйн хийдэлтэй хэвээр байна.

Асуудал 2.

2015 оны Эрүүгийн хуулийн 6 бүлгийн 30 зүйл, заалтад зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан байна. Гэтэл тус хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилж өгсөн учир торгох ял¹ оногдуулахаар заасан хэргүүдэд хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь ойлгомжгүй байсан юм.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10 өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "...Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан

¹ Зөвхөн торгох ялтай гэмт хэргүүдийн хувьд 10.000-80.000, 20.000-100.000, 20.000-120.000, 40.000-200.000, 120.000-400.000, 200.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох ял оногдуулахаар хуульчилсан байна.

гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно..." гэж нэмж хуульчилснаар зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хэргүүд буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан заалтуудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжийг бүрдүүлсэн.

Хүснэгт 2.

№	Зүйл, заалт	Торгох ялын хэмжээ	Хоон хэлэлцэх хугацаа /2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт/	
			Тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар тогтоовод	Хуулийн этгээд хариуцлага хүлээлгэхээр заасан заалтын дээд хэсэгт заасан ижил хугацаагаар тогтоовод
1	18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
2	18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
3	18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	1 жил	12 жил
4	18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	1 жил	12 жил
5	18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	100.000-400.000 нэгж	5 жил	12 жил
6	18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
7	18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	12 жил
8	18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	1 жил
9	18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил
10	20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	20 жил
11	20.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	12 жил
12	20.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
13	20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	200.000-400.000 нэгж	5 жил	5 жил
14	20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	5 жил	5 жил
15	20.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
16	20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
17	20.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	20.000-120.000 нэгж	3 жил	5 жил
18	20.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	200.000-400.000 нэгж	3 жил	5 жил
19	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	3 жил	5 жил
20	24.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
21	24.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
22	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
23	24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	120.000-400.000 нэгж	5 жил	5 жил
24	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	5 жил	5 жил
25	24.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	40.000-200.000 нэгж	5 жил	5 жил
26	24.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
27	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	20.000-120.000 нэгж	1 жил	5 жил
28	24.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	120.000-400.000 нэгж	12 жил	12 жил
29	25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	1 жил	5 жил
30	25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	10.000-80.000 нэгж	3 жил	5 жил

Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна. Үүнд:

1. Тус хуулийн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно..." гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байгаа юм. Тухайлбал, тус хуулийн 18.7 дугаар зүйл гэхэд 4 хэсгээс бүрдэж байна. 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3-т заасан зохицуулалтуудад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг яг аль хэсгээр нь тоолох нь ойлгомжгүй. Өөрөөр хэлбэл, тухайн зүйл, хэсэгт гэдгийг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 гэж 3 янзаар тайлбарлан ойлгож болохоор байна.

2. Хэрэв тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дараах асуудал үүсэж болохоор байна:

– Торгох ялын хэмжээ ижил хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна.

Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8¹-н хэргийн хувьд 3 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 3 жил, 1 хэрэгт нь 5 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор байгаа юм.

– Торгох ялын хэмжээ нь бага хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна.

– Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм.

– Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт тоолох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа богино байх зэрэг асуудлыг үүсгэж болох юм.

3. Хэрэв 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байвал 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолно буюу тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтын дээд талын хэсэгт заасан хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дор дурдсан асуудлууд үүсэхээр байна:

¹ Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг.

Торгох ялын хэмжээ ижил хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8 хэргийн хувьд 2 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 5 жил, 2 хэрэгт нь 12 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх тоолохоор байгаа юм. Хэрвээ энэ хувилбараар зохицуулбал шударга ёсны зарчим алдагдах юм.

Торгох ялын хэмжээ нь бага хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40.000-120.000 нэгжээр торгох ялтай хэрнээ гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 20 жил байгаа бол мөн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 200.000-400.000 нэгжээр торгохоор заасан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна.

Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.

Асуудал 3.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд оруулсан нэмэлт,

өөрчлөлтөд "...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа..." гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд тус зохицуулалтыг "...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа..." гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх нэр томъёо нь нэг утга санааг илэрхийлж байгаа хэдий ч ялгамжтай байдлаар хуульчлагдсныг нэг мөр болгох нь зүйтэй.

Дүгнэлт

Бидний дагаж мөрдөж буй Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал төдийгүй өөр бусад хэд хэдэн эрх зүйн хийдэлтэй зохицуулалтууд байгааг хэлэх нь зүйтэй. Эрүүгийн хуульд заасан эрх зүйн хийдэлтэй, хүний эрхийг хамгийн ихээр зөрчих заалт нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хэмээн үзэж байна. Тиймдээ ч бусад эрх зүйн хийдэлтэй зохицуулалтаас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг сонгон авч судалсан болно.

2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл буюу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэж заасныг тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Зөрчлийн тухай хуультай уялдуулан "... Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно..." гэж өөрчлөн

найруулсан нь тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг арилгаж, уялдаа холбоо хангасан өөрчлөлт болсон байна.

Мөн Эрүүгийн хуульд 1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг нэмж хуульчилсан нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 эсхүл 5 жилийн хугацаагаар тоолохоор хуульчлагдсан заалтад аль алинд нь хамаарч байсан нийт 53 заалтаас 50 заалтад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 3 жилээр тоолох боломжийг бүрдүүлсэн юм. Гэсэн хэдий тус хуулийн 3 заалт одоог хүртэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 1 эсхүл 5 жилийн аль алинд хамаарч байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар заасан буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар зохицуулалтгүй байсныг засаж сайжруулахыг зорьсон боловч тус зохицуулалт нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй байдлыг бий болгосон.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хэдийгээр сайжруулан засаж, нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч цаашид засаж сайжруулбал зохих асуудал байсаар байгааг анхааран үзэж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх Эрүүгийн хууль дахь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон, зөв гольдролд нь

оруулах нь зүйтэй.

Мөн Эрүүгийн хуульд "...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа...", "...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа..." гэсэн ялгамжтай байдлаар хуульд хуульчилсныг нэг мөр болгох шаардлагатай юм.

ЭХ СУРВАЛЖ

1. Сургагч багш нарт зориулсан гарын авлага, 2017 он
2. Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он
3. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016 он, №7

	2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт	2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт өрсөн байдал	Харьцуулалт
1	-	<p>1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалт. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.</p>	<p>Шинээр нэмж хуульчилсан. Энэхүү заалтыг нэмж хуульчилснаар гэмт хэргийг хоон хэлэлцэх хугацааг 1 эсхүл 5 жилийн хугацаагаар тоолохоор хуульчилгдсан заалтад аль алинд нь хамаарч байсан нийт 53 заалтаас 50 заалтад гэмт хэргийг хоон хэлэлцэх хугацааг 3 жилээр тоолох боломжийг бүрдүүлсэн.</p>
2	<p>1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Гэмт хэргийн хоон хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно.</p>	<p>1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Гэмт хэргийн хоон хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн ялаасдагчаар тагах хүртэл тоолно.</p>	<p>Өөрчлөлт оруулсан. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. "Гэмт хэргийн хоон хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно" гэж заасан нь Эрүүгийн хуулийн тус зохицуулалт нь мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтууд өөр хоорондоо зөрүүтэй байсныг нэр мөр болгосон.</p>
3	-	<p>1.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хоон хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.</p>	<p>Шинээр нэмж хуульчилсан. Энэхүү заалтыг нэмж хуульчилснаар татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 1 жилийн хоон хэлэлцэх хугацаатай байсныг 5 жил болгосон. Мөн энэхүү зохицуулалт нь /18.3 дугаар зүйл/ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдээс ганцаараа хоон хэлэлцэх хугацааг тусгайлан хуульчилсан зохицуулалт болсон юм.</p>
4	-	<p>1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг. Хуулийн этгээдийн нэрийн омноос, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн харгуйлага хүлээлгэхээр заасан бол гухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хоон хэлэлцэх хугацаатай ажил байдлаар хоон хэлэлцэх хугацааг тоолно.</p>	<p>Шинээр нэмж хуульчилсан. Энэхүү зохицуулалтыг нэмж хуульчилснаар хуулийн этгээдэд эрүүгийн харгуйлага хүлээлгэхээр заасан гэмт хэргэд хоон хэлэлцэх хугацаа тоолох боломж бүрдсэн.</p>

МОНГОЛЧУУДЫН УДМЫН СУДАР БА МОНГОЛ ОВОГ, НЭРИЙН УЧИР LINEAGE OF MONGOLIANS AND MEANING OF MONGOLIAN FAMILY NAME



*Шихихутуг их сургуулийн Ерөнхий эрдмийн
тэнхимийн багш, дэд проф, доктор (Ph.D)
Д.Отгончимэг*

Key words: Lineage of Mongolians family name, family tree, hearthstone, relatives of mother, relatives of father, various ethnic group.

Aim of article: One special kind of Mongolian traditional customs is to know about lineage and own family history. Various importance was reflected in this theme. It everyone records own "family tree" and "chain of lineage" according to the knowledge, they can respect, protect, keep own hearthstone and prevent from mixing blood embrittling of lineage.

Abstract: Lineage of Mongolians and etymology of family names One of the special features of Mongolian tradition is that knowing their relationships and building family trees. As the every member of the family build their family trees, they keep records of their family trees, respect relationships and keep family tradition.

Family trees can have many themes. Family trees are often presented with the oldest generations at the top and the newer generations at the bottom. Family tree, which shows the relationship of each person, including cousins and gene share are the important record for every members of the family and for their everyday lives.

Аливаа ард түмний гарвал, хэлний хамаарлыг судлан тогтооход тэдний өөрсдийн нь бүтээсэн оюуны болоод эд өлгийн дурсгал гол түлхүүр хэрэглэгдэхүүн болдог. Нэлээд эрдэмтэн Хүннү нарыг монгол угсаатан байсан гэж үзсээр байгаа. Тэгэхлээр монголын түүхийн мэдээ, домог сэлт нь хүннүчүүдийн гарвал, угсаатны хамаарлыг тодруулахад бас нэг хэрэглэгдэхүүн болох юм.

"Өнө эртний түүхтэй монголчуудын хөгжил, тэмцлийн баялаг түүхийг манай нутаг дээр хүн анх амьдарч байсан тэр үеэс буюу одоогоос 750000 жилийн тэртээгээс өнөөг хүртэл хугацаа он цагийн хувьд дараах үндсэн үеүдэд хувааж болно. Үүнд:

1. Ураг төрлийн байгууллын үе
2. Монголын эртний улсуудын үе
3. Их Монгол улсын болон Монгол гүрний үе
4. Улс төрийн бутралын үе
5. Манжийн эрхшээлийн үеийн Монгол

6. Олноо өргөгдсөн Монгол улсын үе
7. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал түүний дараах үе
8. Өөрчлөлт шинэчлэлийн үе¹ гэж ангилан хувааж үзжээ.

Үндэсний ухамсар төлөвшсөний гол шинж бол үндэсний эрх ашгаа дээдлэх явдал юм. Үндэсний эрх ашгийн сонирхол гэдэг нь **удам гарвалаараа нэг төрлийн, хэл түүх, соёлын харилцан холбоогоороо нэгдмэл үндэстний нийтлэг, нэр бүлгийн ашиг сонирхол** юм. УИХ-иар “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана” гэж заасан байна. Ингэхлээр, монголын түүх бол бүхэлдээ үндэсний язгуур эрх ашиг сонирхолоо хамгаалж, хадгалахын төлөө тэмцлийн түүх юм. Иймээс эх түүхээ танин мэдэж судлахын нэг гол зорилго бол иргэн бүрт үндэсний ухамсар төлөвшүүлэхэд оршино.

Монгол Улсын Их Хурлаас 1996 онд батлагдсан “Соёлын тухай” хууль хэрэгжүүлэх зорилгоор 1997 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн Газрын тогтоол гарч овог сэргээх, угийн бичиг хөтлөх журмыг баталсан байна. Монгол Улсын Засгийн Газрын 1997 оны 104 тогтоолоор 1999-2000 онд Монголч улсын иргэдийн паспортыг иргэний үнэмлэхээр солих ажлын явцад бүх

хүний овгийг иргэний үнэмлэхэд бичих, цаашдаа иргэний бүх бичиг баримтанд бичих болжээ.

Монголчуудын удмын судар буюу гэрийн бичмэл. Монгол хэлний хүн, мал гэдэг хоёр үгийн шууд утгын хэн бүхэн сайн мэднэ. Гэвч “биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал”, эс бөгөөс “урагаа мэдвэл хүн, усаа мэдвэл мал” гэдэг зүйр үгэнд байгаа мөнөөх хоёр үг маань арай өөр, тухайлбал: үүх түүхээ мэдэж, бие дааж аж төрөх хэмжээнд хүрч байж сая жинхэнэ хүн, бэлчээр усаа олж чадаж байж жинхэнэ мал болно гэсэн утга илэрхийлэх бөгөөд үүнд, хүний тухайд жинхэнэ мал болно гэсэн утга илэрхийлэх бөгөөд үүнд, хүний тухайд жинхэнэ хүн болоход удам судар, гарвал угсаагаа мэдэх нь хамгийн чухал гэсэн санааг агуулжээ. Жишээлбэл: “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” зэрэг монголын түүхийн зохиол эхлэхдээ л энэ санааг эн тэргүүндээ онцлон тэмдэглэхдээ 5 дугаар Далай лам Лувсанжамц /1617-1698/-ын “Залуусын хурим” хэмээх зохиолоос эшлэл авсан байсан бөгөөд тэрхүү эшлэлийг өдгөө олон хүн амны уншлага болгон дурдахдаа өөр өөрийнхөөрөө янз бүрийн хувилбараар тайлбарласаар ирсэн. Харин уг эшлэлийг хэрхэн зөв уншиж ойлгох вэ? гэвэл өөр өөрийн цээжний вангаар бус тавдугаар Далай лам Лувсанжамцын “Залуусын хурим” хэмээх зохиолын төвөд эхийн зохих хэсэгтэй тулган үзэж толгой зовоох явдалгүй, зөв хувилбарыг хялбархан гаргаж болно.² Үүнд: “Үүх түүх гарвалт угсаагаа мэдэхийг эрмэлздэг энэхүү үзэл

¹ МУИС. Монгол улсын түүх. УБ.2010. х-22-29

² Д.Заяабаатар, “Асрагч нэртийн түүх”-ийн хэлний онцлогын тухайд, 2002

санаа Монголчуудын хувьд аж амьдрал дээрээ чухам хэдийнээс, хэрхэн тусгаж ирсэн бэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна. “Монголын нууц товчоо”-оос авахуулаад монголын түүхийн бараг бүх сурвалжин гол шугам нь чухамхуу үүнд ч чиглэгдэж ирсэн нь санамсаргүй зүйл биш ажээ. Төр улсын түүхэнд төдийгүй ер энгийн хүмүүсийн хувьд ч энэхүү эрмэлзэл онцгой байр суурь эзэлсээр ирсэн байна.

Дундад зууны үеийн ираны түүхч Рашид Ад-Дин “Судрын чуулган”-даа “...Монголчууд өвөг дээдэсийнхээ гарал үүслийг тэмдэглэн хадгалдаг заншилтай тул хүн бүр удмынхаа сударыг хөтөлдөг юм...” гэж тэмдэглэн үлдээжээ¹. Үүний дээр “Монголын нууц товчоо”-ы гол шугам бол Бөртэ чоно, Гоо маралаас эх авсан удсын бичээс гэж хэлж бүрэн болно. Ингэж бодохул лавтайяа тэр үеэс залгуулан тэмдэглэснээр ирсэн ажээ. Чухамхүү тэдгээр тэмдэглэл нь “Монголын нууц товчоо” болон Рашид Ад-Дин “Судрын чуулган”-ыг зохиоход гол хэрэглэгдэхүүн болсоор ирсэн байх магадлалтай.

Төвөдийн сонгодог боловсролтон монгол бичгийн хүмүүсийн зохиосон, мөн л монголчуудын удамын сударт бүрэнээ хамааруулж болох “Алтан товч”, “Эрдэнийн товч”, “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” зэрэг XVII зууны үеийн монголын түүхийн сурвалжид Монголчуудын өвөг дээдсийг эртний Энэтхэгтэй холбон тэмдэглэдэг ёсон “Монголын нууц товчоо”-д байхгүй. Учир иймд тавдугаар далай ламтаны айлдсан сургаалаас хамаагүй өмнө,

Монгол гэдэг овог аймгийн нэр түүхэнд тэмдэглэгдэхээс бүр өмнө, монгол угсаатны эртний өвөгийн үеэс эцэг дээдсийнхээ удам сударыг тэмдэглэн хөтлөдөг ёс уугуул монголынх гэж үзэж болно.

Ийнхүү маш эрт цагаас уламжлал болсон удам сударын тэмдэглэл өдгөө нутаг нутагт, төвшин төвшинд янз бүрийн нэрээр уламжлагдан бие бодотой хэрэглэгдсээр байна. Тухайлбал: Халхын ноёдуудынхийг Тайж нарын цэс буюу Тайж нарын гэрийн үеийн зураг, Гэрийн үеийн зурвас, буриад түмэн Угай буюу Угийн бичиг, Өвөр Монголчууд Гэрийн тууж, ер энгийн хүнийхийг Гэрийн үеийн бичиг гэх зэргээр нэрлэдэг боловч уг чанар нь нэг ажээ².

Гэвч хамрах хүрээ хязгаар нь хоорондоо адилгүй. Тухайлбал: ноёд тайж нарын цэс нь төрийн баримт болдог учир тодорхой нэгэн зааг буюу тодорхой нэгэн салбарласан үеэс нь эхлүүлэн дэлгэрэнгүй хөтөлдөг байхад ер энгийн хүнийх нь хувийн чанартай баримт болохын хувьд дэлгэрэнгүй, товч янз янз байдаг.

Уг удмаа ийнхүү бичиглэн үе уламжлуулдаг монгол ёсыг урагш нь нэхэн хөөж үзвэл нэн эрт цагт, тухайлбал: овгийн байгууллын үед лавтай тулж очдог. Хүмүүс хүй нийтээрээ аж төрдөг ёсон задарч овог овгоороо туурга тусгаарлаж ирмэгц нэгэн талаас, амьдралын эрхээр нэгэн овог нөгөөгөөсөө ялгарч, тэрхүү ялгаагаа хойч үедээ уламжлуулах, нөгөө талаас, хуульзүйн баталгаатай болгох бодит шаардлага гарч иржээ.

¹ Рашид Ад-Дин. Судрын чуулган.

² Х. Пэрлээ. Нэгэн гэрийн түүхийн тухай УБ. 1958

Өрх гэрийн Удамын бичиг нь тухайн өрхийн хүн бүрийн өдөр тутмын хэрэгцээ болдог тул зөвхөн доош нь босоо үелээд зогсдоггүй, хажуу тийш нь эцэгийн буюу авгын, эхийн буюу нагацын талын бүх хүнийг хамран салбарлуулдгаараа албаны Цэсээс ялгардаг. Ингэх нь өөрөс дээш дооши удам сударыг мэдэхийн хажуугаар бүх хамаатан саднаа танин мэдэх эрмэлзэл бөлгөө.

Энэ утгаараа багагүй ач холбогдол өгч их дээд сургуульд суралцаж байгаа оюутан, залуучуудад өөрийнх ураг удмыг таниулан ухамсарлуулах, судалгаа хийлгэх ажлыг сүүлийн нилээд хэдэн жил өөрийн судалгааны ажилтай холбогдуулан хийж байна. Тухайлбал доорх зургаас үзэхэд 2012-2017 оны хичээлийн жилүүдэд тасралтгүй судалгааг авч анализ хийсэн болно.

Энэ дашрамд нэгэн зүйлийг тэмдэглэхэд, Монголчууд эцгийнхээ талыг ясан төрөл, эхийнхээ талыг махан төрөл гэж үзсээр ирсэн билээ. Тийм ч учраас яс махны тасархай гэдэг хэлэлгэ гарсан хэрэг.

Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэн “Буурал ээж” найраглалдаа:

“Халх Монголын малчин
Хатиган овгийн нүүдэлчин
Харч язгуур Дамдинсүрэн
Харь газар суухдаа...” гэж
шүлэглэснийг хүн бүхэн мэднэ.

Ийнхүү монгол хүн бүрийн сайн мэддэг байсан овог маань 70 гаруйхан жилийн дотор мартагдаж, удам угсаа, төрөл саднаа мэдэхгүй болж, овог сэргээн хэрэглэнэ гэхээр гадны улсуудыг

дуурайж 3 нэртэй болж байгаа юм шиг ойлгох, эсвэл овгуудын хооронд зөрчил үүсч монголын ард түмний эв нэгдэлд хохирол учруулах юм шиг бодож төөрөгдсөн хүмүүс ч байх юм. Хэрэв овгуудын хооронд зөрчил үүсдэг байсан бол өнөөдөр хүн төрөлхтний ихэнхи нь овгийн нэр хэрэглэхгүй байсан шүү дээ¹. Энэ талаар манай нэрт эрдэмтэн Б.Ренчин бичихдээ:

“Монголчууд гаднаас гэрлэх гэдэг ёсыг нь баримталсаар ирсэн нь ойр төрлийнхөө хүнтэй гэрлэхгүй байдагтай холбоотой. Тэр учраас монголчууд нэгэн овогтой хүн цөм элгэн төрөл гэж үзэж, өөр овгийн хүнтэй ураг төрөл барилддаг ёс байжээ. Манжийн байлдан дагууллын далдын бодлогоор овог ялган хэрэглэдгийг байлгаж овгийн оронд хошууныхаа нэр хэрэглэх болсноор овог төрлийн мартуулах ноёрхолынхоо турш оролсон учраас нэг хэсэг хүн түүний уршигаар овгоо мэдэхгүйд хүрч ирсэн байна. Ёстой овог гэдэг бол жишээ: Боржигон, Баатад, Олхунуд, Булгатар, Харагчуд, Асуд гэх мэт болно, овгийн дараа эцгийн нэр тэгээд өөрийн нэр хэрэглэж тэр овгийн тэрний хүү тэр гэж нэрлэдэг нарийн ёс байжээ. Жишээ нь: манай нэрт зохиолч Нацагдорж нь, Боржигон Дашдоржийн Нацагдорж байжээ. Боржигон гэдэг нь овог, Дашдорж гэдэг нь эцэг нь, өөрөө Нацагдорж байжээ.

“Бас сонирхолтой асуудал бол иргэний үнэмлэх дээр зайлшгүй овгийн нэртэй байхыг заасан дүрэм журам 1990 оноос хойш гарсан тул Монголчууд өөрсдөдөө шинэ нэр буюу овогийн нэр

¹ Бэсүд Ж.Сэржээ. Монгол овгийн нэрийн учир. УБ.1999

олж авах аянд мордоцгоосон. Барууны хэвлэл мэдээлэлийн хэрэгслүүдийн уг овгийн нэртэй болох үйл явцыг Монголчууд уламжлалаа сэргээж байна хэмээн бичих болсон. Лос Анжелес Таймс сонинд Марк Магниер "овгийн нэр хэрэглэхийг хорьсон" коммунист дарангуйлал үгүй болсоноор Монголчууд уламжлалт монгол "овог"-оо сэргээж байна хэмээн бичжээ. Ийнхүү бичсэн нь эндүүрсэн хэрэг юм. Ихэнхи Монголчууд эцэг, эхийн нэрээр овоглож байсан бөгөөд зөвхөн засаг захиргааны байгууллагаас шаардсаны дагуу "овгийн нэр"-ээ сонгох хэрэгтэй болсон байгаа юм. Үүнтэй адил төстэй үйл явц 1925 онд болсон. 1925 оны хүн амын тооллого хийх дүрэм журамд овогийн нэрээ мэдэхгүй хүмүүс эцэг эсвэл эхийн нэрээр овоглож болно хэмээн заажээ.

Уг нь төрөл гэдэг нь хүний босоо чиглэлийн гарлын холбоог "элэнц, хуланц, өвөг, аав, би, хүү, ач, гуч, жич" г.м нэрлэсэн үг бөгөөд дотроо ясан төрөл буюу "аавын тал", махан төрөл буюу "ээжийн тал" гэж 2 хуваагддаг. Тэгвэл садан гэдэг нь хүний хэвтээ чиглэлийн гарал хамаарлыг "ах, дүү үеэлд, хаяалд" г.м үг юм. Удам гэдэг нь өөрөөс өмнөх үеийн төрөл, угсаа гэдэг нь өөрөөс хойшхи үеийн төрлийг хэлнэ. Ураг гэдэг нь эцэг, эх хоёр талыг хамран багтаасан буюу эхнэр, нөхөр хоёрын нэгдлийн илэрхийлсэн утгатай үг юм. Энэ мэтчилэнгээр авга "аавын ах дүү", нагац "ээжийн ах дүү", ач "хүүгээс гарсан хүүхэд", зээ "охиноос гарсан хүүхэд", гэх мэт товч бөгөөд тодорхой нэр томъёогоо хэрэглэж сурах хэрэгтэй болж байна¹.

¹ Бэсүд Ж.Сэржээ Монгол овог нэрийн учир УБ.1999

Өнөөгийн дэлхийн хүний нэрийн тогтолцоог ерөнхийд нь нэг нэрийн "зөвхөн өөрийн нь нэр", хоёр нэрийн "өөрийн нэрээс гадна эцгийн нэр, овгийн нэр хоёрын аль нэгийг нь хэрэглэдэг", гурван нэрийн "овгийн нэр, эцгийн нэр, өөрийн нэр" гэж үндсэн гурван хэсэгт хувааж болно. Тухайлбал: Испандчууд овог байхгүй, Чех, Польш, Болгарт эцгийн нэг хэрэглэгддэггүй, далайн зарим ард түмний дунд овог ч, эцгийн нэр ч байдаггүй. Одоо Европ, Америк тивд сууж байгаа олонхи ард түмэн, түүний дотор англи, америкчуудын дунд нэр, овог хоёрыг л хэрэглэдэг хоёр нэрийн тогтолцоо түүхийн явцад бүрэлдэн тогтжээ. Орос болон бусад олон үндэстэн 3 нэрийн тогтолцоотой байх жишээтэй.

Төрөөс ураг төрлийн холбоог тодорхойлох оролдлогын дагуу Монголд урьд өмнө басхүү байсан байна. Манж Чин улсын үед манжийн захиргаанаас овгийн нэр болоход тохиромжтой нэр томъёо хэрэглэн Монголчуудын ураг төрлийн хэлхээ холбоог тодорхойлсон систем тогтоохыг оролдсон². Хүн амын тооллого дахь ихэнхи бүлэг хүмүүсийн нийтлэг шинжээр нь ангилсан болохыг тухайн хүмүүст оноосон Тайж нар, Хятад, Ачит Ламынхан "Ачит Ламын хүмүүс" зэрэг нэрсээс нь харж болно³. Уг ангилалыг нь Хатанбаатарын "овог отогын уламжлал" буюу засаг захиргааны дагуух ангилал болохыг харуулж байна. Овогийн нэрийг нягтлан харахад эртний тэгш эрхт нийгмээс үлдсэн овог

² Дэвид Снийг Төр овгийг үүсгэх нь: Антропологиин хийсвэрлэн сэтгэхүй хийгээд Дотоод Ази дахь "Тэрүүн үгүй" төр

³ Очир Сэржээ 1998:26-9

нэрийн улбаас болох магадлал тун бага харагддаг. Дээр дурьдсан онолд тулгуурлан практик үр дүнд суурилсан уг судалгааг товч танилцуулбал:

2019-2020 оны хичээлийн жилд

2020-2021 оны хичээлийн жилд:

1-р улиралд 459 оюутан

2-р улиралд 413 оюутан

НИЙТ 872 оюутанаас 90% буюу 805 оюутан нь өөрийн чадлын хэмжээнд зарим өдрийн ангийн оюутнууд эцэг эхийн тусламжтайгаар, харин эчнээ, магистрантурт хуульч мэргэжлээр суралцаж буй оюутнууд өөрсдөө түүхэн сурвалжит гэрийн зурагт альбом, аман ярилцлага, түүхийн зарим нэг архивын бичиг, эд, өлгийн зүйлд дээр тулгуурлан бодитойгоор чанартай хийж гүйцэтгэсэн байна.

1 УЛИРАЛД 459 ОЮУТАН 17922,

2 УЛИРАЛД 413 ОЮУТАН 3-13 үеийн 17683 хүнийг тус тус нэхэн сурвалжлан 44506 гаргаж ирсэн.

Мөн байгууллагууд дээр энэхүү судалгааны ажлаа 3 жил дараалан явуулж байна. Тухайлбал: Зүүнхараагийн техник мэргэжлийн сургуулийн 60 багш, ажилчид, мөн зүүнхараад байдаг эрэгтэйчүүдийн чанга дэглэмтэй ... хорих ангийн 120 эрэгтэйчүүд, Эрдэнэт хотын ГОК-ийн үйлдвэрчний эвлэлтэй хамтран 6 цехийн 320 хүн, мөн Эрдэнэтийн "Бодь" даатгалын 25 байцагч нар, УБ хотын "Жугамт өргөө" ХХК-ний нийт 80 инженер техникийн ажилчин, Нийслэлийн 14 дунд сургуулийн ахлах ангийн 100 сурагч ангий даасан багш нар, Эмэгтэйчүүдийн хорих ангийн 250 эмэгтэйчүүд зэрэг 1500 гаруй хүн хамрагдаад байна. Давтамжтайгаар 3-6 удаагийн сургалтын дараа үр дүнгийн ахиц гарч эхэлдэг.

2014-2017 оны хооронд хийсэн сургалтын үр дүнгийн үйл явцаас

ХЭЛБЭРИЙН ХУВЬД

www.geni.com 134

Myheritage.mart.com 126

Chje.nygulthiign 115

Ном болгон гаргасан 38

PP-гээр 114

Том цаасан дээр 120

Усан будгаар 76

Ширэн дээр 12

Жаазлан хийсэн 10

Цагаан даавуун дээр 19

Альбом хийж хавтасласан 108

НИЙТ 872

Д/Д	Байгууллагын нэрс	Сургалтанд хамрагдсан хүний тоо	Сургалтын өмнөх ойлголт	Хэд хэдэн сургалтанд дараа	Сургалтын үр дүн
1	З.Хараа МСҮТ	60	31%	61,8%	30,8%
2	Эрдэнэтийн хорих анги	120	12,4%	41%	28,6%
3	Эрдэнэт ГОК	320	41,2%	86,1%	44,9%
4	Эрдэнэт “Бодь”	25	0,6%	51,2%	50,6%
5	УБ. Жугамт өргөө	80	19,5%	49,9%	30,4%
6	Нийслэлийн 14 сургууль	100	0,78%	33,3%	32,22%
7	Эмэгтэйчүүдийн хорих анги	250	23,4%	35,7%	12,3%

Мэдээлэл сайн авч болох боллоцоотой газар нь “Эрдэнэтийн Бодь” даатгалын хамт олон байлаа. Учир нь гэр бүлийн 80 гаруй хувь Эрдэнэт хотдоо амьдардаг учраас харин бага ахиц гарсан 12,3%-тай хорих ангид хүмүүжигдэж хүмүүс мэдээлэл авах боломж тааруу байсан гэж дүгнэлээ.

МҮОНТ-ийн MN-2 сувгаар 2020-2021 оны хооронд “Угийн бичиг” нэврүүлгийг олон нийтийн массад зориулж, “анхан шатны ойлголт, сургалтын үр дүн, хийх аргагчлал, уг сэдвээр судалгаа хийсэн эрдэмтдийн төлөөллийг оролцуулан нэвтрүүлэг хөтлөн явуулсан нь үр дүнтэй болж “Чанарын үнэлгээний шагнал” авсан.

Эцэст нь дүгнэн хэлэхэд: Удамын судараа хөтлөх нь монголчуудын хүн амзүйн бодолгын нэг тодорхой хэсэг бөгөөд удам угсаагаа мэдэх ураг төрлөө таньж хүндлэх, өргөж тэтгэх, өрх гэр тусгаарлахад хоёр талын гарал хамаатлыг тогтоох, эрүүл чийрэг үр ачтай болох зэрэг биологийн төдийгүй мал сүрэг болон эд хөрөнгөө өвлөх, угсаа зэрэг залгах гэх мэтийн нийгэм

хууль зүйн, цаазын эрхэмжийн дагуу нарийн учир холбогдолтой байсан.

ЦААШИД ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ:

1. МОНГОЛ ХҮН БҮРИЙН ЗАЙЛШГҮЙ ХИЙХ АЖЛЫН НЭГ БАЙХ ХЭРЭГТЭЙ
2. ХУВЬ ХҮНИЙ ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБОЖ АВЧ ҮЗЭХ
3. ДУНД СУРГУУЛИАС ЭХЛЭН СИСТЕМТЭЙГЭЭР СУРГАЛТАНД ОРУУЛЖ ӨГӨХ
4. АЛБАН БАЙГУУЛЛАГАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ СУРГАЛТ ХИЙХ

Ном зүй, ашигласан материал:

1. МУИС. Монгол улсын түүх. УБ.2010
2. Ц.Шагдарсүрэн. Ц. Монголчуудын утга соёлын товчоон. УБ 2005
3. Заяабаатар, Д. "Асрагч нэргийн түүх" орчуулга.
4. Рашид Ад-Дин "Судрын чуулган" товчлол.
5. Гонгор, Д. Халх товчоон. УБ.1978.
6. Лонжид, З. Хэдийнээс эцгээр овоглох болсон бэ? Ардын эрх сонин. 1991,06,15
7. Сэржээ, Ж.Монгол овгийн нэрийн учир. УБ.1999
8. Ренчин, Б. "Ураг төрлийн учир", "Залуу үе" сэтгүүл 1968,14.
9. Очир, А. "Монголчуудын овгийн лавлах" УБ. 1998.
10. Отгончимэг, Д. Монгол ёс заншил. УБ. 2016
11. Отгончимэг, Д. Соёлын тухай товч ойлголт. УБ.2015
12. Отгончимэг, Д. Чин сэтгэлийн яриаУБ.2012

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ХҮНИЙ ЭРХ DISCRIMINATION AND HUMAN RIGHTS



*Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш. Хууль зүйн магистр.
(LL.M) Б.Мөнх-Эрдэнэ*

*Хүний эрхийг үгүйсгэдэг хүн өөрийн хүн чанарыг үгүйсгэж байгаа хэрэг.
Нельсон Мандела.*

Гарчиг Оршил

- I. Дэлхий даяар тархаж буй ялгаварлан гадуурхалт гэж юу вэ?
- II. Ялгаварлан гадуурхах хэлбэрүүд
- III. Ялгаварлан гадуурхахтай холбоотой онолын асуудал
- IV. Дэлхий ертөнцөөс ялгаварлан гадуурхахыг арилгах тухай гэрээ буюу эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ шаардлага
- V. Ялгаварлан гадуурхалтыг бий болгож буй гол шалтгаанууд болоод урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Дүгнэлт

Хураангуй: Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, бэлгийн ба хүйсийн баримжаа, хүйс, гэрлэлтийн байдал, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглодог. Мөн ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын асуудал өнөөгийн цаг үед тулгамдаж буй томоохон хүний эрхийн зөрчил юм. Энэхүү нийтлэлээр ялгаварлан гадуурхах асуудлыг тэр дундаа ялгаварлан гадуурхах гэж үзэх зүйл нь юу гэдгийг санал болгохын зэрэгцээ хүний эрхийг хамгаалах талаар хэрхэн урьдчилсан арга хэмжээ авах талаар тусгасан болно.

Түлхүүр үг: Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх

Abstract: The law prohibits discrimination on the basis of ethnicity, language, race, age, sexual orientation, sex, marital status, social origin, wealth, religion, opinion, education, or health. Discrimination in the workplace is also a major human rights violation today. This article suggests what discrimination is, in particular, what constitutes discrimination, and how to take precautionary measures to protect human rights.

Keywords: discrimination and human rights

Оршил

"Хүний эрх" нь хүн төрөлхтөн дунд хүний биеийг олж төрсөн хэн бүхэнд байгалиас хүлээн зөвшөөрөгдөх ёстой үндсэн эрх юм. Гэсэн хэдий ч хүн төрөлхтний түүхэнд байгалийн эрх болох хүний эрхийг бүрэн хамгаалж байсан цаг үе хэзээ ч байгаагүй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл эрт дээр үеэс боолчлолын асуудал байнга яригдаж ирсэн бөгөөд өнөө үед дэлхийн өнцөг булан бүрт гэмт хэрэгтнүүд, хүнийг эрхийн мэдрэмжгүй хүмүүс бусдын эрхэнд ноцтой халдсан хэвээр байна.

Энэхүү нийтлэлээр ялгаварлан гадуурхах асуудлыг тэр дундаа "ялгаварлан гадуурхах" гэж үзэх зүйл нь юу гэдгийг санал болгохыг хүсч байна. Ялгаварлан гадуурхах асуудлыг шууд үгийнх нь утгаар ойлгосон явдал нь "ялгаварлан гадуурхах онол" өнөөг хүртэл төдийлөн сайн боловсруулагдаагүйтэй холбоотой. Дээрх асуудалтай холбогдуулан ялгаварлан гадуурхагч гэж хэнийг хэлэх, түүнтэй хэрхэн харьцах нь судлагдаагүй гэж хэлэхэд болно.

Ялгаварлан гадуурхах асуудлын тухайд салбар бүрт эмпирик судалгаа хуримтлагдсан боловч ялгаварлан гадуурхах янз бүрийн асуудалд нийтлэг байдаг онолын асуудлуудын талаарх хэлэлцүүлэг туйлын хангалтгүй байгаа нь практик талбарт маш их төөрөгдөл үүсгэдэг. Бид ялгаварлан гадуурхагчийн үүднээс л зөвхөн асуудлыг тайлбарладаг учраас хүмүүс бусдыг гадуурхах асуудалтай хэрхэн холбогддог гэдгийг нарийн гаргаж өгөх нь хүний эрхийн зөрчлийг бууруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

I. Дэлхий даяар тархаж буй ялгаварлан гадуурхалт гэж юу вэ?

Өнөө үед арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал дэлхий дээр гаарсаар байна. Нас хүйсээс үл хамааран ялгаварлан гадуурхах үндэс суурь нь гүн гүнзгий бөгөөд өөрөөс нь ялгаатай гэсэн шалтгаанаар ялгаварлан гадуурхах үзлийг хөхүүлэн дэмжих нь нийтлэг. Өөрөөсөө өөр хүмүүсийг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдлаас болж тэгш бус байдал улс оронд, хүмүүсийн дунд таран түгдэг. Ялгаварлан гадуурхалтын түүх нь эзэн хааны колоничлолын дэглэм дэлгэрэхээс өмнө байсан гэж үздэг. Бусдыг өөрөөсөө дорд үзэж гадуурхах нь мөргөлдөөн үүсгэдэг бөгөөд энэ нь өнөөдөр зөвхөн Африк, Ази төдийгүй АНУ, Европ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад ч түгээмэл байгаа¹ нь асуудал дагуулж байгаа юм.

Дэлхий дээр гарч буй арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахыг мэдэхийн тулд бид 19-р зууны сүүлийн хагаст эргэж очих хэрэгтэй. Энэ үед Европт империализм хүчтэй дэлгэрч, хар арьстнуудыг ялгаварлан гадуурхах үзэл хүчээ авсан юм. Учир нь их гүрнүүд гэж нэрлэгддэг Европын орнууд Африкийн орнуудыг колони болгож байсан түүхтэй холбоотой.

Арьс өнгө, угсаа гарлаар нь ялгаварлан гадуурхахтай холбоотой хамгийн тод илэрч гардаг үзэгдлийг энгийнээр тайлбарлахад спортын салбараас жишээ авахад болно. Тухайлбал хөл бөмбөгийн спортод өндөр түвшний алдартай тоглогчид нь янз бүрийн угсаа гаралтай хүмүүс байх бөгөөд мэргэжлийн лигт дэлхийн өнцөг булан бүрээс өрсөлдөж байна. Арьсны

¹ 内藤準、会現象の規範的概念化に関する一つの考察、33頁。

өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг хөл бөмбөгийн спорт олон жил нууж аль болох дарж байсан юм. 1995 оны Босманы тогтоол нь Европын лигүүд болон клубуудын багуудын далд байсан ялгаварлан гадуурхалтыг ил гаргасан билээ. Шийдвэрийн агуулга нь Европын Холбоо дахь мэргэжлийн тоглогчид өөрсдийн багтай байгуулсан гэрээний хугацаа дуусахтай зэрэгцэн чөлөөтэй шилжих боломжтой болсон бөгөөд энэ нь хожим хөл бөмбөгт арьс өнгөөр ялгаварлан гадуурхалт хүчтэй тархах хүчин зүйл болж хувирчээ.

Хамгийн нийтлэг гадуурхалтын хэлбэр нь тамирчдыг арьс өнгөөр ялгаварлан гадуурхдаг хөгжөөн дэмжигчид тоглолтын үеэр болон өдөр тутмын амьдралд нь дарамт учруулах зорилгоор доромжилсон олон зурвас, илгээмж тамирчдад явуулдаг асуудал юм. Түүнчлэн бие биетэйгээ хамтран ажиллаж, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хоорондоо шударга өрсөлдөх ёстой тоглогчдын дунд хүртэл тэмцээний үеэр нэгнээ доромжилсон үг хэллэг, дохио зангаа гаргах үйлдлүүд ихсэх болжээ¹. Цагаан арьстнууд давамгайлдаг Европт өнгөт арьстнууд, ялангуяа хар арьстнуудыг ялгаварлан гадуурхах явдал маш их ажиглагдаж байгаа бөгөөд еврей, ази тамирчдыг ч мөн ялгаварлан гадуурхдаг болсон байна.

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг үйлдлийг арилгахын тулд 1998 онд зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнд олон улсын уралдаанд оролцох эрхгүй байсан Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсыг оролцуулах боломжтой болгосон билээ. Энэ түүхэн үйл явдал нь арьс өнгөөр

ялгаварлан гадуурхах бодлогын золиос болсон улс орон, үндэстнүүдийн төлөө хийсэн дэвшилтэд алхам бөгөөд олон улсын хүний эрхийн байгууллагуудын олон жилийн хичээл зүтгэл байсан юм. Гэсэн хэдий ч дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Францын шигшээ багийн тоглогч арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл гаргасанд дургүйцсэн ӨАБНУ-ын тоглогч тоглолтын үеэр хариу цохилт хийж нэлээн асуудал дагуулсан билээ.

Дээрх цочирдом үйл явдлын хариуд 2006 оны дэлхийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнийг "Арьс өнгөөр ялгаварлах үзэлд үгүй гэж хэлье"² гэсэн уриатай зохион байгуулсан. Европт аюулгүй байдал, ялангуяа хөл бөмбөгийн тоглогч болоод хөгжөөн дэмжигчийн аюулгүй байдал нь нийгмийн гажуудал, тогтворгүй байдалтай шууд холбоотой бөгөөд хөл бөмбөгийн холбоо, лиг, клубуудын дунд арьс өнгөөр ялгаварлан гадуурхахтай тэмцэх ажил одоо ч гэсэн үргэлжилж байна.

Дээр дурьдсанчлантай адил ялгаварлан гадуурхалт Монгол улсад ч бас бий. Тухайлбал жендэрийн асуудал, эмэгтэйчүүд, хүүхдийн болон ахмад настнуудын, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ажлын байран дахь гадуурхалт, ХДХВ болон хамгийн сүүлд цар тахал буюу корона вирус өвчнөөр өвчилсөн хүмүүсийн эсрэг хийсэн ялгаварлан гадуурхалтын асуудлууд орно. Монгол улсын хувьд дээрх хүний эрхийг зөрчсөн гадуурхалтуудыг зөв мэдлэг, боловсрол олгох байдлаар арилгах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад олон орны хүмүүс ажиллаж суралцахаар

¹ Amnesty International. What drives discrimination and how do we stop it?. 2020.

² Say no to racism.

түүнчлэн аяллаар ирэх нь нэмэгдсэн. Энэ бол даяаршсан ертөнцөд энгийн үзэгдэл боловч харийн хүн гэдэг байдлаар ялгаварлан үзэх дарамтлах тохиолдол гарч байна. Монголчууд бид нийтээрээ гадны улсыг ялгаварлан гадуурхах үзэлгүй боловч тодорхой яс үндэс, угсаа гарал, үндэс угсаагаар ялгах асуудал бас бий. Энэ байдал даамжирч болохгүй бөгөөд ялгаварлан гадуурхахыг уриалсан орчин бүрдэх эрсдэлийг үүсгэх аюултай.

Ялгаварлан гадуурхах шалтгаан нь санаатай гэх боловч нөгөө талтаа ухамсаргүйгээр хийгддэг гэж хэлж болно. Орчин үед ялгаварлан гадуурхах үзэл нь ямар ч байдлаар гарч болохоор байгаа нь хүн төрөлхтөний нийтлэг сул тал, гажуудалтай холбоотой гэж үзэж байна. Ялгаварлан гадуурхах байдлыг хувь хүн биш харин тодорхой бүлэглэл зонхилон хийдэг бөгөөд нөгөө талд нь тодорхой хүмүүсийн болоод бүлэглэлийн эрх зөрчигдөж хохирдог¹. Хувь хүмүүсийг тойрсон нийтлэг бүлэг, нийгмийн бүтэц нь ялгаварлан гадуурхахад нөлөөлдөг гол хүчин зүйлүүд болдог.

Ялгаварлан гадуурхалтын шалтгаан нь ихэвчлэн хувь хүмүүс төдийгүй адил бүлгүүдийн хооронд өрсөлдөөний харилцаа үүсэхээс эхлэлтэй бөгөөд зорилгодоо хүрэхэд бусад хүн, хүмүүс болоод бүлгүүд саад болж, ашиг сонирхолд маань заналхийлж байна хэмээн ялгаварлан гадуурхалтын хандлага илэрдэг. Дээрх ойлголт нь хууль ёсны өрсөлдөөнөөс үүдээгүй л бол өрөөсгөл, ялгаварлан гадуурхалт мөн бөгөөд бусдын эрхэнд халдсан ноцтой асуудал юм.

II. Ялгаварлан гадуурхах хэлбэрүүд

Ялгаварлан гадуурхах асуудал нь олон хэлбэртэй бөгөөд тухайн илэрч гарч буй хэлбэр болгон нь хүний эрхийн зөрчил болж байдаг. Гэхдээ ялгаварлан гадуурхах хэлбэр нь цаг хугацаа, газар нутгаас хамааран утга агуулгын хувьд өөр өөр байдаг хэдий ч дараах хэлбэрүүд нь өдгөө хүлээн зөвшөөрөгдөж нийтлэг байдлаар хүний эрхийг хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдаж байгаа болно.

1. Статусын ялгаварлан гадуурхалт:

Хуулийн нэрт эрдэмтэн Хенри Сумнер Мейн "статусаас гэрээ хүртэл" гэсэн хэллэгийг анх ашигласан юм. Тэрээр статус гэдэг нь өргөн утгаараа тодорхой нийгэм, бүлэгт байгаа байр суурийг ойлгоно гэжээ. Статусын ялгаварлан гадуурхалт гэдэг нь хувь хүний авьяас чадвар, хүчин чармайлтаас үл хамааран нийгмийн байр сууринаас хамаарч тодорхойлогддог харилцааг хэлнэ². Тодруулбал нас, хүйс, ураг төрлийн холбоотойгоор нь гадуурхдаг хэлбэр.

2. Анги давхарга ба мэргэжлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт:

Анги давхаргын ялгаварлан гадуурхалт нь ажил мэргэжил, боловсрол эзэмшсэн байдал, өмч хөрөнгө гэх зэргээр дээд анги, ажилчин анги зэрэг байдлаар илэрдэг бол мэргэжлээс үүдэлтэй ялгаварлал нь ажлын байран дээрх албан тушаалаас хамааралтай байх нь нийтлэг. Жишээ нь цагдаагийн болон цэргийн байгууллагуудад цол зэрэг, тэмдэг зэргээс шалтгаалан нэгнээ ялган гадуурхах байдал бий болдог.

¹ チベット人権・民主センター、チベットでの中国の存在と人権の侵害、1997年。

² 社会科学大事典18、鹿島研究所出版会、332頁。

3. **Арьс өнгө, угсаа гарал, шашин шүтлэг, соёлын ялгаварлан гадуурхалт:** Арьс өнгөөр болон үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах үзэл эрт дээр үеэс оршин тогтнож ирсэн. Эртний Грекээс үүдэлтэй "угсаатны үзэл" нь хожим ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болсон гэж үзэж болно. 19-р зууны барууны орнуудад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг колоничлолын худалдааг зөвтгөхийн тулд шинжлэх ухаантай холбож сүүлдээ хуурамч шинжлэх ухаанд суурилсан идеализм болгосон. Арьс өнгө, гарал угсаагаар ялгаварлан гадуурхах нь колоничлол дээр үндэслэгдэж уугуул иргэдийн хэлмэгдүүлэлт, хар арьст африкчуудын боолын худалдаа, боолчлолыг хэрэгжүүлсэн хөрс суурь болсон билээ. Орчин үед үндсэрхэг үзлийн хүчирхийлэл гарах нь ихэссэн бөгөөд тусгаар тогтнолын хөдөлгөөнийг дарангуйллын аргаар янз бүрийн хавчлага, ялгаварлан гадуурхалтаар зогсоох байдал газар авч байна¹. 1930-аад онд Герман улсад нэвтэрсэн еврей, цыган гэх мэт үндэстнүүдийг ялгаварлан гадуурхах, хавчин шахах явдлыг зөвтгөсөн туйлширсан арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогыг хэрэгжүүлсэн нь хүн төрөлхтний түүхэнд томоохон хар мөр үлдээсэн. Дэлхийн 2-р дайны дараа ялгаварлан гадуурхалт багассан ч сүүлийн жилүүдэд угсаатны мөргөлдөөн, терроризм, дүрвэгсэд, цагаачдын тоо нэмэгдэж байгааг нь тодорхой угсаатны

бүлэг болон шашин шүтлэгээр нь гадуурхан хавчиж байгаагийн тод илрэл юм.

4. **Хэл яриа, бүс нутгийн ялгаварлан гадуурхалт:** Хэлний ялгаварлан гадуурхалт нь юуны түрүүнд нийгмийн үзэгдэл юм. Зарим салбарт хэлний ялгаварлан гадуурхалтыг тодорхой хэлний бүлэгт зориулсан бодлого боловсруулах хэлбэр гэж үздэг. Гэхдээ арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь нийгмийн шинжтэй бол хэл, бүс нутгаар ялгаварлан гадуурхах нь улс төрийн шинжтэй байдаг. Хэл гэх ойлголтын хүрээнд авч үзэж болох гол хэсгүүд нь авиа зүйн өргөлт, үгсийн сангийн цар хүрээ юм. Энэ нь тухайн хүний нэг хэлнээс өөр хэл ашиглах чадварыг зайлшгүй чухалчлахтай холбогдож байдаг. Жишээлбэл: Францад байдаг монгол хэлтэй хүнд франц хэлтэй хүнээс өөрөөр хандах нь тодорхой. Хэл яриаг ялгаварлан гадуурхах хэлбэр нь бусад ялгаварлан гадуурхах хэлбэрүүдээс илүү ухамсартай байдаг. Учир нь хүний соёлын талаар хэсэгчлэн хэл шинжлэлийн чадвар дээр үндэслэсэн дүгнэлт гаргах байдлаар энэ гадуурхалт хийгддэг. Хэл шинжлэлийн эрдэмтдийн анхааруулж байгаагаар олон хүний хувьд логик болоод ёс суртахууны хувьд үндэслэлгүйгээр хэл яриагаа гадуурхах хандлага гаргах аюул нэмэгдэж байна гэжээ.

5. **Хүйсийн ялгаварлан гадуурхах байдал:** Олон салбарт эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлаж олон нийтийн өмнө

1 性差別と暴力—銃・性の法律学。角田由紀子 有斐閣選書。

үг хэлэх боломж олгодоггүй байсан цаг үе саяхан. Өнөөгийн цаг үед ихэнх улс оронд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь сонгуулийн эрхийг зөвшөөрдөг бөгөөд эмэгтэйчүүдийн нийгмийн дэвшлийг нааштай хүлээн авч үздэг болсон. Тухайлбал хууль эрх зүйн тогтолцооны хувьд хүн бүр тэгш эрхтэй гэдгийг тунхаглаж байна. Финланд улс 1906 онд Европын түүхэн дэх эмэгтэйчүүдэд анхны сонгуулийн эрхийг олгосон улс болсон нь томоохон хүний эрхийн дэвшил байсан. Гэсэн хэдий ч өнөөгийн цагт Ойрхи Дорнодын зарим улс оронд эмэгтэйчүүдийн сонгох эрхийг зөвшөөрдөггүй, зөвшөөрсөн ч хязгаарладаг байдал хэвээр үлджээ.

Эртний Грекийн дэлхийн анхны ардчилал болох Афин хотод өрхийн тэргүүн эрэгтэй хүн цэргийн алба хааж, хот суурин газарт амьдрах, сонгуулийн эрхээ эдлэх эрхтэй байсан. Францын хувьсгал нь орчин үеийн ардчиллыг бүрдүүлж, цэргийн албыг зөвхөн эрчүүдэд оногдуулсан юм. Энэ нь Конгресст өгсөн сонгуулийн эрхтэй салшгүй холбоотой байв. Өнөөдөр олон оронд зөвхөн эрчүүдийг цэрэгт татдаг. Одоогийн байдлаар эрэгтэй, эмэгтэй аль алинд нь цэрэг татлагад хамрагдаж байгаа орнуудад Израиль, Малайз, Норвеги, Хойд Солонгос, Швед ордог.

Европын Холбоо 2006 оны 1-р сард ижил хүйстнүүдийн талаар хамтарсан тогтоол гарган ижил хүйстнүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг арьсны өнгөөр

ялгаварлан гадуурхахтай адилтгаж үзсэн юм. 2000 онд батлагдсан Европын Холбооны Үндсэн Эрхийн дүрмийн 21-р зүйлд бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглохыг мөн заажээ.

6. Бие махбодийн болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах:

Хүний үндсэн эрх болоод амьдрах таатай орчинг бүрдүүлэхтэй холбоотой асуудлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл зоригоос үл хамааран албадах хандлагатай байдаг. Тодруулбал: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, гүтгэлэг, амьдрах, зорчин явахтай нь холбоотой эрхийг нь зөрчсөн бүх л үйлдэл, үйл ажиллагаанууд нь хөгжлийн бэрхшээлийн улмаас нийгмийн оролцоог хязгаарласан ялгаварлан гадуурхалт юм¹. Урт хугацааны асаргаа шаардагдаж буй хүмүүс дээр гадуурхах хандлага ойр дотных нь хүмүүсээс түлхүү гардаг байна.

7. Өвчнөөр нь ялгаварлан гадуурхах байдал:

Өвчний талаар төдийлөн сайн ойлголтгүй хүмүүс бусдын өвчнөөс үүссэн гадаад төрхийн өөрчлөлтийг хараад эсвэл өвчтэй гэдгийг нь мэдсэн үедээ гадуурхах хандлага гаргадаг. Анагаах ухаан төдийлөн сайн хөгжөөгүй эрин үед өвчтөнүүдийг гаднах төрх байдал болоод халдвар авахаас эмээн хэт их ялгаварлан гадуурхах асуудал байсан. Гэхдээ өнөөдөр ч гэсэн өвчин туссан гэдэг шалтгаанаар ялгаварлан харьцах байдал хуучин

¹ 土居健郎。「日々」の構造, 1971年(昭和46年)、弘文堂、39頁。

цаг үетэй адил байгааг саяхны цар тахал буюу корона вирус авсан хүмүүсийг ялгаварлан харьцаж байсан¹ үйлдлүүдээс харж болно.

8. **Бусад ялгаварлан гадуурхалт:** Бусдыг үзэл бодол, гадаад төрх, авьяас чадвараар нь болоод тодорхой байгалийн гамшиг, бөмбөгдөлтөнд амьд үлдсэнд нь гадуурхах нь бусад ялгаварлан гадуурхалт гэдэгт багтдаг.

III. Ялгаварлан гадуурхахтай холбоотой онолын асуудал

Ялгаварлан гадуурхахыг тодорхойлох гэсэн олон удаагын оролдлого бий боловч харамсалтай нь ихэнх нь ялгаварлан гадуурхалтыг оновчтой тодорхойлж чадаагүй байна. Ялгаварлан гадуурхах нь биднийг “шударга нийгэм” гэсэн асуулт руу ороход хүргэдэг тул тодорхойлоход хэцүү. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхалтыг тэгш, шударга бус байдал гэх мэт үгсийг ашиглахгүйгээр тодорхойлсон бол бүх ялгааг ялгаварлан гадуурхалт гэсэн ойлголтонд хамруулах эрсдэлтэй бөгөөд эсрэгээр нь “тэгш” ба “шударга бус байдал” гэх зэрэг үгсийг ашиглах нь ялгаварлан гадуурхах шалгуурыг “тэгш байдал” ба “шударга бус байдал” гэсэн шалгуураар орлуулдаг нэр томъёо² болгох аюултай юм.

Саяхан ялгаварлан гадуурхалт гэдгийг субъектив тодорхойлолт болгон бэрхшээлийг даван туулах арга зам мэт гаргаж ирсэн тохиолдол ч байдаг. Тиймээс “ялгаварлан гадуурхалт гэж юу вэ” гэсэн асуулт нь өөрөө маргаантай

байгаагаараа бодит байдлыг олж харах оролдлогуудыг хийлгэж байна. Японы эрдэмтэн Казүэ Сакамото ялгаварлан гадуурхалтыг “Хэм хэмжээнээс гажсан асуудал” гэж үзээд дараах байдлаар тодорхойлжээ. Тэрээр “ялгаварлан гадуурхах нь хүмүүсийн харилцаа хоорондох хүний эрхтэй холбоотой хууль ёсны шалгуураар буруутгагдсан үйл явдал юм” гэсэн байна.

Харин өөр нэгэн хүний эрхийн төлөөх зүтгэлтэн Ёшикацү Мизүцү нь Сакамотогийн тодорхойлолтыг дэмжих байдалтайгаар гадуурхалтыг дахин тодорхойлсон юм. Тэрээр “ялгаварлан гадуурхалт нь бодит нөхцөл байдлын хэм хэмжээ болон хийсвэр хэм хэмжээний хоорондох зөрүүтэй холбоотойгоор хүний эрхийн зөрчил болсон асуудлыг хэлнэ” гэжээ.

“Ялгаварлан гадуурхалт гэж юу вэ” гэсэн маргаантай байгаа асуудлыг яллах дүгнэлтийг хүлээн авах эсвэл няцаах үйл явцыг шинжлэх урьдчилсан нөхцөл мэтээр тайлбарлах нь бий. Түүнчлэн ялгаварлан гадуурхах асуудал нь бусдыг гэмгүй байхад нь яллах дээр үндэслэгддэг гэсэн ойлголтыг хүлээн авснаар ялгаварлан гадуурхалтын тухай бараг бүх яриа яллах гэсэн ойлголт дээр тулгуурладаг.

Яллах гэсэн ойлголтын талаар арай илүү дэлгэрэнгүй авч үзвэл хоёр хүний хоорондын харилцаанд нэгнээ буруутгах байдлаар тэгш бус байдлыг бий болгохын тулд хэм хэмжээний дагуу шударга бусаар харьцаж байгаа нь нэг талаасаа “ял” гэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхсан этгээд нь яллагдагч гэсэн үг. Энэ ойлголт цаашлаад “эрүүгийн яллагдагч” гэх ойлголттой холбогдох бөгөөд ялгаварлан гадуурхах

¹ 田南さよ、日本財団ジャーナル編集部、恐れるべきはウイルスで人ではない。社会をむしばむ「コロナ差別」をなくすためには、2020.

² 江原由美子、女性解放という思想、勁草書房、1985年.

ярианаас үндэс суурьтай хүний эрхийг зөрчил нь гэмт хэргийн шинжтэй болох тохиолдол ч бий.

Онолын хувьд хүний эрхийн томоохон зөрчил болох ялгаварлан гадуурхах үйлдлийг хүчирхийлэл гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхах нь буруу үзэл суртал, итгэл үнэмшил эсвэл ялгаварлан гадуурхсан хүний санаатай үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой байдаг. Энгийнээр авч үзвэл ялгаварлан гадуурхах нь хүчирхийлэл үйлдэж буй хэлбэр гэж хэлж болно. Өрөөсгөл буруу ойлголттой хүн түрэмгий аашилдаг гэсэн ойлголтыг огт үндэслэлгүй гэж хэлэмгүй¹. Гэхдээ ялгаварлан гадуурхалттай холбоотой бүх нөхцөл байдлыг ухамсраар тайлбарлахыг оролдох нь туйлын нэг талыг барьсан асуудал бөгөөд өргөжүүлэн тайлбарлах нь энэ төрлийн хүний эрхийг зөрчлийн хүрээ хязгаарыг зөв тогтооход чухал ач холбогдолтой. Тиймээс хүчирхийллийн нэг хэлбэл дотор ялгаварлан гадуурхалт зүй ёсоор багтдаг төдийгүй илрэн гарч буй хэлбэр нь өөр байдаг.

Онолын өөр нэгэн түвшинд "гэнэн" сэтгэлгээтэй ялгаварлан гадуурхалтыг холбож байгаа төдийгүй хүмүүс хоорондын харилцаанд онцгойлон авч үзэхээсээ илүү өнгөрсөнд нь орхих тухай яригддаг². Энэ нь гадуурхалтыг талаарх ойлголт нэгдсэн байдлаар хүлээн зөвшөөрөгдөөгүй, өргөн тархаагүй учраас ялгаварлан гадуурхах асуудлыг бодит байдалд найдах замаар орхигдуулах асуудал бий болгодог.

Хэрэв хор хөнөөл нь ялгаварлан

гадуурхах үйлдлийг тодорхойлж чадахгүй бол ялгаварлан гадуурхах үйлдлийг зөвхөн гадуурхсан үйлдэл, эс үйлдэхүйтэй холбон нотлох замаар тодорхойлж болно гэж үзэх талтай. Энэ тохиолдолд ялгаварлан гадуурхсан үйлдэл, эс үйлдэхүй нь шударга бус байсан гэдгээрээ ялгаварлан гадуурхалттай шууд болон шууд бусаар холбогдсон болох нь нотлогдох ёстой.

Гэсэн хэдий ч нотолгоо гаргах тийм ч амар биш. Шууд бус нөлөөллийг тайлбарлахын тулд бид хийсвэр ойлголттой нүүр тулахаас гадна зарим тохиолдолд ялгаварлан гадуурхах ухамсарыг тодорхойлохоос өөр аргагүй болно. Ялгаварлан гадуурхах онол³ нь ялгаварлан гадуурхах бодит байдалд тулгуурладаг тул дээрх шууд болон шууд бусаар ялгаварлаж байгаа асуудлыг хариуцлагад татах үндэслэл үгүйсгэгдэх талтай.

Тэгэхээр гадуурхалтанд өртсөн гэх нотолгоог хэрхэн хийдэг вэ? Нотолгооны гол арга бол "доройтлын баталгаа" юм. Энэ нь ялгаварлан гадуурхагдсан хувь хүн, бүлэг хүмүүс нь хүнд байдалд байгаа, ирээдүй цаг дээр яригдах боломжтой байсан үр дүн болоод одоо байгаа нөхцөл хоёрын хооронд ялгаа гарсан цаашлаад гадуурхалт үргэлжилсэн гэдгээр нотлогдон тогтоогддог. Дээрх аргыг хүнийг эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зөв дүгнэн тайлбарлахад ашигладаг. Тиймээс хууль ёсны нотолгоо нь шударга бус нотолгоог үгүйсгэж тодорхой ойлголтыг нэг мөр болгоход дөхөм үзүүлдэг. Судлаач Сакамотогийн үзэж байгаагаар "шударга бус нотолгоо" нь хэм хэмжээ дэх зарим төрлийн буруу ойлголтыг илрүүлж нээх үүрэг хүлээдэг.

¹ Baert, S., Norga, J., Thuy, Y., Van Hecke, M. (In press) Getting Grey Hairs in the Labour Market: An Alternative Experiment on Age Discrimination.

² 江原由美子, 『差別の論理とその批判』, 女性解放という思想, 1985, 61頁.

³ 差別論.

Өөрөөр хэлбэл тэгш эрхийн хэм хэмжээ байдаг боловч тогтолцооны хэм хэмжээ байдаггүйтай холбоотойгоор хоосон зайг нөхөх үүргийг шударга бус нотолгоо хүлээдэг гэжээ.

IV. Дэлхий ертөнцөөс ялгаварлан гадуурхахыг арилгах тухай гэрээ буюу эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ шаардлага

Ялгаварлан гадуурхах явдлыг арилгах тухай конвенцыг дэлхийн өнцөг булан бүрт ялгаварлан гадуурхах явдлыг арилгах зорилгоор 1965 онд НҮБ-ын Ерөнхий ассемблейд батласан. Албан ёсны нэр нь "Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц"¹ бөгөөд арьсны өнгөөр болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг арилгах олон талт гэрээ юм. Энэхүү гэрээ нь арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах байдал гэж юу болохыг дараах байдлаар тодорхойлсон болно. Арьс үндсээр алагчлах гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэсний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу дээрд үзэхийг хэлнэ"² гэжээ. Нөгөө талаасаа дээрх конвенц нь дэлхийн өнцөг булан бүрт ялгаварлан гадуурхах үзлийг арилгах, ялгаварлан гадуурхах байдлыг гаргуулахгүй байх тухай оролцогч улсуудын үүрэг, амлалтын эмхэтгэл гэж ойлгож болно.

Монгол Улсын хувьд дээрх

конвенцид нэгдэн орсон бөгөөд олон хууль тогтоомжийг нийцүүлэн гаргасан гэж хэлж болно. Гэвч бодит хэрэгжилтийн асуудал дээрх анхаарах зүйлс цөөнгүй. Түүнчлэн ялгаварлан гадуурхалтыг хязгаарлах болоод урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүссэн гэж үзэж байна. Сүүлийн жилүүдэд гадаадын иргэдийг илт ялгаварлан гадуурхах байдал нэмэгдэж байгаа нь хүний эрхийг ноцтой зөрчил болж байгаас гадна Монгол Улсын нэр хүндийг Олон улсын хэмжээнд унагаах шалтгаан болж байгаа юм. Япон улсын хувьд дээрх асуудлыг шийдэхийн тулд **Японд ирсэн гадаадын иргэдийн эсрэг шударга бусаар ялгаварлан гадуурхсан үг, зан үйлийг арилгах, түүнийг сурталчлах тухай хууль**³ батлан гаргасан бөгөөд энэхүү хууль нь Япон улсад сүүлийн жилүүдэд хууль ёсны дагуу оршин суугч хүмүүс эсвэл тэдний үр удмыг гадуурхах, иргэний эрхийг нь хасах шударга бус ялгаварлан гадуурхалт газар авснаас үүдэн батлагджээ. Үг, үйлдлээр сэтгэл зүйн зовлон шаналал учруулж, түүнчлэн нийгэм дэх ноцтой хагарал гарах эрсдэл байгааг анхаарч дээрх хуулийг хэрэгжүүлэх болсон.

Шударга бус ялгаварлан гадуурхах үйлдлийг зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэж байгаагаа Япон улсын хүний эрхийн холбогдох байгууллагуудын саналаар парламент нь **Японд ирсэн гадаадын иргэдийн эсрэг шударга бусаар ялгаварлан гадуурхсан үг, зан үйлийг арилгах, түүнийг сурталчлах тухай хуулийг** баталж цаашдаа хүний эрхийн боловсрол, хүний эрхэнд хүндэтгэлтэй хандах байдлыг нэмэгдүүлж, соён

¹ International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination.

² Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц. 1965 он.

³ 本邦外出身者に対する不当な差別的言動の解消に向けた取組の推進に関する法律.

гэгээрүүлэх замаар олон нийтэд мэдээлэл өгч, сургалт зохин байгуулан хүмүүс хоорондын ойлголцол, хамтын ажиллагааг идэвхжүүлэн асуудлыг шийдвэрлэхийг Япон улсын хүний эрхийн байгууллагууд болоод холбогдох төрийн байгууллагууд анхааран ажиллаж байна.

Түүнчлэн Япон улс **Хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хууль**¹ баталсан нь тодорхой бүлгийн эрх зөрчигдөж байгаад анхаарч асуудалд хандсан чухал эрх зүйн баримт гэж үзэх үндэслэлтэй юм. Монгол улсын **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль**² тогтоомж нь дээрх Япон улсын хуулийн нэгэн адил агуулга зорилготой юм.

Гэхдээ Япон улсын Хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуулинд манай хуулийн агуулгад ороогүй зохицуулалт бий. Өөрөөр хэлбэл дээрх хуулинд “Хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгаварлан гадуурхах” нь хоёр хэлбэртэй гэж үзжээ.

- a. Хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах, хязгаарлах, болзол тогтоох үйлдэл.
- b. Хууль ёсны хувьд авах арга хэмжээнүүдийг авахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэн үзэхгүйгээр хүсэл зоригийнх нь болоод боломжит чадварт нь нийцүүлэхгүйгээр үйлчилгээг үзүүлсэн болоод үзүүлээгүй үйлдэл.

Монгол улсын **Хөгжлийн**

бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд ялгаварлан гадуурхах үйлдлийг тодорхой байдлаар нарийвчлан зохицуулж оруулах нь хууль зүйн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад хөдөө орон нутаг, хот суурин газрын иргэд гэсэн ялгаварлал бий болж нэгнээ гадуурхах асуудал газар авч үл ойлголцол болоод хүмүүсийн хоорондын харилцаанд хүний эрхийг үл хүндэтгэх асуудлыг дэвэргэх нь тулгамдаж буй асуудлын нэг болж байна. Япон улсад манай улстай адил асуудал гарч эхэлсэн тул 2008 онд **Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хууль**³ баталсан байдаг. Энэхүү хууль нь Үндсэн хуулийн хүний эрхийн зохицуулалтыг баталгаажуулах, ялгаварлан гадуурхалтыг үл хүлээн зөвшөөрч хүний эрхийг хамгаалах зорилготой батлагдсан юм. Дээрх хууль нь нэгдмэл засаг захиргааны бодлого, хүн амын дундах ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээг дэмжих байдлаар иргэдийнхээ үндсэн эрхээ эдлэх эрхийг нь баталгаажуулж өгч байгаа юм.

Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуулийн Улсын болон орон нутгийн засаг захиргааны үүрэг⁴ гэсэн 3 дугаар зүйлд: Бүс нутгийг болоод иргэдийг нь ялгаварлан гадуурхах явдлыг арилгах арга хэмжээ авах, орон нутгийн засаг захиргааны хэрэгжүүлж буй бүс нутгаар ялгаварлан гадуурхахыг арилгах арга хэмжээг сурталчлахад шаардлагатай мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх

¹ 障害を理由とする差別の解消の推進に関する法律.

² Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. 2016 он.

³ 部落差別の解消の推進に関する法律.

⁴ 部落差別の解消の推進に関する法律- 国及び地方公共団体の責務. 第三条.

үүрэгтэй гэж оруулж өгсөн нь чухал ач холбогдолтой заалт болжээ. Манай улсын хувьд ч дээрх хуулийн нэгэн адил бүс нутгаар ялгаварлан гадуурхах байдлыг арилгах эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй хийх шаардлагатай гэж үзэж байна. Учир нь цөөн хүн амтай, өргөн газар нутагтай Монгол улсын хувьд үндэсний эв нэгдэл нь хамгийн чухал тусгаар тогтнолын баталгаа юм.

Бүс нутгаар ялгаварлан гадуурхах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд анхаарч шийдвэрлэх арга замыг хайж байгааг илтгэх өөр нэг жишээ бол **Бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай Японы улсын Нара мужийн захирамж**¹ юм. Энэхүү захирамжаар бүс нутгийн ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээний талаар баримтлах үндсэн бодлогыг гаргах талаар тусгаж өгсөн бөгөөд ялгаварлан гадуурхлыг арилгах талаар мужаас системтэйгээр авах арга хэмжээг чухалчилж тусгасан байна. Захирамжын дагуу Засаг дарга бүс нутгаар ялгаварлан гадуурхахыг багасгах, халах тухай үндсэн төлөвлөгөөг батлуулах бөгөөд Нара мужийн хүний эрхийн зөвлөлтэй зөвшилцөн баримталж буй бодлогыг нь тусгах үүрэгтэй. Засаг дарга үндсэн төлөвлөгөө гаргасны дараа түүнийгээ олон нийтэд мэдээлж сурталчлах давхар үүрэг хүлээдэг.

Монгол улсын хувьд аймаг, нийслэлд дээрхтэй адил захирамж гарган хэрэгжүүлэхдээ Хүний эрхийн үндэсний комиссын заавар зөвлөгөө болоод бодлогыг тусгаж явах нь ялгаварлан гадуурхалтын эсрэг үр дүнтэй ажил болох боломжтой бөгөөд иргэдийн хүний эрхийн тухай ойлголтыг нэмэгдүүлээд зогсохгүй хүний эрхийн

мэдрэмжтэй болоход чухал нөлөө үзүүлж чадна гэж үзэж байна.

V. Ялгаварлан гадуурхалтыг бий болгож буй гол шалтгаанууд болоод урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүмүүсийн харилцаанд цахим интернэт дэх хүрээ өргөжиж, харилцаа илүү хялбар болохын зэрэгцээ бусдыг гүтгэх, хувь хүний нэр төр, хувийн нууцад халдах, ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхах явдлыг сурталчлах мэдээлэл ихэсч байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд кибер дээрэм, өшөө авалтын тоо өсөж байгаа бөгөөд хүний ялгаварлан гадуурхсан мэдээлэл интернэтэд цацагдсаны дараа хурдан тархаж, бүрэн арилгахад амаргүй болдог тул олон хүний эрх зөрчигдөж нэр төр, алдар хүнд нь сэргээгдэхгүйгээр унах эрсдэл дагуулсаар байгаа нь энэ төрлийн ялгаварлан гадуурхалтын асуудлыг зохицуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа юм.

Хувь хүмүүсийн нэр төр, хувийн нууцыг хүндэтгэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, ёс суртахууны талаарх зөв ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай хэрэгцээ өнөө үед бий болжээ. Цахим орчинд хүмүүстэй харилцаанд орохдоо хүнтэй шууд харьцахтай адил дүрэм, ёс суртахууныг дагаж, нөгөө хүнийхээ хүний эрхийг хүндэтгэх нь чухал юм. Хэдийгээр нэгнийхээ царайг харж чадахгүй байсан ч гэсэн интернэтэд холбогдсон хүн бол зүрх сэтгэлтэй амьд хүн гэдгийг санах хэрэгтэй.

Өнөөгийн цаг үед доорх асуудлууд ялгаварлан гадуурхах гол шалтгаан нөхцөл болж байна. Тиймээс доорх агуулга бүхий асуудлуудыг хэрхэн

¹ 奈良県差別差別的解消の推進に関する条例.

харилцаандаа анхаарч байхаас шалтгаалан ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ гэж ойлгох нь зүйтэй.

1. Хаана төрж өссөн байгаагаар нь ялгаварлах
2. Амьдарч буй газар, орчин нөхцөлөөр нь ялгаварлах
3. Гэр бүлийн байдал, гэр бүлийнхний олж авсан боловсролоор нь ялгаварлах
4. Гэр бүлийн хөрөнгө чинээгээр нь ялгаварлах
5. Үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүндэлдэг хүмүүсээр нь ялгаварлах
6. Дэмжиж буй улс төрийн үзэл бодол, байр сууриар нь ялгаварлах
7. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь ялгаварлах¹

1. Хаана төрж өссөн байгаагаар нь ялгаварлах гадуурхах байдлыг багасгах цаашлаад үгүй болгохын тулд дараах асуултуудыг бусдад тавихгүй байхыг чухалчилж байна. Өөрөөр хэлбэл хүний эрхийг хамгаалах эхний алхам бол асуултаа хүнд хэрхэн тавих, харилцан яриан дээр юуг анхаарахаас эхэлнэ.

- ▶ Та хаана төрсөн бэ.
- ▶ Та төрсөн цагаасаа хойш одоог хүртэл хаана амьдарч ирсэн бэ.
- ▶ Та энд ирэхээсээ өмнө хаана амьдарч байсан бэ.

Дээрх асуултууд нь ялгаварлан гадуурхаж болзошгүй байдлыг бий болгох бөгөөд шударгаар үнэлүүлэхгүй

байх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй гэж үздэг.

2. Амьдарч буй газар, орчин нөхцөлөөр нь ялгаварлах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуултууд.

- ▶ Ямар орчинд та амьдарч байна вэ.
- ▶ Гэр тань төв замтай хэр ойр вэ.

3. Гэр бүлийн байдал, гэр бүлийн олж авсан боловсролоор нь ялгаварлах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуултууд.

- ▶ Ам бүл хэдүүлээ вэ.
- ▶ Таны аав, ээж ямар компанид ажилладаг вэ.
- ▶ Таны ажилдаг газрын нэр юу вэ.
- ▶ Танай гэр бүлийн бизнес юу вэ.
- ▶ Танай гэр бүлийнхэн ямар мэргэжилтэй вэ.
- ▶ Таны гэр бүлийн орлого хэд вэ.
- ▶ Таны эцэг эх хамт ажилладаг уу.
- ▶ Хэн таны сургалтын төлбөрийг төлдөг вэ.
- ▶ Таны эцэг эх хоёулаа байдаг уу.
- ▶ Нас барсан үхлийн шалтгаан юу вэ.

4. Гэр бүлийн хөрөнгө чинээгээр нь ялгаварлах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуултууд.

- ▶ Танайх ямар байшинд амьдардаг вэ.
- ▶ Таны байшин эсвэл газар хувийн өмч үү, эсвэл түрээсэлсэн үү.
- ▶ Та хэчнээн үл хөдлөх хөрөнгөтэй вэ.

Яагаад дээрх асуултуудыг тавих ёсгүй вэ?. Хувь хүний ур чадварыг харгалзан үнэлэлт хийхийн оронд дээрх хариуцлагагүй асуултуудаар дүгнэлт хийх байдал нийтлэг бий. Энэ

¹ 豊中市、就職差別は重大な人権問題です。

нь орчин үеийн нийгмийг хуваагдмал байдалтайгаар хүний эрхийг зөрчсөн ялгаварлан гадуурхалт тархах хөрс суурь нь болж өгч байна. Ялгаварлан гадууралт нь сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхийг хязгаарлахаас гадна эрх тэгш боломжийг зөрчих аюул дагуулдаг. Орон сууцны орчин, амьдарч буй газрын нөхцөл байдлыг сонсох нь эргээд тухайн бүс нутгийн амьжиргааны түвшинг үнэлэх эхлэл болдог бөгөөд субъектив шүүлт урьдчилсан байдлаар бий болгодог сул талтай. Дээрх асуудал нь хувь хүний хүчин чармайлтаар шийдэгдэхгүй зөвхөн объектив байдлаар субъектив дүгнэлт хийх нөхцөл байдалд оруулж байгаа юм.

5. Үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүндэлдэг хүмүүс, улс төрийн үзэл бодол, байр сууриар нь ялгаварлах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуултууд.

- ▶ Та ямар итгэл үнэмшилтэй вэ.
- ▶ Таны гэр бүлийн шашин шүтлэг юу вэ.
- ▶ Та ямар бурхан шүтдэг вэ.
- ▶ Та ямар улс төрч болоод улс төрийн намуудыг дэмждэг вэ.
- ▶ Хүндэлж явдаг хүн тань хэн бэ.

Бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, тэднийг дэмждэг улс төрийн намууд, амьдралыг үзэх үзэл нь Үндсэн хуулиар баталгаажсан хувь хүний эрх, эрх чөлөөний асуудал юм. Мөн шашин шүтэх нь үзэл бодол, итгэл үнэмшилд хамаардаг¹. Ажилд авах сонгон шалгаруулалтад ороход дээрх асуултууд тавьсан тохиолдолд хүний үндсэн эрхийг зөрчиж байгаа тул эрс татгалзаж хариулахгүй байх эрхтэй. Хүний бодол

санаа, итгэл үнэмшил, шашин шүтлэгтэй холбоотой асуултуудыг шууд асуухаас гадна шууд бусаар янз бүрийн хэлбэрийн асуух нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг мөн.

6. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь ялгаварлах шалтгааныг бий болгох эрсдэлтэй асуултууд.

- ▶ Гэрлэсний дараа эсвэл төрсний дараа үргэлжлүүлэн ажиллах бодолтой байна уу. (зөвхөн эмэгтэйчүүдийн хувьд)
- ▶ Манайд цөөн тооны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд) байдаг. Энэ ажил удаан хугацаанд үргэлжлүүлэн хийх боломжтой ажил биш боловч та компанид ажиллахыг хүсч байна уу.
- ▶ Илүү цагаар ажиллах боломжтой юу.

Эмэгтэй, эрэгтэй гэсэн хүйс дээр үндэслэсэн асуултууд нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль болоод бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг зөрчсөн хэрэг бөгөөд хүний эрхийг тэгш бусаар ялгаварлан гадуурхаж буй хэлбэр мөн. Цаашлаад өөр бусад эрх, эрх чөлөөг зөрчих эхлэл дээрх асуултуудын агуулгад багтаж байгаа болно. Жендэрийн үндэслэлээр гадуурхах шалтгааны эхлэл нь дээрх асуултуудтай шууд холбоотой байдаг.

Хүний эрхийн асуудлыг анхаарч, хүний үндсэн эрхийг чухалчилж ажиллаж чаддаг, хамтран хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг зохион байгуулдаг байгууллага хамт олны хүрээ хязгаарыг тэлэхэд дээрх хүний эрхийг зөрчих эрсдэл дагуулж буй асуултууд чухал ач холбогдолтой суурь ойлголтуудыг өгч чадах юм.

Хүний эрхийг хүндэтгэж ялгаварлан

¹ “先明看護学校の学童訪問”. 日本障害者リハビリテーション協会. 2017年8月20日閲覧.

гадуурхахгүй байхтай холбоотой доорх гурван зүйлийг чухалчилж үзэх хэрэгтэй байна.

- a. Хүнийг байгаар нь хүн гэж хүлээж авах. Энэ цаашлаад хүмүүсийг хүндэтгэх, бусдын бодол санааг хүндэтгэх өөрөөр хэлбэл хүний үндсэн эрхийг хүндэтгэх явдал юм.
- b. Хувь хүний ур чадварыг нь харгалзан үнэлж үздэг байх.
- c. Хүн бүрт адил тэгш боломжийг олгох.

Дүгнэлт

Хүнийг эрхийг зөрчиж ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхахад хүргэж байгаа асуудлыг зогсоохын тулд хүн бүр дор бүрнээ үг, үйлдлээ хэн нэгнээс гэхээсээ илүү өөрөөсөө эхлэн хянаж байх нь чухал юм. Ялгаварлан гадуурхсан шинжтэй үг, үйлдэл нь хүний эрхийг томоохон зөрчилд хүргэдэг.

Ялгаварлан гадуурхалт нь ямар хор хөнөөлтэй гэдгийн өнөөгийн цагт корона вирусын халдвартай холбож тайлбарлах боломжтой. Халдвар авсан хүмүүст гадуурхалт мэдрэгдэж эхлэх үед олон хүмүүс шинжилгээнд хамрагдахаас зайлсхийх эсвэл халдвараа нуухыг хичээдэг тул халдварын тархалтыг хянахад бэрхшээлтэй болгож байна. Ямар ч хэлбэрийн ялгаварлан гадуурхалт нь хүний нийгмийн хэвийн хэмнэлийг алдагдуулаад зогсохгүй дорд үзэх явдал газар авч улс төр, эдийн засаг, гэр бүл, нийгмийн хүрээнд сөрөг нөлөөлөл даамжрах аюултай. Цөөн хүн амтай улсын хувьд эв нэгдэл алдагдаж, соёлоо хэвээр хадгалж үлдэх боломж хүртэл багасах эрсдэл ялгаварлан гадуурхалтаас үүдэн бий болдог.

Тиймээс ялгаварлан гадуурхалтыг үгүй хийхийн тулд эхний ээлжинд бүх шатны боловсролын байгууллага болон

мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудад хүний эрхийн талаар сайн хөтөлбөр боловсруулан сургалт оруулах хэрэгтэйгээс гадна ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах талаар сурталчилж таниулах нь шаардлагатай байна.

Нийгмээс ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд тууштай хичээл зүтгэл, тодорхой үйл ажиллагаануудыг тэс дараалалтай авах нь нэн чухлаар тавигдах ёстой. Учир нь өнөөдөр ялгаварлан гадуурхалтанд өртөж үндсэн эрх нь зөрчигдөн шаналж байгаа хүмүүс, хүүхдүүд олон байна. Энэхүү нийтлэлдээ ялгаварлан гадуурхалтын эсрэг нийгмийн сэтгэлзүйн асуудлыг хөндсөн төдийгүй ялгаварлан гадуурхалт нь онолын хувьд ямар агуулга илэрхийлдэг болохыг тайлбарыг хичээж хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тодорхой харилцаанд гарч буй хүндрэлийг арилгахад эрх зүйн хүрээнд болоод хүмүүс хоорондын харилцаанд юуг хэрхэн анхаарахыг тусгаж оруулсан болно.

Ном зүй

I. Монгол эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011 он.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. 2016 он.
4. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц. 1965 он.

II. Гадаад эх сурвалж

1. Amnesty International. What drives discrimination and how do we stop it?. 2020.
2. Baert, S., Norga, J., Thuy, Y., Van Hecke, M. (In press) Getting Grey Hairs in the Labour Market: An Alternative Experiment on Age Discrimination.
3. 部落差別の解消の推進に関する法律.
4. 部落差別の解消の推進に関する法律. 国及び地方公共団体の責務. 第三条.
5. 奈良県部落差別の解消の推進に関する条例.
6. 本邦外出身者に対する不当な差別的言動の解消に向けた取組の推進に関する法律.
7. 障害を理由とする差別の解消の推進に関する法律.
8. チベット人権・民主センター. チベットでの中国の存在と人権の侵害. 1997年.
9. 内藤準. 会現象の規範的概念化に関する一つの考察. 33頁.
10. 社会科学大事典18. 鹿島研究所出版会. 332頁.
11. 性差別と暴力—続・性の法律学. 角田由紀子 有斐閣選書.
12. 土居健郎. 「甘え」の構造. 1971年. 39頁.

13. 田南さん. 日本財団ジャーナル編集部. 恐れるべきはウイルスで人ではない。社会をむしばむ「コロナ差別」をなくすためには. 2020年.
14. 江原由美子. 女性解放という思想. 勁草書房. 1985年.
15. 江原由美子. 差別の論理. とその批判. 女性解放という思想. 1985年. 61頁.
16. “光明養護学校の学童疎開”. 日本障害者リハビリテーション協会. 2017年8月20日閲覧.



ОРЧУУЛГА

ТӨРИЙН ЭРҮҮГИЙН БОДЛОГО

ОХУ-ын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор А.В.Бриллиантова хянан тохинуулсан "ОХУ-ын Эрүүгийн эрх зүй" номоос орчуулав.



*Орчуулсан: Шихихутуг их сургуулийн
Практик судлалын тэнхимийн эрхлэгч
Т.Сүхбаатар*

Онцлохуй нь:

Монгол Улс Эрүүгийн хуулиасаа 2015 он гэмт хэргийн захиалагч, гэмт бүлэглэл, гэсэн ойлголтуудыг хассан, хэргийн ангиллыг 2 болгож өөрчилсөн, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэгдсэн ойлголтгүйгээр практик хэрэглэж байгаа зэрэг нь гэмт явдалтай хийх тэмцэлд сөрөг нөлөө үзүүлж болохоор байх тул Төрийн эрүүгийн бодлогыг шинэчлэн боловсруулах шаардлагтайг харгалзан энэхүү сэдвийг орчуулж уншигч танаа хүргүүлж байна.

1. Ойлголт, зорилго, шинж, зарчмууд

Улс төрийн бодлого гэдэг бол төрийг удирдах урлаг. Улс төрийн бодлого нь төрөөс нийгмийн амьдралын аль нэг салбарыг удирдах чиг үүргийг илэрхийлдэг. Хүний нийгэм үүссэн тэр цагаас эхлээд нийгэмд үүссэн

аливаа харилцааг зан үйлийн тодорхой хэм хэмжээний тусламжтайгаар зохицуулахыг хичээж ирсэн. Эхэн үедээ уламжлалын болон **зан заншлын** хэм хэмжээг ашиглаж байсан бол сүүлдээ ёс зүйн болон шашны зан үйлийн хэм хэмжээг ашиглах болсон. Төр үүсэн тэр цагаас нийгмийн харилцааны гол зохицуулагч нь эрх зүйн хэм хэмжээ болсон.

Эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдсөн бүхий л үзэгдэл, үйлдлийг нийгэм сөргөөр хүлээн авдаг. Учир нь эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн бүхий л үзэгдэл, үйлдэл нь нийгмийн харилцааны хэвийн нөхцөл байдлыг зөрчиж нийгмийн харилцаанд нэгэнтээ бүрэлдэн тогтсон системийг эвдэж нураагддаг.

Үүнтэй холбоотойгоор нийгмийн үйл ажиллагааны зонхилох хэсэг нь дээрх байдалтай тэмцэл хийхэд хүргэсэн бөгөөд дараа нь төр өөрийн түүхийн бүхий л үедээ үүнтэй тэмцэл хийх болсон. Гэмт явдлыг төр болон нийгэмд аюултай, сөрөг үзэгдлүүдийн нэг гэж үзэх болсон. Яагаад гэвэл гэмт явдал нь нийгмийн харилцаанд ноцтой хор хохирол учруулах болсон. Төр, нийгмийн харилцаанд учирч буй хохирлыг багасгах зорилгоор **нийгмийн, эрх зүйн, зохион байгуулалтын болон техникийн шинжтэй** иж бүрэн арга хэмжээг боловсруулахад хүрсэн. Криминологийн шинжлэх ухааны үүднээс гэмт явдалтай хийх тэмцэл нь

нийтлэг болон тусгай арга хэмжээний тусламжтайгаар хэрэгжих болсон.

Төрийн эрүүгийн бодлого нь гэмт явдалтай тусгай арга хэрэгслээр хийх тэмцэлд хамаарна. Хууль хамгаалах байгууллагууд (прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, нийгмийн хэв журам хамгаалах алба, гааль, татварын байгууллага, Дотоод явдлын яам, холбооны аюулгүй байдлын алба болон бусад байгууллагууд) голлон тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

Энэ бүх ажил нь ОХУ-ын Үндсэн хууль, Эрүүгийн хуулийн үндсэн дээр ОХУ-ын Эрүүгийн процессын хууль тогтоомжоор тодорхойлогдсон нөхцөл байдлыг нарийн чанд сахиж мөрдсөн хүрээ, хязгаарын дотор хэрэгжинэ.

Гэмт явдалтай хийх тэмцэл нь төрийн бодлогын хүндхэн хэсгийн нэг бөгөөд ихэнхдээ амжилт олох эсэх нь төрийн дотоод, гадаад бодлогын ерөнхий чиг үүргээс шалтгаална.

Түүнээс гадна гэмт явдлыг бууруулах төрийн бодлогын бүхий л төвөг бэрхшээлийг үл харгалзан төрөөс авч хэрэгжүүлж буй цогц арга хэмжээ, төрөөс гэмт явдалтай тэмцэх талаар явуулж буй тусгайлсан үйл ажиллагааг хууль зүйн ном зохиолд "Төрийн эрүүгийн бодлого" хэмээн нэрлэж заншсан байна.

Төрийн эрүүгийн бодлогын нөлөөллийн **объект нь**; эрүүгийн ял шийтгэл хүлээх, хууль зөрчсөн бүх үйлдэл, эс үйлдлийн нийлбэр цогц болох **гэмт явдал**, мөн чанарын болон тоон үзүүлэлтийг багтаасан, нийтийг

хамарсан, нийгэм-эрх зүйн **сөрөг үзэгдлүүд** болох нь ойлгомжтой байна.¹

Гэмт явдлын эсрэг Эрүүгийн хуулийг үндэслэн төрөөс тусгайлан авч хэрэгжүүлж буй арга хэмжээг "Төрийн эрүүгийн бодлого" хэмээн тодорхойлж болно.

Эрүүгийн бодлогын агуулга; гэмт явдлын эсрэг төрөөс явуулж буй үйл ажиллагааны зорилго, чиглэл, удирдлага, арга хэлбэр, хяналт, шалгалтаар тодорхойлогдоно.

ОХУ-ын Үндсэн хуулийн 80 дугаар зүйлд; ОХУ-ын ерөнхийлөгч төрийн дотоод, гадаад бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлно гэж заасан тул Эрүүгийн бодлогын **субъект нь** юуны өмнө ОХУ-ын ерөнхийлөгч байна.

Гэмт явдлын эсрэг чиглэсэн арга хэмжээг шууд авч хэрэгжүүлдэг албан газар, байгууллагууд болон хууль хамгаалах байгууллагууд эрүүгийн бодлогын **объект** болно. Төр эдгээр байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, гэмт явдалтай идэвхтэй тэмцэл явуулдаг.

Эрүүгийн бодлогын шинжүүд:

1. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх. Эрүүгийн бодлогын зорилго, үндсэн чиглэл, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө мөнгийг тодорхойлохдоо философи, социологи, криминологи, сэтгэл судлал, угсаатны зүй зэрэг шинжлэх ухааны ололт амжилтыг үндэслэл болгоно. Эрүүгийн бодлогын **хөтөлбөрийг** боловсруулахдаа гэмт явдлын нөхцөл байдал, бүтэц, түвшин, шалтгаан нөхцөл, цаашдын чиг

¹ Энциклопедический юридический словарь. Под общ. ред. В. Е. Крутских. 2-е изд. М. 1999. С. 256

хандлагыг харгалзан үзэх нь зүйтэй.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзснээр гэмт явдлын тоон үзүүлэлт, бүтцийн өөрчлөлт, ялангуяа нийт гэмт хэрэгт **хүнд, онц хүнд гэмт хэргийн** эзлэх хувийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

Шинжлэх ухааны үндэслэл нь эрүүгийн бодлогыг үр дүнтэй болгоод зогсохгүй гэмт явдалтай хийх тэмцэлд төрд байгаа хүчтэй зэвсэг болдог.

2. Эрүүгийн бодлого нийгмийн нөхцөл шалтгаанд үндэслэгдсэн байх. Эрүүгийн бодлого үр өгөөжгүй байх нь тухайн бодлогыг хэрэгжүүлэхдээ нийгмийн хүчин зүйлс, механизмыг харгалзан үзээгүйтэй холбоотой. Эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэхдээ нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийг заавал харгалзан үзсэн байх ёстой.

3. Эрүүгийн бодлогын үндсэн зорилго нь гэмт явдлыг хамгийн бага, боломжит түвшин хүртэл бууруулах явдал. Одоогоос хэдэн жилийн өмнө төр эрүүгийн бодлогын хүрээнд гэмт явдлыг бүрэн устгана гэсэн өөр зорилт дэвшүүлж байсан бол өнөө цагт энэ зорилгыг хэрэгжүүлэх боломжгүй нь тодорхой болсон. Нийгмийн хөгжлийн өнөөгийн үе шатанд үнэхээр эрүүгийн бодлогын үр дүнгийн зэрэглэл нь зөвхөн эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход бус хувь хүний эрх зүйн танин мэдэхүйн түвшингээр тодорхойлогдож байна.

Хуулийг сахиж мөрддөг иргэдийн олонх нь гэмт хэрэг үйлддэггүй, эрүүгийн хариуцлагад өртөнө гэж айж эмээдэггүй тул хууль бус үйлдэлд өртдөггүй. Түүнээс

гадна өөр бусад хүмүүсийн хууль бус, зан төлвөөс шалтгаалж гарцаагүй байдалд гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл байдал амьдралд олонтоо тохиолддог. Эдгээр асуудлыг зөвхөн төрийн эрүүгийн бодлогын хүчээр шийдвэрлэхэд бэрхшээл тулгардаг тул тэдгээрийг шийдвэрлэхэд төрийн дотоод, гадаад бодлогын бусад элементүүд, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны иж бүрэн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай.

4. Төрөөс явуулж буй үйл ажиллагаа нь гагцхүү агуулгаараа гэмт явдалтай тэмцэхэд чиглэгдсэн байх.

Дээр дурдсан шинжүүдийг нэгтгэн дүгнэж үзвэл **“Төрийн эрүүгийн бодлого гэдэг нь** гэмт явдлын түвшинг бууруулах, гэмт явдал улс орны хөгжлийн тухайн үе шатанд хамгийн бага хэмжээгээр сөргөөр нөлөөлөх тийм түвшинд хүргэж чадах шинжлэх ухааны үндэслэл бүхий гэмт явдалд нөлөөлж буй нийгмийн шалтгаан нөхцөлийг харгалзан үзсэний үндсэн дээр төрөөс явуулж буй үйл ажиллагаа юм” гэж тодорхойлж болохоор байна.

Төрийн эрүүгийн бодлогын үр дүн зөвхөн гэмт хэргийн гаралтын тоо багассанаар бус, гэмт явдлын бүтэц өөрчлөгдсөн, өөрөөр хэлбэл нийт гэмт хэргийн дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн эзлэх хувь мэдэгдэхүйц байдлаар багассанаар тодорхойлогдоно.

Эрүүгийн эрх зүйн нэгэн адил **төрийн эрүүгийн бодлого** гэмт явдалтай хийх тэмцэлд төрийн үйл ажиллагааны агуулгыг тодорхойлж

буйгаа үндсэн зарчмууд дээр үндэслэгдсэн байдаг.

Орчин цагийн ОХУ-ын Эрүүгийн эрх зүйн бодлогын зарчимд дараах зарчмууд хамаарна.

1. Хууль ёсны зарчим. Ямар ч улс төрийн бодлогын нэгэн адил эрүүгийн бодлого нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан, зөвхөн тэр тохиолдолд л үр дүнтэй байх болно. Эрүүгийн бодлогын хэрэгжих үндэс нь юу ч биш зөвхөн хууль байх ёстойн гадна Эрүүгийн бодлого гэмт явдалтай хийх тэмцэлд хууль тогтоомжид байгаа алдаа дутагдлыг арилгахад чиглэгдсэн байх ёстой. Энэ тохиолдолд хууль, эрүүгийн бодлого харилцан хамааралтай байгааг харж болно. Хууль нь эрүүгийн бодлогын үндсэн зорилго, чиглэл, түүний хэрэгжих арга, хэлбэрийг тодорхойлж, түүнд нөлөөлдөг бол, харин эрүүгийн бодлого нь хуулийг үл хэрэгсэж эхэлбэл ардчилсан дэглэмтэй улс оронд яриад байх зүйл огт үгүй болж хууль бус байдал, дур зоргоороо авирлах явдал газар авч, юуны түрүүнд жирийн иргэдийн эрх, эрх чөлөө хохироход хүрнэ. Энэ тохиолдолд гэмт явдалтай хийх тэмцэл нь өөрөө гэмт явдал болж хувирна. Эрүүгийн бодлогын талаар шийдвэр гаргадаг субъектүүд үүнийг л юуны өмнө заавал ойлгож, мэдэж байх ёстой.

2. Эрүүгийн бодлогын нэгдмэл, харилцан ойлголцсон байх зарчим. Эрүүгийн бодлого хууль тогтоомжийг боловсруулах, хууль хэрэглэх явцад хэрэгждэг тул бодлого хэрэгжүүлэгч субъектууд заавал харилцан ойлголцсон байх ёстой. Өөрөөр хэлбэл эрүүгийн

бодлого өөрөө зөрчилдөөнгүй байх ёстой. Эрүүгийн бодлогын нэгдмэл байдал нь түүний нийтлэг зорилт, зорилготой байхад орших бөгөөд гэмт явдалтай хийх тэмцлийн илүү чухал гэсэн чиглэлүүдээр тодорхойлогдоно. Эрүүгийн бодлогын хэлбэр гол бус, агуулга нь бүхнээс чухал тул хоорондоо зөрчилдөхгүй байх шаардлагатай. Хамгийн гол зорилго бол гэмт явдлыг дээд хэмжээгээр хамгийн бага хүртэлх түвшинд бууруулах явдал.

3. Чиглэсэн зорилготой байх зарчим. Эрүүгийн бодлого бол түр зуурын үзэгдэл бус тодорхой зорилтыг өөртөө агуулсан үйл ажиллагаа юм. Эрүүгийн бодлого нь гэмт явдалтай тэмцэл хийх тодорхой зорилготой байна.

Эрүүгийн бодлогын эцсийн зорилт нь гэмт явдлыг бүрэн устгах явдал биш юм гэхэд бодит байдал дээр гэмт явдлыг бууруулах, өөрөөр хэлбэл гэмт явдлын хөдөлгөөнд өөрчлөлт оруулж, нийгэм, иргэнд ноцтой хор хохирол учруулахгүй байх тийм түвшинд хүрэх зэрэг хандлагыг бий болгох явдал юм. Харамсалтай нь орчин цагийн Оросын эрүүгийн бодлогод амжилтанд хүрсэн талаар баярлаад байх зүйл байхгүй. Энэ зорилгод хүрэх талаар ямар нэгэн алхам хийсэн хэдий ч сүүлийн жилүүдэд гэмт явдал бадрангуй явцтайгаар өсөн нэмэгдэх болсон. Түүнчлэн хүнийг алах, хулгай хийх зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн зэрэгцээ урьд өмнө байгаагүй шинэ төрлийн гэмт хэргийн (компьютерийн болон байгаль орчны эсрэг гэмт хэрэг, терроризм) тоо ихээхэн хэмжээгээр өссөн. Гэмт хэргийн

нөхцөл байдал, түүний тоо, чанарын бүтцийн талаарх мэдээлэл, нууц биш болсон төдийгүй телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр байнга мэдээлэгдэх нь жирийн үзэгдэл болсон.

4. Эрүүгийн хариуцлага ялгавартай байх зарчим. Эрүүгийн хариуцлагыг ялгавартай зааглан тогтоож, байгаа хууль тогтоогчийн үйл ажиллагаа нь энэ зарчмын үндсэн агуулгыг илэрхийлнэ.

5. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хатуу чанга ялаар айлгах бус, харин ял шийтгэл хүлээх нь гарцаагүй гэдгийг ойлгуулах нь юу юунаас чухал. Эрүүгийн бодлого дахь “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим” гэмт явдалтай тэмцэх үр дүнтэй арга хэрэгслийн нэгд тооцогддог.

6. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчим. Ямар ч үйл ажиллагаа тэр тусмаа төрөөс гэмт явдалтай хийх тэмцэл, үйл ажиллагаа шинжлэх ухааны ололт, амжилтанд үндэслэгдээгүй бол хангалттай үр дүнд хүрч чадахгүй. Гэмт явдлын шалтгаан нөхцлийн тухай олон янзын онол, гэмт явдалтай тэмцэх арга замууд практикт хэрэглэгдэх хэдий ч, хууль сахиулах байгууллагуудад гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаандаа тэдгээрийг бүрэн удирдлага болгон ажиллаж чадсан зөвхөн тэр тохиолдолд онол, шинжлэх ухааны тэрхүү ололт, амжилт үнэ цэнтэй байж чадна. Шинжлэх ухаан болон төрөөс гэмт явдалтай хийж буй тэмцэл, үйл ажиллагааны энэхүү нягт холбоо нь онол, практикийн харилцан хамаарлын

нийтлэг зүй тогтлыг илэрхийлж байна.

7. Нийгмийн шалтгаан-нөхцөлт зарчим. Төрийн эрүүгийн бодлого амжилттай хэрэгжих гол нөхцөл нь гэмт явдалд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлс, механизмыг заавал харгалзсан үзсэн байх явдал юм. Өнөө цагт гэмт явдал юуны өмнө нийгмийн үзэгдэл болох нь шинжлэх ухаанаар нэгэнтээ нотлогдсон асуудал юм.

Эрх зүйн хэм хэмжээний мөн чанар нь нийгмийн харилцааг аливаа халдлагаас хамгаалахад оршдог. Тодорхой гэмт хэргүүд нийгмийн харилцааг зөрчдөг учраас гэмт явдал нийгмийн шинж чанартай байдаг. Нийгмийн хүчин зүйлсийг зөв тооцож, нийгэмд хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх нь ямар ч хатуу чанга ял шийтгэлийг бий болгосноос илүүтэйгээр гэмт явдлын түвшинг бууруулах боломжийг олгодог.

ОХУ-ын гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор А.В.Бриллиантов хянан тохинуулсан.

“ОХУ-ын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий болон тусгай анги” сурах бичгээс орчуулав. Хоёр дахь хэвлэл. Москва. “Проспект” хэвлэлийн газар. 2016 он. Хуудас 25-29.

Төрийн эрүүгийн бодлогын бүтцэд түүний арга хэлбэр, чиглэл, бүрэлдэхүүн хэсэг хамаарна. **Төрийн эрүүгийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг гэдэг нь эрүүгийн бодлого чухам юунаас бүрэлдэж байгааг бүхэлд нь авч үзэж байгаа хэрэг юм.** Бүрэлдэхүүн хэсгийг үзэл суртлын, гүйцэтгэх гэж 2 хуваан авч үзэж болно.

Эрүүгийн бодлогын **үзэл суртлын хэсэгт** төрөөс гэмт хэрэгт хэрхэн хандаж байгаа харилцаа, гэмт явдлын шалтгаан нөхцөл, эрүүгийн хуулийн дагуу гэмт явдалтай хэрхэн тэмцэж байгааг хамруулан ойлгодог.

Эрүүгийн бодлогын гүйцэтгэх хэсэг гэдэг нь гэмт явдлын эсрэг төрийн эрүүгийн улс төрийн үзэл суртлыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн удирдлагын үйл ажиллагаа юм.

Эрүүгийн бодлогын хэлбэр гэдэг нь тухайн бодлого хэрхэн илэрч байгаагаар тодорхойлогдоно. Эрүүгийн бодлого нь **хууль тогтоох, хууль хамгаалах, шүүхийн гэсэн 3** хэлбэртэй байдаг бөгөөд хэлбэр тус бүр нь эрүүгийн бодлогын хэрэгжилтийн харьцангуй бие даасан арга болдог.

Эрүүгийн бодлогын хууль тогтоох хэлбэр нь эрүүгийн бодлогын үндсэн санааг тусгасан байдаг тул **тэргүүлэх хэлбэр** болдог. Гэвч хуулиар илэрхийлэгдсэн эрүүгийн бодлогын хэрэгжилтийг хангаж буй шүүх эрх мэдлийн болон хууль хамгаалах байгууллагууд хуульд тулгуурлаж гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаагаа явуулаагүй бол зөвхөн хууль байгаа явдал нь гэмт явдалтай тэмцэхэд учир дутагдалтай.

Эрүүгийн бодлогын чиглэл гэдэгт гэмт явдлын эсрэг хэрэгжүүлж буй эрүүгийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг, тодорхой салбаруудыг ойлгоно.

Төрийн эрүүгийн бодлогод дараах үндсэн чиглэлүүдийг онцлон авч үздэг. Үүнд: эрүүгийн эрх зүйн чиглэл, эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэл, эрүүгийн

процессын чиглэл, криминалистикийн чиглэл, криминологийн чиглэл, хууль хэрэглээний чиглэлүүд орно. Түүнээс гадна туслах шинж чанартай чиглэлүүд ч байдаг. Үүнд: боловсон хүчний, мэдээллийн, техникийн, шинжлэх ухааны гэсэн чиглэлүүд хамаарах бөгөөд эдгээр нь төрийн эрүүгийн бодлогыг бүрэлдүүлэхгүй ч гэсэн эрүүгийн бодлогын хэрэгжилтийг хангахад чухлаар нөлөөлдөг.

Эрүүгийн бодлого бүхэлдээ, түүний бүрэлдэхүүн хэсгүүд ч гэсэн **үзэл суртлын болон гүйцэтгэх хэсэгтэй** байдаг.

Төрийн эрүүгийн бодлогын **үзэл суртлын хэсэг** нь төр гэмт явдалтай ямар арга хэрэгслээр тэмцэх вэ? гэдгийг тодорхойлдог бол эрүүгийн бодлогын **гүйцэтгэх хэсэг** нь гэмт явдалтай тэмцэх удирдлагын үйл ажиллагааг тодорхойлдог.

Дээр дурдсан бүхий л чиглэлүүдээс эхний ээлжинд **төрийн эрүүгийн эрх зүйн бодлого** хамгаас чухал, томоохон нь юм гэдгийг онцлон авч үзэх хэрэгтэй. Учир нь төрийн эрүүгийн эрх зүйн бодлого гэмт хэргийн тухай ойлголт, түүний төрөл, бүрэлдэхүүнийг тодорхойлохын зэрэгцээ гэмт явдалтай тэмцэх арга зүйн үндэс болдог.

Төрийн эрүүгийн эрх зүйн бодлогын мөн чанар нь төрийн, нийтийн болон хувь хүний ашиг сонирхлыг нийгэмд аюултай гэмт үйлдэл, учруулж болох аюулаас хамгаалахын зэрэгцээ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг боловсруулахад оршино.

Төрийн эрүүгийн эрх зүйн

бодлогын агуулга нь төрөөс гэмт явдалд хэрхэн хандах хандлага, гэмт хэрэгтэй эрүүгийн эрх зүйн арга хэрэгслээр тэмцэх боломж, нийгмийн амьдралын тодорхой салбарт гарч буй өөрчлөлтүүдэд хяналт хийх зорилгоор гэмт явдлыг судлахад чиглэгдсэн үйл ажиллагаа болон шинээр батлан гаргах хууль тогтоомжийн үр өгөөжийг тодорхойлоход оршино.

Төрийн эрүүгийн эрх зүйн бодлогын субъект нь ОХУ-ын төлөөллийн болон хууль тогтоох байгууллага болох Холбооны зөвлөх, төрийн дүм гэсэн 2 тэнхимээс бүрдэх Холбооны хурал байна. Эдгээртэнхимүүд нь ОХУ-ын холбооны хуулиуд, түүний дотор эрүүгийн хуулийг батлан гаргадаг. ОХУ-ын эрүүгийн эрх зүйн бодлогын субъектэд ОХУ-ын Ерөнхийлөгчийг оруулж тооцох нь зүйтэй. Учир юу гэвээс ОХУ-ын Ерөнхийлөгч ОХУ-ын Үндсэн хуулийн 107 дугаар зүйлд заасны дагуу Холбооны хурлаар байгуулагдсан хуульд гарын үсэг зурах, хуулийг олон нийтэд мэдэгдэх талаар шийдвэр гаргадаг.

Төрийн эрүүгийн эрх зүйн бодлогын объект нь нийгэмд аюултай аливаа хандлагаас эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг шаардаж байгаа төрийн, нийгмийн болон хувь хүний амьдралын амин чухал ашиг сонирхлууд байхын зэрэгцээ эдгээрийн хамгаалалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хууль тогтоомж байна.

Төрийн эрүүгийн бодлогын хэрэгжих арга:

Төрийн эрүүгийн бодлогын зорилго нь төр, нийгэм, хувь хүнийг нийгэмд аюултай гэмт халдлагаас хамгаалах хэрэгцээ шаардлагыг хангасан хууль тогтоомжийг боловсруулахад оршино.

Энэхүү зорилготой уялдуулж төрийн эрүүгийн бодлого нь **дараах зорилтыг** өөртөө агуулсан байдаг. Үүнд:

- ▶ Эрүүгийн эрх зүйн арга хэрэгслээр гэмт явдалтай бүхэлд нь болон түүний зорилт тодорхой хэлбэрүүдтэй тэмцэх боломж, нөхцөл, үзэл бодлыг бий болгох;
- ▶ Нийгэмд аюултай гэмт явдлаас хамгаалахад шаардлагатай байгаа төр, нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг боломжтой хэмжээгээр, аль болохоор бүрэн гүйцэт харгалзан үзсэн байх;
- ▶ Гэмт хэргийг бий болгож байгаа, нийгэмд аюултай үйлдлийн шинжүүдийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд бүрэн гүйцэд, маш тодорхой байдлаар тодорхойлж, тусгасан байх;
- ▶ Нийгэмд аюултай үйлдлийн шинж чанарыг харгалзан эрүүгийн хариуцлагыг ялгавартай тогтоох;
- ▶ Үйлдэгдэн гарч буй гэмт үйлдлийн нийгмийн аюултай байдлын зэрэглэлд нийцүүлэн гэм буруутай этгээдэд оногдуулах хариуцлагын ялгамжтай байх боломжийг бий болгох;

- ▶ Нийгэмд аюултай гэмт хэргийн шинж чанарыг бүрэн хэмжээгээр илэрхийлж чадах ялын төрөл, хэмжээг тодорхойлох;
- ▶ Гэмт явдалтай тэмцэх зорилтыг хангахад нөлөөлөхүйц эрүүгийн эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээг тогтоох

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого нь тодорхой утгаараа эрүүгийн эрх зүйн бодлогоос урган гардаг гэж үзэж болох бөгөөд эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого нь эрүүгийн хуулиар тодорхойлогдсон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхийн шийдвэрийн дагуу нөлөөллийн тодорхой арга хэмжээнүүдийг үр дүнтэйгээр авч хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн хэвийн амьдралд буцаан оруулах зорилтыг агуулдаг. **Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлогын зорилт:**

- ▶ Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн ял болон эрүүгийн эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээг хэрэглэх замаар шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засрал хүмүүжил олох боломжтой гэсэн үзэл бодлыг бий болгох;
- ▶ Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлогод дээд зэргээр нийцсэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн талаарх хууль тогтоомжийг боловсруулан бий болгох;
- ▶ Эрүүгийн ял болон эрүүгийн эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээнүүдийг биелүүлж гүйцэтгэх

төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн зорилгод нийцүүлэн хангах.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэлийн бодлогын хэрэгжих арга нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг дахин шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засрал хүмүүжлийг бий болгох зорилгоор эрүүгийн ял эдлэх дэглэмийг тодорхойлох, эрүүгийн эрх зүйн нөлөөллийн бусад төрлүүдийг хэрэгжүүлэх явдал юм.

LANDMARK UNITED STATES SUPREME COURT CASE RELATED TO PRIVACY, AND ITS IMPACT №2: GRISWOLD CASE

ХУВЬ ХҮНИЙ ДАНГААРШИХ ЭРХИЙН ТАЛААРХ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ГОЛЛОХ ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ЗАРИМ ҮР ДАГАВАР №2: ГРИСВОЛДЫН МАРГААН



Орчуулсан: Шихихутуг их сургуулийн багш, хуульч, докторант М.Хатанзориг

Оршил

Хүн өөрийн амьдралд чухал шийдвэрүүдийг бусдын нөлөө, шахалтаас ангид бие даан шийдвэрлэх эрх либерал чиг баримжаатай улсуудад 19 дүгээр зууны сүүлч, 20 дугаар зууны эхээр хүчтэй яригдаж, хууль зүйн практикт тусгалаа олсон. Үр тогтохоос хамгаалах хэрэгсэл худалдах, хэрэглэхийг хориглосон хэмжээг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж, түүний цаана хүүхэд төрүүлж өсгөхөө гэр бүлийн хосууд өөрсдөө шийдвэрлэдэг байх эрхийг хамгаалан шийдвэрлэснээрээ Грисволдын хэрэг АНУ-д төдийгүй, хүний эрхийн, түүнтэй холбоотой Үндсэн хуулийн тайлбарын хувьд жишиг шийдвэр болдог төдийгүй

шийдвэрээ бие даан гаргах болон бэлгийн эрхтэй холбоотой олон тайлбар, шийдвэрүүдийн үндэс болжээ. Уг нийтлэлээр эл хэргийн шийдвэр, голлох үндэслэл, агуулгыг түүвэрлэн орчуулж, тоймлон тайлбарлалаа.

ГРИСВОЛДЫН ХЭРЭГ

/Griswold v. Connecticut (381 U.S. 479 (1965)/

Хувийн халдашгүй байдлын эрхийн (дангаарших эрх) сонгодог онолуудыг нэг – шийдвэрийн дангааршилд АНУ-д өрнөсөн энэхүү шүүхийн маргаан, шийдвэр чухал ач холбогдолтой байдаг. Ерөнхий агуулга нь Коннектикут мужийн зохицуулалтаар жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аливаа эм бэлдмэл, хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглодог байсан бөгөөд С. Lee Buxton болон Estelle Griswold нарыг уг хоригийг зөрчсөн үндэслэлээр баривчилжээ. Тэд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд тэрхүү хууль нь хүний аливаа шийдвэрийг өөрөө бие даан гаргах Үндсэн хуулиар олгогдсон

¹ Англи хэлний “privacy” буюу орчин үеийн хууль зүйн уггаараа хувийн орон зай, мэдээлэл, шийдвэрийн халдашгүй байдлын эрхийг “дангаарших эрх” хэмээн орчуулахыг санал болгов. Дэлгэрэнгүйг: М.Хатанзориг. Хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэслэл аюулгүй байдлын уламжлалт бус сорилт болох нь: эрх зүйн шинэчлэлээр шийдвэрлэх арга зам. (2021) эрдэм шинжилгээний өгүүлэлээ үзнэ үү.

эрх, тухайлбал хүүхэдтэй болох эсэхээ өөрөө шийдэх эрхийг зөрчсөн хэмээн маргасан байна. Хэдий АНУ-ийн Үндсэн хууль, хүний эрхийн билд энэ талаар шууд заагаагүй боловч Дээд шүүхээс бие даан шийдвэр гаргах эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан гэж үзжээ.

Коннектикут муж болон Грисволд нарын хэрэг (1965) —эр АНУ-н дээд шүүхээс гэрлэгчид нь Үндсэн хуулийн дагуу, засгийн газрын ямар нэгэн хориг, саадгүйгээр жирэмснээс хамгаалах хэрэгсэл авч, хэрэглэх эрхтэй хэмээн тогтоосон. Тухайн үед тус мужид жирэмслэлтээс хамгаалах зорилгоор ямарваа эм, эмнэлгийн бодис, хэрэгсэл худалдаж авахыг хориглосон формал хууль үйлчилж байв. Дээд шүүхээс уг зохицуулалтыг “гэрлэгчдийн дангаарших эрх”-ийг зөрчсөн хэмээн үзэж хүчингүй болгосон аж.² Өөрөөр хэлбэл, жирэмслэхээс урьдчилан сэргийлэх эсэх нь гэрлэгчдийн хувийн шийдвэр бөгөөд уг шийдвэрт хөндлөнгөөс халдах ёсгүй хэмээх үзэл баримтлалыг хууль зүйн практикт бий болгожээ.

Энэ хэрэгт зөвхөн хүүхэдтэй болох эсэхээ шийдэх эрхийн тухай биш, тэрхүү эрхийн тулгуур болох дангааршлын философийн талаар эрх зүйн хүрээнд авч хэлэлцсэн байдаг. Тухайлбал, дээд шүүхийн ерөнхий шүүгч Артур Голдберг (1908-1990) хэргийг хэлэлцэх явцад Meyer v. Nebraska 262 U. S. 390 (1923)-ийн хэргийг эшлэн: “Шүүхээс эрх чөлөөний агуулгыг хөдлөшгүй тодоор цохон тодорхойлоогүй ч, уг нэр томъёонд

ихээхэн анхаарал хандуулдгийн хүчинд зарим талаар нэгдмэл ойлголтод хүрч чадсан байна. Тэр ч үүднээс, эрх чөлөө гэдэг нь зөвхөн бие махбодийн хорио, цагдалтаас ангид байх ойлголт бус, өөр бусад агуулгыг ч, тухайлбал гэр бүл болох, орон гэрээ бүтээж босгох, хүүхэд төрүүлэх эрх зэргийг ч багтаадаг” хэмээн тайлбаржээ.

Мөн дээд шүүхийн шүүгч В.Дуглас: “Бүдэг бадагхан байгаа дангаарших эрхийн талаар бидэнд цөөнгүй санал зөрөлдөөн бий боловч энд яригдаж байгаа дангааршлын тухай үндэслэл бол гарцаагүй хууль ёсны ойлголт мөн” гээд холбогдох хэргүүдийг³ дурджээ. Тэрээр мөн: “Бид цагдаа нарыг гэрлэгчдийн унтлагын өрөөний ариун хил хязгаарыг зөрчин ороод жирэмслэхээс хамгаалах ямар нэгэн хэрэгслийн ул мөрийг эрж нэгжихийг зөвшөөрч болно гэж үү? Ингэх нь гэрлэгчдийн хувийн орон зайн үүднээс бол үзэшгүй жигшүүрт үйлдэл болно” хэмээсэн байна.

Ялласан үндэслэлийн хувьд, Коннектикут мужийн ерөнхий статутын⁴ §§53-32, 54-196-д “Жирэмслэхээс сэргийлэх аливаа эм, эмнэлгийн зүйл, хэрэгсэл ашигласан бол тухайн хүнийг 50-иас доошгүй доллараар торгох, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн ба §§54-196-д “Бусдын гэмт үйлдэлд хамжсан, тэднийг хатгасан, тушаасан хүнд тухайн хэргийг үйлдсэн хүний нэгэн адил ял онооно”

³ Тухайлбал, Breard v. Alexandria, 341 U. S. 622, 341 U. S. 626, 341 U. S. 644; Public Utilities Comm'n v. Pollak, 343 U. S. 451; Monroe v. Pape, 365 U. S. 167; Lanza v. New York, 370 U. S. 139; Frank v. Maryland, 359 U. S. 360; Skinner v. Oklahoma, 316 U. S. 535, 316 U. S. 541.

⁴ Тухайн үед 1958 оны шинэчилсэн хувилбар хүчин төгөлдөр үйлчилж байжээ.

¹ 381 U.S. 479

² 381 U.S. 479

гэж заасны дагуу Ли Бакстон, Э.Грисволд нарыг тус бүр нэг зуун доллараар торгожээ. Уг хэм хэмжээ нь ерөнхийдөө, 1873 онд батлагдсан "Комстокийн хууль"-д¹ үндэслэсэн гэж үздэг. Тус хуулиар "бусдыг доромжилсон текст, жирэмснээс хамгаалах бүтээгдэхүүн, үр хөндөх бүтээгдэхүүн, хэрэгсэл, бэлгийн харилцаанд зориулсан тоглоом, хэрэгсэл, садар самуунд уруу татсан аливаа агуулга бүхий текст, эсхүл эдгээртэй холбоотой зүйлс"-ийг шуудангийн үйлчилгээ ашиглаж илгээхийг гэмт хэрэгт тооцохоор болсон байна. Зарим судлаачийн² тайлбарласнаар, үүний шалтгаан нь Америкийн иргэний дайны үеэр порнограф буюу насанд хүрэгчдэд зориулсан агуулга бүхий бүтээгдэхүүн асар хурдацтай түгэснээр түүнийг эсэргүүцэх хөдөлгөөнүүд өрнөж ийм хууль батлах нөхцөлийг бүрдүүлжээ.³

"Комстокийн хууль" гэж нэрлэсний учир нь тэрхүү хуулийг хүчтэй дэмжигч, хуулийн хэрэгжилтийг хангахын тулд компани ажлууд зохион байгуулсан Anthony Comstock (1844-1915) -той холбоотой бололтой. Тэрээр 1880 онд "Frauds exposed or How the people are deceived and robbed, and youth corrupted" хэмээх ном бичсэн бөгөөд оршил хэсэгт нь "...Миний зорилго (ном хэвлүүлж буйн) бол... гэнэн, болгоомжгүй хүмүүсийг шуудан ашиглаж дээрэмддэг олон системийг илчлэн гаргах; шударга бөгөөд итгэмтгий хүмүүст анхааруулах;

залуу үеэ садар самуун явдал хийгээд муу нөлөөллөөс хамгаалах; хүүхэд багачуудын ёс суртахууны ариун орчилд үхлийн хор шахаж буй цус сорогчдын эсрэг олон нийтийг сэнхрүүлэн босгох хийгээд эдгээр ёс суртахуунд хор хавдар үүсгэгч нарыг хамгаалагч либералуудыг ил болгох юм"⁴ гэсэн байна.

Ямартай ч энэхүү хууль, түүний шалтгаан болон үр дагавар болсон нийгмийн хөдөлгөөнүүд нь зөвхөн порнографт хориг тавиад зогсохгүй үр хөндөлт, жирэмслэх эсэх зэрэг нөхөн үржихүйн эрхүүдтэй холбогдсон ба удалгүй уг хуулийн эсрэг мөн олон хөдөлгөөнүүд⁵ өрнөж яваандаа хүний эрх, эрх зүйн хөгжлийн явцад ихэнх мужид үйлчлэхээ больсон байна.

19 дүгээр зууны сүүлч, 20 дугаар зууны эхээр Америкийн физикчид жирэмсний хяналттай холбоотой аливаа материалыг хүмүүсийн хүсэлтээр ч олон нийтэд дэлгэхээс зайлсхийж байсан төдийгүй энэ талаар гэрлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөхөөс татгалзаж байв. Харин 1914 онд Маргарет Сангер олон нийтийг уриалан жирэмсний хяналтын хоригийг эсэргүүцэж эхлэв.⁶ Тэрээр "Коннектикут мужийн жирэмсний хяналтын холбоо"-г үүсгэн байгуулахад нөлөө үзүүлсэн төдийгүй, өнөөгийн "Гэр бүл төлөвлөлт"

⁴ Antony Comstock. *Frauds exposed or How the people are deceived and robbed, and youth corrupted*. 1880, 9 дэх тал.

⁵ Америкийн Үндэсний либерал холбооны гарын үсэг цуглуулах ажиллагаа, Маргарет Сангерийн Жирэмсний хяналтын хөдөлгөөн гэх мэт.

⁶ Johnson, John W. (2005). *Griswold V. Connecticut*. University of Kansas. pp. 8-10.

⁷ Planned Parenthood буюу хэзээ хүүхэд төрүүлэх талаараа хосууд санхүүгийн боломж, боловсрол эзэмших хугаана зэрэг амьдралынхаа бусад хүчин зүйлсийг харгалзан урьдчилан төлөвлөж, зохицуулах тухай санаа. Маргарет Сангер анх 1921

¹ Хуулийн албан ёсны нэр нь: *Suppression of Trade in, and Circulation of, Obscene Literature and Articles of Immoral Use*.

² Сэтгэл судлаач, профессор Paul R. Abramson.

³ Paul R. Abramson (2002). *With Pleasure: Thoughts on the Nature of Human Sexuality*. Oxford University Press US. p. 180.

-ийн үзэл санааг хөгжүүлэхэд туслалцсан байна. Коннектикут мужид анх 1935 онд Хартфорд хотын жирэмсний хяналтын эмнэлэг байгуулагдсан боловч 1939 онд Ватербүри хотын хяналтын эмнэлэгт анх Комстокийн хуулиар арга хэмжээ авчээ. Үүнээс эхлээд уг асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд авч үзэхийн ач холбогдлыг дурдсан байгууллагуудын удирдлагууд чухалчлах болсон аж.1

Грисволдын хэрэг шийдэгдэх хүртэл АНУ-ын Дээд шүүх дээр түүнтэй төстэй, түүнийг дурдсан агуулгаар шийдвэрлэх үзэл санааны суурийг тавьсан хэд хэдэн хэргүүд мөн шийдвэрлэгдсэн байна. Тухайлбал, *Poe v. Ullman*, 367 U.S. 497 (1961) –ны хэрэг нь мөн л Комстокийн хуулийг эсэргүүцсэн маргаан боловч тухайн хуулиар өмнө нь нэг ч удаа ял шийтгэл оногдуулж байгаагүй учраас хуулийг зөрчсөн этгээдэд бодитой аюул заналхийлэл байхгүй гэсэн үндэслэлээр дээд шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байв.2 Гэвч хэргийг хэлэлцэх явцад Үндсэн хуулин дахь хувь хүний дангааршлын үзэл санааг тайлбарласан ахиц, дэвшлүүд гарсан байдаг. Тухайлбал, Жонн Маршал Харлан (1899-1971) тухайн хэлэлцүүлэгт: “Эрх чөлөөний үзэл санаа нь Үндсэн хуулиар яг тодорхой тогтоосон аль нэг нэр томьёо, нарийвчлан зохицуулсан ухагдахуунаар хязгаарлагдахгүй. Эрх чөлөө гэдэг нь өмчтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн

нийтлэх, шашин шүтэх эс шүтэх, АНУ-д зэвсэг эзэмших, учир шалтгаангүй нэгжлэг баривчилгаанаас ангид байх гэх мэт тодорхой нэр томьёонуудын цуглуулга биш. Энэ бол ерөнхийдөө, аливаа шалтгаангүй хорио цээр, үндэслэлгүй татвар торгуулиас ангид байх үргэлжилсэн ухагдахуун юм” гэжээ.

Шийдвэр

Дээд шүүхийн 9 гишүүний 7 нь нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхийг дэмжсэнээр шийдвэр гарчээ. Үүнд шүүгч В.Дугласын үндэслэл голлох тулгуур болсон гэж үздэг. Шүүхийн шийдвэрээр “гэрлэгчдийн дангааршил” нь Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь эрх мөн гэж үзсэн боловч Үндсэн хуулийн яг тодорхой заалтаар түүнийг тогтооход бэрхшээлтэй байсныг дурджээ.3 Гэвч, шүүхээс хэргийг шийдэхдээ Хүний эрхийн бил болон Үндсэн хуулийн нэг, гурав, дөрөв, тавдугаар нэмэлт өөрчлөлтөөр “гэрлэгчдийн дангаарших эрх”-ийг хуульчилсан хэмээн тайлбарлажээ.4

Дээд шүүхийн гишүүн Дуглас: “Энэхүү хэрэг бидэнд Хүний эрхийн билд нэрлэгдэн тусгагдсан эрхүүд нь тэдгээрийн агуулгыг өргөтгөн тайлбарлах, тэрхүү эрхүүдийг бодитоор хэрэгжүүлэхэд амин шаардлагатай “дагуул эрхүүд” зайлшгүй байх ёстойг харуулж байна. “Дангаарших эрх”-ийг хэд хэдэн эрх, эрхийн баталгаа нэгдэн бүрдүүлдэг” ... “Дангаарших эрх” болон “амгалан тайван байх эрх”-ийн талаар бидэнд цөөнгүй хэрэг маргаан бий.

онд Америкийн жирэмсний хяналтын холбоог (American Birth Control League) байгуулсан ба тэр нь 1942 онд нэрээ Planned Parenthood Federation of America, Inc. (PPFA) болон өөрчилжээ.

¹ Johnson, John W. (2005). *Griswold v. Connecticut*. University of Kansas. pp. Chapter 2

² *Poe v. Ullman*, 367 U.S. 497 (1961)

³ Chemerinsky, Erwin (2019). *Constitutional Law: Principles and Policies* (6th ed.). New York: Wolters Kluwer.

⁴ Chemerinsky, Erwin (2019). *Constitutional Law: Principles and Policies* (6th ed.). New York: Wolters Kluwer.

Тэдгээр маргаанууд бидэнд энэ хэрэг дэх дангааршил бол хууль ёсны дангаарших мөн болохыг баталж байна” хэмээн хэлэлцүүлэгт өгүүлжээ¹.

Дээд шүүхийн гишүүд Хьюго Блэк, Поттер Стьевард нар шийдвэрийн эсрэг байр суурьтай байсан ба Х.Блэк өөрийн баримтлалаа дүгнэж: “Би бусдын л адил дангаарших эрхээ эдлэхийг хүснэ. Гэвч дангаарших эрхийг Үндсэн хуулийн тодорхой нөхцөлд тусгаж хамгаалаагүй цагт би Засгийн газраас хувь хүний дангааршлыг зөрчих бүрэн эрхтэй гэж үзэж байна” гэжээ.² Эцэст нь Дээд шүүх Коннектикутад хэрэгжсэн Комстокийн хууль нь хүний “дангаарших эрх”-ийг зөрчсөн учраас Үндсэн хуульд нийцээгүй буюу харшилсан хэмээн дүгнэсэн байна. Шийдвэрт авагдсан алдартай эшлэлд: “Дангаарших эрх, түүний үзэл санаа нь АНУ-ын хүний эрхийн билээс ч өмнө, бидний улс төрийн намуудаас ч эрт, боловсрол, сургуулийн тогтолцооноос маань ч урьд оршоор байсан юм. Гэрлэлт гэдэг бол сайн муу алинд ч хамт байж, аливаа бэрхшээлийг даван туулах, ариун ёсыг чандлан сахих явдал билээ. Гэрлэлт гэдэг улс төрийн асуудал бус жас ёсны амьдралын уялдаа, ямар нэгэн учир шалтгаанлаг зүйл бус амьдралын жам ёс, бусдад зориулсан нийгмийн эсхүл бизнесийн зорилготой дүр төрх бус хоёр биендээ л зориулсан үнэнч ариун байдал юм” гэжээ.³ Тус шийдвэр АНУ-н дээд шүүхийн хэд хэдэн чухал маргаанд жишиг шийдвэр болон хэрэглэгдсэн.

Грисволдын хэргийг жишиглэн шийдвэрлэсэн чухал шийдвэрүүдээс:

1. Гэрлэлтээ батлуулаагүй хосуудын жирэмсний хяналтын эрхийн тухай (1972);⁴
2. Үр хөндүүлэх эрхийн тухай (1973);⁵
3. 16-аас дээш насны хүмүүсийн жирэмснээс хамгаалах хэрэгсэл ашиглах эрхийн тухай (1977);⁶
4. Ижил хүйстэнтэйгээ гэрлэх эрхийн тухай (2015).⁷

Ном зүй:

Судалгааны бүтээл:

1. Samuel D. Warren, Louis Brandeis. Right to privacy. Harvard Law Review 193 (1890);
2. М.Хатанзориг. “Хувийн мэдээллийн ашиглалт, хамгаалалт үндэсний аюулгүй байдлын уламжлалт бус сорилт болох нь: Эрх зүйн шинэчлэлээр шийдвэрлэх арга зам” (2021) эшэ;
3. Paul R. Abramson (2002). With Pleasure: Thoughts on the Nature of Human Sexuality. Oxford University Press US;
4. Antony Comstock. Frauds exposed or How the people are deceived and robbed, and youth corrupted. 1880;
5. Johnson, John W. Griswold V. Connecticut. University of Kansas. (2005);
6. Chemerinsky, Erwin (2019). Constitutional Law: Principles and Policies (6th ed.). New York: Wolters Kluwer.

¹ Griswold v. Connecticut, 381 U.S. at 484-85; Chemerinsky, Erwin (2019). Constitutional Law: Principles and Policies (6th ed.). New York: Wolters Kluwer.

² Griswold, 381 U.S. 508 дахь хуудас.

³ Griswold, 381 U.S. 486 дахь хуудас.

⁴ Eisenstadt v. Baird (1972)

⁵ Roe v. Wade, 410 U.S. 113 (1973)

⁶ Carey v. Population Services International (1977)

⁷ Obergefell v. Hodges, 576 U.S. 644 (2015)

Хууль:

7. АНУ-н Үндсэн хууль;
8. Коннектикут мужийн хууль:
Suppression of Trade in, and
Circulation of, Obscene Literature
and Articles of Immoral Use.

Шүүхийн маргаан:

9. Griswold v. Connecticut (381 U.S.
479 (1965));
10. Breard v. Alexandria, 341 U. S. 622;
11. Public Utilities Comm'n v. Pollak, 343
U. S. 451;
12. Monroe v. Pape, 365 U. S. 167;
13. Lanza v. New York, 370 U. S. 139;
14. Frank v. Maryland, 359 U. S. 360;
15. Skinner v. Oklahoma, 316 U. S. 535,
316 U. S. 541;
16. Poe v. Ullman, 367 U.S. 497 (1961);
17. Eisenstadt v. Baird (1972);
18. Roe v. Wade, 410 U.S. 113 (1973);
19. Carey v. Population Services
International (1977);
20. Lawrence v. Texas (2003);
21. Obergefell v. Hodges, 576 U.S. 644
(2015).



КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР



*Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш А.Доржготов*

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР:
Үргэлжлэл. Түрүүч нь нь "ШИХИХУТУГ"
Сэтгүүлийн 2015, 2018, 2019 оны
дугааруудад нийтлэгдсэн болно.

23 дугаар зүйл. Компанийг өөрчлөх

23.1 Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно.

23.2 Энэ хуулийн 23.1-д заасны дагуу компанийг өөрчлөх төслийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор шийдвэрлэнэ.

23.3 Энэ хуулийн 23.2-т заасан төсөлд компанийг өөрчлөх

зорилго, нөхцөл, журам, хугацаа, хувьцааг харилцан хөрвүүлэх арга, тооцоо, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хугацаа зэргийг тусгасан байна.

23.4 Энэ хуулийн 60.1-д зааснаар эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд компанийг өөрчлөх замаар үүссэн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж, компанийн дүрэм удирдах байгууллагыг шинэчлэн баталж болох бөгөөд энэ тухай компанийг өөрчлөх төсөлд заана.

23.5 Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр болж байгаа компанид шилжинэ.

23.6 Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгана.

Тайлбар:

Компанийг өөрчлөх. Хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болох замаар өөрчлөгдөж болно. Ингэж өөрчлөх төслийг компанийг төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол гүйцэтгэх удирдлага боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулан уг асуудлаа саналын эрхтэй хуралд оролцогчдын саналын эрхийн дийлэнхи олонхоор шийдвэрлэдэг.

Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг шинээр бий болж буй компанид шилжинэ. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтөөр үүссэн компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэн баталж болох бөгөөд үүнийг компанийг өөрчлөх төсөлд зааж өгөх шаардлагатай. Компани өөрчлөгдөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгадаг.

Хувьцаат компанийг хязгаарлагдмал харуулагатай компани, хязгаарлагдмал харуулагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно.	Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно. (ИХ§31.6)
---	---

Компани (хуулийн этгээд)-ийн хэлбэр өөрчлөгдөх тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцно. Шинээр байгуулагдсан компанийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

Компанийг өөрчлөх төсөл. Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) компанийг өөрчлөх төсөл боловсруулна. Боловсруулсан төслөө хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудал шийдвэрлэгдэнэ. Компанийг өөрчлөх төсөлд шаардлагатай гэж үзвэл дараах асуудлыг зааж болно.



Компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэх тухай зааж болох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулах замаар шийдвэрлэнэ. Компанийг өөрчилсөн тохиолдолд түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болж буй компанид шилжих бөгөөд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр, дүрэмд тус тус тусгана.

18 дүгээр зүйл. Компанийг өөрчлөн байгуулсантай холбоотой хувьцаа эзэмшигчийн эрх

24.1 Нийлүүлэх, нэгтгэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол энэ хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

24.2 Компанид эргүүлэн худалдахаар тохиролцсон хувьцаа эзэмшигчийн хувьцааг уг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлж үл болно.

24.3 Энэ хуулийн 24.2-т заасан тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардахаас бусад хувьцаа эзэмшихтэй холбогдсон эрхээ алдана.

24.4 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг

компаниас шаардаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлнэ.

Тайлбар:

Хувьцаа эзэмшигчийн эрх.

Компанийг нийлүүлэх, нэгтгэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх дараах тохиолдолд бий болно. Үүнд:

- a. Компанийг өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан бол ;
- b. Санал хураалтад оролцоогүй ;

Дээрхи хоёр тохиолдол нь шаардах эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг хувьцаа эзэмшигчид бий болгоно. Энэ эрхийг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хуульд "хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах (§53), шаардах эрхийг хэрэгжүүлэх журамд (§54), заасан үйл ажиллагаа явуулна."

Хөрвүүлж болохгүй тохиолдлыг хуульд заасан. Энэ нь компанид эргүүлэн худалдахаар тохиролцсон хувьцаанд хамаарч байна. Нэгэнт компанид эргүүлэн худалдахаар тохиролцсон хувьцаа эзэмшигчийн хувьцааг тухайн компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлж болохгүй гэж хуульд заажээ.

Хувьцаа эзэмшихтэй холбогдсон эрхээ алдах. Компанид эргүүлэн худалдах авахаар тохиролцсон хувьцаа эзэмшигч нь зөвхөн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг

компаниас шаардах эрхтэй байдаг. Үүнээс бусад хувьцаа эзэмшихтэй холбогдсон эрхээ алдах тул хувьцаа эзэмшигчийн бусад эрх дуусгавар болно.

Хувьцааг хөрвүүлэх. Үндэслэл нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардаагүй байхад оршино. Ийнхүү компаниас шаардаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлнэ.

19 дугаар зүйл. Компанийн өрийг хувьцаагаар солих

25.1 Компанийн үнэт цааснаас бусад үнэт цаас болон өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ.

25.2 Зээлдүүлэгч болон бусад харилцагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компанийн өрийг хувьцаагаар солиход хувьцаа авах тухайн зээлдүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна.

25.3 Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийн өрийг хувьцаагаар солих тухай төсөл боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.


25.4 Өрийг хувьцаагаар солих тухай төсөлд хувьцаагаар солих өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ,

зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг зааж өгсөн байна.

25.5 Хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэдгээрийн хөрвөх нөхцөлийн дагуу хөрвүүлэхийг компанийн өрийг хувьцаагаар сольсонд тооцохгүй.

25.6 Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхтэй.

Тайлбар:



"Компанийн хувьцаанаас бусад үнэт цаас, өрийг хувьцаагаар сольж болно. Үүнийг "өрийг хувьцаагаар солих гэнэ" хэмээн хуульд томъёолон тодорхойлжээ. Компанийн өрийг хувьцаагаар солиход хувьцаа авах тухайн зээлдүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна. Жишээлбэл, энэ ажиллагааг зээлдүүлэгч, харилцагчтай тохиролцож, түүний зөвшөөрлийг авсан байхыг шаардаж байна.

Түүнчлэн зээлдүүлэгч, харилцагчтай байгуулсан гэрээнд өөр байдлаар заасан бол тухайн гэрээний нөхцлийн дагуу шийвэрлэгдэх магадлалтай. Жишээ нь: Нэхэмжлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авахгүйгээр үнэт цаас,

өрийг хувьцаагаар сольж болох талаар гэрээнд заасан байж болно.

Компанийн өрийг хувьцаагаар солих тухай төсөл боловсруулна. Боловсруулсан төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэнэ. Компанийн тухай хуулийн 25.3-т "саналын эрхийн дийлэнхи олонх" гэж заагаагүй. Харин хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж заажээ. Шийдвэрлэх асуудлын мөн чанартай холбон үзвэл саналын эрхийн "дийлэнх олонхоор шийдвэрлэх"-ээр компанийн дүрэмд тусгах нь зохистой.



Эдгээрээс гадна шаардлага бүхий бусад асуудлыг өрийг хувьцаагаар солих тухай төсөлд зааж өгсөн байх ёстой.

Өрийг хувьцаагаар сольсонд тооцохгүй байх нөхцөлийг тодруулан авч үзвэл:

1-рт: Хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг ;

2-рт: Хувьцаанд хөрвөх үнэт цаас. Эдгээрийг хөрвөх нөхцөлийн дагуу хөрвүүлэхийг компанийн өрийг хувьцаагаар сольсон гэж үзэхгүй.

Худалдан авах давуу эрх.

Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд авах эрхтэй. Үүнийг худалдан авах давуу эрх гэж ойлгоно.

26 дугаар зүйл. Компанийг татан буулгах

26.1 Компанийг хувьцаа эзэмшигчийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

26.2 Шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана.

- 26.2.1 дампуурсан;
- 26.2.2 нэг ч гишүүн үлдээгүй;
- 26.2.3 хуульд заасан бусад үндэслэл.

26.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчийн нэхэмжлэлийг барагдуулсаны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг

хувьцаа эзэмшигчдийн хурал оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор шийдвэрлэнэ.

26.4 Татан буулгах комиссыг томилсоор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно.

26.5 Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.

26.6 Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 26.2-т заасан үндэслэлээр хувьцаат компанийг татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

1. Хуульд компанийг татан буулгах эрх зүйн үндэслэлийг дараах байдлаар тодорхойлжээ.



Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгахдаа Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, тухайн компанийн дүрэмд заасны дагуу татан буулгана. Иргэний хуулийн 32 дугаар зүйлд өмчлөгч буюу түүнээс эрх олгосон субъект, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан, мөн үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан, цаашид үйл ажиллагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан, хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан нь татан буулгах үндэслэл болохоор заасан байна.

2. Компанийг татан буулгахдаа компанийн дүрэмд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, Иргэний хуулийн 32 дугаар зүйлд компанийн хуулийн холбогдох заалт, компанийн дүрэм зэрэгт тогтоосон журамд нийцүүлэн татан буулгах ёстой.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийг татан буулгахдаа дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийг татан буулгах комисс томилох;
- татан буулгах хугацааг тогтоох;
- Компанийг татан буулгах журмыг батлах;
- Зээлдүүлэгч болон бусад харилцагчдын нэхэмжлэлийг барагдуулах; Энд компанийн өр төлбөрийг бүрэн төлж барагдуулах, бусад этгээдээс авах авлагыг бүрэн шаардан авах асуудал хамаарна;

е. Компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэрэг бусад шаардлагатай асуудлыг шийдвэрлэнэ.

Эдгээр асуудлыг тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна. Татан буугдаж байгаа компани төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол дээрх асуудлыг шийдвэрлэх төслийг тухайн компанийн гүйцэтгэх удирдлага боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Дээр дурдсан асуудлуудыг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор шийдвэрлэнэ. Эдгээр ойлголтыг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т зохицуулсан байна.

3. Шүүх татан буулгах. Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 заалтад шүүх компанийг татан буулгах үндэслэлийг тодорхойлжээ. Үүнд:

а. Компани дампуурсан. Энэ нь Дампуурлын тухай хуулиар зохицуулагдана. Шүүх дампуурлын хэргийг дараах үндэслэлээр үүсгэж, хянан шийдвэрлэнэ.

1. Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан.
2. Компани харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан.

Нэхэмжлэл ба хүсэлт нь Дампуурлын тухай хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл шүүгч дампуурлын хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна. Шүүх Дампуурлын тухай хуулийн зохицуулалтад үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.10, 1551 дүгээр зүйлд заасны дагуу хянан шийдвэрлэнэ. Компанийг дампуурсанд тооцож, татан буулгах шийдвэр гаргана¹.

Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтаар "нэг ч гишүүн үлдээгүй нь шүүх компанийг татан буулгах үндэслэл болно гэж заажээ. Энэ заалт нь компанийн эрх зүйн байдалтай холбогдоно. Компани хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, эрх зүйн чадамжийг цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсон гэж ойлгож болно. Компанийг нэг ч гишүүн үлдээгүй үндэслэлээр татан буулгах нь түүний хуулийн этгээдийн хувьд бусад этгээд эрх залгамжлаагүй, эрх ба үүрэг нь шилжих боломжгүй болсон гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл, компанид нэг ч хувьцаа эзэмшигч² байхгүй, үлдээгүй нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлд

¹ Шүүх компанийг дампуурсанд тооцож, татан буулгах талаар "Дампуурлын эрх зүйн гарын авлага. Хуудалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл". Боловсруулсан А.Мөнхзул, Л.Энхбилэг, У.Мөнхбат. Хянан тохиолдуулсан А.Доржготов, Т. Алтангэрэл. УБ., 2014 он. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Б.Ундрах, Ц.Амарсайхан, А.Доржготов, Д.Тунгалаг. УБ., 2014 он. 3 дахь хэвлэл. хуудас 341-378-аас тодруулан үзэж болно.

² Н.Чинбат. "Иргэний эрх зүйн лекцийн товчоон" (Ерөнхий анги) номондоо "хязгаардагдмал харилцагатай компанийн оролцогчдыг хувьцаа эзэмшигч биш хуви эзэмшигч гэдэг утгаар тодорхойлох... гэжээ." УБ., 2014 он. Хуудас 99

заасан “Компани” байх үндсэн шинжээ алдана. Үүний улмаас Компанийн тухай хууль, дүрэмдээ заасан компанийн үйл ажиллагааны чиглэл, удирдлагыг хэрэгжүүлэх боломжгүй болно. Иймээс түүнийг татан буулгах үндэслэл болно гэж ойлгон хэрэгжүүлж болох юм.

b. Компанийн тухай хуулийн 26.2.3-д шүүх “Хуульд заасан бусад үндэслэлээр” татан буулгахаар заажээ.

Энэ нь Компанийн тухай хуулиас бусад хуульд зааснаар компанийг татан буулгаж болно гэж ойлгогдож байна. Хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах гэдгийг ойлгохдоо тодорхой төрлийн харилцааны онцлогтой холбоотойгоор татан буулгах асуудлыг шийдвэрлэж байх зохицуулалтыг тодорхойлж болдог¹.

Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т “Хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн” хуульд заасан бусад үндэслэлээр хуулийн этгээдийг татан буулгах тухай шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болохоор заажээ. Нөхөрлөл, компанийн тухай Монгол Улсын хууль (1995.05.11)-ийн 14 дүгээр зүйлд шүүх нөхөрлөл, компанийг татан буулгах үндэслэлд “хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн” гэсэн заалт байжээ.

Монгол Улсын Дээд шүүх тайлбарлахдаа: хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дүгээр заалтын “хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн” гэсний “удаа дараа зөрчсөн” гэдгийг Монгол улсын хууль тогтоомжийг нөхөрлөл, компани нь

гурав буюу түүнээс дээш зөрчсөнийг, “ноцтой зөрчсөн” гэдгийг нөхөрлөл, компани нь дүрмийн санг хуурамчаар бүрдүүлсэн буюу дүрмийн санг багасгаснаа бүртгүүлээгүй, тусгай зөвшөөрөл шаардлагатай буюу хориотой үйлдвэрлэл, үйлчилгээг хууль бусаар эрхэлсэн, тайлан тэнцлээ санаатай будлиантуулж, татвараас зайлсхийсэн, хууль тогтоомжийг бусад хэлбэрээр зөрчсөн нь төр, иргэд, аж ахуй нэгж, бусад байгууллагад их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болох байсан зэргийг ойлгох бөгөөд эдгээр нь нөхөрлөл, компанийг татан буулгах үндэслэл болж болно” гэжээ². Энэ заалт Компанийн тухай 1999 оны хуулиар компанийн хуулиас хасагдаж, харин нөхөрлөлийн хувьд хэвээрээ үлджээ.

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) Монгол улсын хууль (2015.12.03)-д “Шүүх гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж заасны дотор “татан буулгах албадлагын арга хэмжээ” (§9.2.2) гэж заажээ. Мөн “хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах арга хэмжээ хэрэглэнэ.”, “хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөнтөлөхөд зарцуулж үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх” асуудлыг шүүх шийдвэрлэнэ.”, “хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчдийн газар

² Нөхөрлөл, компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 1997 оны 10 сарын 13-ны өдрийн 380 дугаар тогтоол. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010) УБ., 2013 он. Хуудас 582.

¹ Н.Чинбат. “Иргэний эрх зүйн лекцийн товчоон”. (Бронхийн анги) УБ., 2014 он. Хуудас 92

нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчдийн газрыг татан буулгаж болно” (§9.5) гэж тус тус заасан байна.¹ Эдгээр заалт нь хуульд заасан бусад үндэслэлд хамаарна.

4. Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болгох. Компанийг татан буулгах комиссыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхийн шийдвэрээр томилно. Ийнхүү татан буулгах комиссыг байгуулж, комиссын дарга, гишүүнийг томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болно.

Компанийг татан буулгах ажиллагаа хэрэгжүүлэх бүрэн эрх татан буулгах комисст шилжинэ. Татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно хэмээн хуулийн 26.4-т заажээ. Энэ нь хууль хэрэглэх онол, арга зүйн талаас үзвэл дэлгэрүүлэн хэрэглэх ойлголт гэж үзэх ёстой. Учир нь татан буулгах комисс нь компанийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн дийлэнхи олонхоор батлагдсан журам, өр төлбөрийг барагдуулах, үлдсэн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах зэрэг өргөн эрхийг хэрэгжүүлдэг.

Компанийг татан буулгах комисс бол шүүх, арбитр, асуудал шийдвэрлэх эрх бүхий бусад этгээдэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах зэргээр харилцах, шүүх арбитрын хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд болон хуралдаан оролцож мэтгэлцэх зэргээр компанийн эрх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах ажиллагааг идэвхтэй явуулах ёстой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад компанийг төлөөлөн хэргийн оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ гэж ойлгож хэрэглэх нь зүйтэй.

5. Хохирол нөхөн төлнө. Татан буулгах комисс үүргээ шударгаар, хариуцлагатай гүйцэтгэх үүрэгтэй. Татан буулгах комисс нь түүнийг байгуулсан этгээд, компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналтан дор, хууль болон комиссын үйл ажиллагаа явуулах журамд захирагдан дагаж мөрдөнө.

Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэхдээ гаргасан алдаа дутагдал буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компани болон зээлдүүлэгчид (компанийн харилцагч буюу төлбөр авагчид) хохирол учруулсан бол нөхөн төлнө. Хохирлыг нөхөн төлөхдөө хуульд заасан журмыг баримтална.

6. Хуулийн 26.6-д зааснаар санхүүгийн зохицуулах хороо **шүүхэд нэхэмжлэл** гаргах эрхийг тогтоожээ. Энэ нь шүүх компанийг татан буулгах үндэслэлд хамааралтай байна. Санхүүгийн зохицуулах хороо зөвхөн **хувьцаат компанийг** татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Шүүхэд нэхэмжлэл гаргаж болох үндэслэл нь компани дампуурсан, нэг ч гишүүн үлдээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр хязгаарлагдана.

¹ Төрийн мэдээлэл эмхтгэл. 2016 он №7.

27 дугаар зүйл. Компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам

27.1 Компанийг татан буулгах үед түүний өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө.

27.2 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээллэх бөгөөд нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна.

27.3 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

27.4 Компанийг татан буулгах тухай шийдвэр гаргах үед тухайн компани нь ямар нэгэн өр төлбөргүй бол уг компанийг татан буулгах тухай мэдэгдлийг нийтэд мэдээлэхгүйгээр татан буулгаж болно.

27.5 Энэ хуулийн 27.4-т заасан тохиолдолд компанийн эд хөрөнгийг энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

27.6 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссанаар татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийн тухай мэдээ, зээлдүүлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэх

дүнг агуулсан татан буулгах балансыг гаргах бөгөөд түүнийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

27.7 Татан буулгах комисс нь нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх бөгөөд зээлдүүлэгчид нь энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл татан буулгах балансыг гаргах бөгөөд түүнийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

27.8 Хэрэв татан буугдаж байгаа компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс нь компанийн бусад эд хөрөнгийг худалдана.

27.9 Энэ хуулийн 27.8-д заасны дагуу татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг худалдах нь энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохоор бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу дуудлага худалдаагаар худалдана.

27.10 Татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн зээлдүүлэгчдийн өр төлбөрийг татан буулгах балансыг баталсан өдрөөс эхлэн тус балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дарааллын дагуу барагдуулна.

27.11 Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсан тухай

мэдэгдлийг компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээдэд явуулсанаас хойш 30 хоногийн дотор эцсийн баланс гаргана.

27.12 Энэ хуулийн 27.11-д заасан эцсийн балансыг гаргаснаас хойш шүүх тусгайлан шийдвэрлээгүй бол аливаа нэхэмжлэлийг хүлээн авахгүй.

Тайлбар:

Компанийг татан буулгах үед өр төлбөрийг барагдуулах ажиллагаа чухал суурь эзэлдэг.



200

Хуулийн 27 дугаар зүйлд компанийг татан буулгахад өр төлбөрийг хэрхэн барагдуулах асуудлыг журамлан тогтоожээ. Энэ ажиллагааг хууль тогтоомж, нэхэмжлэх хугацаа, түүнийг хэрхэн мэдэгдэх, эд хөрөнгийг хуваарилах, татан буулгах тайлан тэнцэл гаргах, татан буулгах комиссын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах, компанийн эд хөрөнгийг худалдах, татан буулгах ажлын эцсийн тайлан, тэнцэл, баланс гаргах, энэ нь аливаа нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх нөхцөл, журмыг зохицуулсан.

а. Иргэний хуульд “Хуулийн этгээд”-ийн талаар Дөрөвдүгээр бүлэг, 25-34 дүгээр зүйлүүдэд заасан зохицуулалтуудаас гадна уг хуулиар тогтоосон хэлцэл, хугацаа, эдийн болон эдийн бус

баялагийн эрх, өмч, барьцааны эрх зүйн зохицуулалт, үүргийн болон иргэний эрх зүй, гэрээний бус үүрэг зэрэг холбогдох заалтууд компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам, түүнийг хэрэгжүүлэх ажиллагааны эрх зүйн эх сурвалж болно.

б. Компанийн тухай хуулийн компанийг татан буулгах (§26), компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам (§27), татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах (§28) зэрэг шууд эх сурвалжаас гадна “компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өрийг хувьцаагаар солих” гэсэн дөрөвдүгээр бүлэг (§18-29), “Компанийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаас зэрэг бусад бүлэг, зүйл заалтуудад бүхэлдээ компанийг татан буулгах, өр төлбөрийг барагдуулах журам, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн эх сурвалж болно.

с. Компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан “бусад хуулийг дагаж мөрдөнө” гэсэн заалтад компанийн үйл ажиллагаа, түүнийг татан буулгах харилцааг зохицуулсан, Дампуурлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль

(шинэчилсэн найруулга), Татварын хууль тогтоомж зэрэг хамаарал бүхий хуулиуд компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх эх сурвалж болно.

Нэхэмжлэл гаргах хугацаа.

Компанийг татан буулгах комисс нь тухайн компанийг татан буулгах бүхий л ажиллагааг хариуцан зохион байгуулдаг. Татан буулгах комиссыг томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болно. Гүйцэтгэх удирдлагын эрх үүрэг, түүний бүрэн эрх татан буулгах комисст шилжинэ. Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т зааснаар "татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно."¹

Татан буулгах комисс нь дараах асуудлыг нийтэд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

- Компанийг татан буулгах журмыг мэдээлнэ.
- татан буулгах комисст нэхэмжлэл гаргах журмыг мэдээлнэ.
- татан буулгах хугацаа, энэ

хугацааны дотор татан буулгах комисст нэхэмжлэл гаргах хугацааг мэдээлэх ёстой.

Нэхэмжлэл гаргах хугацаа нь компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байхаар тогтооно. Ийнхүү хугацаа тогтоох нь компанийг татан буулгах, өр төлбөр нэхэмжлэлийг барагдуулж дуусгахад эрх зүйн чухал ач холбогдолтой байдаг. Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нэхэмжлэл гаргах, зээлдүүлэгч эрхээ хамгаалах боломжийг илэрхийлдэг. Хугацаа зааж байгаа зорилго нь татан буугдаж байгаа компанийн эдийн баялагтай холбоотой үүргийг шийдвэрлэх, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа хэлбэр юм.²

Бичгээр мэдэгдэх. Компанийг татан буулгах комиссын мэдэгдэл хэлбэрийн хувьд бичгийн хэлбэрээр илэрхийлэгдсэн байх ёстой. Татан буулгах комиссын бичгээр мэдэгдэх үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн бичигт:

- a. Компанийг татан буулгах тухай;
- b. түүнийг татан буулгах журам;
- c. нэхэмжлэл гаргах журам;
- d. татан буулгах хийгээд нэхэмжлэл гаргах хугацаа зэргийг бүрэн тусгах ёстой.

Эдгээр асуудлыг тусгасан мэдэгдлийг зээлдүүлэгч болон компанин зээл тооцооны үүрэг болон эдийн баялагтай холбоотой нийт харилцагчдад хүргүүлэх үүрэгтэй гэж ойлгож хэрэглэх нь зүйтэй. Бичгээр мэдэгдэхээс гадна татан буулгах тухай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл,

¹ Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.6 дахь заалт "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах эрхтэй." Хуулийн 26.4-т "Компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно" гэж заасан. Эдгээрийг харгалзан үзэж татан буулгах комисс томилж, татан буулгах журамд дэлгэрэнгүй ойлгомжтой заах нь зохистой гэж үзнэ. Түүнчлэн нэр томьёоны хувьд "шүүх хуралдаан" гэхийг "шүүх хурал" гэж хуульд бичсэн. Улмаар шүүхэд хэрэг явнан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, арбитрт төлөөлөх тэргийг явцуу томьёолсон. Иймээс энэ томьёолсон эрх зүйн агуулгаар дэлгэрэнгүй ойлголтоор хуулийн заалтын хэрэглэх нь зүйтэй.

² Н.Цинбат. "Цргэний эрх зүйн лекцийн товчоон". УБ., 2014 он. Хуудас 93.

хэвлэлээр нийтэд зарлан мэдэгдэх нь харилцагчийн нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах чухал ач холбогдолтой байдаг.

Нийтэд мэдээллэхгүйгээр татан буулгах. Компанийн тухай хуульд зааснаар компанийг татан буулгах тухай мэдээллийг нийтэд мэдээллэхгүй татан буулгаж болно. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтын агуулгаас үзвэл нийтэд мэдээллэхгүйгээр татан буулгаж болох шалгуур нь тухайн компаниас ямар нэгэн өр төлбөргүй байх явдал юм. Энэ **өр төлбөргүй** байдал компанийг татан буулгах тухай шийдвэр гаргах үед хамаарч байна.

“Өр” гэдэг үгийн утга нь бусдад зээлдүүлсэн зүйлээ буцаан авах, бусдад өгөх зүйлээ өгч гүйцээх, өгөөгүй байх” гэсэн утга санааг илэрхийлдэг ажээ. Өр төлбөр гэдэг ойлголтыг эдийн засгийн агуулгаар нь тухайн компанийн бусад байгууллагын өмнө хүлээх санхүүгийн үүрэг хариуцлага буюу бусдаас зээлээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад үүссэн үр дүн юм. Өр төлбөрийг гадаад эх үүсвэр гэж үздэг.

Өр төлбөрийг төлөгдөх байдлаар нь хоёр ангилдаг. Нэгд, богино хугацаат өр төлбөр, Хоёрт, урт хугацаат өр төлбөр. **Богино хугацаат өр төлбөр** гэдэг нь нэг жилийн дотор төлөгддөг өрийг хэлнэ. **Урт хугацаат өр төлбөр** гэдэг нь жилээс дээш хугацаанд төлөгддөг өрийг хэлнэ. Эргэлтийн хөрөнгөөр, компанийн үйл ажиллагааны ашгаар төлдөг. Өр төлбөр эхний болон эцсийн үлдэгдэл, тайлан тэнцлээр тодорхойлогддог.

Өр төлбөр нь аж ахуй нэгж, байгууллагын бусдын өмнө хүлээсэн

эдийн засгийн хариуцлага юм. Өр төлбөрт бусдад өгөх төрөл бүрийн өглөг, ирээдүйд үзүүлэх үйлчилгээний төлбөрийг урьдчилан авсан орлого хамаарна.

Барагдуулах хугацаа, шинж чанараас нь хамааруулан өр төлбөрийг дараах байдлаар ангилж бүртгэнэ. Өр төлбөр нь балансын өдөр тодорхой дүнтэй эсвэл тухайн аж ахуй нэгж, байгууллага хянаж чадахааргүй ирээдүйн үйл явдлаас хамаарсан байж болох бөгөөд энэ тохиолдолд дүнг тооцоолно. Дүнг нь хэнд төлөх нь тодорхой өрийг жинхэнэ өр төлбөр гэж үзэх бөгөөд энэ хэмжээгээр тайлан тэнцэлд тусгана.

Тооцоолсон өр төлбөр гэдэг нь одоо өр төлбөр болоогүй боловч ирээдүйд өр төлбөр болох эсвэл болохгүй ч байж болох өр юм. Болзошгүй өр төлбөрийг жинхэнэ өр төлбөрөөс тусгаарлах хэрэгтэй бөгөөд ихэвчлэн санхүүгийн тайлангийн тодруулгаар илэрхийлэгдэнэ.

Өр төлбөрийг үүссэн хугацаагаар нь:

- a. Богино хугацаатай - Бизнесийн үйл ажиллагааны хэвийн эргэлтийн эсвэл одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр эсвэл богино хугацаат өөр өр төлбөр үүсгэх замаар барагдах үүрэг хариуцлага юм.
- b. Урт хугацаатай - Урт хугацаат өр төлбөр гэдэг нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн эргэлт эсвэл нэг жилийн хугацаанд төлөгдөхгүй буюу 1 жилийн дотор одоо байгаа эргэлийн хөрөнгөөр барагдахгүй үүрэг хариуцлага хамаардаг байна.¹

¹ Тус ойлголтыг бичихдээ www.sanhuu.mn сайгыг ангилжасан болно.

Хууль зүйн ойлголтоор “Өр” гэдэг нь төлөх үүрэгтэй төлбөрийг төлөөгүйгээс эсхүл хугацаа хэтрүүлсэнээс үүссэн мөнгөн төлбөр юм. Өр дараах тохиолдолд үүсдэг байна.

- хэрэглэсэн үйлчилгээний төлбөрөө төлөөгүй (нийтийн болон бусад тээвэр, байрны хөлс, түрээс, газ, цахилгаан эрчим хүч, харилцаа холбоо, утас, интернет зэрэг);
- хуульд заасан үүрэг төлбөрийг хугацаанд нь төлөөгүй (нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, албан татвар, хураамж, төлбөр, ашигт матмалын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн гэх мэт);
- Гэрээгээр хүлээсэн, зээл тооцооны үүрэг буюу зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй (ИХ§ 281-286);
- Батлан даалт, баталгаа гаргаснаас үүсэн буй болсон үүрэг;
- Хуульд зааснаар үүсэх үүргийн харилцаатай холбоотой (дундын өмчийн, үндэслэлгүйгээр хөрөнгөжих (ИХ§487-496/), зөрчлийн улмаас үүсэх үүрэг гэм хор учруулсаны (ИХ§497-514) зэрэг, гэрээний ба гэрээний бус үүргээс үүсч бий болсон бүх төрлийн өр төлбөрийг хамааруулан ойлгож болно.

Өр төлбөрийг хүчингүй болгох.

Өрийг хүчингүй болгосноор өр, төлбөрийн үүрэг дуусгавар болдог. Энэ талаарх зохицуулалтыг Иргэний хуулийн 239 дүгээр зүйлд зохицуулсан байх бөгөөд өр, авлага бүхий талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр

өрийг хүчингүй болгож болно. Энэ нь үүрэг буюу өр төлбөр дуусгавар болгох нэгэн үндэслэл болдог. Үндсэн үүрэг гүйцэтгэгчийн өрийг хүчингүй болгосноор батлан даагч буюу баталгаа гаргагч үүргээс чөлөөлөгдөнө. Энэ нь компанийг өр төлбөргүй гэж үзэх үндэслэл болох юм.

Төлбөр. Хууль зүйн ойлголтоор төлбөр гэдгийг дангаар нь хэрэглэхэд өр төлбөрөөс өөр байдлаар ойлгогдож болно. Тухайлбал, санхүүгийн болон захиргааны эрх зүйн ойлголтоор “төлбөр” гэдгийг газар эзэмшсэний болон газрын хэвлийг, түүний доорхи баялаг, ой, усны нөөц ашигласны төлөө, иргэн аж ахуй нэгж, байгууллагаас улс, орон нутгийн төсөвт, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө гэх томьёоллоор ойлголтыг илэрхийлнэ.

Нөгөө талаар банкаар дамжуулан хийгдэх мөнгөн хадгаламж, зээл, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээний цогц гэж тодорхойлдог байна. Тухайлбал, агнуурын нөөц ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, газрын төлбөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, ус, рашаан ашигласны, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон, агаарын бохирдлын төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр гэх мэт олон төрлийн төлбөрийг нэрлэж болно.

¹ Татварын ерөнхий хууль (1992), Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан аглах, барих зөвшөөрлийн тухай (1995), Байгалийн баялаг ашигласны төлбөрийн тухай (1995), Агаарын бохирдлын төлбөрийн тухай (2010), Агаарын тухай хууль (2012), Аллагт малгамалын тухай (2006), Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай (1995), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өмчийн тэтгэвэр.

Компанийг татан буулгах шийдвэр гаргах үед өр төлбөргүй байсан үндэслэлээр нийтэд мэдээлэхгүйгээр татан буулгасан бол, татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хуваарилах ажиллагааг татан буулгах комисс хууль, компанийн дүрэм, татан буулгах журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Татан буулгах баланс. Компанийг татан буулгах тайлан тэнцлийг гаргаж, татан буулгах ажиллагааг дуусгавар болгоно. Энэ нь эрх зүйн тодорхой үр дагаврыг бий болгоно. Компанийн тухай хуулийн 27 дугаар зүйлд хоёр төрлийн баланс гаргахаар зохицуулсан байна. Үүнд:

1. Татан буулгах баланс гаргах ;
2. Эцсийн баланс гаргах.

Хуулийн 27.6-д зааснаар татан буулгах баланс гаргана. Татан буулгах баланс нь дараах агуулгыг тусгасан байх ёстой. Үүнд:

- Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийн тухай мэдээ;
- Зээлдүүлэгчийн /харилцагч/ гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүний дүн;
- Нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэх талаар болон түүний дүн.

Эдгээр мэдээ, шаардлагыг хэрхэн шийдвэрлэх дүн зэрэг нь нэхэмжлэл гаргах хугацаа дууссан үеэр тооцоологдон тодорхойлогдсон байх ойлголтыг илэрхийлж байна.

тэтгэмж, төлбөрийн тухай (1994) ажиглах хүч, гадаадад гаргах, гадаадаас ажиглах хүч, мэргэжилтэн авах тухай (2001) тэрэг олон хууль тогтоомжийг гэрлэн зааж болно.

Татан буулгах балансыг татан буулгах комисс гаргана. Түүний гаргасан балансыг тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл батална. Тус компани төлөөлөн удирдах зөвлөлгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлахаар зохицуулжээ. Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх татан буулгах комисс байгуулагдсанаар дуусгавар болж түүнд шилждэг тул ямар нэгэн оролцоо байхгүй, эрх, үүрэггүй болно.

Хуулийн 27.11-д заасан эцсийн баланс гаргах ажиллагаа өр төлбөрийг барагдуулсан байдалтай хамааралтай байна. Татан буулгах комисс тухайн компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээдэд мэдэгдэл явуулна. Мэдэгдлийн агуулгад тухайн татан буулгаж байгаа компанийн өр төлбөрийг хэрхэн барагдуулсан тухай тусгагдана. Мэдэгдлийг эрх бүхий этгээдэд явуулснаас хойш 30 хоногийн дотор эцсийн балансыг татан буулгах комисс гаргана.

Энд **"шийдвэр гаргасан эрх бүхий этгээд"** гэдгийг хуулийн 26.1-д заасан шийдвэр гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурал, шүүх, бусад хуулиар эрх олгосон этгээдүүд хамааруулан ойлгож болох юм.

Шүүхэд гомдол гаргах. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах талаар зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Мэдээж нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн барагдуулах асуудлыг ойлгомжтой, тодорхой тусгасан байх шаардлагатай. Татан буулгах комиссын бичгээр мэдэгдсэн шийдвэрийг зээлдүүлэгч

хүлээн авах үндэслэлгүй гэж үзсэн, улмаар хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.

Нэхэмжлэгч шүүхэд гомдол гаргах эрхээ татан буулгах баланс батлагдахаас өмнө хэрэгжүүлэх ёстой. Энд процессын эрх зүйн үүднээс тайлбарлахад татан буулгах баланс баталсны дараа шүүхэд гомдол гаргасан тохиолдолд гомдлыг шүүхэд хүлээж авахаас татгалзах үндэслэл болох юм. Энэ нь зээлдүүлэгч татан буулгах комиссын нэхэмжлэл, шаардлагыг барагдуулах талаар гаргасан шийдвэрийг эс зөвшөөрөх, улмаар шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болно гэсэн үг. Үүний шалгуур нь татан буулгах баланс батлагдсан эсэхээс хамаарч байна.

Эд хөрөнгийг удирдах.

Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөр хариуцлага хүлээдэг. Компанийн балансд тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэдэг. Эдгээр ойлголт нь компанийн өр төлбөрийг барагдуулах, нэхэмжлэлийг барагдуулахад хамааралтай юм.

Мөнгөн хөрөнгө. Компанийн эргэлтийн хөрөнгийн нэг чухал хэсэг бол мөнгөн хөрөнгө байдаг. Мөнгөн хөрөнгө гэж тайлант үеийн үйл ажиллагаа шууд ашиглагдах аливаа хязгаарлалттай мөнгө буюу мөнгөтэй адилтгах зүйлс орно.

“Мөнгөтэй адилтгах хөрөнгө” гэдэгт мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг үнэт

цаас болон богино хугацаатай хөрөнгө оруулалтыг хамааруулдаг байна. Компанийн касс болон харилцах дансанд байгаа төгрөг, гадаад валют, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлсийг мөнгөн хөрөнгөд хамааруулан компанийн балансд тусгадаг ажээ. Эдгээр хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулах хөрөнгөд хамаарна.

Хуулийн 27.8 дахь заалт нь татан буугдаж байгаа компанийн мөнгөн хөрөнгөөр нэхэмжлэлийг эхний ээлжинд барагдуулна. Хэрэв мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийн шаардлагыг барагдуулахад хүрэлцэхгүй байх тохиолдолд компанийн мөнгөн хөрөнгөөс бусад эд хөрөнгийг худалдах замаар нэхэмжлэлийн шаардлагыг барагдуулах тухай заажээ. Энэ тохиолдолд компанийн бусад хөрөнгийг худалдах ажиллагааг татан буулгах комисс хэрэгжүүлнэ.

Дуудлагаар худалдах. Татан буугдаж байгаа компанийн мөнгөн хөрөнгө нэхэмжлэлийн шаардлагыг барагдуулахад хүрэлцэхгүй гэсэн үндэслэлээр компанийн эд хөрөнгийг худалдах ажиллагааг дуудлага худалдаагаар хэрэгжүүлэх тохиолдлыг хуулийн 27.9-д зохицуулжээ. Энд зааснаар дараах тохиолдолд эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдана. Үүнд:

а. Татан буулгах комисс компанийн эд хөрөнгийг худалдах нь компанийн хуульд заасан сонирхолын зерчилтэй хэлцэлд тооцогдохоор бол¹;

¹ Компанийн тухай Монгол улсын хуулийн

b. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу дуудлагаар худалдах.

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарах хэрэгтэй болно.

1. Энэ тохиолдолд компанийн эд хөрөнгийг Иргэний хуульд заасан үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулах зохицуулалтыг хэрэглэх боломжгүй.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу дуудлагаар худалдах ажиллагааг компанийг татан буулгасан (§26.2) тохиолдолд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж болно.

Харин компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хуульд зааснаар бусад эрх бүхий этгээд татан буулгахаар шийдвэрлэсэн тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасны дагуу дуудлага худалдаа явуулах асуудал хүндрэлтэй гэж үзэж болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн шүүхийн шийдвэр, шүүхээр баталгаажсан цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатын мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэрт үндэслэн явуулах ёстой¹.

Өр барагдуулах дараалал.

Татан буулгах тайлан тэнцэл (баланс) батлагдсан үеэс эхлэн татан буугдаж байгаа компанийн өр төлбөрийг барагдуулах ажиллагааг эхлэх нөхцөл бүрдэнэ. Энэ талаар хуулийн 27.10 дахь

(шигнэжээсн найруулга) 89-93 дугаар зүйлд "сонирхолын зөрчилтэй хэлцэл"-ийг зохицуулсан.

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйл.

заалтад зохицуулсан байна. Энд зааснаар татан буулгах комисс зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулах талаар дараах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

a. Зээлдүүлэгчийн өр төлбөрийг татан буулгах балансыг батлагдсан өдрөөс эхлэн тус балансын дагуу барагдуулах ажиллагаа явуулна.

b. Иргэний хуульд болон Компанийн тухай хуульд заасан дарааллын дагуу өр төлбөрийг барагдуулах ажиллагааг явуулна.

Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангах дарааллыг тогтоосон. Үүнд:

1-рт: бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр;

2-рт: Хэрэг гүйцэтгэгч, татан буулгах комисс, тэдгээрийг адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;

3-рт: Дампуурлын үед хариуцагчийн дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ хэлцлийн дагуу гаргасан шаардлага;

4-рт: Хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;

5-рт: Хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;

6-рт: Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс /цалин/;

7-рт: Хууль тогтоомжид заасны дагуу

бусад этгээдтэй хийх тооцоо гэсэн дарааллын дагуу татан буугдаж байгаа компанийн өр төлбөрийг барагдуулна гэж ойлгогдож байна.

Татан буугдаж байгаа компанийн холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсаны дараа түүний дараагийн дараалалд байгаа төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

Компанийн тухай хуульд зааснаар татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх бөгөөд уг бичигт өр төлбөрийг барагдуулах дараалал болон бусад асуудал бүрэн шийдвэрлэгдсэн байх ёстой. Энэ талаар зээлдүүлэгч шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дээр тайлбарласан болно.

Нэхэмжлэл хүлээн авахгүй байх үндэслэл. Татан буулгаж байгаа компанийг татан буулгах эцсийн баланс гарснаас хойш аливаа нэхэмжлэлийг хүлээн авахгүй. Тухайлбал, татан буугдаж байгаа компанитай холбогдох нэхэмжлэл гаргах эрх, өр төлбөр дуусгавар болно.

Харин хуулийн 27.12 дахь заалтад “шүүх тусгайлан шийдвэрлээгүй бол” нэхэмжлэлийг хүлээн авахгүй гэж заажээ. Тэгэхлээр эцсийн баланс гарснаас хойш “шүүх тусгайлан шийдвэрлэсэн бол” нэхэмжлэлийг хүлээн авах тухай ойлголт бий болгож байна. Иймээс “шүүх тусгайлан шийдвэрлэх” гэдгийг тухайн компанийн холбогдолтой өр төлбөрийн тухай маргаантай асуудлыг шүүх хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байсан, улмаар шүүхийн шийдвэр, компанийг татан буулгах эцсийн баланс гарсны

дараа гарсан буюу хүчин төгөлдөр болсон тохиолдлыг хамруулан ойлгон хэрэглэж болох юм. Харин компанийг татан буулгах тайлан тэнцэл (баланс) гарсны дараа шүүхэд нэхэмжлэл гаргах замаар шүүхийн шийдвэр гаргуулсан бол шүүх тусгайлан шийдвэрлэсэн гэх ойлголтод хамаарах үндэслэлгүй. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.10-т заасан “хуулийн этгээд татан буугдсан” тохиолдолд хамаарна.

Хувь тэнцүүлэх. Татан буулгаж байгаа компанийн өөрийн хөрөнгө /нийт эд хөрөнгө/ төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол хувь тэнцүүлэн хуваарилах зарчмаар өр төлбөрийг барагдуулна.¹ Энэ нь татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн өр төлбөрийг барагдуулсан ч гэсэн хууль болон татан буулгах, өр төлбөр барагдуулах журамд заасан дарааллын дагуу, түүнийг хатуу баримтлан хэрэгжүүлэх шаардлагатай.

28 дугаар зүйл. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хуваарилах

28.1 Татан буулгах комисс нь зээлдүүлэгч болон бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсаны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг дараах дарааллын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

¹ Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д “хувь тэнцүүлэн хуваарилах замаар өр төлбөрийг барагдуулах тухай ойлголт”-ыг тодорхойлсон.

28.1.1. давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг болон давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ, түүнчлэн энэ хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу эргүүлэн худалдаж авах давуу эрхийн хувьцааны төлбөр.

28.1.2. энэ хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу эргүүлэн худалдаж авах энгийн хувьцааны төлбөр.


28.2 Энэ хуулийн 28.1-д заасны дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хуваарилна.

Тайлбар:

Компанийн хуулийн 28 дугаар зүйлд татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам, эргүүлэн худалдаж авах болон давуу эрхийн хувьцааны төлбөр, энгийн хувьцааны төлбөр, хувь тэнцүүлэн хуваарилах зарчмыг тодорхойлон зохицуулсан байна.

Орлого хуваарилах дараалал.

Татан буулгах комисс эхний ээлжинд зээлдүүлэгч, бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулна. Дараа нь компанийн үлдсэн эд хөрөнгийг худалдана. Ийнхүү худалдсанаас олсон орлогоос дарааллын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.



Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг дээр хүснэгтэд үзүүлсэн байдлаар дараалал тогтоож, хувьцаа эзэмшигчид хуваарилахаар хуулийн зохицуулалт ойлгогдож байна.

Давуу эрхийн хувьцааны төлбөр. Хуулийн 28.1.1-д давуу эрхийн хувьцааны төлбөрийг хуваарилах эрх зүйн үндэслэлийг тогтоон зохицуулжээ. Мөн хуулийн 35 дугаар зүйлд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг тодорхойлсон байдаг. Энэ заалтад үндэслэн давуу эрхийн хувьцаа, түүний үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлж болно.

Давуу эрхийн хувьцаа. Компанийн урт хугацаанд санхүүжилтийн арга юм. Зээлийн ба хувьцаат капиталын аль алиных нь шинж чанарыг агуулдаг. Банкны зээл, бондын хүүтэй адил анхнаас нь тогтоосон тогтмол ногдол ашигтай. Энэхүү ногдол ашгаа энгийн хувьцааны ногдол ашиг хуваарилахаас өмнө авах эрхтэй. Уян хатан байдлаар хөвөгч хэлбэртэй ногдол ашгийг тогтоож болно. Энэ тохиолдолд зах зээл дээрх зээлийн хүүгийн хэмжээтэй уялдуулан тогтоох ба ихэвчлэн Засгийн газрын үнэт цаасны хүүтэй уялдуулан тогтоосон байдаг.

Давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийн эрх.

- a. Компани татварын дараах цэвэр ашгаас эхлээд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг, дараа нь энгийн хувьцааны ногдол ашгийг олгохоор хуулиар зохицуулсан.
- b. Компани дампуурсан тохиолдолд хөрөнгө хуваарилалтыг энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж авах эрхээр хангагдан баталгаажина.
- c. Саналын эрхгүй байдаг.

Давуу эрхтэй хувьцааны давуу тал:

- Ногдол ашиг хуримтлагдана.
- Хэрэв компани бэлэн мөнгөний хомсдлоос шалтгаалаад тухайн жилдээ ногдол хуваарилаагүй бол дараа жилд хоёр жилийн ногдол ашгийг авах эрхтэй байдаг. Нэмэгдэл ашгаас хувь хүртэх боломж гаргах тохиолдол байж болно.

Давуу эрхийн хувьцааны сул тал:

- Давуу эрхтэй хувьцаа нь эрэлт багатай. Учир нь хөрөнгө оруулагчид бонд эсвэл энгийн хувьцааг илүүд үздэг.
- Энгийн хувьцаатай харьцуулахад ногдол ашиг нь хязгаарлагдмал байдаг.

Эдгээрийг компанийн хуулиар зохицуулснаас гадна тухайн компанийн дүрэмд тодорхой тусган журамлах шаардлагатай.

Үүнд үндэслэн давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашгийг тооцон хувьцаа эзэмшигчид хуваарилна. Нөгөө талаар давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хуримтлагдсан ногдол ашиг шаардах эрхтэй.

Түүнчлэн давуу эрхийн хувьцаа эзэмшигчид орлогоос зайлшгүй хуваарилах зүйлд:

- a. Давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ, түүний төлбөрийг тооцоолон хуваарилна.
- b. Компани эргүүлэн худалдан авах, давуу эрхийн хувьцааны төлбөрийг нэмж хуваарилах ёстой.

Энгийн хувьцааны төлбөр.

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд компани эргүүлэн худалдан авах хувьцааны тухай, мөн хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх зохицуулалтыг журамлан тогтоосон байдаг. Хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэх явцад компани эргүүлэн худалдаж авбал зохих энгийн хувьцааны төлбөрийг татан буугдаж байгаа компанийн хувьцаа эзэмшигчид хуваарилна.

Хувь тэнцүүлэн хуваарилах. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахдаа хувь тэнцүүлэн хуваарилах зарчмаар хэрэгжүүлэх ойлголт нь энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаанд хамаарна. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг дээр дурдсан дарааллын дагуу хуваарилж дууссаны дараа үлдсэн эд хөрөнгийг дээр дурдсан худалдсанаас

олсон орлогоос үлдсэн хэсгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилна. Ийнхүү хуваарилах аргыг хэрэгжүүлэхдээ энгийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хуваарилдаг.

Хувь тэнцүүлэн хуваарилах зарчмыг компанийн хуулийн зохицуулалтаас гадна тухайн компанийн дүрэм болон компанийг татан буулгах комисс томилох, “нэхэмжлэлийг барагдуулсаны дараа компанид үлдэх хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам” татан буулгах төсөлд нарийвчлан тодорхой тусгасан байх шаардлагатай байдаг.¹

Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйл нь татан буугдаж байгаа компанид холбогдох нэхэмжлэл, шаардлагыг хангах дараалал нь Иргэний хууль (§32.5), Дампуурлын хууль зэрэг холбогдох бусад хуулиар зохицуулагдана. Үндсэн зарчим нь татан буугдаж байгаа компанийн үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг бүрэн барагдуулсаны дараа хувьцаа эзэмшигчид хуваарилах зохицуулалт хэрэгждэг.

¹ Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд эдгээр ойлголтыг зохицуулсан.

ЯРИЛЦЬЯ

Шихихутуг сэтгүүл нь шинээр "ЯРИЛЦЪЯ" булан нээж байгаа бөгөөд анхны зочноороо Хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбааг урьж "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дэх зөвшилцөл" сэдвээр ярилцсаныг уншигч Танд толилуулж байна.

-Сайн байна уу. Манай шинэ буланд цаг гарган ярилцлага өгч байгаад танд маш их баярлалаа. Эрүүгийн шүүхийн шийдвэр зөвшилцөл, шударга ёсонд тулгуурлах ёстой гэж манай эрдэмтэн судлаачид бичих боллоо. Гэтэл саяхан зохиогдсон Шихихутуг их сургуулийн 30 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний нэг салбар хуралдаан дээр та түүнд шүүмжлэлтэй ханддаг тухайгаа тэмдэглэж байсан. Тиймээс яагаад шүүмжлэлтэй хандаж байгаагаас тань асуултаа эхлүүлье гэж бодлоо.

-Тодорхой байр суурийг маань сонсох гэж шинэ буландаа урьж оруулсанд баярлалаа. Тиймээ, би тэр хурал дээр хоёр асуудал тухайлан хөндсөн. Хуулийн төв байгууллагуудын гол сэтгүүлийн нэг гэгддэг "Шүүх эрх мэдэл"-ийн 2015 оны эхний дугаарын тэргүүн өгүүлэлд манай нэрт эрдэмтдийн нэг, тухайн үеийн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга: "Хууль зүйн шинжлэх ухаанд үнэний тухай яригддаггүй, харин зөвшилцөл шударга ёс гол стандарт болдог учраас туйлын үнэн хэм хэмжээ гэж бас байдаггүй. Тиймээс ч түүнийг тайлбарлан гаргасан шүүхийн шийдвэр бас харьцангуй" хэмээн онцолжээ. Өнгөц харахад гүн ухааны утга төгс үг

хэллэгээр илэрхийлэгдсэн сонирхолтой санаа мэт. Харин хууль зүйн талаасаа шүүмжлэл дагуулж маргаан дэгдээх магадлал ихтэй юм даа.

Хэргийн үнэн гэж хэзээ ч байхгүй, тиймээс шүүхийн шийдвэр бүхэн харьцангуй гэвэл "шийтгэх, цагаатгах тогтоол бүр хэсэг хугацааны дараа хэлмэгдүүлэлтийн түүхэн баримт болно" гэсэнтэй агаар нэгэн буй заа. Ром-германы төдийгүй "Холимог" гэгдэх эрх зүйн бүлийн бүхий л процесс ажиллагаанд бодит үнэнийг тогтоох зарчим үйлчилдэгтэй хэн ч маргахгүй биз. "Түүхийг бичдэггүй, буулгадаг юм" гэж гүн ухааны эрдэмтэн Ц.Гомбосүрэн онцлон тэмдэглэсэн байдаг. Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа ийм л зарчмаар явагддаг.

Гарсан гэмт үйлдлүүдийг мөрдөгч процессийн хуулийг чанд баримтлан шалгаж, бүрдүүлсэн материалаа прокурорт хүргүүлнэ. Уг ажиллагаанд эхнээсээ хяналт тавин оролцож байсан прокурор маань тухайн хавтаст хэргийг нягтлан шалгаж ихэнх тохиолдолд яллах дүгнэлт үйлдэж шүүхэд уламжлан, мэтгэлцээн өрнүүлэх замаар эцэслэн шийдвэрлүүлнэ. Энэхүү цогц ажиллагаа тодорхой орон зай, цаг хугацааны шалгуураар хэмжигдэж, болж өнгөрсөн гэмт үйл явдлын бодит үнэлгээ болно. Түүнд хөндлөнгөөс ямар нэг болзол тавьж нэмэлт нөхцөл, хийсвэр дүгнэлтээр эргэлзээ төрүүлэх оролдлого хийх нь тун явуургүй санаа юм.

-ЭХХШТХуульд шүүхийн шийдвэр хуулийн болоод бодит үндэслэлд тулгуурласан байна гэсэн тодорхой заалт бий. Энэ нь шийтгэх,

цагаатгах тогтоолын мөн чанар, зөв шинжийг харуулсан хоёр үндсэн тулгуур биз дээ.

-Хууль зүйн шинжлэх ухаанд үнэний тухай ярьдаггүй гэсэн профессорын үгийг би дээр дурдсан тэргүүн өгүүллээс ишлэл болгосноо танд харуулсан. Чухамдаа энэ нь эрүүгийн процесс ажиллагаанд "бодит үнэний зарчим" үйлчилдэггүй гэсэнтэй адил. Чингэснээр хууль тогтвортой үйлчлэх боломжийг алдагдуулж, аливаа хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэх үндэслэлгүй болгож байгаа юм.

-Тэгвэл шударга ёсны тухай профессорын хэлсэн үг бас л эргэлзээтэй болж байна уу?

-Шударга ёс заавалчгүй тодотголтой байх нь зүйтэй. Учир нь "шударга" гэдгийг "томчууд" хувьдаа өмчлөөд байдаг зовлон манайд бий. 1996 онд тэр үеийн Хууль зүйн сайд "Сэрүүлэг" сонинд "Намайг энэ албанд байсан цагт нэг ч шударга бус шүүгч ажиллахгүй" гэж мэдэгдсэнийг би бахархан уншиж одоо хүртэл тэр дугаарыг хадгалж байдаг юм. Гэтэл байдал ямар болов? Нөгөө сайд манай 25 жил тэр салбарыг тасралтгүй толгойлоод ч шүүх эрх мэдлийн хүрээнд эерэг нөлөө үзүүлж чадсан уу? гэсэн зүй ёсны асуултанд өнөө болтол хариулт өгөгдөөгүй хэвээр.

Элбэгдорж ерөнхийлөгчийн үед түүний хуулийн команд хөдөө, гадаа явах үед "Шүүхийн шинэчлэл 70 хувьд хүрлээ" Германы судлаачид Монголын шүүхийн ил тод байдал, шинэчлэлийг Европынхоос ч даваад явчихсан байна" гэж дүгнэлээ гээд олон сайхан өгүүллүүд "Өдрийн" болоод бусад

сонин, хэвлэлүүдэд нэлээдгүй гарч монголчуудын урмыг мөн ч их сэргээдэг байж билээ.

Тэр ч битгий хэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг хөдөө гадаа айлчлахад нь "Анхаар! Шударга ёс явж байна", "...Ирж байна" гэж ирээд л хэвлэл мэдээллийн албанаас нь Б.Сэмүүн, Э.Бат нарын сурвалжлагчид мэдээ, сурвалжлагаа 2014-2016 онуудад цөөнгүйг нийтлүүлсэн дээ. Эндээс би: "Шударга ёс" гэдэг ойлголт "Нийгмийн" гэх шалгууртай байхгүй бол хувь хүний карманд дорхноо орох юм байна гэсэн хатуу дүгнэлтэнд хүрсэн юм.

-Таны "Нийгмийн шударга ёсны үндсэн хуулийн шалгуур" гэсэн томоохон өгүүллийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүй: Судалгаа шинжилгээ, хамтын бүтээлээс уншсан. Та тэнд "Оросын эрдэмтдээс ишлэл авахаас зайлсхийх нь зүйтэй гэж хэлснийг тань хараад би гайхсан. Яагаад орос эрдэмтдээс ишлэл авч болохгүй гэж үзэж байгаа юм бэ?

-Би хүүхдүүдээрээ дамжуулж барууны орнуудын хэвлэл мэдээлэлтэй танилцдаг "унаа морь муутай хүн" шүү дээ. Харин орос хэл ашиглаж орчин цагтай хөл нийлүүлж явахыг эрмэлздэг. Гэтэл түүнийгээ нуухаас өөр аргагүй болсон. Учир нь Хууль зүй, дотоод хэргийн нэгэн залуухан сайд намайг МУИС-д багшилж байхад биднийг "Оросын нийгмийн шинжлэх ухааныг ашиглаж хичээл заах нь буруу. ЗХУ, ОХУ-д хууль зүйн чиглэлээр сурсан, эрдмийн зэрэг хамгаалсан хүмүүсийг хоцрогдсон гэж тэрбээр зарлаж орхив. Бид одоо яадаг билээ гэж сэтгэл түгшиж

байтал анхны академич маань Сүхбаатар дүүргийн шүүх дээр уг асуудлаар сайдын эсрэг зарга үүсгэсэн боловч "С.Нарангэрэл доктор хоцрогдоогүй юм байна, харин "бусад нөхдийг" нь ингэж үзэх үндэслэл тогтоогдсонгүй" гэсэн шийдвэр шүүхээс гарсан нь одоо ч хүчинтэй хэвээр байдаг юм шүү.

Дашрамд дурдахад, дээр дурдсан эрхмүүд маань "бидэндээ л томорч" ном хаяхаас биш манай хуулийн амьдралд, Ерөнхийлөгчид эерэг нөлөө үзүүлж чаддаггүй байсан бололтой.

-Энэ юу гэсэн үг вэ?

-Энгийн ганц жишээ хэлэхэд: Элбэгээ ерөнхийлөгч маань 34 тэрбумын татвар төлөхөөс зайлсхийсэн АНУ-ын иргэн Жастин Капала гэгчид уучлал үзүүлж сулласны улмаас Монгол Улсад төлөгдөх ёстой тэр их мөнгө "дашийн шог" болсондоо.

-Уучлаарай. Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрхтэй биз дээ?

-Уучлалыг шүүхийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон үед л үзүүлж болно доо. Харин шүүх засаглалаа үл тоож, ноён Капала давж заалдаагүй байхад нь зарлиг гарсан нь хэтэрхий яарч зулгуйдсан хэрэг дээ. АНУ-ын чөлөөт иргэн манайхаас гараад явчихлаар бид хаанаас түүнийг олох билээ. Тэртээ тэргүй шүүхийн шийдвэрийн биелэлт захиргааны шүүхэд 10, иргэний шүүхийн хувьд 40 хувиас хэтэрдэггүй дүн мэдээ байнга давтагддаг манай орны хувьд Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлагууд шүүхийн нэр хүндийн талаар үнэхээр шаналж ирсэн юм бол харьяа агентлагийнхаа мөнгө хамаагүй

зарцуулж, (сайддаа хуягласан ланд бэлэглэх, түрүүлж үзүүрлэсэн бөхийг байр орон сууцаар шагнаж урамшуулах зэргээр) үргүй зардал гаргуулж байсанд орвол энэ байгууллагын үндсэн үйл ажиллагаанд анхаарах цаг нэгэнт болсон доо.

-Зөвшилцөл нэрийн дор наймаалцах үйл явц хэт өргөн хүрээнд яваад дампуурал маягийн юм болно гэж үзээд байгаа үндэслэл болох Эрүүгийн хууль тогтоомжоосоо нэрлэж болох уу?

-ЭХХШТХуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д

4.2. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрөх

4.3. прокурорын сонгосон ялыг хүлээн зөвшөөрсөн эсэх

Энэхүү заалтууд хэрэг шүүхэд ирэхээс өмнө яллагдагч маань прокурортой ямар хэмжээний ял авахаа урьдчилан тохирсон байна гэсэн үг юм даа.

Өнөө үйлчилж буй хуулинд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатанд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай чухал заалт шинээр нэмэгдсэн. Шүүх хуралдааны бэлтгэлийг хангуулах үндсэн чиг үүрэгтэй энэхүү үе шатанд

- Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх
- Учруулсан хохирлоо нөхөн төлөхөө мэдэгдэх
- Хохирогчтой сайн дураар эвлэрснээ мэдэгдсэн бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд үргэлжлүүлэн явуулж болохоор байгаа нь чухамдаа ээдрээт асуудлыг тал

бүрээс нь бүрэн бодитой тунгаахаас зөвшилцөлд гол анхаарлаа төвлөрүүлжээ гэдгийг хэн хүнгүй ойлгох заалтууд юм.

Анхан шатны шүүх хуралдааны үед (ЭХХШТХуулийн 34.1)

1. ...хуралдаанаар... гэм буруутай эсэхийг тогтоосны дараа (онцлов);
2. Маргагч (онцлов) буюу шүүгдэгчид ... гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа (онцлов)... эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна;
3. ...(шүүх хуралдааны үед)... хохирлоо нөхөн төлөх санал, хүсэлтийг үндэслэн хуралдааныг завсарлуулж болно; гэсэн заалтууд нь шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчмыг зөрчиж, зөвхөн шүүгдэгчид ашигтай боломж, нөхцөлийг үүсгэх, шүүгчийн дотоод итгэл бүрдэх, улмаар хэргийг бодитойгоор, цогц байдлаар шийдвэрлэхэд илт сөрөг нөлөө үзүүлэх, "хөндлөнгөөс хар муур гүйлгэх" зай завсрыг үүсгэж байна.

Эрүүгийн хуулийн 6.5-д заасан "ял хөнгөрүүлэх нөхцөл байдал"

- д ...3 жил хүртэл хорих, аль эсхүл түүнээс бага ял шийтгэлтэй гэмт хэрэг өдүүлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төсөн, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн бол ялаас чөлөөлөх, эсхүл тэнсэх, үүрэг хүлээлгэх эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авах;

- 1.3-т ...8 жил хүртэлх хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирлоо нөхөн төлж хохирогчтой эвлэрсэн бол 8 жилийн ялын хагасаас хэтрүүлэхгүй ял оноох;

- 1.4-т ... 12, 15 жил хүртэлх хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирлоо нөхөн төлж хохирогчтой эвлэрсэн бол заагдсан ялын 3-ны 2-оос хэтрүүлэхгүй ял оноох зэргийг энд дурдаж болно.

Гэтэл гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй этгээдийг татан оролцуулсан, хүүхдээр гуйлга гуйлгах, эрүү шүүлт тулгах хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр ялаас чөлөөлж болохгүй; гэх мэт нь дээрх 3 заалттай өнгө будаг нь огт зохиогүй, илт ач холбогдол багатай хэргүүдэд "сүр үзүүлсэн" өрөвдмөөр тодотгол юм даа.

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ер нь зөвшилцөл байгаад хэрэг байна уу?

-Таны егөөдлийг ойлголоо. Зөвшилцөлд эерэг тал байхыг би огт үгүйсгээгүй. Тухайлбал:

- Процесс ажиллагааг хямд төсөр, энгийн, хялбар болгодог. Чингэснээр цаг хугацаа, зардал, хөрөнгө хүчний зарцуулалт багасна.

- Нийгэмд эерэг уур амьсгал бүрдүүлэхэд нааштайгаар нөлөөлөх үндэслэл байна.

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг цаг алдалгүй нөхөж арилгах боломж, нөхцөлийг бүрдүүлэх тал бас ажиглагддаг.

Гэхдээ сөрөг шинж бас бий. Энэ нь: Эрүүгийн процесс ажиллагааны

холбогдох зарчмуудыг “үл тоомсорлох” хандлага эрс нэмэгддэг. Чингэснээр ард нийтийн эрх зүйн хүмүүжил, ухамсарт илт муу нөлөөтэй.

Нийгмийн шударга ёсны шалгуурыг тэр бүр хангадаггүй.

Эрх зүйн бүлүүдийг өөр хоорондоо ойртох үйлчлэл, үр нөлөө бүхий хуулийн зохицуулалт, хэм хэмжээг ул суурьтай судалгаанд тэр бүр тулгуурладаггүй, чингэснээр уялдаа холбоог нь алдагдуулах зэргийг юуны түрүүнд нэрлэж болно.

Өнөө үйлчилж буй Эрүүгийн материаллаг болон процессийн хуулийн аль алинд нь мөн чанар, утга агуулга, тэр тусмаа хэрхэн үйлчилж ямар үр дагавар авч ирэхийг нь тооцолгүйгээр бусдаас хуулбарласан зүйл, заалтууд цөөнгүй байгааг би урьд өгүүлсэн. “Нэг хүний хэргийг нэг л удаа яллах” далбаан дор “рецидив гэмт хэрэгтэн, ял шийтгэлгүйд тооцох хугацаа мэтийн Ром-германы эрх зүйн бүлийн гэгдэх уламжлалт зохицуулалтыг судалгаанд тулгуурлалгүй Эрүүгийн хуулиас хасав. Гэтэл манай зарим нэрт эрдэмтэд: “Хүн байгалийн болоод нийгмийн бүтээгдэхүүн” гэсэн уламжлалт ойлголтоос ихээхэн ялгаатай “ёс суртахууны хромсомоор тодорхойлогдох шинжийг” гарган тавьж цоо шинэ онол дэвшүүлж байгаа шүү дээ.

Саяхан нэгэн ярилцлагадаа Ерөнхийлөгч асан нэгэн хүн “Манайд одоо Ерөнхийлөгч хийж чадах хоёр л хүн байна. Нэг нь Санжийн Баяр, нөгөө нь Мэндсайханы Энхсайхан гээд, Тэд чинь ял эдэлж байгаа биш үү гэсэн сурвалжлагчийн гайхсан асуултанд,

Ер нь шоронгоос сайн Ерөнхийлөгч, хатуужсан улс төрч төрдөг юм шүү дээ. Өмнө нь Африкийн Нельсон Мандела, Өмнөд Солонгосын зарим удирдагчаас эхлээд олон жишээ бий гээд ярьж байна лээ.

Өнөөдрийн хуулиар, зүйрлэвэл хүчин, дээрэм, хүний амь насанд халдсан, зэрлэгээр танхайрсан хэн боловч ялаа эдэлж дуусмагц сонгох, сонгогдох эрхээ ямар ч саадгүй эдлэх учиртай. Энд эрүүгийн төдийгүй ёс зүйн саад болох шалгуур ч байхгүй.

-Таны яриан дундуур сүүлчийн асуултаа тавья. Зөвшилцлийн үр дүнгийн талаар таны бодол?

-ХБНГУ-ын нэрт эрдэмтэн, Бонны их сургуулийн эрх зүйн философи, кибернетикийн профессор Б.Шюнеманн гуай манай Эрүүгийн процессийн хуулийн төсөлд биечлэн санал өгч байхдаа АНУ-ын “ял наймаалцах” ажиллагаа нь танайд нөлөөлж болзошгүй байна. Ром-Германы эрх зүйн бүлийн эрүүгийн процессд нэг талын эрх, ашгийг хэт өмгөөлсөн “гаж зөвшилцөл” ихээхэн сөрөг үр дагаварт хүргэнэ шүү гэж зөвлөж байсан юм. Энэ талаар МУИС-ийн “Эрх зүй” сэтгүүлийн 2010 оны 1-т нийтлэгдсэн “АНУ-ын эрүүгийн процесс дэлхийд давамгайлах гэж үү” гарчигтай, манайд тусгайлан зориулсан гэмээр өгүүлэлдээ онцолсон юм шүү.

Эрүүгийн материаллаг болон процессийн шинэ хууль үйлчилж эхэлмэгц үр дүн нь ашиглагдаж эхэлсэн. Нөгөө алдарт хөөн хэлэлцэх хугацаанаас болоод мөрдөх, шийдвэрлэх шатанд зөвхөн авилга, албан тушаалын 80

гаруй хэрэг замхарсан. Энэхүү алдааг засаж залруулсан дүр эсгэсэн ч “хууль эргэж үйлчилдэггүй энэрэнгүй ёсны зарчмыг баримтлах нэрийдлээр нэр бүхий эрхмүүдийн нүглийг илт хамтатган үүрсэн Жастын Батхүүгээс бусад нь бүгд гэм зэмгүйд тооцогдон цайрсан.

“ЖДҮ-ийнхэн” гэгдэх бүлэг луйварчдын цөөн хэдийг “зөвшилцөл” нэрийдлээр үнэгэн зальтай шийдвэр гарган өршөөсөн. Ер нь эх газрын эрх зүйн бүлийн орнуудад “ил тод, бүдүүлэг, соёлгүйчүүдийн” өдүүлсэн хэргүүдэд зөвшилцөл явагдах боломж, үндэслэл муутай даа. Харин “цагаан захтнуудын” нийгэмд асар их хор уршигтай хэргүүдэд зөвшилцөл процессийн бүхий л үе шатанд тасралтгүй өрнөж “ял наймаалцах” ажиллагаа болон хувирдаг жамтай. Тиймээс ч хууль ёсны, хэргийн бодит үнэнийг тогтоох, шударга ёсны төдийгүй хэрэг маргааныг хөндлөнгийн хараат бус шүүхээр шийдвэрлэх, шүүх хуралдаан тасралтгүй явагдах, шүүгч элдэв нөлөөлөлгүй, зөвхөн дотоод итгэлдээ тулгуурлан шийдвэрлэх зарчмууд янз бүрийн шахалт хавчилтанд орж зерчигдөж эхэлдэг.

Эцэст нь “хууль бүтээхдээ даяаршлын далбаан дор нүүдэлчдийн сониучхан сэтгэлгээгээр таалагдсанаа шүүрэн хуулбарлаж болохгүй шүү” гэж Монголд ихээхэн элэгтэй доктор Х.Шөллер гуайн захисан үгээр өндөрлөө. Баярлалаа.

-Танд ч гэсэн ярилцлага өгсөнд баярлалаа.

Ярилцсан: Сэтгүүлийн нарийн бичгийн дарга Б.Мөнх-Эрдэнэ.



СУДАЛГАА

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХУГАЦАА

(Судалгааны ажлын тайлан)

*Шихихутуг их сургуулийн
Практик судлалын тэнхим*

Судалгааны багийн ахлагч:

*Шихихутуг их сургуулийн Практик
судлалын тэнхимийн эрхлэгч*

Т.Сүхбаатар

Судалгааны багийн гишүүд:

*Шихихутуг Их Сургуулийн 46 ангийн
оюутан: Н.Мишээл, Б.Номинсүрэн,
Ч.Лхамсүрэн, Ц.Билэгт, Д.Шихихутаг,
Г.Халиун нар ажилласан болно.*

Нэг: Ерөнхий мэдээлэл

Шихихутуг Их сургуулийн Практик судлалын тэнхимын эрхлэгч Т.Сүхбаатарын баталсан удирдамжийн дагуу судалгааны баг Монгол Улсын ЭХХШТ Хуульд заасан хугацааны талаарх заалтуудыг 2020.10.12-оос 2020.11.15 хүртэл хугацаанд судаллаа.

Судалгааны баг энэхүү судалгааг хийхдээ Монгол Улсын ЭХХШТХуульд заасан хугацааг хуулийн зүйл заалтаар нэг бүрчлэн түүвэрлэж , судалгааны харьцуулан судлах аргыг ашигласан болно.

Судалгааны дүнгээс үзвэл Монгол Улсын ЭХХШТХуульд хэрэг бүртгэх мөрдөн байцаах , хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдвөл зохих олон төрлийн хугацааг хуульчлан заасан нь эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэхэд чухал ач холбогдолтой болохыг тодорхойлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан хугацаанд шуурхай бүрэн гүйцэт явагдаж байх нь Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрх, эрхчөлөөг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа тул ЭХХШТхуульд заасан хэргийг мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдөх хугацаануудыг мөрдөгч , прокурор , шүүгч болон эрх бүхий албан тушаалтнууд чанд мөрдөж ажиллах үүрэгтэй .

Судалгааны баг энэхүү судалгааг хийснээрээ “ЭХТХ-2” хичээлийн хүрээнд ЭХХШАжиллагааны үе шат бүрт ямар үндсэн хугацаа байгаа , түүний хэрхэн мөрдөж ажиллах ёстой , тухайн хугацааг мөрдөгч болон прокурор , шүүгч нар мөрдөж ажиллаагүйн улмаас үүсэх хууль зүйн үр дагаварыг мэдэж авсан төдийгүй, хууль хэрэглээний талаар зохих дадлагатай болж , энэ чиглэлээр олж авсан мэдлэг, ойлголтоо бататгаж авсан болно.

Хоёр: ЭХХШТХуульд заасан хугацаа

Монгол Улсын ЭХХШТХуульд мөрдөн шалгах ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдөх хугацааг олон янзаар тодорхойлж хуульчилсан байна.

Тухайлбал: Хугацааг цагаар , хоногоор , сараар , жилээр , заасны гадна хугацааны хувьд тодорхой ач холбогдол бүхий “ даруй “, “ дараа” , “дуусмагц” гэсэн хугацааны тодотголтой заалт олон байна.

Монгол Улсын ЭХХШТХуульд тодорхой хугацаа заагаагүй атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч , прокурор , шүүгч хэргийн

талаар шийдвэр гаргахаар заасан заалт цөөнгүй байна.

Жишээ нь: ЭХХШТХуулийн 10.4. 1-д “... шүүгч шүүх хуралдааныг хойшлуулж, уг асуудлыг шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ” гэж заажээ. Шүүгч шүүх хуралдааныг хойшлуулах хугацааг тогтоохдоо хэргийн нөгцөл байдал болон хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудыг харгалзан үзсний үндсэн дээр энэ талаар шийдвэр гаргах нь тодорхой байгаа боловч шүүх хуралдааныг хойшлуулж болох хугацааг тодорхойлсон заалт хуульд байхгүй байна.

ЭХХШТХуульд “даруй” гэсэн хугацааны тодотголтой заалт “39, “дараа” гэсэн хугацааны тодотголтой заалт 7 байна.

Хуульд заасан “даруй” гэдэг нь хамгийн богино хугацаа гэж ойлгогдож байгаа хэдий ч түүнээс богино боломжит хугацаа гэж үзэж болох хуулийн заалт ч байна. Тухайлбал: ЭХХШТХуулийн 41.2.4-т: “Шинээр илэрсэн нөгцөл байдал мөрдөн шалгах ажиллагаа эхлэмэгц хэргийн хугацааг шинээр тогтоож, хугацаа сунгахад энэ хуулийн 31.13 зүйлд заасан журмыг баримтлана” гэж заажээ.

ЭХХШТХуульд **шөнийн цаг** гэсэн хугацааг 2 удаа заасан байна. Тухайлбал: Мөрдөгч ЭХХШТХуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай саналдаа тухайн ажиллагааг шөнийн цагаар явуулах бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг саналдаа хавсаргахын зэрэгцээ хуулийн 22.3.6-д заасны дагуу прокурор тухайн мөрдөн шалгах ажиллагааг шөнийн цагаар явуулж болох эсэхийг зөвшөөрөлдөө заана.

Судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсын ЭХХШТХуульд хугацаа заасан заалт 115 байна.

Монгол Улсын ЭХХШТХуульд заасан хугацааны төрөл

№	Хугацааны төрөл	Хуулийн хэдэн зүйлд байгаа
1	цагаар заасан хугацаа	21
2	хоноогоор заасан хугацаа	40
3	сараар заасан хугацаа	11
4	Жилээр заасан хугацаа	4
5	Даруй гэж заасан хугацаа	39
6	Дараа гэж заасан хугацаа	7
7		
	Бүгд	115

2.1. Цаг заасан хугацаа

№	төрөл	Хуулийн зүйл заалт
1	2 цаг	14.13.10.1, 22.4.2, 22.4.3, 31.4.3
2	6 цаг	18.6.4, 31.5.5, 31.6.5,
3	12 цаг	15.3.1, 31.3.4
4	24 цаг	14.12.1, 14.13.2, 22.2.2, 31.2.4, 31.5.3, 31.12.6, 22.4.2, 22.4.3
5	48 цаг	22.1.6, 31.4.5, 31.12.2,
6	72 цаг	30.9.1

2.2 Хоног заасан хугацаа

№	төрөл	Хуулийн зүйл заалт
1	3 хоног	2.11, 2.3.6, 4.1.4, 11.9.2, 14.4.3, 15.7.4, 15.8.1, 23.1.6, 32.2.2, 39.2.3
2	5 хоног	2.12, 11.8.2, 15.4.2, 30.7.1, 33.3.2, 34.1.5, 37.4.1.
3	7 хоног	11.8.1, 17.4.2, 30.10.3, 30.10.4, 32.6.1, 32.6.2, 38.3.3,
4	10 хоног	40.2.1
5	14 хоног	15.7.2, 17.2.3, 32.4.1, 32.7.1, 38.2.1, 40.1.2
6	15 хоног	33.1.1, 36.13.1, 37.11.1, 39.10.4,
7	21 хоног	15.7.2
8	30 хоног	39.2.1, 39.2.2, 40.3.1, 40.11.1

2.3 Сар заасан хугацаа

№	төрөл	Хуулийн зүйл заалт
1	1 сар	30.12.1, 31.13.3, 37.9.3,
2	3 сар	30.12.3,
3	5 сар	31.13.4.1, 31.13.4.3,
4	6 сар	18.8.21,
5	7 сар, түүгээс дээш	31.13.4.1, 31.13.4.2, 31.13.4.4,

2.4 Жил заасан хугацаа

№	Төрөл	Хуулийн зүйл заалт
1	2 жил	37.5.1, 37.9.2,
2	10 жил	45.8.1
3	25 жил	37.9.1

Гурав: ЭХХШтХуульд заасан хугацааг хэрэглэхэд анхаарах зарим асуудал

Хууль хэрэглээний хувьд дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй Үүнд:

1. ЭХХШтХуулийн 1.4 дүгээр зүйлд “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт”-ыг заасан бөгөөд 1.4.1.7-д: “даруй” гэж боломжит богино хугацааг ойлгохоор тодорхойлсон.
2. ЭХХШтХуулийн “ Арван нэгдүгээр бүлэг”- ийн 11.1 дүгээр зүйл, 11.2 дугаар зүйл, 11.3 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэрхэн тоолох, хэрхэн сунгах, хэрхэн сэргээх талаар заасан нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
3. ЭХХШт Хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.9.2-т: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж нэр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Мөн хуулийн 25.2 дугаар зүйлд “ Мэдүүлэг авах хугацаа

"-г хуульчлан заасан нь чухал ач холбогдолтой. Иймд мөрдөгч хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын явцад мэдүүлэг авахдаа мэдүүлэг авах хугацаа, мэдүүлэг авахдаа завсарлагаа авах хугацааг мөрдөж ажиллах нь чухал.

4. Хэрэг бүртгэлтийн хугацааг сунгаж болох хуулийн заалт / 30.12 дугаар зүйл / байгаа хэдий ч Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол эрүүгийн хэрэг хянан ажиллагаа явуулж болохгүй./ ЭХХШТХуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2/

Дүгнэлт, санал

1. Монгол Улсын ЭХХШТХуулийн 115 зүйлд хэрэг мөрдөн шалгах , хянан шийдвэрлэхтэй холбоотой хугацаануудыг хуульчлан заасан байна
2. ЭХХШТХуульд заасан хугацаанууд нь өмнө мөрдөж байсан Монгол Улсын ЭБШХуулиар зохицуулсан хугацаатай харьцуулахад багассан / богино болсон / нь хэргийг шуурхай бүрэн гүйцэт мөрдөн шалгах , хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн байна . Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хууль зүйн баталгаа юм.
3. ЭХХШТХуулийн 8.3 дугаар зүйлийн 1-д: Хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу тодорхой ажиллагаануудыг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор түүнд энэ тухай мэдэгдэнэ" гэж заасны

гадна мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 12 цагийн дотор явуулахаар заасан нь /31.3.4/мөрдөгч болон прокуроруудын үйл ажиллагаа аль болохоор шуурхай байхад чиглэгдсэн хуулийн зохицуулалт юм.

4. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд мөрдөж ажиллах хугацаанууд нь хэргийг шуурхай шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Тухайлбал: Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх боломжтой гэж үзсэн бол мөрдөгч 14 хоногийн дотор мөрдөн байцаалт явуулна /17.2.3 /, Прокурор яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд даруй шилжүүлнэ /17.3.3 /, шүүх хэргийг шууд шийдвэрлэх боломжтой гэж үзвэл даруй эсхүл 7 хоногийн дотор ял оногдуулах шүүх хуралдаан зарлан явуулж болно. / 17.4.2 /

5. Хуулийн заалтыг ийнхүү нарийвчлан судалсан нь үр дүнтэй болсон бөгөөд цаашид энэ талаар хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах саналтай байна.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГААР ШУДАРГА ЁСНЫ ХАНДЛАГА, АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ТАЛААРХ ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГЫН ДҮН

Судалгааны багийн ахлагч:

Шихихутуг их сургуулийн Чанарын албаны дарга **Б.Одончимэг**

Судалгааны багийн гишүүд:

Боловсролын Хүрээлэнгийн Дээд Боловсрол судлалын эрдэм шинжилгээний ажилтан **У.Мягмаржав**

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн мэргэжилтэн

Б.Мядагмаа

224

Дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулахын боловсрол судлалын төвийн эрхлэгч **Б.Мөнхдорж**

Аварга дээд сургуулийн Боловсрол судлалын тэнхимийн ахлах багш

Б.Энх-Амгалан

Монгол Германы технологийн их сургуулийн оюутан хариуцсан мэргэжилтэн **Э.Оюун-Эрдэнэ**

Абстракт

Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга туссан байдалд хийсэн дүн шинжилгээг

- их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдлын шинжилгээ,
- ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгагдсан байдлын шинжилгээ,
- ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээл, сургалтын хөтөлбөрөөр авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, сэргийлэх боломжийн талаарх экспертийн ярилцлагын шинжилгээ бүтэцтэйгээр гүйцэтгэснээс экспертийн ярилцлагын шинжилгээг толилуульж байна.


Түлхүүр үг

Авилга, авилгаас урьдчилан сэргийлэх, боловсрол, сургалтын хөтөлбөр, экспертийн ярилцлага

Оршил

“Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилт дэвшүүлсэнийг бага, дунд, дээд боловсролын хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ямар боломж байгааг бидний хэдэн судлаачид цогц байдлаар судлах оролдлого хийсэн болно. Энэхүү судалгааны үр дүнг танилцуулж байх хугацаанд Берлин дэх “Транспаренси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас жил бүр боловсруулдаг Авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнгээр Монгол Улс 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.

График. Монгол Улсын авлигын төсөөллийн индекс /2013-2020 он/



Монгол Улсын Боловсролын тухай хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд “Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор 2015 онд баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад “Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ”, 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтад “Сурлагын амжилтын олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана.” хэмээн тус тус

тодорхойлсон. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагаас 2015 онд Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотод зохион байгуулсан “Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, насан туршдаа суралцах чанартай боловсрол” сэдэвт Дэлхийн боловсролын форумаас Инчеоны тунхаглалыг гаргасан. Тус тунхаглалд 2030 он хүртэлх Дэлхийн боловсролын алсын харааг “Нэгдсэн зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулна” хэмээн тодорхойлсон. Мөн “Чанартай боловсрол нь бүтээмж болон мэдлэгийг дэмжин хөгжүүлж, бичиг үсэг, математикт суралцахтай ижил задлан шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, танин мэдэхүйн, хувь хүний хөгжил, харилцааны чадваруудыг хөгжүүлдэг”-ийг онцлон тэмдэглэжээ.

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 10.1 ба 10.2 заалтад боловсролын агуулга гэдэг нь “суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх бөгөөд энэхүү хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөтөлбөрөөр зохион байгуулагддаг байхаар тусгагдсан юм.

Сургалтын хөтөлбөр нь тодорхой түвшний боловсрол эзэмших, олгох үйл явц бөгөөд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үндсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хөтөлбөрийн төлөвлөлтийн үйл ажиллагааны үр дүнд хөтөлбөрийн баримт бичиг бий болно.

Ихэнхи судлаачид сургалтын хөтөлбөрийн баримт бичгийг тодорхой түвшний сургалтын үйл ажиллагааны суралцахуйн үр дүнгээр илрэх зорилго, зорилт; агуулга; арга зүй; суралцагчийн үнэлгээ; сургалтын орчин; чанарын баталгаажуулалт тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлсон цогц баримт бичиг гэж үзэх болсон.

Манай улсад одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ерөнхий боловсрол олгох бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрүүд, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж, сургалтын цагийн төлөвлөлт зэрэг нь БСШУСЯ-ны сайдын 2019 оны 08 сарын 01-ний өдрийн А 491 тоот тушаалаар батлагдсан юм. Энэхүү шинэчлэн сайжруулсан сургалтын хөтөлбөр нь

1. Сургалтын цагийн төлөвлөлт
2. Сургалтын хөтөлбөр
3. Судлагдахуун бүрийн боловсролын түвшин, анги бүрээр боловсруулсан суралцахуйн удирдамж зэргээс бүрддэг бөгөөд түүнийг хэрэгжүүлэх сурах бичгүүдийг, багшийн номын хамтаар хэвлэн улс орон даяар судлагдахууны багш бүрт, 1-5р ангийн сурагч бүрт үнэ төлбөргүйгээр 6-12р ангиудад тодорхой түрээсийн төлбөртэйгээр сургуулийн номын сангаар дамжуулан хэрэглүүлдэг болно.

Сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүний хувьд ийм хангамжтай мөн сургалтын цагийг баталж чанд мөрддөг учир

хөтөлбөр хэрэгжүүлэхэд шууд тулгарах бэрхшээлгүй гэж үзэж болох юм.

Дээд боловсролын түвшинд хөтөлбөрийн баримт бичгийг цогцоор боловсруулах талаар нэгдсэн удирдамж 2014 он хүртэл журамлагдаагүй байсан бөгөөд сургалтын төлөвлөгөө, графикаар хязгаарлагдаж байсан.

Олон улсад боловсролын талаарх үзэл баримтлал шинэчлэгдэж, Монгол улс боловсролын үйл ажиллагаа, үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрөлцөх үүрэг хариуцлагыг өөртөө хүлээж эхэлсэнтэй холбогдуулан дээд боловсролын хөтөлбөрийн баримт бичгийн боловсруулалтад шинэ шаардлага тавигдаж эхэлсэн.

Тухайлбал, ЮНЕСКО-гийн шинэчлэн боловсруулсан Боловсролын олон улсын ангиллын стандарт /International standard classification of education "ISCED-2013"/, Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал /ISCO-08/ зэрэг олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны статистик боловсруулалтын баримт бичгийн стандартад нийцүүлэн 2014 оноос БСШУ-ны сайдын А/78 тоот тушаалаар бакалаврын сургалтын хөтөлбөрийн чиглэл ба индекс; БСШУ-ны сайдын А/370 тоот тушаалаар магистр, докторын сургалтын хөтөлбөрийн чиглэл ба индексийг тус тус батлан мөрдөж эхэлсэн.

Мөн бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Дээрх тушаалуудаар сургалтын хөтөлбөрийг нийтлэг шаардлагаар

журамлаж, хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийн бүрдлийг тогтоосон байдаг. Тухайлбал, бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад “Тодорхой түвшний боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн сурах, сургах үйл ажиллагааны агуулга, зохион байгуулалтыг тодорхойлсон цогц баримт бичгийг хөтөлбөр гэнэ.” хэмээн тодорхойлжээ.

Нийтлэг шаардлагад төгсөгчийн эзэмших ур чадварыг хувь хүний болон мэргэжлийн мэдлэг, ур чадвар, төлөвшил гэж ангилаад мэргэжлийн ур чадварын хувьд мэргэжлийн ёс зүйтэй, хариуцлагатай байхаар тодорхойлсон байна.

Нийтлэг шаардлагын 3 дахь хавсралтад Ерөнхий суурь хичээлийн зөвлөмжид “Ерөнхий суурь хичээлийг судалснаар ... мэргэжлийнхээ мөн чанар, үнэ цэнийг тодорхой мэддэг, ёс зүйтэй иргэн болж хөгжихөд ач холбогдолтой” гэж үзээд Хүмүүнлэгийн ухаан агуулгад ... ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх; Иргэний боловсрол агуулгад ... хувь хүний төлөвшил хөгжлийн талаар суралцах зэрэг үр дүнг тодорхойлон тус бүр 3 багц цагаар судлуулахаар зөвлөмжилсөн байна.

Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага нь дээд боловсролын тухайн түвшний сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, үнэлгээг цогц байдлаар журамлаж чадсан.

БСШУС-ын сайдын 2018 оны А/533 тоот тушаалаар батлагдсан “Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого” –ын баримт бичиг

нь суралцахуйн үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулалт, сургалтын орчин, арга зүй, технологийн шинэчлэл, багш нарын заах арга зүйн чадамж, суралцахуйн үр дүнгийн үнэлгээ, чанарын баталгаажуулалтын чиглэлээрх үйл ажиллагааг чанаржуулах зорилготой.

Энэ баримт бичгийн 4.3.1-т Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах мэдлэг, чадвар, хандлага, ёс зүйн шаардлагыг тодорхойлж батлан мөрдүүлэх, 4.3.4-т багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, харилцаа, хандлага, ёс зүй зэрэг уян хатан /soft skills/ чадварыг оюутанд эзэмшүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах зэрэг заалтууд нь хөтөлбөрийн баримт бичгийн боловсруулалтыг шинэ шатанд гаргасан ёс зүй, хандлагын үзүүлэлтийг чухалчилснаараа өмнөх актуудаас ялгаатай юм.

Өнөөгийн байдлаар бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу их дээд сургуулиуд өөрсдийн онцлогт нийцсэн хөтөлбөрийн баримт бичгийн загвар, заавар, стандартуудыг боловсруулан мөрдөж ажиллаж байгаа бөгөөд сүүлийн үед үр дүнд суурилсан сургалтын технологийн загвар, арга ажиллагааг хөтөлбөрийн баримт бичигтээ тусгах болсон.

Экспертийн ярилцлагын зорилго

Авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бага, дунд, дээд боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад тусгасан байдал, сургалтын хөтөлбөр

агуулгаар шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх боломжийн талаар эрдэмтэн судлаач, өндөр мэргэжлийн төлөөллүүдийн санал бодлыг цуглуулан нэгтгэн дүгнэж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.10.2.1 дэх зорилтыг¹ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Экспертийн ярилцлагын арга зүй

Тухайн сэдвийн хүрээнд шинэлэг, хэрэгжихүйц, бодит санал, зөвлөмж, дүгнэлт авахад чиглэсэн агуулгаар; удиртгал, зөвшилцлийн бичиг үйлдэх, бие халаалт, үндсэн хэсэг, төгсгөл гэсэн бүтцээр; чөлөөт хэлбэрээр ярилцлагыг зохион байгууллаа.

Ярилцлагыг шударга ёсны мөн чанар, бодлого, агуулга, арга зүйн талаар нийт 4 багц 12 асуултын хүрээнд биечлэн болон цахим хэлбэрээр авсан. Экспертүүдтэй зөвшилцөн тэдний ярилцлагыг дуу хураагуурт хураах, судалгааны тайлан хэвлэлд нэр оруулах, хожмын судлаачдад энэ ярилцлагын материалыг ашиглах талаар зөвшөөрөл авч баримтжуулсан. Мөн судлаачийн зүгээс тэдний өгсөн мэдээллийн нууцлалыг дээр дурдсан зөвшөөрлийн дагуу чандлан хадгалахыг баталгаажуулсан болно.

Экспертүүдийн сонголт

Судлагдаж буй сэдвийн хүрээнд бие хүний хөгжил төлөвшил, шударга

ёсны философи, боловсролын хөтөлбөр хөгжүүлэлт, эрх зүй, нийгмийн ухаан, сэтгэл судлал, боловсрол судлалын чиглэлээр мэргэшсэн, салбарын холбогдох албан тушаалтан, эрдэмтэн судлаач, багш, мэргэжилтнүүдэд санал тавьсан.

Сонголтод нийцэхүйц экспертүүдийг судлан, нийт 30 хүнд санал тавьсан. Тэдний 23 нь зөвшөөрснөөс 20 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийлээ.

Экспертийн ярилцлагын боловсруулалт

Ярилцлагын үр дүнг 4 багц 12 асуулт тус бүрээр <https://docs.google.com/spreadsheets> ашиглан боловсрууллаа.

Ярилцлагад оролцогчдын 5 нь эрэгтэй, 16 нь эмэгтэй. Боловсролын зэрэг цолны хувьд 1 нь шинжлэх ухааны доктор, 14 нь доктор, 6 нь магистр зэрэгтэй.

Профессор-2, дэд профессор-1, Монгол улсын зөвлөх багш-1, тэргүүлэх багш-1, ахлах багш-2 багш-3, тэнхмийн эрхлэгч агентлагын захирал-1, орлогч болон дэд дарга-2, тэнхим, төв, секторын эрхлэгч-6, төслийн ахлах зөвлөх-1, олон улсын өмгөөлөгч-1 бүрэлдэхүүнтэй байна. Нийт 21 хүний ярилцлагад дүн шинжилгээ хийв.

1. ШУДАРГА ЁСНЫ МӨН ЧАНАРЫН ТАЛААР

1.1. Бид боловсролоор хүүхэд, залууст шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлж чадаж байна уу?

¹ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын их Хурлын тогтоол №51, 2016/11-03. "Боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах"

Тус асуултад ярилцагчид өөрийн ажлын туршлага болон үзэл бодлооо чөлөөтэй илэрхийлсэн байна. Шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлж чадаж байна гэж ярилцлагад оролцогчдын 10,5 хувь нь үзэж байна.

Тухайлбал: тодорхой утгаар энэ асуудал бүх шатны боловсролын хөтөлбөрт туссан байгаа

Оролцогч 17

Шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлж чадахгүй байна гэж ярилцлагад оролцогчдын 42 хувь нь үзэж байна.

Ярилцлагад оролцогчид хүүхэд залууст шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэхэд нийгмийн нөлөө, боловсролын байгууллага, мэргэжлийн багшийн хүрэлцээ, багшийн шударга байдал хүн хоорондын харилцаа, зэргээс шалтгаалан чадахгүй байгааг дурдсан байна.

Тухайлбал: Чадахгүй байгаа. Хичээл, судлагдахууны агуулга төдийгүй суралцагчдын дүнг хэр бодит гаргаж байгаа, уралдаант шалгалт хэр шударга болж байгаа зэргээс буюу сургалтын байгууллага, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны шударга байдлаас шалтгаалаад чадахгүй байгаа.

Оролцогч 4

Жигд бус, эргэлзээтэй, дутмаг гэж ярилцлагад оролцогчдын 42 хувь нь үзэж байна.

Ярилцлагад оролцогчид хүүхэд залууст шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэхэд

гэр бүлийн тогтсон хэв шинж, аав ээжийн үлгэр дуурайлал, багшийн үлгэр дуурайлал бусдын үлгэр дуурайлал чухал нөлөөтэй болохыг дурдсан байна.

Мөн тухайн хичээл, сургуулийн онцлог хөтөлбөр заах арга зүй гээд олон зүйлээс шалтгаалаад харилцан адилгүй гэж үзсэн байна.

Тухайлбал: Харьцангуй, гэр бүлийн хүмүүжил суурь болно, шударга ёс бол хандлагын ойлголт, насан туршийн, бүх нийтийн боловсролын хүрээнд байвал хэрэгтэй.

Оролцогч 9

Хэмжих боломжгүй гэж 5,2 хувь нь хариулсан байна.

Тухайлбал: Миний хувьд өөрийн эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв учир холбогдож болохуйц хичээлүүддээ дурддагаас биш төлөвшүүлж байгаагаа хэмжиж байсангүй учир нь хөтөлбөртөө тийм зорилго тавьж байгаагүй, орох боломжгүй.

Оролцогч 3

1.2. АТГ-ын Хүүхдийн шударга байдлын талаарх 2019 оны судалгаагаар хүүхдийн шударга байдал 3,91 пунктээр үнэлэгджээ. /5 онооны үнэлгээгээр/ Шударга ёсны хичээлд хамрагдсан сурагчдын шударга байдал тухайн хичээлд хамрагдаагүй сурагчдынхаас 0,11 пунктээр өндөр гарсан байна. Та энэ үзүүлэлтийг бие хүний төлөвшлийн талаас хэрхэн тайлбарлах вэ?

Энэхүү үзүүлэлтийн талаар оролцогчид дараах төрлийн хариултуудыг өгсөн байна.

Ихэнх оролцогчид шударга ёсны талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл, шйлчилгээний чанар, эцэг эхийн ойлголт, нийгмийн сэтгэл зүй, багшийн шударга байдал, бие хүний танин мэдэхүй, чадамжтай холбоотой гэж үзсэн байна.

Зарим оролцогчдын хувьд судалгааны үр дүнг тайлбарлахдаа судалгааны зорилго оролцогчдыг хэрхэн бэлтгэж судалгаанд оролцуулсан эсэх талаарх өөрсдийн таамаглалыг судалгааны үр дүнтэй уялдуулан хариулсан байна.

Тухайлбал: тухайлан хичээлийн агуулгаар тэдэнд танилцуулаад тэр агуулгын хүрээндээ шударга байдлыг хэмжсэн байх гэж ойлгож байна. Энэ судалгаагаа тэр хичээлийг судалснаас нэлээд хэд хэдэн удаа давтан авч байж тодорхой дүгнэлт өгөх нь бодит үр дүнг гаргахад ач тусгай байх.

Оролцогч 17

Бусад оролцогчид нь хичээл сургалтын агуулгаар албан ёсоор оруулдаг байх жишээ нь иргэний ёс зүйн боловсролыг 1-12 ангид оруулж байгаа нь ялангуяа 2 үеийнхэнд эерэг хандлага, ахас ихсээ хүндлэх, орчин бий болгох талтай гэжээ.

Тухайлбал: Мэдээж хичээлд суусан зөв ойлголт авсан нь илүү өндөр оноо авна. Энэ жишээ бол хүүхдэд багаас нь боловсролоор дамжуулан үнэт зүйлс суулгах ач холбогдолыг харуулж байгаа байх. Тэрнээс бие хүний төлөвшилтэй огт хамааралгүй зүйл. Хүүхдэд албаар зааж байж л ойлгоно. Хүүхэд эцэг эх гэр бүлээсээ шударга зөв зан чанар өвлөх нь бий. Гэхдээ маш цөөхөн тохиолдолд л гэр бүл нь зөв үлгэр жишээ болдог. Ихэнхдээ өнөөгийн Монголчууд бол буруу жишээ болж байна.

Оролцогч 19

1.3. Шударга ёсны үзэл, авлигыг үл тэвчих соёл, үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагыг ямар үзэл баримтлалд суурилан хэрхэн төлөвшүүлэх вэ?

Тус асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Шударга ёс бүх үзэл баримтлалын суурь байх -5.2%
2. Thomas Hobbes, John Roles, Мишель Санделийн, нарын онол-10.5%
3. Үндсэн хууль либерал үзэл баримтлалд суурилсан байх - 5.2%
4. Хүмүүнлэг ёсны онол, ёс суртахууны философи дээр тулгуурлах-31.5%
5. Ардчилсан үндсэн хуулиа баримтлах, эрхэм зарчмаа баримтлан төлөвшүүлэх-5.2%
6. Монгол ёс улалмжлалд, монгол хүний сэтгэлд байгаа тэр үнэ цэнэ дээр тулгуурлах -21%
7. Олон ургальч үзлээр аливаад олон талаас нь хандахыг зөвлөдөг байх-5.2%
8. Түүхэн бодит баримтуудад тулгуурлах -5.2%
9. Итгэл үнэмшил бий болгох -5.2%
10. Нэр томьёо чухал гэж үзсэн -5.2%

Хэрхэн төлөвшүүлэх талаар оролцогчдын хариултаас төлөөлөл болгон авч үзвэл судалгаанд оролцогчийн 31.5 хувь нь хүмүүнлэг ёсны онолд тулгуурлах нь зөв гэж үзсэн байна.

Тухайлбал: 1. Прагматик буюу миний хийсэн үйлдийн үр дүн юу вэ буюу би үүнийг хийсэн/эс хийснээрээ бусдад, олон нийтэд ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг тооцоолдог хандлага. Миний эрх ашгаас нийтийн эрх ашиг илүү.

2. Хүний эрхийн буюу хүмүүнлэг хандлага. Шударга байна гэдэг нь хүнд эдлэх ёстой эрхийг нь тэгш нээлттэй эдлүүлэх. Олдох ёстой боломжийг нь хаахгүй байх. Шаардлагатай нэгэнд илүү боломжийг түрүүлж олгох. Үүнийг

1. Хууль эрхзүйн

2. Ёс суртахууны гэсэн 2 замаар хэрэгжүүлэх

Оролцогч 4

Мөн түүхэн бодит баримтуудад тулгуурлан заах нь зөв гэж үзсэн нэг судлаачийн хариултыг жишээ болгон харууллаа.

Тухайлбал: Ямар үзэл баримтлал гэх асуулт нь өөрөө маш ерөнхий байна. Гэхдээ миний бодлоор бол хүн төрөлхтөний мөнхийн үнэт зүйлсийг түүхэн бодит баримтуудад тулгуурлан заах нь зөв байх. Учир нь шударга байдал гэдэг бол бодит зүйл, жинхэнэ амьдарлын хэв хаяг юм. Тэрнээс хоосон үзэл суртал биш. Хүүхэд үүнийг зүгээр л нэг уриа лоозон гэж ойлговол бодит амьдралд хэрэгжүүлж чадахгүй. Тиймээс бодит түүхэн хүмүүсийн амьдралаас жишээ авч заах нь зөв гэж бодож байна.

Оролцогч 19

1.4. Шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзлийг бие хүний ёс суртахууны төлөвшилтэй хэрхэн холбож ойлгох вэ?

Тус асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Эцэг эхийн удам судартай холбоотой -10.5%
2. Гэр бүлийн суурь хүмүүжил, төлөвшил -10.5%
3. Өөрийн ёс суртахуунтай -47.3%
4. Онол түүхийн мэдлэгтэй холбогдоно -5.2%
5. Гэрийн боловсрол, зөөлөн үр чадвар-10.5%
6. Сэтгэл зүйн хүчин зүйлтэй холбоотой-5.2%
7. Ойлгуулах тусгах дадуулах дасгалуудыг хийлгэх байдалтай-5.2%
8. Соёл үнэт зүйл, гэдгийг төлөвшүүлдэг байх-5.2%

Оролцогчдын хариултуудаас харахад шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзлийг өөрийн ёс суртахуунтай холбоотой гэж ярилцлагад оролцогчдын 47.3 хувь нь үзсэн байна.

2. БОДЛОГЫН ТАЛААР

2.1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.3.4 дэх хэсэгт "Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр

харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.” гэж зорилго тавьсан байна. Үүнийг монгол хүний онцлог, зан чанарт тохируулан хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Ярилцлагын явцад оролцогчид дээд боловсролын зарим судлагдахуун болон ЕБС-ийн цөм хөтөлбөрт тусгасан байдаг тухай ярилцсан байна

Тухайлбал: Мэргэшсэн судлаачтай хамтарч яг ямар шатны, насны хүүхдэд өгөх вэ гэдэгт цогц хөтөлбөр боловсруулбал үр дүнтэй. Одоо бол засгийн газрын хөтөлбөрт бүх шатны ЕБС-д хичээлүүд тусгагдсан байгаа боловч энэ нь үр дүнгийн хувьд хангалтгүй, хүүхэд төлөвшихөд үр дүнтэй байх уу гэдэгт би бас сайн хэлж мэдэхгүй байна. миний харснаар мэргэшсэн хүмүүсийн оролцоо дутагдсан юм болов уу гэж бодогдсон.

Оролцогч 14

232

Бидний асуулга ярилцлагад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Философи, Хүний хөгжил, Монголын түүх, Үндэсний хэл бичиг зэрэг судлагдахууны агуулгыг яамнаас санал болгоод, нэг болгох-10.5%
2. Эх оронч сэтгэлгээ буюу үлгэр домог, тоглоом наадгай богино хэмжээний видео, кино, контентэд суурилах -5.2%
3. Монгол хүний сэтгэлгээ, нүүдэлчдийн соёл, нийгэм газарзүйн онцлог, ёс зүй дээр дээр тулгуурлах -15.7%
4. Ёс суртахууны үнэт зүйлээ тодорхойлж, түүн дээр тулгуурлах -10.5%

5. Судалгаанд суурилсан байх хэрэгтэй, монгол хүнээ таньж мэдэх -21%
6. Суралцагч нэг бүрийн суралцахуйн хэв маягыг шинжлэх ухааны үүднээс тогтоож, түүнд тохирсон арга зүйгээр сургалтыг менежментийн шинжлэх ухааны үүднээс зохион байгуулах-10.5%
7. Шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл гэдгийг ойлгуулах -5.2%

Оролцогчдын хариултуудаас харахад Монгол хүний сэтгэлгээ, нүүдэлчдийн соёл, нийгэм газарзүйн онцлог, ёс зүй дээр дээр тулгуурлах, Судалгаанд суурилсан байх хэрэгтэй, монгол хүнээ таньж мэдэх, шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл гэдгийг ойлгуулах нь хамгийн чухал болохыг дурдсан байна.

Шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл гэдгийг ойлгуулах талаар оролцогч дараах байдлаар ярилцсан байна.

Тухайлбал: Шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл болохоос Монгол хүний онцлогтой ямар ч хамаагүй зүйл. Монгол хүний онцлогтой шударга байдал гэж огт байхгүй. Ийм хүний нийгмийн нийтлэг ойлголтуудыг Монгол хүнд тохируулна гэдэг нь өөрөө шударга ёс гэсэн дэлхийн хаана ч адилхан тогтсон зүйлийг Монголд гуйвуулах, утга санааг нь алдагдуулах аюултай.

Оролцогч 19

- 2.2. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын 5.6-д Авилгагүй засаглал бүлгийн Үндэсний шударга ёсны

тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх I үе шатыг шударга ёсыг эрхэмлэсэн нийгэм гэж нэрлэсэн байна. Энэ үе шатанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлага төлөвшүүлэх үе гэжээ. Үүний тулд 5.6.1-д Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг монгол хүний ахуй, соёл, зан төлөвт нийцүүлэн бүх шатны боловсролын хөтөлбөрт тусган ... шударга ёсны тогтолцоог төлөвшүүлнэ. Боловсролын хөтөлбөрөөр бүх нийтийн хандлага төлөвшүүлэхэд ямар арга замыг та санал болгох вэ?

1. Бидний асуулга ярилцлагад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.
2. Үндэсний хөтөлбөр -5.2%
3. Хэвлэл мэдээлэл цахим орчин шударга байх хэрэгтэй. Зөөлөн ур чадварт суурилна.
4. Эцэг эхчүүдийн үлгэрлэл-10.5%
5. Багшийн шударга байдал -5.2%¹
6. Танхимын сургалтаас өөр хэлбэрээр оруулах -5.2%
7. Хичээлээр орох /Монголын түүх, ёс заншил, философи хичээлийн хөтөлбөрт тусгах, бусад хичээлд 50:50 тусгах заавал судалдаг хичээл байх,/-21%
8. Соён гэгээрүүлэх ажил хийх -10.5%
9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил орлоготой байх-5.2%

10. Мэдээллийн хэрэгсэл ашиглан насан туршийн, бүх нийтийн боловсролд зориулсан модуль боловсруулах -10.5%

11. Багшлах боловсон хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх -5.2%

Оролцогчдын хариултуудаас харахад Монгол хүний сэтгэлгээ, нүүдэлчдийн соёл, нийгэм газарзүйн онцлог, ёс зүй дээр дээр тулгуурлах, судалгаанд суурилсан байх хэрэгтэй, монгол хүнээ таньж мэдэх, шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл гэдгийг ойлгуулах нь хамгийн чухал болохыг дурдсан байна.

Тухайлбал: Боловсролын хөтөлбөрт монгол хүний үнэт зүйл, түүний дотор шударга ёсыг төлөвшүүлэх 1. Тусгай хичээл оруулах, 2. Бусад хичээлийн агуулгад эдгээр ойлголтуудын талаар түлхүү оруулах /тооны болон бусад хичээлийн бодлог дотор монгол ёс заншил, ахуй, шударга ёсыг тойрсон сэдэвтэй байх, биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт үндэсний бөх, сурын харваа зэргийг оруулах/, Интеграци судлагдахууныг бий болгож сургалтын төлөвлөгөөнд судлан шинжлэх, сэдвийг тодорхойлж тусгах 3. Шударга үйлдэл хийсэн сурагчийг алдаршуулах гэх мэт/, 4. Сурагчдын мэдлэгийн үнэлэмжийг илүү шударга, ил тод болгох нөхцөлийг бүрдүүлэх, 5. Хотын сурагчдын зуны амралтыг сайн дурын үндсэн дээр үр бүтээлтэй хөдөө орон нутгийн амьдрал ахуйтай танилцуулж, хамт олны зэрэг уур амьсгал бүрдүүлэн өнгөрүүлэхэд анхаарах. Хөдөөний сурагчдыг эсрэгээр нь хоттой танилцуулах. 6. Тодорхой зарим хичээлийг музей, театр, номын сан болон түүхт газар, албан байгууллагуудад очиж ордог болгох шаардлагатай байна.

Оролцогч 16

3. АГУУЛГЫН ТАЛААР

3.1 Бүх шатны боловсролын хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлага, авлигыг ҮЛ тэвчих үзэл төлөвшүүлэх агуулгын хүрээг та хэрхэн тодорхойлж байна вэ?

Албан болон албан бус байдлаар боловсролын бүх түвшинд тухайн насны онцлогт тохирсон агуулгыг боловсруулах, бүх нийтийн боловсролд л анхаарах шаардлагатай гэж үзсэн байна. Үүний хүрээнд агуулгыг дараах байдлаар боловсронгуй болгох хөгжүүлэх шаардлагатайг дурдсан байна.

1. Авилга өөрөө ямар хор уршигтай гэдгийг зөв ойлгуулах, аливаа үзэл төлөвшихөд таниулан мэдүүлэн ухааруулах, үүний дараа үзэл болгох, тэгээд хүний итгэл үнэмшил болгох
2. Цэцэрлэг, бага ангид нь - уламжлалт ёс суртахууныг төлөвшүүлэх, Дунд ахлах ангид нь нийгэм нийтийн ерөнхий зарчмыг ойлгуулах, Оюутан болоод ирэхээр нь моральтай байх талаар ойлгуулах
3. Цэцэрлэгийн түвшинд шударга ёс, ЕБС-ын түвшинд - бусдыг хохироохгүй байх, Их дээд сургуулийн түвшинд олонхийг сайн сайхны төлөө өөрийнхөө үйлдлийг хязгаарлах зэрэг чиглэлээр агуулгатай байх
4. Хичээлийн хөтөлбөр, сэдэв бүр дээр томъёолох
5. Хөтөлбөрийн агуулгыг байнга баяжуулах

6. Нэр томъёо, түүнийг хэрэглэхэд анхаарах

Хэрэгжүүлэх арга зүйг боловсруулахдаа дараах зүйлд түлхүү анхаарахыг санал болгосон байна. Үүнд:

1. Өөрийг нь өөртэй нь ажиллуулах, дүгнэлт хийх
2. Өдөр тутмын үйл ажиллагаатай холбох
3. Ойлгон таниулах, богино хэмжээний видео, танилцуулга, контентууд бэлдэх
4. Агуулыг Монгол ухаан, Монгол уламжлалтайгаа интеграцчилж, кэйс, жишээ, баримтаар баяжуулан хүргэх

Түүнчлэн ёс суртахууны илрэлүүдийг сурталчлах шаардлагатай гэж үзжээ.

3.2 Бүх нийтийн хандлага төлөвшүүлэхэд холбогдох агуулгыг боловсролын хөтөлбөрт ямар хэлбэр, хэмжээгээр тусгахыг та санал болгох вэ?

Бидний асуулга ярилцлагад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Хүн ам зүйн онцлогоо харгалзан насанд нь тохирсон агуулгыг тохирсон арга зүйгээр оруулах
2. Судлагдахуун бүрийн зорилго, агуулга, арга зүйд нь тусгах
3. Танхимын болон цахим хэлбэрээр хэрэгжүүлэх
4. Хичээлээс гадуурах үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх
5. Их дээд сургуулийн ерөнхий эрдмийн багш нарт зориулсан

- сургалт зохион байгуулах
6. Үндэсний хөтөлбөр гаргах
 7. Сурталчилгаа хийх
 8. Улсын хэмжээнд Үндэсний ёс заншил, түүх, шударга ёсыг эрхмэлсэн төрөл бүрийн зохион бичлэг, соёл урлагын тэмцээн уралдаан албан ёсоор зохион байгуулах зэрэг асуудлуудыг хөндсөн байна.

3.3. Шударга ёсны үзэл, хандлагыг сургалтын хөтөлбөр, АГУУЛГААР төлөвшүүлсэн сайн жишээнээс ярьж өгнө үү?

Бидний асуулга ярилцлагад зарим оролцогчид харилцан адилгүй байдлаар хариулсан байна. Ихэвчлэн хэрхэн хийх талаар ярьсан бөгөөд туршлага болгон танилцуулсан нь маш бага байна.

Зарим сургуульд Хууль хяналтын байгууллагуудын ахмадуудыг урьж нээлттэй уулзалт зохион байгуулж байсан. Багш, суралцагчид, эцэг эхийн гурвалсан харилцааг идэвхжүүлсэн байна.

Зарим байгууллага дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал: 2014-Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир, 2015- Ёс суртахууны монгол цагаан толгой, 2016, 2017, 2018-Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, 2020- Монголчуудын ёс суртахуун.сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт зэрэг сэдвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Оролцогч 1

4. АРГА ЗҮЙН ТАЛААР

4.1 Бүх нийтийн хандлага төлөвшүүлэхэд холбогдох агуулгыг боловсролын хөтөлбөрт тусгавал багшлахуй, суралцахуйн ямар арга, аргачлалыг та санал болгох вэ?

Бидний асуулга ярилцлагад зарим оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Үнэт зүйлийн эрэмбийг тогтоох
2. Цэцэрлэгийн сургалтын материал буюу үлгэр, зүйр үг, сургааль зэргээр дуу, шүлэг, үлгэрийг стандартчилах.
3. Бага ангид Ёс суртахуунц цагаан толгой, Дунд ангид Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир, Ахлах ангид Ёс зүйн үндэс сонгосон мэргэжилтэн холбоотой, Их дээд сурргуульд Мэргэжлийн ёс зүй, мораль заах, нийгмийн хариуцлага, иргэний үүргийн тухай ойлгуулах, хуулийг таниулах хичээлийг мэргэжил хамааралгүй заавал оруулах
4. Монгол арга ухаанд суурилсан уламжлалт ёс, Асуудал дэвшүүлэх, технологид суурилсан сургалт, зан үйлийн онол, олон талт оюуны онол, Оюун тархинд суурилсан сургалтын онол гэх мэт агуулгаар оруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Хэрэгжүүлэхдээ:

1. Багшийн арга зүйг сайжруулах сургалт зохион байгуулах
2. Багш нар өөрсдөө дүн гаргах, оюутан элсүүлэх, багш сонгон

- шалгаруулах гэх мэт процессуудыг ил тод, ардчилсан байлгаж байж үлгэрлэх
3. Багш үлгэрлэх
 4. Ёс суртахуунтай байх
 5. Итгэл үнэмшил төрүүлэх
 6. Сургалтын дэвшилтэт арга технологийг ашиглах
 7. Судлан шинэлэх чадварыг хөгжүүлэх, практикт тулгуурлах, тохиолдол шинжлүүлэх
 8. Багш, суралцагчийн гарын авлага боловсруулах шаардлагатай гэж үзжээ.

4.2 Хүүхэд өсвөр үеийнхэнд шударга ёсны үзэл, хандлагыг төлөвшүүлсэн таны ямар арга барил байдаг вэ?

Бидний асуулга ярилцлагад зарим оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

1. Ёс суртахууны монгол цагаан толгойг баримталдаг байх.
2. Английн туршлагаар Сонсогчийн шүүх ажиллуулдаг. Шийтгэлээ өөрсдөө зохионо. Ээлжилж шүүгч, өмгөөлөгч ялагч болдог. Бурууд дуугарч чаддаг болно.
3. Хичээл бүрийн сүүлд дүгнэлт бичүүлдэг, мэдсэн зүйлээ амьдрал дээр яаж хэрэгжүүлснээ бичдэг.
4. Сайн муугийн тухай сурталчлах, эцэг эхтэйгаа ярилцдаг, багц аргачлал гаргасан: асуулга, кейс, тест
5. Бүгдэд тэгш хүртээмжтэй ажиллахыг хичээдэг, хүүхэд болгонд яг нэг зарчим тавьдаг

6. Шударга ёсны агуулгатай ном зохиол, болсон явдал ярьж өгөх, хүмүүжлийн агуулгатай кино, ном хэлж өгч түнийг унших, үзэхийг зөвлөдөг.
7. Лекц унших, сэдэвчилсэн жүжигчилсэн тоглолт үзүүлэх, кейс дээр ажиллах, тодорхой сэдвийн дор хамтран ярилцах
8. Өөрийнхөө туулсан амьдарлыг жишээгээр тайлбарладаг.

Тухайлбал: Миний ордог судлагдахууны бүх агуулгад л тусгагддаг. Анхны хичээл дээр оюутнуудтай тохиролцоо хийдэг. 10-с илүү хоцрохгүй, хэн нэгэнд субъектив буруушаалт хийхгүй, утсаа унтраана гэх мэт. Хэрвээ ийм хэлцлээ зөрчвөл 5 оноо хасна. Бүх хүүхдээр ямар нэг илтгэл тавиулдаг ба шударга ёс, авилга, албан тушаалын тухай ойлголт буруу байвал засч өгдөг. Мөн радио нэвтрүүлэгт ордог ба ютүб видео хийгддэг.

Оролцогч 3

Экспертүүдийн ярилцлагын дүнд дараах санал, зөвлөмж гарч байна.

1. Бид боловсролоор дамжуулан хүүхэд, залууст шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлж төдийлан чадахгүй, хийж буй үйл ажиллагаа оролдлого нь бүрэн хэрэгжихгүй байна гэж ярилцлагад оролцогчдын 80 гаруй хувь үзсэн нь цаашид энэ чиглэлээр дорвитой үйл ажиллагаа явуулах шаардлагатайг илэрхийлнэ.
2. Ихэнх оролцогчид хүүхдийн шударга байдал нь шударга ёсны талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл, үйлчилгээний чанар, эцэг эхийн ойлголт, нийгмийн сэтгэл зүй, багшийн шударга

байдал, бие хүний танин мэдэхүй, чадамжтай холбоотой гэж үзсэн тул энэ чиглэлийн үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог хангах шаардлагатай.

3. Шударга ёсны үзэл, авлигыг үл тэвчих соёл, үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагыг оролцогчийн 31.5 хувь нь хүмүүнлэг ёсны онолд тулгуурлах нь зөв гэж үзсэн тул энэ чиглэлийн мэдээллийг олон нийтийн хүртээл болгох шаардлагатай.
4. Шударга ёсны үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзлийг өөрийн ёс суртахуунтай холбоотой гэж ярилцлагад оролцогчдын 47.3 хувь нь үзсэн байна. Ёс суртахууны боловсролын агуулга, хэрэгжилтэд хяналт хийх, нийт гэр бүлийн хүрээнд ёс суртахууны нэгдмэл ойлголттой болгох шаардлагатай.
5. Монгол хүнээ таньж мэдэх, шударга байдал бол хүн төрөлхтөний үнэт зүйл гэдгийг ойлгуулах нь хамгийн чухал байна. Иймд Дэлхийн иргэний боловсрол олгоход анхаарах нь зүйтэй.
6. Боловсролын хөтөлбөрөөр бүх нийтийн хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ эцэг эх, багш нарын үлгэр дууриалал хамгийн чухал байна.
7. Албанболон албанбус боловсролын бүх түвшинд тухайн насны онцлогт тохирсон агуулгыг боловсруулах, бүх нийтийн боловсролд анхаарах шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын боловсролын тухай хууль
2. Бага, дунд боловсролын тухай хууль
3. Дээд боловсролын тухай хууль
4. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр
5. Д.Нарантуяа, Судалгааны арга зүй, 2017
6. Экспертүүдийн ярилцлагын тэмдэглэл



УДИРДАХУЙН УХААНЫ ИЛТГЭЛ, ОРЧУУЛГА

Удирдахуйн ухааны тэнхим

НИЙГМИЙН КАПИТАЛ БА "НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯПОН ЗАГВАР"

Раймонд Чан К, Чао Киу Ченг, Ито Пенг



Орчуулсан: Шихихутуг их сургуулийн
Удирдахуйн ухааны тэнхимийн эрхлэгч.
Доктор (Ph.D), профессор Г.Энхбаяр

Товч танилцуулга

Фрэнсис Фукуяамагийн нийгмийн шинжлэх ухааны судлагдахууныг өргөтгөж нэвтрүүлсэн "нийгмийн капитал" хэмээх ойлголт нь хүн төрөлхтөн хамтран ажиллаж, амьдрах эерэг бололцоог буй болгож байгаа албан бус үнэт зүйлс юм. Тухайлбал, итгэлцэл бол Фукуяамагийн үзсэнээр хөгжингүй нийгмийн гол шинж, нийгмийн үнэт капитал ажээ. Нэр бүхий эрдэмтдийн энэхүү судалгаа Япон дахь нийгмийн хамгааллын тогтолцооны үндсэн мөн чанар нь итгэлцэл, нийгмийн сүлжээ ба албан бус бүлгүүдийн хамтын ажиллагаа, тэдгээрийн гишүүддээ үзүүлэх дэмжлэгийн нөлөөгөөр илэрдэг болохыг харуулсан байна.

"Нийгмийн хамгааллын Япон загвар"

Хэдийгээр нийгмийн хамгааллын албан тогтолцоо нь дайны дараах үеээс хэрэгжиж эхэлсэн боловч үндэс суурь нь

нилээд эрт тогтсон байжээ. "Хөршийн холбоо" буюу "Хөршөө халамжлах", "Нийгмийн тусламжийн холбоо" зэрэг үйл ажиллагаа нь Мэйжигийн үед хүчирхэгжиж эхэлсэн. Хөдөө тосгоны тариачид хөдөлмөрөө хоршихын зэрэгцээ хамтын нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгосон байна. Энэхүү тогтолцоо нь Дэлхийн 2-р дайны төгсгөл хүртэл үргэлжилсэн бөгөөд одоо ч зарим орон нутагт хэвээр хадгалагдаж үлдсэн юм.

1960 оноос төрийн нийгмийн халамж, байгууллагад суурилсан хөдөлмөрийн халамжийн хөтөлбөрүүд бий болжээ. 1973 онд Япон улсын Засгийн газраас "Халамжийн эриний нэг жил" нэртэй ахмад настануудад зориулсан үнэ төлбөргүй эрүүл мэндийн, тэтгэвэрийн тогтолцоог бий болгосон бөгөөд энэ нь Япон улсыг "халамжийн улс" гэж нэрлэхэд хүргэсэн.

"Амьдралын мөчлөгийн төлөвлөгөө"(1975), "Амьдралын мөчлөгийн халамжийн төлөвлөгөө" (1976), нэртэй тайлангууд нь тухайн үеийн Японы нийгэм-эдийн засгийн хүчирхэг байдлыг илтгэж байлаа. Нийгмийн буюу бүх нийтийн хөгжлийг үндэс сууриа болгосон Япон маягийн нийгмийн хамгааллын тогтолцоо нь Барууны хэв маягаас ялгаатай төдийгүй илүү алсыг харсан бодлого байв. Японы нийгмийн хамгааллын тогтолцооны Барууны загвараас ялгагдах гол онцлог

нь Засгийн газар буюу төр дангаар иргэдийн нийгмийн халамжид анхаарал хандуулах бус хувь хүн, өрх гэр, албан байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл зэрэг олон талын оролцоо бүхий хамтын ажиллагааг бэхжүүлсэнд оршино.

1987 онд Японы Засгийн газраас нийгмийн хамгааллын төрийн оролцооны төвлөрлийг сааруулах зорилгоор, нэн тэргүүнд хувь хүн өөртөө туслах систем, хоёрдугаарт, гэр бүл, орон нутаг, засаг захиргааны хамтын ажиллагаа, эцэст нь байгууллагын оролцоо гэсэн шат дарааллаар байж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн бөгөөд энэхүү тогтолцооны үр дүнд хувь хүмүүс болон орон нутаг, засаг захиргааны хамтын ажиллагаа эрс сайжирсан. 1993 онд Нийгмийн хамгааллын төв зөвлөлөөс бие биедээ харилцан туслах зорилго бүхий ашгийн бус нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулах, тэдгээр ажлыг зохион байгуулах сайн дурын ажиллагсдыг бий болгох төслийг боловсруулан хэрэгжүүлсэн нь Японы нийгмийн хамгааллын тогтолцоог шинэ шатанд гаргахад түлхэц болсон юм.

Гэвч нийгмийн хамгааллын дээрх тогтолцоог шүүмжлэгчид зарим нэгэн засвар хийхийг сануулсаар байдаг бөгөөд тэдний төлөөлөл болох эрдэмтэн, судлаач Ватанүки “Японы нийгмийн хамгааллын тогтолцоог гаднаас нь харахад гоё сайхан харагдаж болох ч үнэндээ ард иргэдийн оролцоог ашиглан Засгийн газар төсвийн зардлаа бууруулж байгаа нь зүйд үл нийцнэ” хэмээн шүүмжилсэн байдаг.

Нийгмийн капитал

Нийгмийн капитал нь итгэлцэл, хамтын ажиллагаа, харилцан туслалцаа, иргэний ухамсар, сайн дурын оролцоогоор тодорхойлогдоно гэвэл нийгмийн хамгааллын Япон загвар энэхүү үзэл санааг дэмжиж байгаа бөгөөд энэ нь нийгмийн бүлэг өөрийн гишүүнээ дэмжиж хамгаалах ёстой гэсэн санаа юм.

Энэхүү судалгаанд нийгмийн капиталыг 3 элементийн үндсэн дээр үнэлсэн. Үүнд:

- нийгмийн бүлэг, холбоодын сүлжээ; сүлжээний үнэ цэнэ;
- хувь хүмүүсийг үр ашигтай нөөц, тусламжаар хангах сүлжээний чадамж;
- хувь хүмүүсийн авсан тусламжийн хэмжээ.

Нийгмийн капиталын бүтцийн элементүүд нь албан болон албан бус сүлжээ бөгөөд үүнд найз нөхөд, хөршүүд, сайн дурын байгууллага ч хамаарна. Нийгмийн капиталын суурь хэмжээс нь итгэлцэл ба харилцан туслалцах юм. Итгэлцэл нь хүмүүс бол найдвартай, үр ашигтай, харилцан туслалцаатай, мөн шударга байж болно гэсэн итгэл үнэмшил дээр үндэслэдэг. Харилцан туслалцах нь хэдийгээр альтруист зан байдлаар өдөөгдөж болох ч эцсийн дүндээ урьдчилан тооцоолсон, эс тооцоолсон хувийн сонирхолыг багтаадаг билээ. (Фукуяама, 1997)

Түүнчлэн сүлжээний хүчирхэг байдлыг “эмпирик нийгмийн капитал (диагноз)”, “хувь хүний түвшин дэх ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал (прогноз)” гэж ангилан үнэлсэн.

Эмпирик нийгмийн капитал нь нийгэм дэх хувь хүмүүсийн бусдад тусласан хийгээд бусдаас тусламж хүртсэн туршлага юм.

Ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь ирээдүйн нөхцөлт болон нөхцөлт бус тусламжаар илэрдэг бөгөөд энэхүү тусламж нь дараагийн үед залгамжлагддаг.

Нөхцөлт тусламж нь өмнө нь үзүүлсэн тусламжийн хариуг хүртэх хэлбэрээр тусламж хүртдэг бол нөхцөлт бус тусламж нь өмнө нь хэн нэгэнд тусламж үзүүлсэн эсэхээс үл хамааран ирээдүйд бусдаас тусламж хүртэх явдал юм.

Японы нийгмийн капиталын үндэс суурь

“Нийгмийн капитал” хэмээх ойлголт Японд 1990 оноос хойш танигдаж эхэлсэн бөгөөд маш өргөн утга агуулгатай. Энэ үед нийгмийн капитал гэдэг ойлголтыг микро, макро түвшин дэх иргэний нийгэм, ашгийн бус байгууллага, төрийн бус байгууллагын нийгэм дэх оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд голчлон авч үзсэн. Учир нь 1970 оноос хойш иргэний нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоо нэмэгдсэн. Ашгийн байгууллага 5448-аас 14728, холбоо 2218-аас 5248, академик болон соёл урлагийн холбоо 349-өөс 941, улс төрийн холбоо 201-ээс 840 болж нэмэгджээ. Судалгаагаар “иргэний оролцоо” 1981-1996 оны хооронд 20 гаруй хувиар өссөн бөгөөд 30-40 насны эмэгтэйчүүд, 40 хүртэлх насны эрэгтэйчүүд сайн дурын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог болох нь батлагдсан байна.

Судалгаа

Кобэ бол Японы томоохон хотуудын нэг бөгөөд 1995 онд болсон газар хөдлөлтийн үеэр 5000 гаруй хүн амь үрэгдэж, 320,000 гаруй хүн орон гэргүй болсон юм. Энэхүү газар хөдлөлт Японы ард түмэнд том сургамж болсон бөгөөд гамшигийн үйл ажиллагаанд сайн дураараа оролцохоор 1,000,000 гаруй иргэн Японы өнцөг булан бүрээс ирж байжээ. Кобэ хот нийгмийн капиталын бодит шалгуур болсон байна.

Хүснэгт 1. Албан болон албан бус сүлжээнд хамаарах оролцоо

Нийгмийн бүлэг	Өрөлцөө,онгорсон жилд оролцсон тоо /дундаж/	1 жил дэх өрөлцөөны үргэлжлэх хугацаа / дундаж/
Сургуульд хамааралтай бүлэг	5.5	0.9
Худалдааны болон бизнесийн бүлэг	4.8	2.1
Спортын бүлэг	4.3	0.5
Сайн дурын байгууллага эсвэл бүлэг	2.2	1.1
Шашны бүлэг	2.1	1.9
Хөрийн болон сумын холбоо	1.5	2.7
Урлагийн холбоо	1.3	1.1
Эмгэгтэйчүүдийн бүлэг	1.3	0.5
Иргэний бүлэг	0.9	0.4
Оршин суугчдын эсвэл коммунист үйл ажиллагааны бүлэг	0.8	0.7
Эцэг эхийн бүлэг	0.7	0.7
Сургуулийн комисс	0.7	1.3
Мэргэжлийн холбоо	0.4	0.6
Ус болон хөгжмийн үйлдвэрийн бүлэг	0.3	0.3
ГББ	0.3	0.1
Эрүүд мэндийн комисс	0.2	0.2
Улс төрийн бүлэг	0.2	0.8
Залуучуудын бүлэг	0.2	0.5
Тариаланчдын болон загасчдын бүлэг	0.2	0.6
Үйлдвэрчний эвлэл	0.1	0.6
Үндэстэн ястны бүлэг	0.1	0.7
Улс төрийн нам эсвэл улс төрийн компаниг ажил	0.0	0.0

Хүснэгт 2. Бүтцийн нийгмийн капитал /сонгогдсон бүлгүүд/

Бүлгүүд	Дундаж
Бүтцийн нийгмийн капитал	44.3
Сүлжээний нягтрал	
Танай нийгмийн бүлэг дотор хүмүүс хоорондоо хичнээн удаа бие биетэйгээ холбоо тогтоож байсан бэ?	46.8
Танай нийгмийн бүлэг дотроо бие биенээ хир сайн мэдэх вэ?	47.7
Танай нийгмийн бүлэг доторх хүмүүсийн хичнээн нь нэг байгууллагад хамаарагддаг вэ?	46.9
Танай нийгмийн бүлэг доторх хүмүүсийн хичнээн нь нэгнийхээ найз байсан бэ?	46.1
Сүлжээн дэх адил төстэй байдал	45.8
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь танытай адилхан хүйтэй вэ?	38.4
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь нэг мэргэжилтэй вэ?	51.5
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь адил түвшний боловсролттой вэ?	50.8
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь адил түвшний хөрөнгөтэй вэ?	45.3
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь адил улс төрийн үзэлтэй вэ?	41.8
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь нэг шашинтай эсвэл шашны бүлэгт хамаарахгүй вэ?	26.8
Танай нийгмийн бүлгийн хичнээн нь нэг гэр бүлийн гишүүд вэ?	18.5
Сүлжээн дэх ойр дот байдал	13.7
Танай нийгмийн бүлэг хоорондоо хэр дотно байсан бэ?	43.0
Танай нийгмийн бүлэг бие биендээ хэр их туслалцаа үзүүлдэг байсан бэ?	48.8
Танай нийгмийн бүлгийн гишүүдийн хичнээн нь бие биетэйгээ ойр амьдардаг байсан бэ?	44.8
Танай нийгмийн бүлгийн гишүүдийн хичнээн нь бие биетэйгээ ойр амьдардаг байсан бэ?	32.4

Хүснэгт 3. Эмпирик нийгмийн капитал /сонгогдсон бүлгүүд/

Бүлгүүд	Дундаж
Эмпирик нийгмийн капитал	23.9
Тусламж авсан	23.3
Гэр бүлээсээ	55.2
Найз нөхдөөсөө	42.9
Хамт олноосоо	33.3
Хөрнөөсөө	25.2
Мэргэжлийн зөвлөгч нараас	20.3
Үл таних хүмүүсээс	16.9
Сайн дурынхнаас	5.7
Улс төрчдөөс	1.7
Хариу хүсээгүй хөрөнгө оруулалт /нөхөн төлбөр хүсэхгүйгээр/	24.5
Найз нөхөддөө туслах	43.3
Хамт олондоо туслах	35.2
Үл таних хүмүүст туслах	27.7
Хоршүүддээ туслах	25.1
Сайн дурын ажил хийх	24.8
Хамаатан садандаа туслах	22.5
Байгууллагуудад туслах	9.6
Улс төрчдэд туслах	7.3

Хүснэгт 4. Ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал /сонгогдсон бүлгүүд/

Бүлгүүд	Дундаж
Ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал	
Хүлээж буй нөхцөлт тусламж	46.1
Танай хоршүүд таны тусламж үзүүлэхний хариуг барихдаа бэлэн байдаг уу?	40.8
Таны хамааралтай байгууллага таны тусалсны хариуг барихдаа бэлэн байдаг уу?	44.4
Хүлээж буй нөхцөлт бус хувийн тусламж	37.3
Таны элсэн орсон байгууллага дах итгэлцлийн байдал ямар вэ?	41.1
Таны найз нөхөд хариу хүсэхгүйгээр танд туслахад хэр бэлэн байдаг вэ?	46.9
Таны хоршүүдийн итгэлцэл хэр вэ?	52.0
Та хоршүүдийнхээ хэдэд нь итгэж чадах вэ?	43.1
Таны хорш хариу хүсэхгүйгээр танд туслахад хэр бэлэн байдаг вэ?	39.5
Хүлээж буй нөхцөлт бус бүлгийн тусламж	39.3
Таны гэр бүлийн эв санааны нэгдэл хэр вэ?	45.0
Таны элсэн орсон байгууллагуудын эв санааны нэгдэл хэр вэ?	60.6
Таны нийгмийн бүлгийн эв санааны нэгдэл хэр вэ?	50.1
Таны хорш зэргэлдээ айлуудын эв санааны нэгдэл хэр вэ?	48.2
Хүлээж буй харилцаа холбооны үргэлжлэх байдал	37.9
Та хотод хэр удаан амьдрах вэ?	57.0
Та байгаа энэ орчиндоо хэр удаан амьдрах вэ?	63.2
Таны одоогийн байгаа найз нөхдийн холбоо хэр бөх баг вэ?	61.4
Танд нийгмийн бүлгээс үзүүлж буй дэмжлэг таны тэдэнд үзүүлж буй дэмжлэгтэй адил уу?	60.2
Таны нийгмийн бүлэг хэр тогтвортой вэ?	59.1

Нийгмийн капитал ба итгэлцэл, хүлээлт

Бүтцийн нийгмийн капиталын хуримтлал нь эмпирик нийгмийн капитал болон ирээдүйд чиглэсэн нийгмийн капиталын оролцооны үр дүнгээс шууд хамаардаг. Бидний судалгаагаар “Эмпирик болон ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь их байх тусам хүлээгдэж буй үр дүн их байна” гэдэг нь батлагдсан бөгөөд энд эмперик нийгмийн капитал (0,124), ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал (0,255) байв.

Эмпирик нийгмийн капитал, ирээдүйд чиглэсэн нийгмийн капиталын хувьд төдийлөн зөрүү ажиглагдаагүй бөгөөд (0,065) урьд өмнө нь тусламж хүртсэн үгүйгээс

эс хамааран ирээдүйд тусламж хүртдэг болох нь судалгаагаар тогтоогдсон. Японы нийгмийн капиталын чадамжийн итгэлцэлийн түвшин өндөр төдийгүй ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь эмпирик нийгмийн капиталаас илүү хэмжээгээр эцсийн үр дүнд нөлөөлдөг болох нь мөн ажиглагдсан. Энэхүү судалгаа нь Японы нийгмийн капиталын үр нөлөөг дараах байдлаар тодорхойлон гаргасан. Үүнд:

1. Бүтцийн нийгмийн капитал нь ирээдүйд чиглэсэн нийгмийн капиталыг тэтгэх үндсэн нөхцөл болдог хэдий ч ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь өөрийгөө санхүүжүүлэх боломжтой үед энэ нь бүтцийн нийгмийн капиталыг бууруулахад хүргэдэг.

2. Бүтцийн нийгмийн капитал нь зөвхөн нийгмийн сүлжээний үйл ажиллагаа найдвартай байгаа үед л үр дүнтэй.

Нийгмийн капиталын түвшин нь тухайн нийгмийн нийгэм-хүн ам зүйн хүчин зүйлээс хамаардаг. Судалгаагаар, ажил эрхлэдэг Япон хүмүүсийн хүүхэдтэйгээ цагийг хамт өнгөрүүлэх буюу тэдэнд тавих анхаарал сул байгаа нь ажиглагдсан. ($\beta = -0.228, p < 0.05$) . Түүнчлэн уг судалгаагаар хүн амын боловсролын түвшин өндөр байгаа нь тогтоогдсон ($\beta = 0.259, p < 0.05$).

Өндөр орлоготой ($\beta = 0.101, p < 0.05$) , тухайн орон нутагтаа олон жилийн турш амьдарсан ($\beta = 0.115, p < 0.05$) өндөр настнуудын эмпирик суурилсан нийгмийн капитал өндөр ($\beta = 0.259, p < 0.05$) байв.

Ажил эрхэлдэг (β), хөршүүдтэйгээ

тухайн орон нутагтаа олон жилийн турш амьдарсан гэр бүлийн хувьд ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь өндөр үзүүлэлттэй байна. ($\beta = 0.268$).

Нийгмийн хамгааллын Япон-загвар дахь Нийгмийн капиталын ач холбогдол

Бидний хийсэн судалгааны үр дүнд Нийгмийн хамгааллын Япон-загварын оршин тогтнох үндсэн нөхцөл нь нийгмийн сүлжээ буюу олон нийтийн оролцоо бөгөөд төрийн оролцооны түвшин бага болох нь ажиглагдлаа. Түүнчлэн бүтцийн нийгмийн капиталын түвшин “дундаж” үзүүлэлттэй байсан хэдий ч Японы нийгэм дэх нийгмийн капиталыг хүчирхэгжүүлж буй гол хүчин зүйл нь хүмүүсийн ирээдүйд үүний хариу буцаж ирнэ гэсэн итгэлээр илэрч байв.

Гэр бүл, найз нөхөд, сүлжээний хоорондын хамтын ажиллагааны түвшин өндөр, харилцан туслалцах замаар энэхүү харилцаагаа удаан хугацаанд хадгалж чаддаг байна. Гэвч Японы нийгэм итгэлцэлийн хомсдол, ирээдүйд тусламж хүртэнэ гэдэгтэй найдахгүй байдалд орж болзошгүй бөгөөд энэ нь нийгмийн капиталын хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх нь гарцаагүй. Нийгмийн капиталын илүү хүчирхэг бүтцийг бий болгохын тулд хүмүүсийн туршлагад суурилсан хийгээд ирээдүйд чиглэсэн нийгмийн капиталын эерэг нөлөөг дэмжих нь чухал ач холбогдолтой.

Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж буй хүмүүсийн дийлэнх хувийг өндөр настнууд эзэлж байгаа бөгөөд цаашид энэ үйл ажиллагаанд залуусыг татан оролцуулах нь чухал ач холбогдолтой.

Бидний судалгаагаар, Японы өндөр настнуудын туршлагад суурилсан нийгмийн капитал нь дундаж үзүүлэлтээс дээгүүр, харин ирээдүйд чиглэсэн нийгмийн капитал нь дунджаас доогуур байлаа. Энэ нь дээрх бүлгийн хүмүүс ирээдүйгээ тун ч тодорхой бусаар төсөөлж буйг тусгаж байж болох юм. Японы нийгэм дэх өндөр настнуудын хувийн жин өссөөр байгаа өнөө үед тэдний итгэл найдварын түвшин буурч байгаа нь нийгмийн тогтвортой байдлыг сарниулах хүчин зүйл болж болзошгүй.

References

- Anderson SJ (1993). *Welfare policy and politics in Japan: beyond the developmental state*. New York, Paragon House.
- Bourdieu P (1983). Forms of capital. In: Richardson JG, ed. *Handbook of theory and research for the sociology of education*. New York, Greenwood Press.
- Bullen P, Onyx J (1998). *Measuring social capital in five communities in NSW*. Retrieved April 6, 2001 from <http://mapl.com/au/A2.htm>
- Coleman JS (1988). Social capital in the creation of human capital. *American Journal of Sociology* 94 (Supp): S95–S120.
- Evans P (1996). Government action, social capital and development: reviewing the evidence on synergy. *World Development* 24(6): 1119–1132.
- Fukuyama F (1995). *Trust: the social virtues and the creation of prosperity*. New York, Free Press.
- Fukuyama F (1997). *Social capital: the problem of measurement*. Retrieved April 6, 2001 from <http://www.cipe.org/mdf1997/socicap.htm>
- Fukuyama F (1999). *Social capital and civil society*. Paper presented at the IMF Conference on Second Generation Reforms, Washington, DC, 8–9 November.
- Furukawa S (2000). An institutional framework for Japanese crisis management. *Journal of Contingencies and Crisis Management* 8(1): 3–14.
- Goodman R, Peng I (1996). The East Asian welfare states: peripatetic learning, adaptive changes and nation building. In: Esping-Andersen G, ed. *Welfare state in transition: national adaptations in global economies*. London, Sage; Geneva, UNRISD.
- Hampshire A, Healy K (2000). *Social capital in practice*. Paper presented at the Seventh Australian Institute of Family Studies Conference, Sydney, 24–26 July.
- Hjerppe R, Kajanoja J (2000). *Social capital: the missing link in the performance measurement*. Paper presented at The Year 2000 International Research Conference on Social Security, Helsinki, 25–27 September.
- Hofferth SL, Boisjoly J, Duncan GJ (1999). The development of social capital. *Rationality & Society* 11(1): 79–110.
- Inoguchi T (1996). *The decline of social capital: Japan*. Paper presented at the Conference on the Decline of Social Capital, Boston, 27–28 April.
- Inoguchi T (1998). *Social capital in Japan*. Paper prepared for the Inoguchi T (2002). Broadening the basis of social capital in Japan. In: Putnam, RD, ed. *Democracies in flux: the evolution of*

social capital in contemporary society. New York, Oxford University Press.

Kodansha (1999). *Encyclopedia of Japan*. Tokyo, Kodansha.

Krishna A, Shrader E (1999). *Social capital assessment tool*. Paper for the World Bank Conference on Social Capital and Poverty Reduction, Washington, DC, 22–24 June.

Maruo N (1986). The development of the welfare mix in Japan. In: Rose R, Shiratori R, eds. *The welfare state East and West*. New York, Oxford University Press.

Mochizuki K (2002). Japan: from activist groups to management organisations. In: Shigetomi S, ed. *The state and NGOs: perspective in Asia*. Singapore, ISEAS.

Omori T, Yonezawa A (2002). *Measurement of social capital in Japan*. Paper presented at the Social Capital Measurement Conference, London, 25–27 September.

Putnam R (2000). *Bowling alone: the collapse and revival of American community*. New York, Simon & Schuster.

Scheufele D, Shah, DV (2000). Personality strength and social capital. *Communication Research* 27(2): 107–131.

Shiratori R (1985). The experience of the welfare state in Japan and its problems. In: Eisenstadt SN, Ahimeir O, eds. *The welfare state and its aftermath*. London, Croom Helm.

Shiratori R (1986). The future of the welfare state. In: Rose R,

Shiratori R, eds. *The welfare state East and West*. New York, Oxford

University Press.

Stone W (2001). *Measuring social capital: towards a theoretically informed measurement framework for researching social capital in family and community life*. Melbourne, Australia

Institute of Family Studies.

Takahashi M (1997). *The emergence of welfare society in Japan*. Aldershot, Avebury.

Tsujinaka Y (2002). *The cultural dimension in measuring social capital: perspectives from Japan*. Paper presented at Social Capital: The Challenge of International Measurement, London, 25–27 September.

Wallis A (1998). Social capital and community building. *National Civic Review* 87(4): 317–337.

Watanuki J (1986). Is there a 'Japanese-type welfare society'? *International Sociology*, 1(3).

Yoshino R (2002). A time to trust – a study on people's sense of trust from a viewpoint of cross-national and longitudinal study on national character. *Behaviormetrika* 29(2): 231

ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН



Удирдлагын академийн Менежментийн
тэнхимийн профессор, Монгол улсын
Гавьяат багш: Я.Шуурав

248

Хураангуй: Улс үндэстний онцлог, бусдаас ялгаатай оршин байх нэг хүчин зүйл бол тухайн үндэстний соёлын үнэт зүйл байдаг. Тэгвэл дэлхийн 100 гаруй улс үндэстний соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнийг Голландын эрдэмтэн Г.Хофстэйд /G.Hofstede/ болон бусад судлаачид түүний загварын дагуу үнэлж гаргасан байдаг. Харин Монгол улсын хувьд Г.Хофстэйдийн өөрийнх нь судалгаанд хамрагдаагүй байдгийг иш үндэс болгон түүний боловсруулсан Үнэт зүйлийн судалгааны загвар (Value Survey Model)-ын хамгийн сүүлчийн хувилбар болох VSM13-ыг ашиглан Монголчуудын соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнийг тодорхойлж гадаад, дотоодын бусад судлаачдын судалгааны дүнтэй харьцуулан дүгнэлт хийх оролдлого хийлээ.

Түлхүүр үг: соёл, соёлын үнэт зүйл, үндэстний соёл, соёлын хэмжигдэхүүн, Г.Хофстэйдийн VSM загвар

НЭГ. СОЁЛ, ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ СУДАЛГААНЫ ТОЙМ

Дэлхийн улс орнууд хөгжлийн янз бүрийн түвшинтэй байдаг. Энэ нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлт, ёс уламжлалаа шингээсэн соёлын үнэт зүйлд суурилсан менежментийн ухаан, арга барилаас хамааралтай байдаг нь тодорхой юм.

Соёл судлалын болон менежментийн ухаанд соёлын талаарх олон зуун тодорхойлолт¹, гурван гол хандлага² байдаг бөгөөд энэ нь соёл хэмээх ойлголтын нарийн төвөгтэй, нийлэг, системлэг мөн чанарыг илтгэн харуулж байгаа юм. Би лекцийнхээ зорилго, агуулгад нийцүүлэн үйл ажиллагааны ба үнэт зүйлсийн хандлагыг суурь болгон авч, соёлыг нийгмийн амьдралын хэв маяг, бүтээн туурвих, үйлдвэрлэн бүтээх арга ажиллагаатай холбон авч үзэх болно. Өөрөөр хэлбэл, соёлыг нийгмийн гишүүдийн бүтээлч үйл ажиллагааны бүтээгдэхүүн, нөгөө талаар ирээдүйн үйлийн нөхцөл гэдэг утгаар нь тодорхойлж, хэмжих болно. Үгийн үндэс, гарлаар нь хөөлөө ч гэсэн Латин хэлний Cultura гэдэг үг нь тарих, өсгөх, боловсруулах гэсэн утгатай билээ. Менежментийн ухаан, онол нь хийсвэр зүйл биш, амьдрал, үйлдлэгээс ургуулан судалж олсон бодитой зүйл

¹ История Мировой культуры. Культурология. М., 1998, стр. 101

² Д.Тунгалаг. "Соёл"-ын эргэн тойронд: Үг, утга, ойлголт, хандлага. "Менежмент" сэтгүүл, 2005/01/04/, х. 149

гэдэг нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, менежментэд үндэстнүүдийн ялгаанаас үл хамаарах ерөнхий зарчмууд байдаг гэсэн үг. Харин тэдгээрийг менежментийн үйлдлэгт хэрхэн хэрэглэх вэ гэдэг нь үндэсний соёлоос ихээхэн хамааралтай нь олон улсын туршлагаас илт харагддаг бөгөөд энэ нь соёлын судалгааны үйл ажиллагааны хандлагын үндсэн санаа болдог билээ.

Үндэсний соёлын үнэт зүйлийн ялгааг тодорхойлж, хэмжих чиглэлээрх судалгаагаараа нэрд гарсан хүн бол Голландын эрдэмтэн Гийрт Хофстейд юм. Тэрээр 1970-аад оны эхээр IBM корпорацийн тив тивийн 40 оронд байрладаг салбаруудад ажилладаг ажилтнуудын дунд судалгаа хийж Япон, Австрали, Энэтхэг, Солонгос зэрэг орнуудын соёлын үнэт зүйлийн ялгааг тодорхойлж, хувьч ба хамтач үзэл, эрх мэдлийн алслалт (зөрүү), тодорхойгүй байдал (эрсдэл)-д хандах хандлага, эршүүд ба ээнэг (феминизм) шинжийн индекс (хэмжигдэхүүн)-ийг тодорхойлсон байна. Энэ судалгаагаараа Г.Хофстейд соёлын үнэт зүйлийн эдгээр 4 бүрдэл нь улс орон, байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагаа, мөн байгууллагын менежментэд ч нөлөөлдөг хэмээн дүгнэжээ. Сүүлийн жилүүдэд тэрбээр судалгааныхаа хамрах хүрээг улам өргөжүүлж дэлхийн 3 бүс нутгийн 50 гаруй улс орны соёлын үнэт зүйлийг судалсан бөгөөд түүний судалгаа нийтдээ тив тивийн 104 улс орныг хамарсан байна (<http://geerthofstede.com/countries.html>).

Г.Хофстейдын VSM загвар нь хэдийгээр "төгс биш, мохоодуу" хэрэгсэл

ч гэсэн түүнээс өөр үндэстнүүдийн соёлын үнэт зүйлийг хэмжих арга олдоогүй гэдэг (Charles Rarick and others, p. 6). Тиймээс ч түүний зохиол, бүтээлүүд дэлхийн 23 хэлээр хэвлэгдэж, 1987-2011 оны хооронд 9000 удаа иш татагдан Европтоо энэ үзүүлэлтээр тэргүүлсэн байна.

Г.Хофстейд болон түүний багийн судалгаанд хамрагдсан улс орнуудын жагсаалтанд Монгол улс ороогүй байдаг. Гэвч Монголчуудын соёлын үнэт зүйлийг тодорхойлж, хэмжих оролдлогыг гадаадынхан анхлан хийсэн байдаг нь сонирхол татна. 2014 онд АНУ-ын Турдуегийн Калумет их сургуулийн Чарльз Рэрик, Грсгори Уинтер нарын зургаан хүнтэй баг Г.Хофстейдийн VSM94 загварыг ашиглан манай их сургуулиудын 50 оюутныг респондентээр сонгон судалгаа хийж, дүнгээ ClobalJornal of Management and Business Research: A administration and Management (Volume 14, Issue 9, Version 1.0, Year 2014) сэтгүүлд "Монгол: Хофстейдийн 5-D загвараар соёлын төрхийг тодорхойлох нь (Mongolia: A Cultural Portrait using the Hofstede 5-D Model)" гарчигтайгаар нийтлүүлжээ. Уг өгүүлэлд Монгол улс бол байгалийн асар их нөөцтэй, бизнесийн боломж ихтэй, 3G (Global Growth Generator) буюу Глобаль өсөлтийн хөдөлгүүр ангилалд багтаж буй орон хэдий ч энэ орны ард түмний соёлын үнэт зүйлийн талаар гадаадынхан бараг төсөөлөлгүй байдаг гээд бизнесийн хүрээнийхэн Монголд хөрөнгө оруулж, амжилт олохын тулд үүнийг судалж мэдэх хэрэгтэйг тэмдэглэжээ. Америкчуудын

судалж тогтоосноор Монголчууд эрх мэдлийн алслалт (зөрүү) багатай (18), хувьч үзэл өндөртэй (71), эршүүд шинжээрээ дэлхийд дээгүүрт ордог (103), тодорхойгүй байдал (эрсдэл)-д болгоомжтой ханддаг (92), богино хугацааны баримжаатай (41) гэсэн соёлын үнэт зүйлтэй ажээ. Эдгээр үзүүлэлтүүдийг Хятад, Орос, Энэтхэг, Солонгос, АНУ-тай харьцуулахад хувьч үзлээр АНУ-тай (85), тодорхойгүй байдал (эрсдэл)-д хандах хандлагаараа Оростой (90), эрх мэдлийн алслалт (зөрүү)-аар Хятадтай (18) ойролцоо байгаа нь харагдана. Энэ судалгааны дүнгээр Монгол, АНУ-ыг соёлын үнэт зүйлийн бүх ангилалаар харьцуулсныг График 1-ээс үзнэ үү. Дээр дурдсан Чарльз нарын судалгаанаас гадна АНУ-ын иргэн Удирдлагын академийн докторант Жорж Кенворти-гийн судалгааг энд дурьдаж болох юм. Тэрбээр Монгол улс дахь Олон улсын ТББ-уудын байгууллагын соёлын төлөвшил, хөгжлийн асуудлыг мөн л Г.Хофстейдийн 5D загвараар судалж байгаа бөгөөд ингэхдээ үндэсний соёлын үнэт зүйлс байгууллагын шинж чанар (соёл)-д хэрхэн нөлөөлдөгийг тодорхойлох чиглэлээр судалгаа хийж байгаа ажээ. Өөрийн үндэстний соёлын үнэт зүйлсийг судалж, хэмжих оролдлогыг манай судлаачид ч хийж эхлээд байна. Тухайлбал, СЭЗДС-ийн багш, доктор С.Түвшинзаяа ахлагчтай багийн “Үндэсний үнэт зүйлийн судалгаа”, ШУТИС-ийн БУХС-ийн багш, доктор Х.Ариунаагийн “Монголын үндэсний соёлын хэмжүүр”, Удирдлагын академийн багш, доктор Б.Хэрлэнгийн

“Төрийн байгууллагуудад зонхилж буй соёлын судалгаа”, П.Саранчулууны “Монгол, Хятад хоёр улсын соёлын ялгааг Хофстейдийн аргачлалаар харьцуулсан судалгаа (Магистрийн ажил)” сэдэвт судалгаануудыг, мөн “Төрийн захиргаа” сэтгүүлийн 2015 оны нэгэн дугаарт профессор А.Цанжид, доктор С.Зульфикар нар энэ асуудалд хамаарах сэдвээр өгүүлэл нийтлүүлснийг энд дурьдаж болох юм.




График 1. Үндэсний соёлын үнэт зүйлийн харьцуулалт (Монгол, АНУ)

Г.Хофстейдийн үндэстний соёлын үнэт зүйлийг тодорхойлж хэмжих загвар нь VSM82, VSM94, VSM08, VSM13 буюу 4 хэмжигдэхүүнээс 6 хэмжигдэхүүнтэй болж өргөжин шинэчлэгдэж ирсэн байна. Уг загварын хамгийн сүүлчийн хувилбар болох VSM13-д соёлын хэмжигдэхүүнийг дор дурьдсанаар тодорхойлжээ. Үүнд:

- PDI (Power Distance Index) - Эрх мэдлийн алслалт (зөрүү)-ын индекс,
- IND (Individualism Index) - Хувьч ба хамтач үзлийн индекс,
- MAS (Masculinity Index) - Эршүүд/ээнэг (feminism) шинжийн индекс,

- UAI (Uncertainty Avoidance Index) - Тодорхойгүй байдал (эрсдэл)-аас зайлсхийх хандлагын индекс,
- LTO (Long Term Orientation Index) - Урт хугацааны баримжааны индекс,
- IVR (Indulgence Versus Restraint Index) - Эрэмших ба өөрийгөө эзэмдэх байдлын индекс эдгээр болно.

Хүснэгт 1. VSM загварын хэмжигдэхүүний өөрчлөлтүүд

VSM13	VSM08	VSM94	VSM82
/6 хэмжигдэхүүн/	/7 хэмжигдэхүүн/	/5 хэмжигдэхүүн/	/4 хэмжигдэхүүн/
PDI	PDI	PDI	PDI
IND	IND	IND	IND
MAS	MAS	MAS	MAS
UAI	UAI	UAI	UAI
LTO	LTO	LTO	
IVR	IVR		
	MON		


Хоёр. СУДАЛГААНЫ ДҮН

Судалгааны өгөгдлийг анхдагч болон хоёрдогч эх сурвалж ашиглан бүрдүүлж боловсруулалт хийлээ. Үүнд:

1. Г.Хофстейдийн үндэсний соёлын ялгааг тодорхойлж хэмжих VSM13 загварын англи эх хувилбар, орос, хятад орчуулгуудыг харьцуулан монгол хэл рүү хөрвүүлж, өөрөө гүйцэтгэх асуулга (анкет)-ын аргаар өгөгдөл цуглуулж, соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнүүдийг VSM13 Manual (formulas for Index Calculation)-ын аргачлалаар тооцож гаргав.
2. Сэдвийн хүрээнд бидний хийсэн судалгааны үр дүнг бусад судлаачдын судалгааны дүн, Г.Хофстейдийн соёлын үнэт зүйл, түүний хэмжигдэхүүнийг тодорхойлсон улс орнуудтай харьцуулан зэрэглэж дүн шинжилгээ хийсэн болно.

Энэ удаагийн судалгаанд нийт 200 төрийн албан хаагч хамрагдсан бөгөөд тэдний 34 хувь нь эрэгтэй, 66 хувь нь эмэгтэй байв. Респондентуудын зонхилох хувь (64 хувь) нь 15, түүнээс олон жил албан ёсны сургуульд сурч төгссөн, 24-49 насныхан (84 хувь) байсан юм.

Г.Хофстейдийн VSM загварын хувьд нийт 24 асуултын хариултуудын жигнэсэн дундачийг тооцож дүгнэлт хийхээс өгөгдлийн шинжилгээ эхэлдэг байна (VSM13 Manual). Бидний хийсэн судалгааны өгөгдлөөр жигнэсэн дундач хэмжигдэхүүнийг тооцоход дараах дүн гарч байна (График 2).



Гарфик 2. Асуултуудын хариултын жигнэсэн дундач хэмжигдэхүүн

Дундач хэмжигдэхүүнүүдийг харьцуулж үзэхэд эрх мэдлийн алслалт буюу зөрүү (PDI)-д хамаарах 20, 23 дугаар асуултуудын хариулт хамгийн өндөр (3.2, 2.7) дундажтай, цаг хугацааны баримжаа (LTO)-нд хамаарах (14, 19, 22) дугаар асуултуудын хариулт хамгийн бага (1.5, 1.7, 1.8) утгатай байгаа нь манайд эрх мэдлийн алслалт (зөрүү) их байдгийг, мөн бид богино хугацааны баримжаатай ажиллаж амьдардаг болохыг харуулж байгаа хэрэг юм. Мөн бидний монголчууд зоргоороо, эрэмшдэг (17, IVR) атлаа эх орноороо төдийлөн бахархдаггүй (19, LTO), үрэлгэн хандлагатай (14, LTO) болохыг ч эндээс харж болохоор байна.

Хүснэгт 2. Хамгийн их ба бага жигнэсэн дундач утгатай асуулт, хариултууд

Хамгийн өндөр үзүүлэлттэй асуултууд (дугаар, хамаарах хэмжигдэхүүн)	Дундач утга	Хамгийн бага үзүүлэлттэй асуултууд (дугаар, хамаарах хэмжигдэхүүн)	Дундач утга
Таны бодлоор, ажилтнууд удирдлагатайгаа (Оюутнууд багцтайгаа) сөргөлдөхөөс байнга эмээдэг үү? (20, PDI)	3.2	Даруу зан (зайлшгүй хэрэгцээгээ илүү зарцуулдаггүй байх) (14, LTO)	1.8
Таныг хүссэн зүйлээ хийхэд таны бусад хүмүүс болон нөхцөл байдал саад болдог уу? (17, IVR)	3.1	Та өөрийн эх орны иргэн гэдгээрээ бахархдаг уу? (19, LOT)	1.7
Та бүхмэдэл, түүшүүрийн байнга мэдэрдэг үү? (15, UAI)	3.0	Хичээж хөдөлмөрлөх нь үр дүнд хүрэх хамгийн найдвартай зан мөн (22, LTO)	1.5
Зарим ажилтнууд хоёр даргатай байдаг бүтээс ямар ч үнээр хамаагүй зайлсхийх хэрэгтэй (23, PDI)	2.7	Хүссэн (ая тухтай) газар (хот)-таа амьдрах (8, MAS)	1.4

Судалгааны өгөгдлийг нэгтгэн дүгнэж, монголчуудын соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүн (индекс)-ийг тооцоход дараах үр дүн гарч байна.

1. $PDI=35(m07-m02)+25(m20-m23)+C(pd) = 89,$
2. $IND=35(m04-m01)+35(m09-m06)+C(ic) = 43,$
3. $MAS=35(m05-m03)+35(m08-m10)+C(mf) = 45,$
4. $UAI=40(m18-m15)+25(m21-m24)+C(ua) = 16.5,$
5. $LTO=40(m13-m14)+25(m19-m22)+C(ls) = 59,$
6. $IVR=35(m12-m11)+40(m17-m16)+C(ir) = 110.5.$

Эндээс дүгнэж үзэхэд судалгаанд хамрагдагчид (төрийн албан хаагчид)-ын үнэлгээгээр манайд эрх мэдлийн алслалт (зөрүү) их (89), хувьч үзэл (43) болон эршүүд шинж (45) дундач түвшинд, тодорхойгүй байдал (эрсдэл)-аас зайлсхийх хандлага (16.5) тун тааруу, урт хугацааны баримжаа дундачаас арай дээгүүр (59), харин эрэмших (дэврүүн хүсэл) байдал (110.5) их байдаг ажээ. Бидний энэ удаагийн болон гадаад, дотоодын эрдэмтэдийн судалгааны дүнг харьцуулан уншигч, судлаачид өөр өөрсдийнхөө дүгнэлтийг хийнэ бизээ хэмээн харьцуулсан график (График 3), мөн хүснэгт (Хүснэгт 3)-д тус тус тусгалаа.



График 5. Монгол судлаачдын судалгааны харьцуулалт

Гадаад, дотоодын судлаачдын судалгааны үр дүнгээр тооцсон Монголчуудын соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүн тоон утгын хувьд нэлээд зөрүүтэй байгаа нь харагдана. Энэ нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарсан, бас олон зүйлийн шалтгаантай байж болох юм. Тухайлбал:

Хүснэгт 3. Гадаад, дотоодын судлаачдын судалгааны дүнгийн харьцуулалт

Загвар	Судлаач	Судалгаанд хамрагдагчдын бүрэлдэхүүн	PDI	IND	MAS	UAI	LTO	IVR
VSM 13	Я.Шуурав	Төрийн албан хаагчид	89	43	45	16.5	59	110.5
	Б.Бүжмаа							
	Х.Ариунаа	Холимог давхарга, бүлэг	85	57	70	28	36	59

VSM 94	Charles Rarick нар	Оюутнууд	18	71	103	92	41	-
VSM94	Siyena Chang	Тодорхой бус	75	30	44	78	-	-
VSM94	С.Түвшинзаяа	Холимог давхарга, бүлэг	12	19	53	76	43	-
VSM94	Н.Саранчулуун	Дунд түвшний менежерүүд	80	59	63	29	41	-
Дундаж хэмжигдэхүүн (индекс)			59.8	46.9	63.0	53.2	44	84.7

Судалгаанд VSM загварын өөр өөр хувилбар (VSM82, 94, 208, D13)-ыг ашигласан, асуулга болон түлхүүрийн орчуулга албан бус байгаа, мөн судлаачдын ойлголт, мэргэжлийн ур чадвар ялгаатай байгаа нь судалгааны чанарт нөлөөлсөн байж болно.

Түүврийн хэмжээ, бүтэц голлон нөлөөлсөн байх талтай. С.Түвшинзаяа нарынхаас бусад судалгааны түүврийн хэмжээ 50-200 хүн байгаа, мөн оюутан, эмэгтэйчүүд, төрийн албан хаагчдын төлөөлөл зонхилсон респондентүүдтэй байгаа нь ажиглагдлаа.

Орон зай, цаг хугацааны хүчин зүйлийг ч харгалзах учиртай. Дээрх судалгаанууд Улаанбаатар хотод, гол төлөв ажлын цагаар хийгдсэнийг ч бодолцох хэрэгтэй болов уу.

Г.Хофстейдийн соёлын үнэт зүйлийн судалгаанд дэлхийн бүх тивийн 104 улс орон хамрагдсан гэдгийг өмнө дурдсан билээ. Тэдгээрийн тоонд манай хоёр хөрш улс болон Азийн том, жижиг олон улс орон багтсан байдаг. Иймд нэг талаар сонирхуулах үүднээс, нөгөө талаар сонсогч, судлаачдад санаа авахуулж сэдэл төрүүлэх зорилгоор Монголд хийгдсэн бүх судалгааны дундач үзүүлэлтийг Орос, Хятад болон Азийн бусад орнуудтай харьцуулсан болно (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Үндэстнүүдийн соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүний харьцуулалт

Улсууд	PDI	IND	MAS	UAI	LTO	IVR
Монгол	59.8	46.9	63	53.2	44	84.7
Хятад	80	20	66	30	87	24
Орос	93	39	36	95	81	20
БНСУ	53	20	37	80	58	-
Япон	54	46	95	92	88	42
Энэтхэг	50	41	55	33	57	-

Улс орнуудын соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнийг харьцуулж үзэхэд Монголд эрх мэдлийн алслалт (зөрүү) их талдаа, эршүүд шинж давамгайл, харин хувьч үзлээрээ Азидаа дээгүүрт ордог, тодорхойгүй байдал (эрсдэл)-аас зайлсхийх хандлагаараа Япон, Солонгостой харьцуулахад сул боловч аливаад Хятад, Энэтхэгээс илүү болгоомжтой ханддаг ажээ. Мөн Азийнхантай харьцуулахад богино хугацааны баримжаатай (алсаа хардаггүй), эрэмших (зоргоороо байх) байдлаараа бусдаас ихээхэн дээгүүр болох нь харагдлаа.

ГУРАВ. ЗАРИМ ДҮГНЭЛТ, БОДОМЖУУД

PDI - Эрх мэдлийн алслалт (зөрүү) их, түүнийг байдаг л зүйл хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага бидний соёлын давамгайл үнэт зүйлүүдийн нэг болжээ. Энэ нь нэг их судалгаа, нотолгоо шаардаад байхааргүй, нүдэнд ил, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээ, аль ч түвшинд мэдрэгддэг үзэгдэл юм.

IND - Бид хөрш орнууд, Азийнхантай харьцуулахад илүү хувьч үзэлтэй ажээ. Ийм хандлага бидний өдөр тутмын амьдралд (айл хөршийн харилцаа, замын хөдөлгөөнд оролцогчдын ааш авир, нийтийн эзэмшлийн эд зүйлтэй харьцах байдал гэх мэт)-д ч газар, ус, байгалийн бусад нөөцийг ашиглаж, хамгаалж байгаа байдал дээр ч ажиглагддаг төдийгүй улс төр, нийгмийн оюун санааны хүрээнд ч нэвчжээ. Энэ талдаа би ч алдаатай бодол, дүгнэлттэй явжээ. Хэдэн зүйр цэцэн үг иш татаад л бид хамтач, бидний менежмент бол бүлгийн менежмент гэж ярьж бичиж ирсэн билээ.

MAS - Эршүүд ба ээнэг (феминист) шинж манайд эерэг тал руугаа өөрчлөгдөх хандлагатай болсон нь хүйсийн тэгш байдалд бүх түвшиндээ анхаардаг болсны үр дүн байж болох юм. Өөр хүчин зүйлүүд ч нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй.

UAI - Тодорхойгүй байдал (эрсдэл)-

аас зайлсхийх хандлага Азийн дундачийн түвшинд байгаа нь боломжийн үзүүлэлт хэдий ч бид зоримог, шийдэмгий алхам хийж урагшлах талаар Энэтхэг, Хятадын зиндаанд хүрээгүй байгаа нь харагдана. Энэ нь манай төр, засгийн бодлого, шийдвэрээс ч байгууллагын менежментийн үйлдлэгээс ажиглагдахаар зүйл юм.

LTO - Монголчууд алс хэтээ биш богино хугацааг баримжаалсан соёлын үнэт зүйлстэй гэж үзэхээр үр дүн бүх судалгаанаас гарчээ. Энэ бол хувь хүн, байгууллага, хамт олон, улмаар төр, засгийн бодлого, шийдвэрт хүртэл хамаарах дүгнэлт юм.

IVR - Эрэмших (чөлөөт байдал гэх нь ч бий) байдлын индекс дурьдсан судалгаануудын тус бүрийн дүнгээр болон дундачаар 80-аас дээш байгаа нь бүс нутагтаа төдийгүй олон улсын түвшинд өндөр үзүүлэлт юм.

Бидний энэ удаагийн судалгаа, мөн гадаад, дотоодын эрдэмтэдийн хийсэн судалгааны тус тусын болон харьцуулсан дүнг толилуулахад ийм байна. Өмнө тэмдэглэсэнчлэн Г.Хофстейдийн VSM загвар нь төгс биш, “мохоодуу” хэрэгсэл юм. Уг загвараар хийгдсэн судалгаануудын тус тусын болон нэгтгэж харьцуулсан дүнг энд багтаалаа. Зарим гүймэл бодомж, дүгнэлтүүд нь зөвхөн энэ өгүүлэл, зохиогчдынх гэдгийг тэмдэглэж байна. Юутай ч гэсэн монголчуудын соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүн, бидний соёлын

төрх (Rafick, p. 4) өнөөдөртөө ийм л байна. Энэ нь өнгөрсөн түүхийн улбаа юу, өнөө цагийн өнгө үү гэдгийг, мөн соёлын үнэт зүйлийн б хэмжигдэхүүн (PDI, IND, MAS, UAI, LTO, IVR)-ий ямар утга юуг илэрхийлж, юун тухай өгүүлнэ вэ гэдгийг шүүн тунгаах, бодож боловсруулах боломжийг уншигч, судлаач Танд үлдээж байна.

Дашрамд нь нэрт эрдэмтэн, сэтгэл зүйч Г.Хофстейд өөрийнхөө “Соёл ба байгууллагууд: Сэтгэлгээний уян чанар (Cultures and organizations: Software of the mind)” хэмээх бүтээлдээ соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнүүдийн утга санаа (түлхүүр ч гэж болно)-г гэр бүл, сургууль, ажлын байрны түвшинд, мөн улс төр, үзэл суртлын хүрээнд гэсэн ялгамжтайгаар тус бүрийг нь 10-15 үзүүлэлтээр тодорхойлсон байдгийг дурьдая.

PS: Соёлын үнэт зүйлийг судалж, хэмжих нь бодлого тодорхойлоход ч, байгууллагын менежментэд ч ач тустай байж болох юм. Иймд энэ судалгааг түүврийн зохистой хэмжээ, бүтэцтэйгээр үндэсний хэмжээнд явуулж, монгол үндэстний соёлын үнэт зүйлийн хэмжигдэхүүнийг нэг мөр тодорхойлох шинжлэх ухааны болон үйлдлэгийн хэрэгцээ шаардлага байгаа нь маргаангүй. Ийм судалгаагаар бид соёлын түрэмгийлэл (Cultural imperialism)-д өртөж байна уу, эсвэл бусдын соёлоос сурч байна уу гэдгийг, түүнчлэн манай соёлын үнэт зүйл цаг үетэйгээ нийцэж байна уу, эсвэл бид соёлын хоцрогдол (Cultural lag)-д оров уу гэдгийг тогтоож болох байх гэж бодогдоно. Судалгааг олны хүчээр,

чадварлаг баг бүрдүүлж хийж болно. Ийм чадавхи, эрдэмтэн, судлаачдын нөөц бий гэдэгт итгэж байна. “Миний ярьсан зүйл өөрсөдөд чинь таалагдсан гэж бүү хэл. Ирэх даваа гарагт юуг өөрөөр хийхээ л надад хэл” гэсэн алдарт Питер Ф.Дракерийн үгээр өндөрлөө.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. Х.Ариунаа, "Монголын үндэсний соёлын хэмжүүр", Менежер сэтгүүл, 05/2015, х. 57-62
2. С.Түвшинзаяа, Ц.Булган, Ц.Гэрэл, Б.Дэлгэрсайхан, Г.Нарантунгалаг, А.Одгэрэл "Үндэсний үнэт зүйлийн судалгаа", Менежер сэтгүүл. 12/2015, х. 8-12
3. А.Цанжид, "Монгол үндэсний соёл ба менежмент", Төрийн захиргаа сэтгүүл, 2015/04, х. 8-15
4. П.Саранчулуун, "Монгол, хятад хоёр улсын соёлын ялгааг Хофштэйдийн аргачлалаар харьцуулсан судалгаа", (Магистрийн судалгааны ажил), УА, 2015
5. Жорж, Кенворти, "Монгол улс дахь Олон улсын ТББ-уудын байгууллагын соёлын төлөвшил", Менежер сэтгүүл. 12/2015, х. 15-18
6. Д.Тунгалаг, "Соёлын эргэн тойронд: Үг, утга, ойлголт", Менежмент сэтгүүл, 2005/01/04/, х. 149-152
7. История мировой культуры. Культурология, М., 1998
8. Charles Raric, Gregory Winter and etc., "Mongolia: A Cultural Portrait using the Hofstede 5-D Model", Global Journal of Management and Business Research: A Administration and management. Volume 14, Issue 9, version 1.0, Year 2014.
9. Geert Hofstede and Michael Minkov, "VSM13", 2013
10. Geert Hofstede, "Cultures and Organizations: Software of the Mind", London, 1991
11. Jean Pierre MiahouakanaMatonda, "A Comparative study of five cross - cultural dimensions: Chinese", 2012
12. www.geerthofsdete.com

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС ТОДОРХОЙЛОХ НЬ

(Криптовалютын жишээн дээр)



Хууль зүйн доктор (Ph.D)
М.Түвшинжаргал

ТОВЧ УТГА :

Сүүлийн жилүүдэд цахим технологи хөгжихийн хэрээр түүнд тулгуурласан шинэ санхүүгийн бүтээгдэхүүнүүд нэвтрэх болсон билээ. Технологи дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг товчоор “Финтек” (Fin-financial; Tech-technology) гэж нэрлэх болсон¹. Финтекийн судлагдахууныг үндсэн 3 хэсэгт ангилаж болох юм. Үүнд: нэгдүгээрт: виртуал хөрөнгө (криптовалют), хоёрдугаарт: санхүүгийн бүтээгдэхүүнийг хүргэх технологийн шинэ загвар, гуравдугаарт: хиймэл оюун ухааны ашиглалт юм.

Виртуал хөрөнгийн нэг төрөл болох анхны криптовалютыг 2008 онд анх Сатоши Накамото нь блокчэйн технологи дээр тулгуурлан криптовалютыг үүсгэх кодлолыг бичсэн өгүүлэлээ цахим

сүлжээнд нийтэлснээр анх бий болсон гэж үздэг. Кодлолын тусламжтайгаар виртуал орчинд тодорхой удирдлагын (олборлогч) зүгээс үүсгэж болдог криптовалют нь биет физик шинжгүй виртуал хөрөнгө юм.

Криптовалют нь тодорхой нэг этгээд эсвэл тодорхой нэг эрх бүхий этгээдийн зүгээс удирдах боломжгүй бөгөөд блокчэйн технологи дээр тулгуурлан зөвхөн интернет сүлжээгээр дамжуулан тухайн хэрэглэгчийн зүгээс удирдах боломжтой юм.

Криптовалютыг төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагагүйгээр чөлөөтэйгээр бусдад арилжаалах эсвэл худалдан авах боломжтой бөгөөд дэлхийн зарим оронд төлбөр тооцооны болон хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгон ашиглаж байна.

Манай улсын хувьд харьцангуй шинэ гэж хэлэж болох виртуал хөрөнгийн зах зээл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж, төрийн зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ одоогоор байхгүй бөгөөд энэ талаар судалсан тодорхой бүтээлүүд хомс байна.

Энэхүү өгүүлэлийн зорилго нь виртуал хөрөнгийн нэг төрөл болох криптовалютыг тодорхойлох, эрх зүйн үүднээс зохицуулагдаж болох хувилбарыг олон улсын болон бусад орны туршлагаас харьцуулан судлах юм.

¹ Финтек гэдэг нь financial -санхүү, technology-технологийн (FinTech) буюу санхүүгийн технологи гэсэн үгний товчлолын нийлбэр юм. <https://www.investopedia.com/terms/f/fintech.asp> (сүүлийн хандалт 2021.05.10)

ТҮЛХҮҮР ҮГС: Виртуал хөрөнгө, Криптовалют, Блокчэйн технологи

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС ТОДОРХОЙЛОХ НЬ

(Криптовалютын жишээн дээр)

I. Оршил

II. Виртуал хөрөнгийн тухай ойлголт

- A. Виртуал хөрөнгийн төрөл
- Б. Криптовалютын үүсэл
- В. Криптологи
- Г. Блокчэйн технологи
- Д. Криптовалютын (биткойн) олборлолт:

III. Криптовалютын хэрэглээ ба тулгарч буй асуудал.

- A. Криптовалютын хэрэглээ
- Б. Криптовалют дээр тулгуурласан санхүүгийн үйлчилгээнүүд
- В. Криптовалютыг эрх зүйн хувьд тодорхойлход тулгарч буй асуудал
- Г. Криптовалютыг эрх зүйн үүднээс тодорхойлоход анхаарах асуудал

IV. Олон улсын туршлага

- A. Монгол улс дахь криптовалютын эрх зүйн орчин.

V. Дүгнэлт

I. Оршил

Виртуал хөрөнгийн нэг төрөл бол криптовалют (crypto-currency) юм. Криптовалютын хамгийн их танигдсан хэлбэр бол “Биткойн” (Bitcoin) болон Этериум сүлжээний (Ethereum) “Этер” (Ether) юм. Эдгээр криптовалют нь гарт баригдахгүй биет бус тоон байдлаар оршдог капитал буюу үнэт хөрөнгө юм¹. Биет байдлаар оршин байдаг алттай адил криптовалют нь виртуал орчинд тоон байдлаар оршин байдаг ба тусгай төхөөрөмж болон программ хангамжын тусламжтайгаар бий болгодог. Криптовалютыг цаасан мөнгө шиг үйлдвэрлэгч буюу хэвлэн гаргагч гэж байхгүй. Харин тэднийг тусгай төхөөрөмж, программ хангамжын тусламжтайгаар бий болгодог үйлдвэрлэгчид буюу олборлогчид (miner) байдаг².

Сүүлийн жилүүдэд биткойны загварчлал дээр тулгуурласан ижил төстэй олон төрлийн криптовалютууд бий болсон. Манай улсад ч мөн адил ижил төстэй криптовалютыг зах зээлд гаргасан. Криптовалютын төрөл нэмэгдэхний хэрээр криптовалютыг үйлдвэрлэлт (олборлолт-mining), эзэмшигчийн нэр дээр хадгалах электрон хэтэвчний

¹ Энгийн Ловие “Биткойн ба блокчэйний тухай үндсэн ойлголтууд (крипто-валют боёонд нь ажиллуулаж байгаа технологийн талаарх удиргал)” 2018 он., 14-тэл

² Өгүүдэлд дараахь үгүүдийг хэрэглэсэн болно. Үүнд: virtual currency-виртуал хөрөнгө; fiat money-фиат мөнгө (бодит монгол тэмдэгт); peer to peer (P2P network)- P2P сүлжээ нэгээс нөгөөд (нэг нэгээс нөгөө нэг); blockchain- блокчэйн (блок хэлхээ); hash- хэйн; crypto currency- криптовалют; cryptography-криптограф; alternative coin (altcoin)-бусад койн; miner-олборлогч; public key- олон нийтийн түлхүүр; private key-хувийн түлхүүр гэж тус тус орчуулан хэрэглэсэн болно.

(e-wallet) үйлчилгээ, криптовалютын зах зээлийн зөвөлгөө үзүүлэх зуучлагч санхүүгийн байгууллагууд, арилжаалах зорилго бүхий цахим бирж болон онлайн платформууд гэх бүхэл бүтэн виртуал хөрөнгийн шинэ зах зээл бий болсон.

Өгүүлэлийн эхний хэсэгт криптовалютын тухай ойлголт, блокчэйн технологи, криптовалютын давуу болон сул талыг тухай авч үзсэн. Хоёрдугаар хэсэгт криптовалтын онцлог шинжийг эрх зүйн үүднээс тодорхойлох ба бусад орны туршлагыг тус тус товч судласан болно.

II. Виртуал хөрөнгийн тухай ойлголт

ФАФТ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт ФАФТ-ын зөвлөмж хэсэг¹ виртуал хөрөнгө (virtual asset; virtual currency²) гэж цахим хэлбэрээр арилжаалах, шилжүүлэх боломжтой төлбөрийн болон хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох цахим үнийн дүн. Виртуал хөрөнгөд бодит мөнгөн тэмдэгт (fiat currency), үнэт цаас, бусад санхүүгийн хөрөнгийн цахим илэрхийлэлийг хамрахгүй байхаар тодорхойсон байна.

2012 онд Европын төв банк виртуал хөрөнгөтэй холбоотой анхны

¹ ФАФТ-ын "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт", 2012., 79 тал

² Европын төв банк болон ФАФТ-ын зүгээс "virtual currency" буюу виртуал валют гэх нэр томъёог хэрэглэж байсан ба 2019 оноос эхлэн ФАФТ-ын зүгээс бусад ойлголтуудтай төөрөгдөл үүсгэхгүйн тулд "virtual asset" буюу виртуал хөрөнгө гэх нэршлэлийг хэрэглэж эхэлсэн байна.

өргөн хүрээтэй судалгааг хийсэн ба уг судалгааны тайланд "виртуал хөрөнгө гэж тодорхой зохицуулалтгүй боловч үйлдвэрлэгчийн зүгээс үүсгэж мөн хянаж болох виртуал орчинд хүлээн зөвшөөрөгдөх дижитал мөнгө" гэж тодорхойлсон байна. Европын төв банк виртуал хөрөнгийн шинж чанарт чухал өөрчлөлт бий болсон тохиолдолд уг тодорхойлолт өөрчлөгдөж болохыг онцлон тэмдэглэжээ³.

2015 онд Европын төв банкнаас гаргасан хамгийн сүүлийн тайланд⁴ виртуал хөрөнгөд татвар ногдуулах, виртуал хөрөнгө эзэмшигчийн бүртгэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл олгох болон мөнгө угаах гэмт хэргийн хэрэгсэл болгон ашиглахаас урьдчилан сэргийлэх гэх мэт олон хүчин зүйл шинээр урган гарсан учир виртуал хөрөнгийг шинээр тодорхойлох болон ангилах хэрэгцээ шаардлага урган гарч байгааг тодотгосон.

Үүний дагуу "виртуал хөрөнгө гэдэг нь банк санхүүгийн байгууллага болон төв банкнаас хүлээн зөвшөөрөөгүй боловч виртуал орчинд оролцогч талууд харилцан хүлээн зөвшөөрсний дагуу мөнгө болгон ашиглаж болох дижитал үнэ цэнэ" гэж тодорхойлсон байна⁵.

³ European Central Bank: Virtual Currency Schemes, Germany; October, 11 (2012) <https://www.ecb.europa.eu/pub/pdf/other/virtualcurrencyschemes201210en.pdf>. (сүүлийн хандлаг 2021.05.25).

⁴ European Central Bank: Virtual Currency Schemes- a further analysis, 23 (2015). <https://www.ecb.europa.eu/pub/pdf/other/virtualcurrencyschemesen.pdf> Тус тайланд виртуал хөрөнгийг тодорхойлохдоо виртуал мөнгө буюу "money" гэсэн үгийг хэрэглэхээс татгалзах мөн зарим улс орнууд виртуал хөрөнгийг тодорхойлон хууль тогтоомжоор зохицуулах болсонтой холбоотойгоор "тодорхой зохицуулалтгүй" гэж бичсэн хэсгийг хассаж тодорхойлох нь зохимжтой гэж тусгажээ.

⁵ Virtual Currency Schemes- a further analysis, 23 (2015).

Виртуал хөрөнгийн нэг төрөл бол криптовалюта¹ (crypto-currency) юм. Криптовалютын хамгийн их танигдсан хэлбэр бол биткойн (bitcoin BTC)² болон бусад койнууд (altcoin)³ юм. Биткойн, бусад койн болон криптовалютыг бүгдийн тоон токен гэж нэрлэж болно⁴.

Токен (token) гэдэг нь криптовалютаар адил тоон хэлбэрээр илэрхийлэгдэж болдог тодорхой хөрөнгө, үнэ цэнийг илэрхийлэж болдог виртуал хөрөнгө юм. Токен нь криптовалютаас ялгагдах шинж нь виртуал орчинд маш олон төрлөөр ашиглах боломжтой ба үйлдвэрлэгч нь тодорхой байдаг ба гэрээ хэлэлцээр, алт, мөнгө хөрөнгө гэх мэт олон биет зүйлийг төлөөлүүлж ашиглаж болдог.

Холбогдох зарим эх сурвалжуудад криптовалютыг цахим мөнгө (electronic money; e-money) гэж тодорхойлсон байдаг. Үүний шалтгаан нь зарим улс орнууд криптовалютыг цахим мөнгөтэй адил төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглахыг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотойгоор хэрэглэгдэх болсон. Гэхдээ криптовалюта бол цахим мөнгө биш юм. Цахим мөнгө нь бодит мөнгөн хэмжээтэй ижил хэлбэрээр байх ба зөвхөн төлбөр төлөх, шилжүүлэг хийх зорилгоор ашиглагдах боломжтой цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа мөнгө юм.

¹ Крипто-нуун далд гэх утгыг нэрхнийлэн. Криптовалют (crypto currency) буюу нуун далд мөнгө гэж орчуулаж болох юм.

² Биткойн нь анхны криптовалюта бөгөөд түүний дараа олон төрлийн койнууд гарсан түүнийг алтернатив койн (alternative coin-altcoin) буюу бусад койн гэж нэрлэдэг.

³ Биткойноос бусад койнууд: Ether, Bitshares Ripple, Dash, Litecoin, Ardeon гэх мэт.

⁴ Virtual Currency Schemes, 28 (2012).

А. Виртуал хөрөнгийн төрөл:

Виртуал хөрөнгийг а) хаалттай виртуал хөрөнгийн нэгж б) нэг чиглэлт виртуал хөрөнгийн нэгж в) хоёр чиглэлт виртуал хөрөнгийн нэгж гэж 3 төрөлд ангилаж болно⁵.

Хаалттай виртуал хөрөнгө (closed virtual currency) гэж эдийн засагт бодитоор оршин байх боломжгүй зөвхөн виртуал хаалттай систем дотор зарцуулагдах боломжтой хөрөнгө юм. Энэ хөрөнгийг зөвхөн онлайн видео тоглоомд ашиглах боломжтой⁶.

Өөрөөр хэлбэл тухайн тоглоомын хэрэглэгч өөрийн нэр дээр бүртгэл үүсгэж тоглоомын явцад тодорхой нэгжийг (мөнгө) хожих боломжтой ба тухайн нэгжийг зөвхөн тоглоомд ашиглах юм. Жишээ нь: "World of Warcraft" гэх тоглоомыг тоглох явцад тоглогчид "wow gold" гэх виртуал хөрөнгийн нэгжийг цуглуулж болдог бөгөөд тоглох явцад тухайн хөрөнгийн нэгжээ зарцуулаж болдог.

Нэг чиглэлт виртуал хөрөнгийн нэгж (unidirectional flow) гэдэгт виртуал орчинд фиат мөнгөөр худалдаж авах боломжтой ба харин худалдаж авсан виртуал хөрөнгийн нэгжээ буцааж мөнгө болгох боломжгүй юм. Энэ ангилал дахь виртуал хөрөнгийн нэгжээр бодит бараа бүтээгдэхүүн үйлчилгээг худалдаж авч болдог. Жишээ нь: "Facebook Credits" юм.

Хоёр чиглэлт виртуал хөрөнгийн нэгж (bidirectional flow) гэж хэрэглэгч фиат мөнгөөр виртуал хөрөнгийн нэгж

⁵ Virtual Currency Schemes, 28 (2012).

⁶ Michael Strauss, A Comparison of Virtual of Currency Systems, 35 (2010).

худалдаж авч болох ба хүсвэл авсан виртуал хөрөнгийн нэгжээ буцааж худалдан фиат мөнгө болгох боломжтой виртуал хөрөнгийн нэгжүүд юм. Энэ ангилал дахь виртуал хөрөнгийн нэгжээр бодит бараа бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах бүрэн боломжтой юм. Жишээ нь: бүх төрлийн криптовалюта үүнд багтана.

Нэр томъёоны хувьд Европын төв банк, ФАТФ зэрэг олон улсын байгууллагуудын судалгаа, эрх зүйн баримт бичгүүдэд виртуал хөрөнгө гэсэн нэр томъёог хэрэглэхийг санал болгож байгаа хэдий ч биткойны нөлөөлөөр хөрөнгийн зах зээл дээр “криптовалют, крипто зах зээл” гэх нэр томъёог түлхүү хэрэглэж байна. Иймд тус өгүүлэлд криптовалюта гэх нэр томъёог голчлон хэрэглэсэн болно.

Б. Криптовалютын үүсэл

Анхны криптовалюта нь биткойн юм. Биткойн нь кодлолоор бичигдэн виртуал орчинд үүсдэг тодорхой бодит физик шинжгүй виртуал хөрөнгө гэж тодорхойлож болно. Биткойныг анх 2008.10.30-ний өдөр Сатоши Накамото (Satoshi Nakamoto) биткойнийг хөгжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн “Биткойн: Нэгээс нөгөөд электрон төлбөр тооцооны систем”¹ гэх судалгааны өгүүлэлээ цахим шуудангаар илгээж улмаар тус өгүүлэл нь интернэт орчинд түгснээр биткойныг анх олон нийтэд таниулсан гэж үздэг.

¹ Satoshi Nakamoto, Bitcoin: A Peer-to-peer Electronic Cash System https://www.uscc.gov/sites/default/files/pdf/training/annual-national-training-seminar/2018/Emerging_Tech_Bitcoin_Crypto.pdf (Сүүлийн хандлагт 2021.05.25).

Сатоши Накамото гэдэг нь хувь хүн эсвэл байгууллага эсвэл тодорхой бүлэг этгээд эсэх нь одоогоор тодорхойгүй бөгөөд яагаад жинхэнэ нэрээ нууцалсан нь сонирхол татдаг билээ. Сатоши Накамото гэх нэрний тайлбарыг зарим судлаачид “Sa-Samsung”; “Toshi-Toshiba”; “Naka-Nakamichi”; “Moto-Motorola” гэсэн томоохон технологийн компаниудын нэрний товчиллол гэж үздэг ба түүнийг цахим шуудангаар өгүүлэлээ илгээсэн анхны газар нь Япон улс болохыг тогтоосон байна². Сатоши Накамото нь 2010 онд өөрийн бүтээсэн биткойны системээсээ гарсан гэх ба гарах үедээ их хэмжээний биткойныг өөртөө авсан гэж үздэг.

Накамотогийн биткойныг танилцуулсан тус өгүүлэлийн гол агуулга нь гуравдагч этгээдийн зуучлалгүйгээр (банк, эрх бүхий байгууллага) хоёр тал чөлөөтэй мөнгийг шилжүүлэж болох боломжтой электрон төлбөр тооцооны шинэ системийг нийтэд санал болгосон юм. Энэ шинэ төлбөр тооцооны систем нь блокчэйн технологи дээр тулгуурлах юм.

В. Криптолож

Криптовалютыг тодорхойлохын тулд түүнийг бий болгодог орчин буюу криптовалютаг ашиглах үед хэрэглэгддэг технологүүдийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь чухал билээ.

Криптовалютыг удирдах эрх бүхий төрийн байгууллага эсвэл давуу эрхтэй өмчлөх хувь хүн, аж ахуй нэгж Аsuman Sönmez, Sanal Para Bitcoin. The Turkish Online Journal of Design, Art and Communication, 4 (3).. 2 (2014).

гэж байхгүй зөвхөн тусгай программ хангамжийн тусламжтайгаар кодоор тодорхойлогдсон дүрмийн дагуу үүсдэг бас устаж болдог.

Криптовалютын суурь зарчим нь криптологигоос (cryptology) үүсэлтэй юм. Криптологи гэдэг нь мэдээллийг (тоо, бичиг, мессеж) тодорхой системд зориулан кодлож аюулгүй байдлыг хамгийн дээд зэргээр хангасан байдлаар тодорхой хүнд зориулан илгээх тухай судалдаг кодлолын салбар юм¹.

Криптологи нь криптограф (cryptography)-мэдээллийг кодлох, кодлогдсон мэдээллийг тайлан унших болон криптанализ (cryptanalysis)-кодлогдсон мэдээллийг тайлан унших түлхүүрийг олох гэсэн хоёр төрлөөр хөгжиж ирсэн байдаг. Энэ аргыг дайны жилүүдэд тагнуулчид хэрэглэдэг байжээ².

Криптовалют нь аюулгүй байдлын үүднээс криптографик буюу математикийн кодлолыг ашигладаг байна³.

Криптографик нь өгөгдөл (дамжуулах мэдээлэл) нууцлал үүсгэх ба нууцлал нь өөрчлөгдөх боломжгүй байхаар үүсгэгддэг. Үүний дараа нууцлалыг түлхүүр ашиглана код болгон хувиргадаг. Зөвхөн кодыг тайлах түлхүүр эзэмшигч л мэдээллийг тайлах боломжтой юм.

Г. Блокчэйн технологи

Криптовалютын гүйлгээний шилжүүлэгт ашигладаг бүртгэлийн систем бол блокчэйн (blockchain)⁴ технологи юм. Блокчэйн нь криптовалютын дансанд нэвтрэх үйлдэл болон дансны гүйлгээний бүртгэлийг тэмдэглэн авдаг гүйлгээний мэдээллийн сан юм. Блокчэйн технологи нь 1991 онд бүтээгдсэн хэдий ч 2008 оноос эхлэн олон нийтэд танигдаж ирсэн биткойнтой хамт хэрэглээнд түгээмэл нэвтэрч эхэлсэн юм.

Блокчэйн технологи нь олон төрлөөр ашиглах боломжтой технологи ба зөвхөн биткойнд ашиглагддаг гэх нь хэт өрөөсгөл болох юм. Өөрөөр хэлбэл биткойн нь блокчэйн технологи дээр оршин байдаг криптовалют юм.

Блокчэйн технологи гэдэг нь блок хэсгүүд нь нэг нэгэнтэйгээ гинжин хэлхээ байдлаар холбогдон дамжуулалт үүсгэдэг мэдээллийн сан юм. Өөрөөр хэлбэл мэдээлэл нь блокчэйн системд байх блок руу бүртгэгддэг ба мэдээлэл тус бүр бүртгэгдсэн хугацааг бас давхар бүртгэдэг. Системд бүртгэгдсэн бүх үйлдэл кодлогдсон хэлбэрээр блок хэсэгт байршина. Блокууд тодорхой өгөгдсөн багтаамжтай ба блокын багтаамж дүүрсэн үед "Хэйш" (Hash) гэж нэрлэгдэх мэдээллээр багтаамж нь дүүрсэн блокыг илэрхийлсэн урт үргэлжилсэн тоо (тоо үсэг холилдсон) гарч ирдэг.

Хэйш бүр тухайн блокт нэвтрэх хурууны хээ гэж хэлж болно. Нэг блок дүүрсэн тохиолдолд дараагийн шинэ

¹ Bureu Aslantaş Ateş, Crypto Currencies, Bitcoin and Accounting, Cankiri Karatekin University Journal of Institute of Social Sciences, 7(1), 350 (2016).


² Bureu Aslantaş Ateş, 359.

³ Hanna Halaburda, Neil Gandal, Competition in the Cryptocurrency Market, Bank of Canada working paper, 33 (2014). <http://www.econstor.eu/bitstream/10419/103022/1/791932281.pdf>. (Сүүлийн хандлаг 2021.05.25).

⁴ Blockchain- блок хэлхээ гэж Монгол хэлний хөрвүүлж болно.

блок үүсдэг ба шинэ блок нь өмнөх блокын мэдээлэлтэй холбогдсоноор гинжин хэлхээ үүсдэг. Нэг блокийн мэдээлэлд хийсэн аливаа өөрчлөлт тухайн блокын хэйшийг өөрчилдөг ба улмаар хэлхээнд холбогдсон бусад блокын хэйшийг өөрчилхөд хүргэдэг. Энэ нь блокчэйн технологийн хамгийн чухал онцлог гэж хэлж болно. Блокт байгаа кодлогдсон бүх гүйлгээний мэдээллийг системд холбогдсон бүх хэрэглэгч харах боломжтой ба нэг блок үүсэх хугацаа ойролцоогоор 10 минут байдаг.

Блокчэйн нь нэг хэрэглэгчээс нөгөө хэрэглэгч (P2P network -peer to peer) нэг этгээдээс нөгөө этгээд гэсэн сүлжээний систем дээр тулгуурладаг. P2P сүлжээ нь хамгийн гол онцлог нь төв компьютер шаардлагагүйгээр өөрөө сүлжээний бүтэц дээрээ бүртгэл хийдэг. P2P сүлжээ нь хэрэглэгчидэд хэн нэгэн зуучлагч (банк) эсвэл тодорхой эрх бүхий этгээдээс (төрийн байгууллага) зөвшөөрөл авах шаардлагагүйгээр хоёр талаас чөлөөтэй гүйлгээ хийх боломжыг бүрдүүлдэг.



Дээрх зураг нь блочэйн технологи ашиглан шилжүүлэг хийх ерөнхий зураглал юм. Криптовалютыг виртуал

орчинд интернет сүлжээнд холбогдсон компьютер бусад төхөөрөмж ашиглан төлбөрийн хэрэгсэл болгохыг хүлээн зөвшөөрсөн хэнд ч хүссэн хэмжээгээрээ хаанаас ч шилжүүлэг хийж болно.

Криптовалютын шилжүүлэгийг хийхдээ хүлээн авагчийн өөрийн хаягыг шилжүүлэгч рүү илгээнэ. Шилжүүлэгч нь гүйлгээ хийх үед хувийн түлхүүрийг ашиглана шилжүүлэг хийнэ. Олон нийтийн түлхүүр нь криптовалютыг (биткойн) кодлоход харин хувийн түлхүүр нь кодлолыг тайлхад ашиглана.

Шилжүүлэг хийх үед системд холбогдсон бусад бүх хэрэглэгч гүйлгээний мэдээлэлийг мэдэх боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл системд хийгдсэн гүйлгээний бүх мэдээлэлийн хуулбар нь бусад хэрэглэгчдэд үлддэг гэсэн үг. Үүний гол шалтгаан нь нэг ашигласан криптовалютыг (биткойн) дахин ашиглахаас хамгаалах ба дахин ашиглах оролдлого хийх тохиолдолд бүх криптовалют эзэмшигчийн хуулбарласан мэдээллийг өөрчлөх шаардлагатай болох ба энэ нь үндсэндээ боломжгүй юм.

Гүйлгээг эцэслэн тоон гарын үсгээр (digital signature) баталгаажуулах ба хэн нэгэн этгээд хуурамчаар үйлдэх боломжгүй юм.

Криптовалютын арилжаанд шаардлагатай өөр нэг технологийн бүтэц бол электрон хэтэвч юм. Электрон хэтэвч (e-wallet) нь өөрийн нэр дээр биткойныг хадгалах, бусдад шилжүүлэх зорилгоор ашиглагддаг ба электрон хэтэвчийн хамт хэрэглэгчийн хувийн түлхүүр (private key) үүсдэг. Өөрөөр

хэлбэл электрон хэтэвч нь олон нийтийн болон хувийн түлхүүрийг багтаасан файл гэж хэлж болно. Хувийн түлхүүр нь криптовалютыг бусдад шилжүүлэх үед ашиглагдах ба хувийн түлхүүртэй хамт олон нийтийн түлхүүр (public key) үүснэ. Олон нийтийн түлхүүр дээр криптовалют (биткойн) байрладаг¹.

Электрон хэтэвч нь гар утас компьютер дээр суурилсан программ хэлбэрээр эсвэл цахим платформ дээр (blockchain, flexcoin, my wallet) ч байх боломжтой. Электрон хэтэвч нь хэрэглэгчийн хаяг гэсэн үг юм. Электрон хэтэвчийг интернэт цахим хаяг дээр эсвэл өөрийн компьютер, цаасан дээр ч хэвлэн хадгалах боломжтой юм. Электрон хэтэвчийг хамгийн сайн хадгалах хэлбэр нь цаасан дээр буулгах гэж үздэг².

Д. Криптовалютын (биткойн) олборлолт: Криптовалют цаасан мөнгө шиг үйлдвэрлэгч буюу хэвлэн гаргагч гэж байхгүй³. Харин тэднийг тусгай төхөөрөмж, программ хангамжын тусламжтайгаар бий болгодог. Үүнийг криптовалютын олборлолт (mining) гэж нэрлэдэг.

Криптовалютыг олборлоход компьютер болон олборлоход зориулагдсан төхөөрөмжүүдийн тусламжтайгаар олон төрлийн математикийн үйлдэл ашиглан олборлолт хийдэг ба олборлох үйл ажиллагааг хувь хүн эсвэл тодорхой байгууллага хийж болдог ба эдгээр

хүмүүсийг олборлогч (miner) гэж нэрлэдэг.

Олборлох үйл ажиллагаа нь бүх хүмүүст нээлттэй ердийн компьютерээр олборлох боломжгүй юм. Олборлох үйл ажиллагаанд өндөр хүчин чадал бүхий компьютерийн процессор (CPU), график карт (GPU) болон олборлолтын тусгай төхөөрөмж (Asic Miner) шаардлагатай ба олон цагийн турш, их хэмжээний цахилгаан эрчим хүч шаардагддаг.

Олборлогч нь үндсэндээ биткойны үйлдвэрлэгч гэж ойлгож болно. Олборлох үйл ажиллагааг хувь хүн дангаараа хийх нь маш хүнд тул хамтран олборлолтын сан (pool mining) буюу бүлэг үүсгэж хамтран олборлолт хийж болдог⁴.

Биткойн олборлолтын хэмжээ тодорхой хязгаартай ба нийт 21 сая ширхэг биткойн олборлох боломжтой юм. Энэ тоон дэлхий дээр байж болох нийт биткойны тоо юм. Өөрөөр хэлбэл 21 саяд хүрснээрээ биткойны олборлолт дуусах ба энэ хугацааг ойролцоогоор 2140 он гэсэн урьдчилсан таамаглал дэвшүүлдэг⁵.

Товч дүгнэвэл криптовалют нь технологи дээр суурилсан шинэ бүтээгдэхүүн бөгөөд хэрэглэхэд шаардлагатай өөрийн технологийн дэд бүтцийг шаардаж байдаг виртуал хөрөнгө юм. Криптовалют нь уламжлалт мөнгөнөөс ялгаатай шинжийг товч тодорхойлвол.

¹ Yaşar Gültekin, Yetkin Bulut, Bitcoin Economy: Emerging new sectors of bitcoin eco-system and its analysis, 45 (2016).

² Gültekin, Bulut, 48 (2016).

³ Nakamoto, 3.

⁴ Bikramaditya Singhal, Gautam Dhameja, Priyansu Sekhar Panda, Beginning Blockchain., 34 (2018).

⁵ <https://www.investopedia.com/tech/what-happens-bitcoin-after-21-million-mined/#:~:text=The%20reward%20will%20continue%20to,changed%20between%20now%20and%20then>.

- Криптовалют нь эрх бүхий байгууллагын оролцоогоогүйгээр P2P сүлжээг ашигладаг.
- Криптовалют нь бүхэлдээ дижитал шинжтэй.
- Криптовалют нь технологи дээр суурилсан нарийн түвэгтэй ойлголт.
- Криптовалютыг ашиглах хэлбэр хязгаартай (мөнгөтэй адил биш).
- Криптовалют нь тооны хувьд хязгаартай (жишээ нь: биткойн 21 сая ширхэг).
- Криптовалютыг даатгах боломжгүй. (100% баталгаатай биш).

III. Криптовалютын хэрэглээ ба тулгарч буй асуудал.

А. Криптовалютын хэрэглээ

Криптовалютыг худалдан авах, хадгалах, бусдад арилжаалаж болно. Тухайлбал хэрэглэгч криптовалтыг бусдад арилжаалах боломжтой ба үүний хариуд шилжүүлсэн криптовалютын үнэд тэнцэх мөнгө эсвэл тодорхой үйлчилгээ, бүтээгдэхүүнийг авч болно. Энэ зарчмаар криптовалтыг төлбөр тооцооны хэрэгсэл болгож ашиглаж болно.

Криптовалютыг мөнгөтэй адил төлбөр тооцооны албан ёсны хэрэгсэл болгон ашиглахыг зарим орнууд хүлээн зөвшөөрөөгүй ч ялангуяа биткойныг төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах хэрэгцээ улам нэмэгдэж байна. Тухайлбал Япон, Ирланд, Канад, Турк гэх мэт орнуудад биткойноор үйлчилдэг АТМ хүртэл ажиллаж байна.

Криптовалютын зах зээл хөгжихийн

хэрээр түүнийг арилжаалдаг биржүүд бий болсон. Онлайн цахим биржээс биткойн болон бусад койнуудыг зах зээлийн үнэ унасан үед худалдан авч үнэ нэмэгдэх үед буцаан зарж өгөөж хүртэх буюу хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгон түгээмэл ашиглаж байна.

Б. Криптовалют дээр тулгуурласан санхүүгийн үйлчилгээнүүд

Криптовалютыг төлбөр тооцоо, хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгон түгээмэл ашиглах болсонтой холбоотойгоор криптовалютын зах зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, криптовалютын үйлчилгээний төрлүүд бий болсон байна.

Дэлхийн зарим улс орнуудад криптовалют дээр тулгуурласан олон төрлийн санхүүгийн үйл ажиллагаануудыг явуулж байна. Үүнд:

1. Криптовалютын арилжааны (trading) үйлчилгээ. Онлайн цахим платформыг ашиглан криптовалютыг шилжүүлэх, арилжаалах үйлчилгээ болон арилжааны зориулалтаар шинээр криптовалют гаргах үйлчилгээ тус тус багтана.
2. Криптовалютын зах зээл дээр койнг анх удаа олон нийтэд санал болгох (Initial coin offering- ICO)
3. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ. Криптовалютыг худалдан авах, криптовалютэд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ.
4. Криптовалютын биржийн үйл ажиллагаа (exchange platform). Виртуал хөрөнгийг хооронд нь болон албан ёсны мөнгөн

тэмдэгтэд арилжих зарчмын хүрээнд худалдан авагч болон худалдагчийн хооронд урьдчилан тохирсон үнийн дагуу арилжаанд зуучлагчийн үйлчилгээ¹ гэх зэрэг багтаж байна.

ФАФТ-аас гаргасан зөвлөмжид “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага; криптовалютыг албан ёсны мөнгөн дэвсгэртэд хөрвүүлэх, олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих, виртуал хөрөнгийн шилжүүлэг гүйцэтгэх, криптовалютын электрон хэтэвч үүсгэх, хадгалах үйлчилгээ гэх мэт олон төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж тодорхойлсон байна².

Манай улсын хувьд ч дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүд криптовалютыг хөрөнгө оруулалтын хэрэгслээр сонирхож эхэлсэн бөгөөд сошиал сувгаар дамжуулан зохицуулалтгүйгээр өөр хоорондоо арилжаалах болон гадаадын биржүүдэд бүртгүүлэн арилжаанд оролцож байна. Дотоодын криптовалютын зах зээлд 2021 оны байдлаар 3 бирж, зуучлалын үйлчилгээ үзүүлж буй 20 гаруй иргэд, аж ахуй нэгж байна гэсэн албан бус тоон мэдээлэл байна.

Дотоодын биржүүдийн хувьд trade.mn биржийн платформ 2017 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 70 гаруй мянган хэрэглэгчидтэй 200 гаруй тэрбум төгрөгийн арилжаа хийсэн дүн мэдээ байна³. Мөн криптовалтын арилжааны үйл ажиллагаа явуулдаг

Дакс (dax.mn) болон БитМонэкс (bitmonex.mn) зэрэг платформууд үйл ажиллагаа явуулж байна.

Криптовалтын зуучлалын хувьд Ард санхүүгийн нэгдэл компани өөрийн хөгжүүлж буй ард апплекэйшнээрээ дамжуулан охин компаниудын хувьцаагаа токенжуулан криптовалют худалдах, худалдан авах үйлчилгээ үзүүлж байна. Одоогоор манай улсад харъяалагдах АрдКойн (Ardx) нь анхны ганц криптовалют бөгөөд Ethereum сүлжээний платформ дээр 2019 оны 1 сард бүртгэгдсэн. АрдКойн нь Ард санхүүгийн нэгдэл болон түүний охин компаниудын үйл ажиллагаанд ашиглагдах урамшууллын онооны зориулалтаар ашиглагдаж байна⁴.

Эндээс үзэхэд Монгол улсад криптовалютыг сонгон хөрөнгө оруулалт хийх хэрэглэгч мөн энэ чиглэлээр санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг иргэд, аж ахуй нэгжүүд хэдий бий болсон байна. Гэвч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын хүрээнд криптовалют болон криптовалют дээр тулгуурласан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

В. Криптовалютыг эрх зүйн хувьд тодорхойлход тулгарч буй асуудал

2013 оноос эхлэн криптовалют болон биткойны зах зээл мэдэгдэхүйц түвшинд өссөнөөрөө олны анхаарлын төвд орсон. Одоогийн байдлаар криптовалютыг дэлхийн улс орнууд бүрэн хүлээн зөвшөөрөөгүй боловч

¹ Монгол банк, Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, 21 тал.

² Зөвлөмж 75 (2012).

³ Монгол банк, 3 тал.

⁴ <https://trade.mn/news/show/810> (сүүлийн хандалт 2021.02.01).

ирээдүйд дэлхийн хөрөнгийн зах зээлийн нэг хэсэг болно гэдэг нь тодорхой байна. Криптовалютыг эрх зүйн хувьд тодорхойлон хүлээн зөвшөөрч хуульчлах нь улс орнуудын хувьд нарийн төвөгтэй асуудлын нэгд орж байна. Нөгөө талаар эдийн засагт байр сууриа олон хөгжиж буй энэ салбарыг хүлээн зөвшөөрч зохицуулахаас татгалзан шууд хориглох нь түүний эдийн засгийн үр өгөөжийг ашиглах боломжыг алдах юм.

Криптовалют нь технологийн хувьд шинэ, түргэн, шуурхай, зуучлагчын хэрэгцээ шаардлагагүй гэх мэт олон давуу талыг бий болгодог ч түүнийг эдийн засаг, эрх зүйн үүднээс тодорхойлон хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрхөд хэд хэдэн бэрхшээлтэй асуудлууд хөндөгддөг.

Туйлбал криптовалют нь баталгаатай хэрэгсэл мөн эсэх; хандах төв удирдлага байхгүй байгаа нөхцөл байдал; мөнгө угаах хамгийн тохиромжтой хэрэгсэл болох; татвар ногдуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээл; төрийн байгууллагын зүгээс зохицуулалт хийхэд технологийн дэд бүтцийн дутмаг байгаа байдал зэрэг асуудалуудыг дурьдаж болно. Дээрх тулгарч буй хүндрэлтэй асуудлыг товч дурьдвал.

Баталгаатай байх: Криптовалют нь өмнө түгээмэл хэрэглэгдэж байгаагүй технологи болох блокчэйн дээр суурилсан нь технологийн дэд бүтэц дутмаг зарим улс орнуудын хувьд зохицуулалт хийхэд хүндрэлтэй тулгарч байна. Иймд дээрх улс орнууд криптовалютыг хангалттай баталгаатай биш гэдгийг тодотгон олон нийтэд

анхааруулгын шинжтэй мэдэгдэл гаргах түгээмэл байна.

Нөгөө талаараа криптовалют нь ялангуяа биткойныг ашиглах анхны зорилго бол төлбөр тооцооны хэрэгсэл болгох байсан гэвч үндсэн зорилгоосоо өөрөөр буюу хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болгон ашиглах болсон. Мөн криптовалют нь уламжлалт мөнгөний шинжийг агуулаагүй, төрийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрч хуульчлаагүй учир үнэ цэнэ нь тогтвортой байх нь эргэлзээтэй байна.

Зарим судлаачид биткойны үний өсөлт ажиглагдаж байгаа үе бол бодит бус зүгээр зах зээлийн хөөсрөл гэж тодотгоод биткойны ханшын өсөлт уналтанд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь түүний технологи биш харин биткойныг ихэнхи хувийг эзэмшдэг цөөн тооны бүлэг хүмүүсийн өгөөж хүртэх хүлээлт мөн тэдний олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдэх мэдээлэл дээр тулгуурладаг нь харагдаж байна гэж онцолсон байна. Үүний хамгийн том нотолгоо бол 2017 оны 12 сарын 08-ны өдөр 19 мянган долларын ханштай байсан биткойн “70 сая долларын үнэ бүхий 4.700 ширхэг биткойн хулгайлагдсан гэх” мэдээ нийтлэгдсэнээс хойш гучин минутын дотор 15 мянган доллар болтлоо ханш нь унасан үйлдэл гэж тодотгосон байдаг¹.

Энэ үүднээс криптовалют тэр дундаа биткойн нь баталгаатай тогтвортой үнэ цэнэтэй байж чадан гэдэг нь эргэлзээтэй юм. Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валютууд олон улсад

¹ İnci Parlaktuna, Bitcoin'in tanıtılma sorunu, Muhasebe ve Finansman Dergisi (86), 34 (2019).

хүлээн зөвшөөрөгдсөн баталгаатай төлбөрийн хэрэгсэл бол криптовалютыг баталгаажуулаж буй тодорхой үнэ цэнэ бүхий зүйл одоогоор байхгүй байна.

Криптовалют нь хамгийн аюулгүй буюу блокчэйн технологи дээр тулгуурладаг гэж үздэг хэдий ч олон аргаар биткойн нь кибер халдлагад өртсөөр байна. Жил бүр дунджаар 2 эсвэл 3 удаа биткойн хулгайлах оролдлогууд амжилттай болж байгаа нь аюулгүй байдлын хувьд баталгаатай биш гэдгийг харуулж байна. Тухайлбал хамгийн том кибер халдлагын нэгд тооцогдсон биткойны онлайн биржийн үйл ажиллагаа эрхэлдэг Mt.Gox компани кибер халдлагад өртсөн явдал юм¹. Энэ үйл явдлын дараа мянган долларын ханштай байсан биткойны үнэ гурван зуун доллар хүртэл унасан тохиолдол байдаг.

Иймд криптовалюта нь ханшын тогтвортой байдал болон кибер аюулгүй байдлын хувьд хангалттай баталгаатай биш байгаа явдал нь улс орнуудын хувьд криптовалютыг албан ёсоор төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах шийдвэр гаргахад эргэлзээ төрүүлж байгаа юм.

Одоогоор дэлхийн ихэнхи улс орнуудад криптовалюта, блокчэйн технологийг зохицуулсан хууль тогтоомж байхгүй байгаа мөн зарим улс орнуудад хориглох хүртэл шийдвэр гаргасан нь криптовалютыг эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэж дүгнэхэд хүргэж байна.

Хандах төв удирдлага байхгүй:

Иргэн, хуулийн этгээдийн аливаа хууль зөрчсөн үйлдэлтэйн холбогдуулан торгох, үйл ажиллагааг нь зогсоох гэх мэт хууль зүйн хариуцлага хүлээлгэж болдог. Харин криптовалютын үндсэн шинж нь түүнийг хариуцах тодорхой нэг субъект эсвэл төв удирдлага гэж байдаггүй нөгөөтэйгүүр криптовалюта эзэмшигчийн хувийн мэдээлэл нууцлалтай байдаг. Энэ үүднээс хууль зүйн хариуцлагад татах албан ёсны төв байгууллага, тодорхой субъектыг тогтоох нь хүндрэлтэй асуудалд тооцогдож байна. Одоогоор дэлхийн улс орнуудад криптовалютын арилжааны үйл ажиллагаанд санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг бүртгэх, зөвшөөрөл олгох, хяналт тавих байдлаар л ажиллаж байна.

Мөн криптовалютын арилжаа хийх боломжтой олон төрлийн онлайн платформууд үйл ажиллагаа явуулдаг. Банкид хэрэглэгч харилцах данс нээлгэн дансны дугаараараа дамжуулан шилжүүлэг хийж болдог бол криптовалютын системд электрон хэтэвч энэ үүргийг гүйцэтгэдэг. Банкны данс хооронд алдаатай гүйлгээ хийсэн тохиолдолд банканд мэдэгдэж засах эсвэл гүйлгээг цуцлах боломжтой байдаг. Харин криптовалютын арилжаа, гүйлгээ хийх үед шилжүүлэх дүнг буруу бичих, цифрyг алдаатай бичих гэх мэт хувь хүнээс шалтгаалсан алдаа гаргасан тохиолдолд засах эсвэл хандах тодорхой субъект байхгүй юм.

Криптовалютын дотоод сүлжээ хамгийн аюулгүй гэж үздэг хэдий ч зарим тохиолдолд дотоод сүлжээн дээр алдаа

¹ <https://uzmancoin.com/secden-uyari-bitcoin-vadeli-islmlerine-dikkat-edim/> (сүүлийн хандалт 2021.02.15).

гарсан тохиолдол байна. Тухайлбал биткойн ердөө 21 сая ширхэгийг олборлох боломжтой хэдий ч 2010 онд биткойны систем дэх кодлолын алдааны улмаас 184 сая ширхэг хуурамч биткойн автоматаар системд үүссэн байна. Үүний дараа биткойны суурь зарчмыг үүсгэсэн Сатоши Накамотогийн зүгээс богино хугацаанд зассан гэж үздэг¹. Гэхдээ энэ мэдээлэл нотлогдоогүй.

Хариуцах төв удирдлага, тодорхой субъект байхгүй байгаа нь ялангуяа нэг өдөр биткойны олборлолтыг зогсоох эсвэл системийг хаасан тохиолдолд хэн ч хариуцлага хүлээх боломжгүй юм. Дээрх үндсэлэлээр хариуцах эсвэл хандах тодорхой субъект байхгүй байгаа нь криптовалютыг хүлээн зөвшөөрч, эрх зүйн хувьд тодорхойлоход хүндрэл учруулж буй хүчин зүйлийн нэг юм.

Мөнгө угаах арга хэрэгсэл болох: Криптовалютын хамгийн онцлог шинж нь хэрэглэгчийн хувийн мэдээлэл шаардлагагүйгээр хүссэн этгээд рүү шилжүүлэг хийж болдог. Криптовалютаар шилжүүлэг хийх үед банкаар дамжуулах эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлага байдаггүй. Энэ онцлог шинж нь криптовалютыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ашиглаж болох хамгийн тохиромжтой хэрэгсэл болгосон гэж хэлж болно. Учир нь блокчэйн технологи дээр шилжүүлэг хийж буй виртуал хаягыг тогтоох боломжтой ч шилжүүлэг хийгч, хүлээн авагчыг хэн болохыг тогтоох боломж бага байдаг².

Криптовалютын зах зээлийн өсөхийн хэрээр энэ төрлийн хууль бус үйл ажиллагааны арга хэрэгсэл болох магадлал улам нэмэгдэж юм. "Economist" сэтгүүл дээр нийтлэгдсэн өгүүлэлд "биткойны зах зээл дээрх үнэ яагаад ийм өндөр байгаагын хамгийн том шалтгаан бол түүнийг мөнгө угаах арга хэрэгсэл болгон ашиглах сонирхолтой бүлэг хүмүүс байдаг" гэж тодотгосон байдаг³. Жишээ нь биткойны арилжааны 82 хувийг гүйцэтгэж байсан арилжааны онлайн цахим платформ болох Silkroad (marketplace) цахим хуудсыг АНУ-ын холбооны мөрдөх газраас (FBI) хаасан үйл явдал юм. Тус платформ мансууруулах бодисын худалдаа, захиалгат аллага гэх мэт хэд хэдэн гэмт хэрэгтэй нэр холбогдсон юм. Тус платформ нь 2011-2013 оны хооронд хууль бус үйл ажиллагаанаас 9.5 сая ширхэг 1.2 тэрбум долларын үнэлгээ бүхий биткойныг ашигласан нь тогтоогдсон. Silkroad платформын захирал гэхэд л зөвхөн биткойны арилжааны зуучлалын үйлчилгээгээр гэхэд 80 сая долларын ашиг олсон байна⁴.

Татвар: Аливаа улсын татварын системийн дагуу аливаа орлогоос хувь хүн хуулийн этгээдэд орлогын албан татвар ногдуулдаг. Харин ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээд эцсийн зорилго бол зардлыг хамгийн бага ашгийг хамгийн өндөр байлгах хүсэлтэй байдаг. Энэ ч үүднээс зарим тохиолдолд татвар

¹ Para Aklanması Bakımından Durumu, *GiSi Dergisi*, 89 (2015).

² Parlaktuna, 36 (2019).

³ [https://en.wikipedia.org/wiki/Silk_Road_\(marketplace\)](https://en.wikipedia.org/wiki/Silk_Road_(marketplace))

¹ Parlaktuna, 36 (2019).

² Sarıkatiipoğlu, M.A., Çapkın T.A., Karalioglu, F. Bitcoin: Bir Sanal Para Birimi Olarak Regülasyonu ve Kara

төлөхөөс зайлсхийх эсвэл татварын орлогоо нуун дарагдуулах үйлдэл гаргах түгээмэл байдаг.

Аливаа орлогод татвар ногдуулахын тулд хамгийн нэгдүгээрт татвар төлөх субъект нь тодорхой байх ёстой, хоёрдугаарт орлого нь татварын хууль тогтоомжийн хүрээнд татвар ногдуулах орлого байх ёстой. Криптовалют нь дээрх шалгуурын гадна үлдэх боломжтой юм. Тийм ч учраас биткойныг үүсгэх болсон гол шалтгааны нэг нь эзэмшигч субъектыг нь тодорхойлох боломжгүй байлгаснаар татварын төлөхөөс зайлсхийх, орлогоо нуун дарагдуулахыг хүссэн этгээдүүдэд зориулагдсан гэж үздэг¹.

Криптовалютын арилжаанаас олсон орлогыг олж тогтоон татвар ногдуулах нь технологийн нарийн мэдлэг шаардсан ажил учир зарим улс орнууд криптовалютыг татварын эрх зүйн үүднээс зохицуулалтгүй орхих нь түгээмэл байна.

Нөгөөтэйгүүр криптовалютыг төлбөрийн хэрэгсэл болгон хүлээн зөвшөөрч хуулийн хүрээнд татвар ногдуулах орлогод хамааруулах нь чухал боловч төрийн эрх бүхий байгууллагаас криптовалютын харилцааг зохицуулах, хянаж чадах технологийн дэд бүтэц, хүний нөөцийн чадамж зарим орнуудад хангалттай бус байгаа явдал нь криптовалютыг албан ёсоор хүлээн зөвшөөрч эрх зүйн зохицуулалт хийхэд тулгарч буй хамгийн том бэрхшээлүүдийн нэг болож байна.

Г. Криптовалютыг эрх зүйн үүднээс тодорхойлоход анхаарах асуудал

Криптовалютын зах зээл хөгжихийн хэрээр түүнийг хүлээн зөвшөөрөх, хууль зүйн хувьд тодорхойлон хуульчлах шаардлага урган гарч байна. Криптовалютын онцлог шинж, түүний шинэ технологитой холбоотойгоор татвар, хөрөнгө оруулалт, төлбөр тооцоо, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зэрэг олон салбартай холбогдох болсон.

Криптовалютыг хууль зүйн хувьд тодорхойлохдоо татвар ногдуулах, нягтлан бодох бүртгэлийн үүднээс бүртгэх боломжтой байх үүднээс тодорхойлох нь илүү үр дүнтэй юм. Криптовалютыг тодорхойлохдоо хамгийн түрүүнд криптовалют нь мөнгө эсвэл эд хөрөнгийн аль болохыг эсвэл ямар шинжтэй болохыг нарийвчлан тодорхойлох нь чухал юм.

Криптовалютыг тодорхойлж байгаа дэлхийн улс орнуудын чиг хандлагаас хархад дараах 3 байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

а) Хувьцаатай адил хөрөнгө оруулалтын хэрэгсэл

Криптовалют нь хөрөнгийн зах зээл дээр эрэлттэй бүтээгдэхүүн тулд компанийн хувьцаатай адил чөлөөтэй арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн байж болно.

б) Доллартай адил дижитал орчинд ашиглах мөнгө

Криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь "цахим мөнгө" гэж тодорхойлох

¹ Marian, O. Is Cryptographic Currency An Outstanding Tax Heaven?, 28 (2016).

боломжтой.

в) Алттай адил үнэт зүйл бүхий хөрөнгө (өмч).

Биткойны олборлолт буюу байж болох нийт хэмжээ 21 сая ширхэг байдаг. Үүнтэй адил бусад криптовалютууд ч гэсэн тодорхой тооны хязгаартай. Тиймдээ ч хүссэн хэн ч худалдан авах, хадгалах боломжтой тул үнэт зүйл бүхий “цахим хөрөнгө” гэж үзэж болно.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд криптовалютыг ямар шинжээр нь тодорхойлох нь тухайн улс орны эрх зүйн онцлог, хөгжлийн түвшинтэй шууд холбоотой юм. Криптовалютыг тодорхойлохдоо хэд хэдэн шалгуурыг харгалзан үзэх нь зохимжтой. Үүнд:

а) Зохицуулагч байгууллагын харъяалал: Криптовалютыг хөрөнгө гэж тодорхойлсон тохиолдолд тухайн орны санхүүгийн зохицуулах төв байгууллагын зүгээс хянах боломж бүрдэнэ. Харин мөнгө гэж тодорхойлсон тохиолдолд тухайн улсын төв банкны зүгээс хянах боломжтой юм.

б) Татвар: Криптовалютыг хөрөнгө оруулалтын хэрэгсэл (эсвэл хөрөнгө) гэж тодорхойлсон тохиолдолд орлогын татвар оногдуулах боломж бүрдэнэ. Харин мөнгө гэж тодорхойлсон тохиолдолд шилжүүлэг гүйлгээнээс шимтгэл хураамж авч болох ба гадаад валютад үйлчилдэг дүрэм журам давхар үйлчлэх байдлаар зохицуулах боломжтой юм.

в) Өмч: Криптовалют нь хөрөнгө гэж үзвэл өмчийн эрх зүйн үүднээс өмчлөх эрх, өвлөлийн харилцаа үүснэ. Иймд өмчлөлтэй холбоотойгоор

холбогдох хууль тогтоомж үйлчлэх хэлбэрээр зохицуулалт хийх боломжтой.

г) Нягтлан бодох бүртгэл: Нягтлан бодох бүртгэлийн үүрэг бол орлого зарлагын баримт бичгийг шаардлагын дагуу бүртгэж дотоод оролцогчид болон хөндлөнгийн этгээдүүдэд үнэн зөв мэдээллийг өгөх юм. Иймд криптовалютаар холбоотой гүйлгээний мэдээллийг нягтлах бодох бүртгэлд ямар байдлаар бүртгэх нь түүнийг юуг гэж тодорхойлсоноос шууд хамаарна.

IV. Олон улсын туршлага

Дээр дурьдсан нөхцөл байдлаас үүдэн улс орнууд криптовалютыг тодорхойлохдоо дараах үндсэн хандлагад тулгуурлаж байна. i) Эрсдэлтэй гэж үзэн шууд хориглох хандлага, ii) эрх зүйн хувьд зохицуулалт хийлгүй хүлээх хандлага буюу сэйндбокс (sandbox) орчин бүрдүүлэх¹ хандлага, iii) эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрч хөхүүлэн дэмжих хандлагыг тус тус баримталж байна. Харин криптовалютыг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрч байгаа улс орнууд татварын хууль болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, эсвэл аль аль хуулийн үйлчлэх хүрээнд багтаан зохицуулсан байдалтай байна.

Европын холбоо: Криптовалютад татвар ногдуулах зорилгоор Европын холбооны шүүхийн (CURIA) 2015 оны 10 сарын 22-ний өдрийн C-264/14 тоот шийдвэрт биткойн нь эд хөрөнгө биш виртуал мөнгө бөгөөд криптовалютыг

¹ Зөвшөөрөл олгохоос өмнө хууль, журмын дагуу хэрэгжүүлэх гэж буй шинэ инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээг төстээр турших үйл явц.

арилжаалах тохиолдолд нэмэгдсэн өртөгийн татвар авах ёстой гэсэн байна¹.

2018 оны 2 сарын 12-ны өдөр Европын холбооны санхүүгийн комиссоос криптовалютыг албан ёсоор хуулиар хүлээн зөвшөөрч зохицуулаагүй тул аливаа үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, үүсэж болзошгүй эрсдэлээс зохицуулах боломжгүй гэдгийг албан ёсоор мэдэгдсэн. Европын холбооны банкны хорооноос (EBA) криптовалютаас үүсэж болзошгүй эрсдлийг зохицуулахын тулд биеэ даасан хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлага байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Швейцарь: 2013 онд биткойн болон криптовалютын эерэг талыг санхүүгийн салбарт ашиглах зорилгоор албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Үүний дагуу криптовалютыг мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх тухай хуулийн үйлчлэх хүрээнд багтаан нэмэгдсэн өртгийн татварын хуулиар хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний ангилалд оруулан татвар ногдуулахаар зохицуулсан байна². Криптовалютыг хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн мөнгө гэж үзэн төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглахыг зөвшөөрөн байна. Хотын нийтийн тээврийн үйлчилгээ болон бусад газруудад төлбөр тооцоог криптовалютаар хийхийг зөвшөөрсөн байна.

Австрали: Криптовалютыг хэрэглэх, олборлох үйл ажиллагааг хууль зүйн

¹ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:62014CJ0264&from=EN> (сүүлийн хандлаг 2021.03.20).

² Burçin Bozdoğanoglu, Virtual currency bitcoin's effects to informal economy, money, laundering process and it's taxation, *Journal of Fiscal Law*, (2014).

хувьд хүлээн зөвшөөрсөн орнуудын нэг юм. Австралийн татварын төв байгууллагаас биткойныг мөнгө буюу гадаад валют биш бөгөөд, ханшны өөрчлөлтөөр ашиг хүртэх боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэж тодорхойлсон байна.

2018 онд тус улс нь криптовалютыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн үйлчлэх хүрээнд багтаах зорилгоор хуулийн төсөл боловсруулан батлуулсан³. Австрали улсын татварын байгууллагаас криптовалютын эрсдэл, аюулгүй байдалтай холбогдуулан удаа дараа мэдэгдэл хийх, криптовалютыг ашиглах заавар, зөвлөмжийг боловсруулан ажилласан ба криптовалютад татвар ногдуулахд мөрдөх журмыг гарган мөрдүүлж байна⁴.

Канад: Криптовалютыг интернет худалдаанд бүтээгдэхүүн үйлчилгээг авхад цахим мөнгө болгон ашиглах цахим бирж дээр арилжаалах хэлбэрээр ашиглах боломжтой гэж үзсэн. Үүний дагуу татварын байгууллагаас бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлд багтаасан ба бараа үйлчилгээг худалдан борлуулхад үйлчилдэг татварын журам нэгэн адил үйлчилэхээр зохицуулсан байна⁵. Тус улсын санхүүгийн зохицуулах төв байгууллагаас биткойн болон

³ Digital Currency Exchange Providers, (2018) <http://www.austrac.gov.au/digital-currency-exchange-providers> (сүүлийн хандлаг: 07.11.2020)

⁴ Australian Taxation Office (ATO), 'Tax Treatment of Crypto-Currencies in Australia – Specifically Bitcoin', 2017 <https://www.ato.gov.au/general/gen-tax-treatment-of-crypto-currencies-in-australia---specifically-bitcoin/> (сүүлийн хандлаг: 11.03.2019)

⁵ <https://www.cbc.ca/news/canada/toronto/bitcoin-richmond-hill-property-tax-comberrry-1.5220107>

криптовалютыг солилцооны эд хөрөнгө гэж тодорхойлсон ба албан ёсны төлбөр тооцооны хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөөгүй байна¹.

Америк: Тус улсын сангийн яамны (USDT) албан ёсны тайлбарт криптовалютыг хөрөнгийн зах зээл дээр арилжаалах боломжтой төв удирдлага байхгүй виртуал хөрөнгө гэж тодорхойлсон. Үнэт цаас биржийн хорооноос (SEC) гаргасан тайлбарт эд хөрөнгийн нэгэн төрөл гэж тодорхойлсон байна².

АНУ-ын татварын төв байгууллагаас (IRS) биткойныг мөнгө биш харин эд хөрөнгө гэж тодорхойлож татвар ногдуулах ёстой гэж тайлбарласан байна. АНУ-д криптовалютыг муж улс бүр өөрөөр тодорхойлон ойлгох хандлага ажиглагдаж байна.

Япон: Тус улс нь криптовалютыг мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагааны эсрэг хууль болон виртуал валютыг зохицуулах тухай хуулийн хүрээнд зохицуулаж байна. Криптовалютыг албан ёсны төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж болохыг хүлээн зөвшөөрсөн ба криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл гэхээсээ илүү эд хөрөнгө гэж тодорхойлсон байна³.

Герман: Тус улсын санхүүгийн үйлчилгээг зохицуулах байгууллагаас криптовалютыг санхүүгийн хэрэгсэл

гэж тодорхойлсон⁴. Тус улсын сангийн яамны албан тайлбарт криптовалютын уламжлалт мөнгөтэй адил төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа гэх үндэслэлээр татварын ногдуулах боломжтой гэж тайлбарласан. Татвар ногдуулахдаа криптовалютыг нэг жил хүртэл хадгалан өгөөж хүртэж буй тохиолдолд орлогын татвар ногдуулахаар шийдвэрлэсэн байна⁵.

Хятад: Тус улсын Төв банк криптовалютыг бодит мөнгө биш учир төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах боломжгүй гэж үзэн 2013 онд биткойныг албан ёсоор ашиглахыг хориглосон. Хятадын төв банк 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд "Цахим мөнгөний хүрээлэн" гэх нэгжийг байгуулсан ба 2016 онд өөрсдийн криптовалютыг хөгжүүлж байгаагаа олон нийтэд мэдээлсэн⁶. 2017 онд биткойны олборлолт болон санхүүгийн байгууллагыг криптовалютаар үйлчлэхийг албан ёсоор хориглосон. Хятад улс 2019 онд анхдагч зах зээл дээр койн гаргах (ICO-initial coin offering), хувьцаагаар баралгаажсан токены үйлчилгээг (STO-security token offerings) тус тус хориглосон⁷.

¹ Financial Consumer Agency of Canada, Digital Currency, (2018) <https://www.canada.ca/en/financial-consumer-agency/services/payment/digital-currency.html> (сүүлийн хандлагт: 07.11.2018).

² <https://www.sec.gov/rules/sro/cbochzx/2021/34-91326.pdf>

³ Japan Crypto Asset Regulations, <https://www.loc.gov/law/help/cryptocurrency/japan.php> (сүүлийн хандлагт: 2021.02.10).

⁴ Gesetz über das Kreditwesen KWG, Banking Act, (1998) https://www.bafin.de/SharedDocs/Downloads/EN/Aufsichtsrecht/dl_kwg_en.pdf?__blob=publicationFile&v=3

(Сүүлийн хандлагт: 2021.02.10).

⁵ Banking Act of Germany, § 35.

⁶ Zhon Xiaochuan, Future Regulation on Virtual Currency Will Be Dynamic, Imprudent Products Shall Be Stopped for Now, Xinhuanet (2018) http://www.xinhuanet.com/finance/2018-03/10/c_129826604.htm (сүүлийн хандлагт: 2021.02.10)

⁷ <https://coin-turk.com/cin-hukumetine-bagli-medy-a-kapanli-2019-beklentisini-acikladi> (сүүлийн хандлагт: 01.03.2021)

А. Монгол улс дахь криптовалютын эрх зүйн орчин.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжыг судлан үзэхэд Иргэний хуулийн 85.4 дэх хэсэгт эдийн бус хөрөнгийн тухай зохицуулалт байдаг ч энэ зохицуулалтаар криптовалютын харилцааг тодорхойлож болох эсэх нь эргэлзээтэй байна. Мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд Монгол улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэхээр зохицуулсан, Татварын ерөнхий хуульд криптовалют, виртуал хөрөнгөөс татвар авах тухай тодорхой зохицуулалт байхгүй байна¹.

Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд криптовалютын гүйлгээг тусгайлан зохицуулаагүй, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд криптовалютын харилцааг зохицуулагч байгууллага нь аль байгууллага байх талаар, криптовалют дээр суурилсан санхүүгийн үйлчилгээний төрлийг тодорхой зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд криптовалютын тухай нарийвчилсан зохицуулалт алга байна.

Манай улсын хувьд одоогоор криптовалютыг албан ёсоор тодорхойлоогүй, эд хөрөнгө, дижитал мөнгө, эсвэл санхүүгийн хэрэгсэлийн аль нь болох талаар тодорхой өгсөн тайлбар мэдээлэл алга байна.

¹ Монгол банк “Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан талдан судалгаа” 3 тал.

Харин 2021 оны 03 сарын 10-ны өдөр Монголбанкнаас албан мэдэгдэлд криптовалют, токен зэрэг виртуал хөрөнгө нь “цахим мөнгө”-ний шинжийг агуулдаггүй учир Монголбанкны хяналт, зохицуулалтад хамаардаггүй, хууль эрх зүйн орчин тодорхойгүй үйл ажиллагаа болохыг анхааруулсан байна².

Мөн 2021 оны 02 сарын 26 өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны албан мэдэгдэлд зохицуулалтын бус арилжааны хэрэгсэл буюу койн, криптовалют нь тухайн гаргасан компанийн хөрөнгө, хувьцаа хэлбэрээр баталгааждаггүй, бодит үнэт цаасаар солих, хөрвүүлэх боломжгүй байдаг. Иймд токен, криптовалют, койны үнэ ханшийг урьдчилан таамаглах боломжгүй, үнийн савалгаа ихтэй байдаг ба эдгээрийг худалдан авах нь оруулсан хөрөнгөө алдах өндөр эрсдэлтэй болохыг сануулсан байна³.

Харин 2021 онд Хууль зүйн яам болон холбогдох байгууллагуудын зүгээс ФАТФ-ын зөвлөмжийн дагуу “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн төслийг боловсруулсан байна. Уг хуулийн төсөлд “виртуал хөрөнгө гэж дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг” гэж тодорхойлсон байна.

Уг тодорхойлолтоос дүгнэлт хийхэд криптовалютыг “төлбөр тооцооны

² <https://montsame.mn/mn/read/256635> (сүүлийн хандлагт: 01.03.2021).

³ <http://www.frc.mn/a/3527> (сүүлийн хандлагт: 01.03.2021).

болон хөрөнгө оруулалтын хэрэгсэл” болгон ашиглах боломжтойг онцлон тодорхойлсон байна. Виртуал хөрөнгийн нэг төрөл бол криптовалют. “Дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг” гэж тодотгосон нь криптовалютыг хөрөнгө гэж тодорхойлсон гэж үзэх боломжтой байна.

V. Дүгнэлт

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжын хүрээнд криптовалютыг харилцааг нарийвчилан зохицуулсан зохицуулалт дутмаг байна. Нөгөөтэйгүүр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн төслийн хамрах хүрээ нь зөвхөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэлжүүлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд үйл ажиллагаанд нь хяналт тавихаар байдлаар хязгаарласан нь учир дутагдалтай байна.

Иймд дээр дурьдсанчлан криптовалютыг эрх зүйн хувьд тодорхойлход тулгарч буй асуудалыг харгалзан, олон улсын байгууллага, бусад орны туршлагыг судлан үзэн өөрийн орны зах зээлийн нөхцөл байдалд тулгуурлан виртуал хөрөнгийн (криптовалют) харилцааг технологийн хувьд аюулгүй, олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогод нэгдсэн, криптовалютын зах зээлийг хөхүүлэн дэмжсэн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх нь манай орны хөрөнгийн зах зээлийн хөгжилд тодорхой хувь нэмэр болох юм.

Ном зүй

Монгол эх сурвалж:

- Монгол банк, Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, 2021 он.
- Энтони Лювис “Биткойн ба блокчэйний тухай үндсэн ойлголтууд (крипто-валют болон ард нь ажиллуулж байгаа технологийн талаарх удиртгал)” 2018 он.
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, 2021 он.
- ФАФТ-ын “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт.

Гадаад эх сурвалж:

- Zhou Xiaochuan, Future Regulation on Virtual Currency Will Be Dynamic, Imprudent Products Shall Be Stopped for Now, Xinhuanet (2018).
- Burzin Bozdoganoglu, Virtual currency bitcoin's effects to informal economy, money, laundering process and it's taxation, Journal of Fiscal Law, (2014).
- Marian. O, Is Cryptographic Currency An Outsanding Tax Heaven?, (2016).
- European Central Bank: Virtual Currency Schemes, (2012).
- European Central Bank: Virtual Currency Schemes- a further analysis, (2015).
- Michael Strauss, A Comparison of Virtual of Currency Systems, (2010).

- Satoshi Nakamoto, Bitcoin: A Peer-to-peer Electronic Cash System (2008).
- Yaşar Göltekin, Yetkin Bulut, Bitcoin Economy: Emerging new sectors of bitcoin eco-system and its analysis (2016).
- Bikramaditya Singhal, Gautam Dhameja, Priyansu Sekhar Panda, Beginning Blockchain, (2018).
- İnci Parlaktuna, Bitcoin'nin tanımlanma sorunu, Muhasebe ve Finansman Dergisi (86), (2019).
- Sarıkatipoğlu M.A, Zapkın T.A, Karaalioğlu. F, Bitcoin: Bir Sanal Para Birimi Olarak Regülasyonu ve Kara Para Aklanm

(Footnotes)

1 Иргэний хууль. 2002 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/299>

2 Civil Act of the Republic of Korea (Law No.471). (1958).Эх сурвалж: www.moleg.go.k

3 Civil Code of the Philippines. Republic Act No. 386.18 June 1949.

4 Эрүүгийн хууль.2015 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/11634>

5 Penal Code of Vietnam (No.15/1999/QH10). Translated version is originated from Ministry of justice and for reference only. Эх сурвалж: www.boluathinhsu.com/pena-codel/

6 Criminal code of Canada. Эх сурвалж: <http://laws-lois.justice.gc.ca>

7 Penal Code of Malaysia (Act 574). Enacted 1936 (F.B.S.Cap.45), Revised 1997 (Act 574), Latest amendment 31 Decembet 2014 (Act A1471). Эх сурвалж: www.aqc.gov.my

Семейный кодекс Российской Федерации.29,12,95 И 223-ФЗ. Принят Государственной Думой декабря 1995 года. Эх сурвалж: www.consultant.ru

8 Swiss Criminal Code of 21 December 1937 (Status as of October 2016). The Federal Council (The portal of the Swiss Government). Эх сурвалж: www.admin.ch/opc/en/

9 Criminal Act of New Zeland. Эх сурвалж: www.legislationgovt.nz

10 Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5."төрлийн хүн" гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг

эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

11 Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6. "садангийн хүн" гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

12 Гэр бүлийн тухай хууль.1999 он. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/226>

13 Вьетнамын Гэрлэлт, гэр бүлийн тухай хууль: 3.17.ижил шууд цусны хүмүүс гэж дараалан төрсөн цусан төрлийн холбоо бүхий этгээдийг ойлгоно.

14 Вьетнамын Гэрлэлт, гэр бүлийн тухай хууль: 3.18.гурван үеийн төрөл садан гэж эцэг, эхийн дундаас төрсөн нь нэг дэх үе, төрсөн ах, дүүс, эцэг нэгтэй ах, дүүс, эх нэгтэй ах, дүүс нь хоёр дахь үе, авга ах, нагац ахын хүүхдүүд, авга эгч, нагац эгчийн хүүхдүүд нь гурав дахь үеийг тус тус ойлгоно.

15 Law on marriage and family of Vietnam (No. 52/2014/QN13). June 26, 2014

16 Marriage and Divorce Act of Malasia – 1976 (Act 164)

17 Семейный кодекс Российской Федерации. 29.12.95 И 223-ФЗв

18 The Family Code of the Philippines. Executive Order No. 209- Full Text – Chan Robles Virtual Law Lebrary. Эх сурвалж: www.chanrobles.com

19 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1."гэр бүлийн хүчирхийлэл" гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн

засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг;

20 Зөрчлийн тухай хууль.2017 он. Эрх сурвалж:<https://www.legalinfo.mn/law/details/12695>.

21 Punishment of Incest Act of Ireland, 1908. Эх сурвалж: www.irishstatubook.ie

22 The Incest (Punishment) Act. Эх сурвалж: <http://moj.gov.jm>

23 Санхүүгийн тайланг ил болгох хуультай ч үйл ажиллагааны тайланг ил тод болгохыг хуульчлаагүй.

24 Нэгж байгуулах тухай хуульд тусгасан ч судалгаанд хамрагдсан ихэнх компанийн нийтэд ил болгосон мэдээлэлд тусгагдаагүй.

25 Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно. Мөн Компанийн хуулиар хувьцаат компанийг заавал хийлгэхийг шаарддаг.

26 Компанийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар Олон улсад хүлээн зөвшөөрсөн санхүү, нягтлан бодохын стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг.

27 Компанийн тухай хуулиар УЗ-ийн дэргэдэх хороонд харьяалагдаж тайлагнах ёстой. Гэвч ил байгаа мэдээллээс энэ заалт хэрэгжиж байгаа эсэхийг мэдэх боломжгүй байна.

28 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ.

29 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зохицуулалт орсон ч хэрэгжилт тааруу байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ) нь хувьцааны эрхийг хэрэгжүүлж буй компаниудын гүйцэтгэх захирлын тайлан, гэрээг дүгнэхдээ аудитын тайлангийн гүйцэтгэлийг үндэслэдэг жишээ байна.

30 ТӨК-иуд нь бусад хэвшлийн компанийн адил Компанийн тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Шилэн дансны хууль нь зөвхөн ТӨК болон орон нутгийн өмчит компаниудад үйлчилдэг.

31 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно.” гэж хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

